



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



ДЭЛХИЙН БАНКНЫ
“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот
2013 он

**DDC
340.2
X-262**

ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

Зөвлөх: Ж.Амарсанаа (Sc.D)

Багийн гишүүд:

М.Ариунаа (LL.M)
П.Баянбаатар (LL.M)
Б.Одонгэрэл (LL.M)
Д.Отгонтуяа (LL.M)

ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН:

Зөвлөх: Ж.Амарсанаа (Sc.D)

Зохиогчид:

Ж.Амарсанаа (Sc.D)
Б.Амарсанаа (Ph.D)
М. Ариунаа (LL.M)
П.Баянбаатар (LL.M)
Б.Одонгэрэл (LL.M)
Д.Отгонтуяа (LL.M)
А.Төмөр (LL.M)

Хэвлэлийн хуудас: 15.6

Цаасны хэмжээ: B5

Хэвлэсэн тоо: 1200

Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

ISBN 978-99962-56-73-8

© Энэхүү гарын авлага нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН БАГШ, ОЮУТАН НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон. 2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн Зохицуулагч
Больхофлогийн Сарантуяа*

ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг. 1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

Төслийн зөвлөх Ухнаагийн Туяа (Ph.D)

ЖҮГНЭЭГИЙН АМАРСАНАА

Монгол Улсын гавьяат хуульч, Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), Профессор



Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төвийн захирал, Олон улсын эрх зүйн тэнхимийн зөвлөх профессор, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Монголын олон улсын эрх зүйн нийгэмлэгийн ерөнхийлөгч.

Сүүлийн 40 шахам жил 500 орчим хуулийн төсөл, олон улсын 40 орчим гэрээний төсөл бэлтгэх, гэрээнд нэгдэн орох (санал өгөх, ажлын хэсгийн гишүүн, санаачлан боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох зэрэг)-д оролцсон. Судалгааны ажил нь Үндсэн хууль, бусад 70 орчим хуульд тусгалаа олсон. Магистр (60), доктор (10)-ын ажлыг удирдаж хамгаалуулсан буюу удирдаж байна.

БАТБОЛДЫН АМАРСАНАА

Хууль зүйн ухааны доктор (LL.D)

МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, дэд профессор, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэд захирал



2008 онд Япон улсын Нагояагийн их сургуульд хууль зүйн ухааны доктор (LL.D)-ын зэрэг хамгаалсан. Тайваний үндэсний их сургууль, АНУ-ын Вашингтоны их сургуульд зочин судлаачаар ажиллаж байсан.

Компани, хуулийн этгээдийн эрх зүй, хууль зүйн мэргэжлийн болон эдийн засагчдад зориулсан бизнесийн эрх зүй, олон улсын бизнесийн эрх зүй, харьцуулсан эрх зүй судлал, олон улсын хувийн эрх зүйн чиглэлээр судалгааны ажил хийдэг.



МӨНХДАЛАЙН АРИУНАА

Хууль зүйн магистр

*Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн
Олон улсын эрх зүйн тэнхлийн ахлах багш*



Хууль зүйн клиник сургалтын төвийн эрхлэгч. Хууль зүйн их, дээд сургуулийн багш нарын мэргэжил дээшлүүлэх үндэсний сургагч багш. Тэрээр Төрийн онол, Эрх зүйн онол, харьцуулсан эрх зүй болон Хууль зүйн клиник дадалын хичээл заадаг бөгөөд 10 гаруй судалгааны өгүүлэл болон 15 ном, сурах бичиг дангаар болон хамтран боловсруулж хэвлэн нийтлүүлсэн.

Эрх зүйн бакалаврын хичээлийн хөтөлбөр, гарын авлага боловсруулах, турших, хууль зүйн клиникийн багш бэлтгэх, чадавхижуулах, хууль зүйн клиникийн стандарт, гарын авлага боловсруулах, хүүхдийн эрх хамгаалал, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүүхэд хамгаалын хуулийн төсөл боловсруулах чиглэлээр 10 гаруй төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгч багийн гишүүнээр ажилласан.

ПҮРЭВЖАВЫН БАЯНБААТАР

Хууль зүйн магистр

Шихихутуг Хууль зүйн дээд сургуулийн Салбар эрх зүйн тэнхимийн багш



2008 онд Шихихутуг ХЗДС төгссөн. 2010 оноос Хууль сахиулах Их сургуулийн докторант. УИХ-ын Тамгын газрын зөвлөх. Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл 10 орчмыг нийтлүүлсэн. “Салбар эрх зүйн бодлого бодох аргачлал” гарын авлагын хамтран зохиогч, “Үгээр урлахуйн ухаан” номын редактор. Харьцуулсан эрх зүй, эрх зүйн онол, эрүүгийн эрх зүйн чиглэлээр судалгааны ажил хийж байна.

БИРААГИЙН ОДОНГЭРЭЛ

Хууль зүйн магистр

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн

Хууль зүйн судалгааны төвийн бодлогын ахлах судлаач



МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийг 2004 онд эрх зүйч мэргэжлээр төгсч, тус сургуульд 2008 онд Хууль зүйн магистр, Япон улсын Кюүшюүгийн Их сургуульд 2011 онд Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.

20 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажил дангаар болон багаар гүйцэтгэж, 14 өгүүлэл, нийтлэл бичиж 2 гарын авлага зохиох ажилд оролцож, олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний бага хуралд 8 удаа илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Эрүүгийн эрх зүй, харьцуулсан эрх зүй болон криминологийн чиглэлээр мэргэшсэн.

ДАГДАНГИЙН ОТГОНТУЯА

Хууль зүйн магистр

Шихихутуг Хууль зүйн дээд сургуулийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхимийн ахлах багш



1996 онд Шихихутуг ХЗДС, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль төгссөн. “Эрх зүйн философи” сурах бичиг, “Төрийн онол” гарын авлагын хамтран зохиогчоор ажилласан. Төрийн онол, эрх зүйн философийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж байна.

АМАРСАНААГИЙН ТӨМӨР

Хууль зүйн магистр

Гадаад харилцааны яатны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал



1998-2003 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйч мэргэжлээр, 2002-2003 АНУ-ын Калифорнийн Олон улсын Их Сургуульд суралцаж, 2006-2007 онд Японы Кюүшүгийн Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг төгссөн. Олон улсын нийтийн эрх зүй, Олон улсын хувийн эрх зүй, Харьцуулсан эрх зүй, Гадаад харилцааны сэдвээр дангаар болон хамтарсан бүтээл туурвисан.



ӨМНӨХ ҮГ

Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш харьцуулсан эрх зүйг судлах, сургах нь ихээхэн өргөжжээ. 1997 оноос Хууль зүй, Гэгээрлийн сайдын хамтарсан тушаалаар анх эрх зүйн ангид заавал судлах хичээл болгон орж эхэлсэн бөгөөд улмаар Дэлхийн банкны “Эрх зүйн шинэчлэлт” төслийн оролцоотойгоор боловсруулан хэрэгжүүлж буй “Эрх зүйн бакалаврын боловсролын стандарт”-д “Харьцуулсан эрх зүй”-г заавал судлах мэргэжлийн суурь хичээлийн жагсаалтад оруулан, судлах багц цагийн доод хэмжээг 2 кр байхаар тусгасан байна. Харьцуулсан эрх зүй нь орчин үеийн эрх зүйн боловсролын чухал бүрэлдэхүүн хэсэг төдийгүй хуульчийн эрх зүйн ерөнхий соёл төлөвших, үндэсний эрх зүйн тогтолцоог төгөлдөржүүлэх арга замыг тодорхойлох, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах “хичээл” болно.

Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн дэмжлэгээр энэ чиглэлийн хичээл заадаг, судалгаа хийдэг багш, судлаачид хамтарч хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудад зориулан “Харьцуулсан эрх зүй” хичээлийн хөтөлбөр, гарын авлагыг анх удаа гаргаж байна.

Харьцуулсан эрх зүйн чиглэлээр цөөнгүй өгүүлэл, ном нийтлэгдэж, хэд хэдэн эрдэм шинжилгээний бага хурал болсон байна.

Өдгөө хүртэл эрх зүйн аймаг, эрх зүйн бүл, эрх зүйн бүлэг гэх мэтээр бичиж ярьж иржээ. Орос хэлний семья-гэр бүлийн бүлийг авч, англи хэлний family-ийг бүл хэмээн орчуулж байна. Заавал гэр бүл юм уу, бүл гэх албагүй л дээ. Одоогоор зөгийн бүл гэх зэргээр хэл зүйн хувьд энэ үгийг хэрэглэж байна. Амьтны аймаг, ургамлын аймаг, үгсийн аймаг гэж бий. Монгол хүн ч гэсэн бид аймагт хуваагдаад амьдарч байна. Бид эрх зүйн аймаг гэж нэршихээр тогтож эл гарын авлагад оруулсан болно.

“Харьцуулсан эрх зүй” гарын авлагыг суралцаж буй оюутан болон багш, судлаач нар уншиж судалбал эрх зүйн мэдлэг, эрх зүйн соёл, боловсролд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах болно. Энэхүү гарын авлагыг бусад эх сурвалжтай хамтатган судлавал сайн.

Танд эрдтийн амжилт хүсье.

ЗӨВЛӨХ Ж.АМАРСАНАА

ГАРЧИГ**НЭГ. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

1. Харьцуулсан эрх зүйн хичээлийн тодорхойлолт.....	9
2. Харьцуулсан эрх зүйн хичээлийн товч агуулга	11
3. Харьцуулсан эрх зүйн хичээлийн заах арга зүй.....	20
4. Харьцуулсан эрх зүйн хичээлийн үнэлгээ	35
5. Сургалтын хэрэглэгдэхүүн	36

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА**А. Лекцийн хичээл**

1. Харьцуулсан эрх зүйн ойлголт, судлах зүйл	42
2. Харьцуулсан эрх зүйн хөгжил.....	48
3. Харьцуулсан эрх зүйн зорилго, чиг үүрэг.....	54
4. Олон улсын ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал.....	56
5. Эрх зүйн аймаг, түүний ангилал	61
6. Ром-Германы эрх зүйн аймаг.....	69
7. Англи-Америкийн эрх зүйн аймаг.....	72
8. Ром-Германы эрх зүй болон Англи-Америкийн эрх зүйг ойртуулах.....	79
9. Хиндү эрх зүй.....	80
10. Лалын эрх зүй.....	85
11. ОХУ-ын эрх зүй.....	90
12. БНХАУ-ын эрх зүй.....	96

Б. Семинарын хичээл

1. Харьцуулсан эрх зүйн ойлголт, судлах зүйл	105
2. Олон улсын ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал.....	111
3. Эрх зүйн аймаг, түүний ангилал	113
4. Ром-Германы эрх зүй болон Англи-Америкийн эрх зүйг ойртуулах.....	118
5. Скандинавын эрх зүй	121
6. Африк, Латин-Америкийн эрх зүй	133
7. Японы эрх зүй.....	138
8. БНСУ-ын эрх зүй.....	146



НЭГ. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1.ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Харьцуулсан эрх зүйн хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр:	Харьцуулсан эрх зүй
Хичээлийн кредит:	2 кредит цаг
Нийт цаг:	40 цаг (24 цагийн лекц, 16 цагийн семинар)
Залгамж холбоо:	Төрийн онол, Эрх зүйн онол, Эрх зүйн философи, Үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны эрх зүй, Иргэний болон Эрүүгийн эрх зүй хичээлийг судалсны дараа судална.

1.2. Хичээлийн хэрэгцээ:

Харьцуулсан эрх зүй хичээлээр дэлхийн эрх зүйн тогтолцоо, тэдгээрийн үүсэл, хөгжил, эрх зүйн тогтолцооны ангилал, ангиллын шалгуур, харьцуулсан эрх зүйн арга, харьцуулсан эрх зүйн түүх, эрх зүйн аймгийн уг гарал, төрөл, ангиллыг судалснаар оюутны эрх зүйн сэтгэлгээ, соёлд ахиц өөрчлөлт гарна.

1.3. Хичээлийн зорилго:

Харьцуулсан эрх зүй хичээлээр оюутанд эрх зүйн тогтолцоо, түүний мөн чанар, тэдгээрийг эрх зүйн аймагт хамааруулахын учир холбогдол, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, харьцуулалт хийх чадварт суралцах, эрх зүйн үзэгдэл, харилцаанд орчин үеийн эрх зүйн соёл, хөгжлийн үүднээс хандах хандлага төлөвшүүлэхэд чиглэнэ.

1.4. Хичээлийн зорилт:

- Харьцуулсан эрх зүйн үүсэл, хөгжил, үндэсний болон олон улсын эрх зүйн уялдаа холбоо, зүй тогтлыг танин мэдэх
- Эрх зүйн тогтолцоо, түүний үндсэн шинж, бүтцийг судлах, харьцуулах, үнэлэлт дүгнэлт өгөх
- Хууль зүйн шинжлэх ухаанд харьцуулсан эрх зүйн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг тодорхойлох

1.5. Харьцуулсан эрх зүй хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

№	Хичээлийн сэдэв	Лекц	Семинар
1	Харьцуулсан эрх зүйн ойлголт, судлах зүйл	2	2
2	Харьцуулсан эрх зүйн хөгжил	2	
3	Харьцуулсан эрх зүйн зорилго, чиг үүрэг	2	
4	Олон улсын ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал	2	2
5	Эрх зүйн аймаг, түүний ангилал	2	2
6	Ром-Германы эрх зүйн аймаг	2	
7	Англи-Америкийн эрх зүйн аймаг	2	
8	Ром-Германы эрх зүй болон Англи-Америкийн эрх зүйг ойртуулах	2	2
9	Скандинавын эрх зүй		2
10	Африк, Латин-Америкийн эрх зүй		2
11	Хиндү эрх зүй	2	
12	Лалын эрх зүй	2	
13	Оросын эрх зүй	2	
14	Хятадын эрх зүй	2	
15	Японы эрх зүй		2
16	БНСУ-ын эрх зүй		2
	Нийт	24 цаг	16цаг



2. “ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ” ХИЧЭЭЛИЙН ТОВЧ АГУУЛГА

А. ЛЕКЦИЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

СЭДЭВ 1: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- Харьцуулсан эрх зүй, түүний судлах зүйлийн талаар мэдлэгтэй болох
- Эрх зүйн шинжлэх ухаан болон харьцуулсан эрх зүйн харилцан хамаарлыг тодорхойлох

Нэр томьёо:

- Харьцуулсан эрх зүй
- Харьцуулсан эрх зүй судлал
- Эрх зүйн харьцуулсан судлал
- Эрх зүйн харьцуулалт
- Арга, аргачлал
- Арга зүй

Сэдвийн агуулга:

- Харьцуулсан эрх зүйн ойлголт
- Харьцуулсан эрх зүйн судлах зүйл
- Эрх зүйн шинжлэх ухаан болон харьцуулсан эрх зүйн харилцан хамаарал
- Харьцуулсан эрх зүй нь шинжлэх ухаан, хичээл, судалгааны арга зүй болох нь
- Харьцуулалтын ойлголт, төрөл, ач холбогдол

СЭДЭВ 2: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- Харьцуулсан эрх зүйн үүсэл хөгжлийн түүхэн үе шатны талаар мэдлэгтэй болох
- Эрх зүйн үзэгдлийн үүсэл хөгжлийг харьцуулсан эрх зүйн хөгжлийн үе шаттай холбон тайлбарлах, чиг хандлагыг тодорхойлох

Нэр томьёо:

- Харьцуулсан эрх зүйн үүсэл
- Харьцуулсан эрх зүйн хөгжлийн үе шат
- Эрх зүйн соёл
- Өрнийн эрх зүйт ёс
- Харьцуулсан нийтийн эрх зүй

- Харьцуулсан хувийн эрх зүй
- Эрх зүйт төр
- Эрх зүйн үзэл суртал
- Эрх зүйн үнэт зүйл

Сэдвийн агуулга:

- Харьцуулсан эрх зүйн үүсэл хөгжил
 - Эртний соёл, иргэншлийн үеийн харьцуулсан эрх зүйн үүсэл
 - Дундад зууны үеийн харьцуулсан эрх зүйн хөгжил
 - Шинэ үеийн харьцуулсан эрх зүйн хөгжил
 - Орчин үеийн харьцуулсан эрх зүйн хөгжил, чиг хандлага
- Германд харьцуулсан эрх зүй үүсэж хөгжсөн онцлог
- Францад харьцуулсан эрх зүй үүсэж хөгжсөн онцлог
- Англи, АНУ-ын харьцуулсан эрх зүй үүсэж хөгжсөн онцлог
- Монгол Улсад харьцуулсан эрх зүй үүсэж хөгжсөн нь

СЭДЭВ 3: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ЗОРИЛГО, ЧИГ ҮҮРЭГ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- *Харьцуулсан эрх зүйн зорилго, чиг үүргийн талаар мэдлэгтэй болох*
- *Харьцуулсан эрх зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх, практик болон онолын ач холбогдлыг тодорхойлох*

Нэр томъёо:

- Харьцуулсан эрх зүйн зорилго
- Харьцуулсан эрх зүйн чиг үүрэг
- Танин мэдэхүйн чиг үүрэг
- Шинжлэх ухааны чиг үүрэг
- Мэдээллийн чиг үүрэг

Сэдвийн агуулга:

- Харьцуулсан эрх зүйн зорилго
- Харьцуулсан эрх зүйн чиг үүргийн тухай ойлголт, ангилал
- Харьцуулсан эрх зүйн танин мэдэхүйн чиг үүргийн агуулга
- Харьцуулсан эрх зүйн шинжлэх ухааны чиг үүргийн агуулга
- Харьцуулсан эрх зүйн мэдээллийн чиг үүргийн агуулга
- Харьцуулсан эрх зүйн хууль зүйн онолын болон практик ач холбогдол



СЭДЭВ 4: ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Судлах цаг: 2цаг

Сэдвийн зорилго:

- Олон улсын ба үндэсний эрх зүйн харилцан хамаарлын талаар мэдлэгтэй болох
- Үндэсний эрх зүйн үнэт зүйлсийн олон улсын эрх зүйд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох

Нэр томъёо:

- Үндэсний эрх зүй
- Олон улсын эрх зүй
- Эрх зүйн нөлөөлөл
- Монизмын онол
- Дуализмын онол
- Үндэсний хууль тогтоомж

Сэдвийн агуулга:

- Үндэсний эрх зүйн тогтолцооны ойлголт, мөн чанар
- Үндэсний эрх зүйн тогтолцооны үнэт зүйл
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээ
- Олон улсын гэрээний эрхийн тухай Венийн конвенц /1969 он/
- Олон улсын ба үндэсний эрх зүйн тогтолцооны харилцан хамаарлын талаарх ойлголт
- Олон улсын ба үндэсний эрх зүйн тогтолцооны хоорондын харилцааны онол

СЭДЭВ 5: ЭРХ ЗҮЙН АЙМАГ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- Эрх зүйн аймаг, түүний ангилал, шалгуурын талаар эрдэмтдийн онол, арга зүйн үзэл баримтлалыг харьцуулан судлах,
- Тэдгээрийн нийтлэг болон ялгаатай талуудыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээлэл цуглуулах чадварыг хөгжүүлэх

Нэр томъёо:

- Эрх зүйн аймаг
- Эрх зүйн тогтолцоо
- Эрх зүйн уламжлал
- Эх сурвалж

- Институт
- Эрх зүйн үндсэн аймаг
- Ром-Германы эрх зүйн аймаг
- Англи-Америкийн эрх зүйн аймаг

Сэдвийн агуулга:

- Эрх зүйн аймаг, түүний ангилал
- Эрх зүйн аймагт ангилах шалгуур, түүний элемент
- Эрх зүйн аймгийн ангиллын талаарх эрдэмтдийн үзэл баримтлал

СЭДЭВ 6: РОМ-ГЕРМАНЫ ЭРХ ЗҮЙН АЙМАГ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- Ром-Германы эрх зүй аймаг үүсч хөгжихөд нөлөөлсөн хүчин зүйлс болон хөгжлийн үе шатыг тодорхойлох

Нэр томьёо:

- Ромын эрх зүй
- Ром-Германы эрх зүй
- Эх газрын эрх зүй
- Хуульчлах (кодификаци)
- Хууль
- Нийтийн эрх зүй
- Хувийн эрх зүй
- Заншил
- Жишиг

Сэдвийн агуулга:

- Ром-Германы эрх зүйн аймаг үүсч бүрэлдсэн нь
- Ром-Германы эрх зүйн аймгийн онцлог шинж
- Ром-Германы эрх зүйн эх сурвалж, тэдгээрийн төрөл
- Ром-Германы эрх зүйн аймгийн дэлхийн эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь, хөгжлийн чиг хандлага

СЭДЭВ 7: АНГЛИ-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙН АЙМАГ

Судлах цаг: 2цаг

Сэдвийн зорилго:

- Англи-Америкийн эрх зүйн аймгийн онцлогийг илрүүлэх
- Англи-Америкийн эрх зүйн аймгийн эх сурвалжийн төрлийг тодорхойлох, үнэлэх, хэрэглэх, мэдээлэл цуглуулах чадвар хөгжүүлэх



Нэр томъёо:

- Англи- Америкийн эрх зүйн аймаг
- Материаллаг эрх зүй
- Процессын эрх зүй
- Статут
- Кодификаци
- Консолидаци
- Шүүхийн жишиг
- Заншлын хэм хэмжээ

Сэдвийн агуулга:

- Англи-Америкийн эрх зүйн аймаг, түүний онцлог
- Англи-Америкийн эрх зүйн аймгийн эрх зүйн эх сурвалж, түүний ялгагдах чанар
- Английн эрх зүйн эх сурвалж, тэдгээрийн төрөл, хэлбэр
- Америкийн эрх зүйн эх сурвалж, тэдгээрийн төрөл, хэлбэр
- Заншлын ба жишгийн эрх зүйн хэм хэмжээ /Англи, Америкийн жишээн дээр/
- Англи- Америкийн шүүхийн тогтолцоо
- Англи- Америкийн эрх зүйн аймгийн дэлхийн эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь, хөгжлийн чиг хандлага

СЭДЭВ 8: РОМ-ГЕРМАНЫ ЭРХ ЗҮЙ БОЛОН АНГЛИ-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙГ ОЙРТУУЛАХ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- Ром-Германы эрх зүй, Англи-Америкийн эрх зүйн хооронд эрх зүйг ойртуулах талаарх жишээ баримтыг судлах
- Эрх зүйг ойртуулахын хэрэгцээ шаардлага, зайлшгүй харгалзан үзэх хүчин зүйлсийг тодорхойлж, ач холбогдол, үр дүнг үнэлэх

Нэр томъёо:

- Ойртуулах /конвергенци¹/
- Хөрвүүлэх /рецепци²/
- Шилжүүлэг /трансплантаци/
- Жигдрүүлэх /сближение/
- Ижилтгэх /унификаци/
- Уялдуулах /гармонизаци/
- Нэгтгэх /интеграци/

¹ Конвергенци-convergere /грек/ Verger – ижилсэх, ойртох

² Рецепци-реceptio/лат/ - хуулах, шилжүүлэх, хүлээн авах, зээлдэх, сэргээх

Сэдвийн агуулга:

- Эрх зүйн хөрвүүлэл, шилжүүлэгийн тухай ойлголт, хэрэгцээ шаардлага, харгалзан үзвэл зохих хүчин зүйлс
- Эрх зүйн хөрвүүлэл, шилжүүлэгийн хэлбэрүүд, тэдгээрийн үр дүн
- Ром-Германы ба Англи-Америкийн эрх зүйн харилцан уялдаа холбоо, хөгжлийн хандлага

СЭДЭВ 9: ХИНДҮ ЭРХ ЗҮЙ

Судлах цаг: 2цаг

Сэдвийн зорилго:

- Хиндү эрх зүйн онцлог эх сурвалжийг судлах
- Өнөөгийн Энэтхэгийн эрх зүйн тогтолцоонд Хиндү эрх зүйн үзүүлсэн нөлөөллийг тодорхойлох

Нэр томьёо:

- Шашин
- Хиндү шашин
- Хиндү эрх зүй
- Шашны нөлөөлөл
- Дхарма
- Энэтхэгийн эрх зүй

Сэдвийн товч агуулга:

- Хиндү эрх зүйн ойлголт, эх сурвалж
 - Сонгодог Хиндү эрх зүй
 - Англи- Хиндү эрх зүй
 - Орчин үеийн Хиндү эрх зүй
- Өнөөгийн Энэтхэгийн эрх зүйн тогтолцоонд Хиндү эрх зүйн үзүүлсэн нөлөөлөл

СЭДЭВ 10: ЛАЛЫН ЭРХ ЗҮЙ

Судлах цаг: 2цаг

Сэдвийн зорилго:

- Лалын эрх зүйн ойлголт эх сурвалжийг судлах
- Лалын эрх зүй нь улс орнуудын хууль тогтоомжид хэрхэн нөлөөлж буй талаар харьцуулах

Нэр томьёо:

- Лалын шашин
- Шариатын ёс
- Коран
- Сунна



- Ижма
- Кияс

Сэдвийн агуулга:

- Лалын эрх зүйн ойлголт, түүхэн тойм
- Лалын эрх зүйн голлох эх сурвалжууд
- Орчин үеийн Лалын эрх зүйд гарч буй өөрчлөлт шинэчлэлт
- Лалын эрх зүй Лалын шашинт улс орнуудын хууль тогтоомжид үзүүлсэн нөлөөлөл

СЭДЭВ 11: ОХУ-ЫН ЭРХ ЗҮЙ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- ОХУ-ын эрх зүйн тогтолцооны онцлогийг өөрийн орны эрх зүйн тогтолцоотой харьцуулан судлах, нийтлэг болон ялгаатай талыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх
- Үндэсний эрх зүйн тогтолцоонд хөрвүүлэх болон шилжүүлэх боломжтой эрх зүйн зохицуулалт, туршлагыг эрэлхийлэх

Сэдвийн агуулга:

- ОХУ-ын эрх зүйн тогтолцооны онцлог
- ОХУ-ын эрх зүйн эх сурвалж, төрөл
- Ром-Германы эрх зүй, Славяны эрх зүйн уялдаа
- ОХУ-ын Үндсэн хуулийн бүтэц, онцлог шинж
- ОХУ-ын шүүхийн тогтолцоо
- Монгол улс, ОХУ-ын эрх зүйн тогтолцоо, харилцан хамаарал, нөлөөлөл

СЭДЭВ 12: БНХАУ-ЫН ЭРХ ЗҮЙ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- БНХАУ-ын эрх зүйн тогтолцооны онцлогийг өөрийн орны эрх зүйн тогтолцоотой харьцуулан судлах, нийтлэг болон ялгаатай талыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх

Сэдвийн агуулга:

- Хятадын эрх зүйн хөгжлийн түүхэн тойм
- БНХАУ-ын эрх зүйн тогтолцооны онцлог
- БНХАУ-ын эрх зүйн эх сурвалж, төрөл
- БНХАУ-ын Үндсэн хуулийн бүтэц, онцлог шинж
- БНХАУ-ын шүүхийн тогтолцоо

Б.СЕМИНАРЫН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

СЭДЭВ 1: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- Харьцуулсан эрх зүйн судлах зүйл, түүний хүрээ, ялгаатай талыг ойлгох
- Харьцуулсан эрх зүй судлалын зорилго, чиг үүрэг, ач холбогдлыг тодорхойлох

Сэдвийн агуулга:

- Харьцуулсан эрх зүйн судлах зүйл
- Харьцуулсан судалгааны арга
- Эрх зүйн харьцуулалтын ангилал
- Харьцуулсан судалгаа хийх аргачлал

СЭДЭВ 2: ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Судлах цаг: 2цаг

Сэдвийн зорилго:

- Олон улсын ба үндэсний эрх зүйн харилцан хамаарлын талаар дүгнэлт хийх, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эрх зүйн үүднээс нь хандах

Сэдвийн агуулга:

- Үндэсний эрх зүйн тогтолцоо ба үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Шилжүүлгийн онол / adoption /
- Хэрэгжүүлэх онол / execution /

СЭДЭВ 3: ЭРХ ЗҮЙН АЙМАГ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ

Судлах цаг: 2цаг

Сэдвийн зорилго:

- Эрх зүйн аймаг, түүний ангиллын талаар мэдлэгээ бататгах
- Үндэстний эрх зүйн тогтолцоонд дүн шинжилгээ хийж эрх зүйн аймагт ангилах, ангиллын шалгууруудыг тодорхойлох чадвартай болох

Сэдвийн агуулга:

- Үндэстний эрх зүйн тогтолцоо ба эрх зүйн аймгийн ангилал
- Үндэстний эрх зүйн тогтолцоонд дүн шинжилгээ хийх, ангиллын шалгуур



СЭДЭВ 4: РОМ-ГЕРМАНЫ ЭРХ ЗҮЙ БОЛОН АНГЛИ-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙГ ОЙРТУУЛАХ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- Үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгоход эрх зүйг ойртуулах аргын гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг бататган тодорхойлох
- Тодорхой салбар эрх зүйн хүрээнд эрх зүйг ойртуулах, хамтран ажиллах, ялгаатай үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, эрх зүйн соёлд суралцах

СЭДЭВ 5: СКАНДИНАВЫН ЭРХ ЗҮЙ

Судлах цаг: 2цаг

Сэдвийн зорилго:

- Скандинавын улс орнуудын үндэсний эрх зүйн тогтолцооны талаар мэдлэгтэй болох
- Скандинавын эрх зүй эрх зүйн аль аймагт хамаарахыг тодорхойлох

Сэдвийн агуулга:

- Скандинавын эрх зүйн түүхэн хөгжил, Германы эрх зүйн үзүүлсэн нөлөө
- Скандинавын эрх зүйн эх сурвалж
- Норвегийн эрх зүйн тогтолцооны онцлог
- Шведийн эрх зүйн тогтолцооны онцлог
- Данийн эрх зүйн тогтолцооны онцлог
- Финландын эрх зүйн тогтолцооны онцлог

СЭДЭВ 6: АФРИК, ЛАТИН-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙ

Судлах цаг: 2цаг

Сэдвийн зорилго:

- Африк, Латин-Америкийн эрх зүйн түүхэн уламжлал, онцлогийн талаар таньж мэдэх
- Африк, Латин-Америкийн зарим орнуудын эрх зүйн тогтолцоо, эх сурвалжийг судлан дүгнэлт хийх

Сэдвийн агуулга:

- Африкийн эрх зүйн ойлголт, түүхэн уламжлал / нутгийн ердийн эрх зүй /
- Африкийн эрх зүйн онцлог
- Африкийн эрх зүйд бусад эрх зүйн тогтолцооны нөлөөлөл
- Африкийн зарим улсуудын эрх зүйн тогтолцооны онцлог, эх сурвалж / Конго улс, Сенегол улс, Танзан улс, Нигер улс /
- Латин- Америкийн эрх зүйн ойлголт, үүсэл хөгжил

- Латин- Америкийн эрх зүйд Ром- Германы эрх зүйн аймгийн үзүүлсэн нөлөө
- Латин Америкийн зарим улсуудын эрх зүйн тогтолцооны онцлог / Куб улс, Бразил улс, Венесуэль улс /

СЭДЭВ 7: ЯПОНЫ ЭРХ ЗҮЙ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- Японы эрх зүйн тогтолцоо, эх сурвалжийг судлан өөрийн орны эрх зүйн тогтолцоонд шилжүүлэг хийх боломжтой эрх зүйн шийдэл, туршлагыг эрэлхийлэх

Сэдвийн агуулга:

- Японы эрх зүйн тогтолцоо, эрх зүйн түүх болон эрх зүйн онцлог
- Японы эрх зүйн эх сурвалж, түүнд Үндсэн хуулийн эзлэх байр суурь
- Японы шүүхийн тогтолцоо, эрх зүйн мэргэжил
- Японы эрх зүйн зорилт болон цаашдын хөгжлийн чиг хандлага

СЭДЭВ 8: БНСУ-ЫН ЭРХ ЗҮЙ

Судлах цаг: 2 цаг

Сэдвийн зорилго:

- БНСУ-ын эрх зүйн тогтолцоог судлан түүний онцлогийг тодорхойлох
- Өөрийн орны эрх зүйн тогтолцоонд шилжүүлэг хийх боломжийг нээн илрүүлэх

Сэдвийн агуулга:

- Солонгосын эрх зүйн тогтолцоо, түүхэн хөгжил болон эрх зүйн онцлог
- БНСУ-ын эрх зүйн эх сурвалж
- БНСУ-ын шүүхийн тогтолцоо, эрх зүйн мэргэжил
- Япон, БНСУ-ын эрх зүйн төсөөтэй болон ялгаатай талууд

3. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙ

3.1 Тавигдах шаардлага

Харьцуулсан эрх зүй хичээлийг судлах үндэслэл, хичээлийн зорилго, зорилттой уялдан уг хичээлийг заах арга зүйд дараахь шаардлага тавина.

- Тухайн хичээлийн зорилгыг хангахуйц, түүний агуулгад тохирсон арга, хэлбэрийг сонгож хичээлээ заах
- Тухайн хичээлээр оюутан эрх зүйн талаар өөртөө мэдлэг бүтээгээд зогсохгүй



бүтээсэн мэдлэгээ амьдралд хэрэглэх чадвар эзэмших, мэргэжилдээ хариуцлагатай хандах хандлага төлөвших нөхцөл боломжийг хангах

- Оюутан хичээлд жигд, идэвхтэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх

3.2 Мэдээлэл түгээх арга, аргачлал

Лекцийн арга/Lecture/: Лекцийн товчлол болон танилцуулгыг хэвлэжурьдчилан тараана. Хичээлийн явцад оюутан тодруулж тэмдэглэх зүйлээ бичиж болохуйц зайг тусгайлан гаргаж лекцийг хэвлэнэ. Лекцийн хичээлийг багш харьцуулсан эрх зүй судлалын ерөнхий ойлголт, өргөн хүрээний мэдлэгийг оюутанд өгөх, ойлгоход нарийн төвөгтэй зүйлийг тайлбарлан таниулах болон гагцхүү олон цаг зарцуулан янз бүрийн эх сурвалж уншиж байж бий болох мэдлэгийг хүргэх, зорилгоор ашиглах нь илүү тохиромжтой. Лекцийн хичээлд, зураг, бүдүүвч, дэлгэц, компьютер, проектор болон бусад үзүүлэн таниулах материал өргөнөөр ашиглах нь цаг хэмнэх, оюутны мэдээлэл хүлээн авах чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Лекцийн аргыг хэрэглэхэд анхаарах зүйл:

- Лекцийг үргэлжилсэн урт хугацаагаар унших нь оюутан анхаарал хандуулахад бэрхшээл үүсдэгийг харгалзан боломжтой нөхцөлд хэлэлцүүлэг, дүрд хувирах, биечлэн үзүүлэх зэрэг бусад аргыг хичээлдээ ашиглах нь зүйтэй.
- Багш ярихын зэрэгцээ үзүүлэн таниулах материал ашигласан тохиолдолд оюутнуудын тогтоох мэдээллийн хэмжээ 25 хүртэл хувиар дээшилдэг бол заалгасан зүйлээ туршиж хэрэглэсэн нөхцөлд энэ үзүүлэлт 70 хувь хүртэл дээшилнэ.

Эвлүүлгийн арга/Jacksaw/: Энэ арга нь оюутанд богино хугацаанд их хэмжээний мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад түүнийг ашигладаг. Тухайлбал, эрх зүйт ёсны зарчмуудыг нэгтгэн ойлгоход энэ арга үр нөлөөтэй байж болох юм. Эвлүүлгийн аргын зорилго нь оюутнууд бие биедээ заах, сургах боломж олгодог ба тухайн хичээлээр мэдээлэл олж авахад хүндрэлтэй тохиолдолд тайлбарлах, асуулт тавих, бусадтай харилцах, бусдыг сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд илүү үр дүнтэй байдаг. Хичээлийн зарим сэдвийг судлахад оюутнууд дэлгэрэнгүй мэдээлэл шаардагддаг ба энэ тохиолдолд тухайн мэдээлэл, лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнийг жижиг багийн тоогоор хувааж бэлтгэнэ. Бэлтгэсэн материалаа дугтуйд хийж багуудад тарааж өгнө. Тэдэнд “мэргэжилтэн” болоход хангалттай хугацаа өгөх хэрэгтэй учир баг бүр дээр багш очиж материалаа ойлгож байгаа эсэх, бусдад хэрхэн тайлбарлах талаар ярилцаж туслах шаардлагатай.

Сократын яриа /Socrat’s Talk/: Бүлэг сэдэв танилцуулах, богино хугацаанд их хэмжээний мэдээлэл олж авах болон нэлээд сэтгэлгээ хөгжүүлэх сэдвийн дор энэ аргыг ашиглана. Тухайлбал, хуульд дээд хүчин чадал олгох үзэл баримтлал

ба төрийн эрх мэдэл хоёрын сөргөлдөөний талаарх сэдвийг харилцан ярилцах нь тохиромжтой байдаг. Энэ арга нь сургалтын үйл явцад оюутнуудыг идэвхтэй оролцуулах, оюутнуудад үзэл бодлоо илэрхийлж, хамгаалах боломж олгох, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх ач холбогдолтой. Энэ аргыг ашигласнаар оюутнуудын хичээлд хандах сонирхлыг өдөөж, бусадтай санал бодлоо хуваалцаж, мэтгэлцэх, маргах соёлд суралцуулна. Хичээлийн үзэх сэдэв, товч агуулга, ашиглах эх сурвалж зэргийн талаархи мэдээллийг багш урьдчилан оюутнуудад танилцуулан, тараасан байна. Мөн оюутнуудын хичээлд суух байршил, нэрс зэрэг нь багшид урьдчилан өгөгдсөн байна. Багш оюутанд нэрээр нь хандан тухайн асуудлаар үзэл бодлыг нь сонсож, үндэслэгээг нь сонсон харилцан ярилцаж, бусдад дүгнэх боломж олгож, хэлэлцүүлэг өрнүүлэн явуулна.

Хүн бүр багш /Each one teach one/: Бүлэг сэдвийг танилцуулах эсхүл үзсэн сэдвийн агуулга, ухагдахуунуудыг дүгнэх, лекцийн агуулгыг оюутнуудад хүргэхэд энэ аргыг гол төлөв ашиглана. Энэ аргын зорилго нь сургалтын үйл явцад оюутан бүр идэвхтэй оролцох, бие биетэйгээ санаа бодлоо солилцоход ач холбогдолтой. Энэ аргыг ашигласнаар хичээлээр заавал эзэмших ёстой сэдвийн агуулга болон ухагдахууны талаар ерөнхий ойлголт өгөх ба оюутнуудын сонирхлыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

- Лекцийн агуулга, мэдээллийг утгадхэсгээр нь хувааж, тарааж өгөх зорилгоор жижиг цаасан дээр бичиж бэлдэнэ. Энэ нь таны сургалтад оролцогчдын тоогоор байх ёстойг анхаарч оролцогч бүрт тараана.
- Оюутнууд мэдээллийг уншсаны дараа уншсан зүйлийнхээ агуулгыг ярих, зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэл хийнэ. Энэ үед багш тусламж шаардлагатай хүн дээр очиж зөвлөгөө өгч, тайлбарлаж болно.
- Бэлтгэх хугацаа дууссаны дараа тэд мэдээллээ бие биедээ танилцуулж ангиа тойрон явна. Хүн бүр өөрт байгаа мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал энэ ажил үргэлжилнэ. Зорилго нь бусадтай мэдээлэл солилцох буюу өөрт байгаа мэдээллээ бусдад тарааж, шинэ мэдээлэл бусдаас олж авахад оршино.

Энэ ажлыг дууссаны дараа багш оюутнуудад хандан, бие биенээсээ юу олж мэдсэн, ямар шинэ мэдээлэл авсан тухай, уг мэдээлэл өөрт нь ямар хэрэг болох тухай асууж ярилцана. Ярилцлагын явцад оюутнуудад юу хэрэгтэй байгаа, тэд бие биеэсээ авсан мэдээллийг хэрхэн цэгцлэх шаардлагатайг багш ажиглаж, тэр дагуу нэмэлт мэдээллийг өгнө.



Удирдан чиглүүлэх арга: Энэ аргыг хэрэглэх үед багш оюутны мэдлэгийг тандах, эсвэл тэдний таамаглал, дүгнэлтийг мэдэж авах, тэгснээрээ тэдний хариултыг ангилан үзэх зорилгоор нэг буюу хэд хэдэн асуулт тавина. Энэ арга нь үргэлжилсэн лекцийн үед хамгийн завсарлага болдог бөгөөд өмнө үзсэн зүйлсээс оюутан юу ойлгож, мэдсэнийг судлахад нь багшид тусалдаг онцлогтой. Ялангуяа хийсвэр ухагдахууныг заах үед хэрэглэхэд тохиромжтой арга юм.

Хэрэгжүүлэх дараалал

1. Оюутны бодож байгааг болон мэдэж байгааг тандан мэдэх зорилгоор нэг буюу хэд хэдэн асуулт асуу. Аль болох олон янзаар хариулж болох асуулт байх хэрэгтэй. Тухайлбал, Эрх зүйн ангийн оюутанд харьцуулсан эрх зүй судлах нь ямар хэрэгтэй вэ?
2. Оюутан хосоороо юм уу хэсэг бүлгээрээ хэлэлцээд, хариулах хэсэг хугацаа өгөөрэй.
3. Нийт ангиар нь дахин хэлэлцүүлж, оюутны санаа бодлыг тэмдэглэж авна. Боломж байвал, өөрийн төлөвлөсөн дэс дараалал, ерөнхий ухагдахуунуудад нийцүүлэн тус тусад нь ангилан жагсаавал зүгээр. Дээр жишээ болгож авсан асуултын хувьд, “ямар мэдлэг, чадвар хэрэгтэй” гэсэн санааг техникийн мэдлэг, чадвар гэсэн ангилалд оруулж бичих жишээтэй.
4. Хичээлийнхээ гол гол ойлголтыг оюутанд танилцуул. Оюутан өөрсдийн хариулт нь таны бодсонтой хир дөхүү байгааг эргэцүүлэн бодож үзэг. Оюутны бодол санаанаас хичээлдээ нэмэрлэх зүйлс байна уу гэдгийг анхаараарай.

Хэрэгжүүлэх хувилбар:

1. Оюутны хариултыг ангилалгүйгээр нэг үргэлжилсэн жагсаалт болгож бичээд, харин оюутнаар өөрсдөөр нь ангилуулж болно.
2. Хичээлийн өмнө урьдчилан ангилал хийлгүй, оюутантай хамтран тэдний санаа бодлыг ангилалд оруулж болох юм.

3.3 Оролцооны арга, аргачлал

Хийсвэр жишээ /Abstract example/: Хийсвэр жишээ нь мөн Сократын ярианаас үүдэлтэй бөгөөд оюутнуудын сэтгэлгээг хөгжүүлэх, эрх зүйн үзэгдэлд онолын задаргаа, эрх зүйн зарчим, үзэл баримтлалын дүн шинжилгээ хийх чадвар эзэмшүүлэхэд энэ арга өргөн хэрэглэгддэг. Зорилго нь сургалтад оролцогчийн өмнө онолын үндэслэл, тайлбаруудыг нарийвчлан хийж болохуйц хийсвэр жишээ бүхий нөхцөл байдлыг тавьж, суралцагсдын өмнө авсан мэдээлэл, туршлага болон амьдралдаа баримтладаг үнэ цэнд нь тулгуурлан уг нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлэн сорьж, идэвхтэй оролцуулахад оршино.

Хэрэгжүүлэх дараалал:

- *Үндэс суурийг тавих.* Дүн шинжилгээ хийхэд хэрэглэх зарчим, агуулгыг танилцуулсан байх ёстой.
- *Хийсвэр жишээг ашиглах.* Эрх зүйн зарчим, үзэл баримтлал, дүрмүүдийг ашиглан олон сонголт гаргаж ирж болох хариулттай, эсхүл тэдгээрээр дэс дараатай алхамууд хийж болох хийсвэр жишээ гаргах.
- *Танилцуулах.* Олсон хийсвэр жишээг сонирхлыг татах хэлбэрээр буюу болж өнгөрсөн бодит зүйл, моодонд орж байгаа зан заншил, алдартай хүмүүс, уран бүтээлтэй холбох, иш татах, үйл явдлыг ноцтойгоор эсхүл хошигносон хэлбэрээр танилцуулж болно.
- *Зөрүүг олж тогтоох.* Эрх зүйн онолыг ашиглаад шууд шийдчихэж болохооргүй хийсвэр жишээ бол харилцан идэвхтэйгээр дүн шинжилгээ хийх боломжтой байвал зүгээр.
- *Санал асуулга асуух.* Тодорхой сценари бүхий жишээг хэлэлцсэний дараа оролцогч бүрт тухайн жишээнд дурдсан асуудлаар нэг буюу түүнээс дээш асуулт тавьж, асуулт бүр дээр олон сонголт бүхий хариулт өгч саналыг нь асуух хэрэгтэй.
- *Харилцан идэвхитэй дүн шинжилгээ хийх.* Хийсвэр жишээг уншиж сонгоод, оюутнууд саналаа өгч, хариуг цаасан дээр булгасны дараа багш тухайн санал буюу хариуны хувилбарын талаар тайлбар шаардаж хэлэлцүүлгийг эхлүүлнэ.

Тохиолдол шинжлэх /Case method/: Тохиолдол шинжлэх арга нь оюутнуудад эрх зүйн хэм хэмжээг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад нь туслах зорилготой асуултын аргад тулгуурласан хэлбэр юм. Тодорхой жишээ гэдэг нь тухайн явдал, бодит хэрэг, шүүхийн шийдвэр зэрэг оюутнуудад нийгэм, эрх зүй, хүний эрхийн асуудлаар шинэ сэргэг ойлголт, мэдлэг өгөх, асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглүүлж ашиглах хэрэглэгдэхүүн юм. Сургалтын тохиолдлууд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино болон дүрс бичлэг, дуу хураагчид бичигдсэн, дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхийн тулд амьдрал, практикт гарч байсан эрх зүйн онолын маргаантай холбоотой хэрэг маргааны талаарх янз бүрийн мэдээлэл, хууль тогтоомж, эрх зүйн актууд болон холбогдох гарын авлагуудыг бэлтгэсэн байх шаардлагатай. Зорилго нь сургалтын энэ арга нь суралцагчийн ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлүүдэд чухал болохыг тодорхойлж, тэдгээрийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тохиолдол бүрт эргэцүүлэн бодож байх боломж олгодог. Тохиолдлыг шинжлэх явцдаа суралцагчид нь цээжлэн тогтоох эхний хэлбэрээс эхлээд бодит баримтыг үнэлэх хүртэл сэтгэхүйн үйлдлүүдийг хийж дадлагажиж болно.



Түүнчлэн оюутнууд шүүхийн шийдвэр болон хэрэг маргаанд дүн шинжилгээ хийх, хууль хэрэглэх дадал, арга зүй олгох, тэдний идэвхийг өрнүүлэхэд энэ аргын зорилго оршино.

Тохиолдол шинжлэх аргыг яагаад хэрэглэдэг вэ?

- Тоймлосон дүгнэлт, тодорхой үзэл санааг гаргадаг.
- Харьцангуй өндөр түвшинд хийсвэрлэн сэтгэх боломжийг хангадаг.
- Суралцагчдын дотоод сэтгэлгээний дадлага, чадварыг хөгжүүлэх, бие даасан задлан шинжилгээ хийх болон шийдвэр гаргах хүнд бэрх сэтгэн бодох үйлдэлд дасгана.
- Танхимд суралцаж буй суралцагчдыг бодит амьдралын туршлага, жишээтэй сэтгэлгээний хувьд холбоотой байх нөхцлийг бүрдүүлнэ.
- Суралцагч онолын болон ерөнхий мэдлэг, арга зүйн чадвар, өөрт буй болсон хандлагаа амьдралд хэрэглэх боломж олгохын зэрэгцээ, эрх зүйн практикт шинэ үзэл санаа, ойлголт, зарчмыг хөгжүүлэхэд нөлөөлнө.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхэд тавих хязгаарлалт болон санамж:

- Хэдийгээр авч байгаа тохиолдол нь бодит байдлын тусгал болдог ч жинхэнэ бодит байдал хараахан биш юм. Нэг ч жишээ жинхэнэ бодит байдлыг бүрэн орлож чадахгүй гэдгийг санах хэрэгтэй. Зарим тохиолдолд жинхэнэ байдал дээр шийдвэр гаргахдаа танхимын сургалтын жишээнд үзүүлж хэрэглэх аргагүй тийм үл ойлгогдох баримтад үндэслэхэд хүрэх нь ч бий.
- Сургалтад хэрэглэгдэж буй жишээ бүр нь өөрийн тодорхой үзэл бодол, мэргэжлийн түвшин бүхий хүн /багш/-ээр суралцагчдад хүрдгийг мартаж болохгүй. Уг аргыг хэрэглэх нь үлэмж их цаг хугацаа шаардана. Энэ чанараар бусад хичээл, сэдвийн цагт сөргөөр нөлөөлдөг. Иймээс тохиолдол нь маш сайн шилж авсан, баялаг агуулгатай, өгөөжтэй, суралцагчдын дадлага, чадварыг үнэхээр хөгжүүлж чадахуйц байх ёстой.
- Зөвхөн ганц тохиолдлыг шинжилснээр сурагчид маш сайн дүгнэлтэд хүрч болох юм. Мөн нэг сэдэв дээр хэд хэдэн жишээ, эсхүл өгөгдсөн жишээн дээр, болон статистик тоо баримт дээр ажиллах боломжтой.
- Ердийн танхимын нөхцөлд багш нь энэ аргаар хичээл явуулахад лектор биш ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох болно. Гэтэл багш бүр энэ үүргийг биелүүлэхэд бэлэн биш байж болохыг бас анхаарах шаардлагатай. Зарим тохиолдолд хууль, эрх зүй тэр бүр ойлгомжтой биш, тэгээд ч зөрчилдөөнтэй байх нь бий. Батлагдсан хуулиудын эдгээр дутагдал нь сургалтын жишээг танхимын нөхцөлд заахад хүндрэлтэй болгож болно. Ийм тохиолдолд багш, суралцагчид ямар хууль батлагдсан байх ёстой байсан, хуулийг хэрхэн өөрчлөн сайжруулж болох, ийнхүү өөрчлөн сайжруулахад оролцох арга замуудын талаар ярилцахад хүрдэг.

- Энэ аргыг хэрэглэхдээ нэг багшид 20-оос илүүгүй оюутан оногдохоор бодож тооцоолох хэрэгтэй бөгөөд оюутны тоо үүнээс илүү байх тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлдөг.
- Холбогдох гарын авлага /гарын авлага, дасгал, бодлогын хураамж зэрэг/, материал, хууль тогтоомжоор зайлшгүй хангагдсан байх ёстой бөгөөд энэ шаардлага хангагдаагүй тохиолдолд хичээлийг үр дүнтэй явуулах боломжгүй.
- Багшийн хувьд хуулийн практикт ажилласан туршлагатай байх нь энэ хичээл амжилттай явагдах гол нөхцөл юм.

Тохиолдлыг бэлтгэх: Тохиолдлыг сонгон авах болон боловсруулахдаа дараах шалгууруудыг анхаарах хэрэгтэй.

- Хүмүүсийн амьдрал, төрийн онол, практикт олонтаа тохиолддог маргаантай асуудлуудыг тусгасан, өөрөөр хэлбэл, бодит байдалд бүрэн нийцсэн эсэх
- Суралцагчдад сонирхолтой бөгөөд зохимжтой эсэх
- Тохиолдолд авсан нөхцөл нь суралцагчдын зүгээс задлан шинжилгээ хийж, өөрсдийн эргэцүүлээ бодож боловсруулах боломж олгохуйц байгаа эсэх
- Эерэг, сөрөг баримт нотолгоог гаргаж болохуйц, мэдээллийн тэнцлийг хангаж чадсан эсэх

Хэрэгжүүлэх үе шат:

Нэг. Шийдвэр гаргахад бэлтгэх үе.

Аливаа шийдвэрийг гаргахад хангалттай сайн мэдээлэл, баримт нотолгоо цуглуулж боловсруулах хэрэгтэй байдаг. Үүний нэг адил тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахын тулд бэлтгэл ажил хэрэгтэй. Үүнд:

1. Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх. Мэдээллийг өгөх олон янзын арга байдаг. Тухайлбал, уншуулах, бага хэмжээний лекц сонсгох, видео бичлэг үзүүлэх гэх мэт.
2. Тохиолдлыг уншуулах. Энэ үед оюутанд тохиолдол /шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа/-ын эцсийн үр дүн, шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит төгсгөлийг нилээд хожим нь авч үзэх болно.
3. Цаашдаа суралцагчдын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх нь чухал. Юуны түрүүнд тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуулах нь чухал. Дараах асуудалд хариулт авах замаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлж болно.
 - Уг тохиолдолд /шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа/ чухам юу болсон бэ?
 - Уг маргаанд ямар хүмүүс, аль аль талууд оролцсон болох?
 - Оролцсон талууд болон хүмүүсийн үйлдсэн, хийсэн зүйл нь чухам ямар учир шалтгааны улмаас үйлдэгдсэн болох?
 - Онолын ямар үндэслэл, арга зүйн ямар нөхцөлүүд чухал болох, шүүхийн шийдвэрт ямар үндэслэгээ чухал болох.



Хичээлийн энэ үед бүх суралцагчид нэг ижил баримтад тулгуурлах ёстой бөгөөд энэ үндсэн дээрээ идэвхтэй ажиллах ёстой тул багш сургалтын тухайн шатанд анхааралтай байх нь чухал. Түүнчлэн уншлагын дадал суугаагүй суралцагчдад ч энэ үе нь чухал ач холбогдол, нөлөөлөлтэй байдаг.

Багшийн зүгээс өөрөө асуулт боловсруулж суралцагчдад ч тавих эсхүл тэднээр өөрсдөөр нь ажиллуулж, асуулт боловсруулж ч болох юм. Ингэхдээ хоёр хоёроор нь ажиллуулах бөгөөд нэг нь чухал баримтууд дээр товч дүгнэлт хийж байхад хоёр дахь асуултуудыг боловсруулан бэлтгэж байх юм.

Хоёр. Шийдвэр гаргах үе:

Суралцагчид хэрэгтэй мэдээллээ авч, тохиолдлыг хангалттай сайн судалж, ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах үйл ажиллагаандаа орно. Тэдний шийдвэр гаргах үйл явцыг багш янз бүрийн аргаар зохион байгуулж болно.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга: Энэ арга нь онолын эсрэг, тэсрэг үзэл бодлыг оюутнууд хамтран хэлэлцэж, өөрийн санал бодол, байр суурийг илэрхийлэх, хамгаалах, мэдээлэл солилцох, өрсөлдөгчийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх чадвартай болгох зорилготой. Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах аргаар хичээлийг явуулахад оюутнууд эсрэг, тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, няцаах, нотолгоог дэвшүүлэх чадвар, хандлага төлөвших боломжтой. Суралцагчдаас, уг асуудалд тэдний үзэж байгаагаар хамгийн чухал маргаантай асуудлууд нь чухам аль нь болохыг асууснаар багш уг сэдэвт холбогдолтой хэлэлцүүлэг, ярилцлага эхэлж болох юм. Хичээлийн явц дүнгээс шалтгаалаад олон төрлийн /хууль эрх зүй, ёс суртахууны эсхүл практикийн холбогдолтой гэх мэт/ асуудлууд гарч болох юм. Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулахад оюутан эхлээд тухайн тохиолдлын хамгийн маргаантай болох цөм хэсгийг ойлгох нь чухал бөгөөд үүнгүйгээр тэдэнд уг тохиолдлын бусад зүйлийг ойлгоход бэрх болно.

Багшийн зүгээс оюутны түвшин болон уг аргаар ажиллах дадлага туршлага зэргийг харгалзан өөрөө уг жишээний гол маргаантай хэсгийг нь тайлбарлан ярьж ч болох талтай. Ингэж багшийн эсхүл оюутны өөрсдийн хүчээр тодорхой ойлгож авсан асуудлын гол хэсгийг дараа дараагийн үзэх зүйлүүдээс ялгаж салгах нь чухал юм. Үүний дараа оюутан онолын үндэслэл, баримт, нотолгоо олох, боловсруулах болон тэдний гаргасан баримт нотолгоо нь нэг үзэл санааг дэмжиж, нөгөөг эсэргүүцэх нь ойлгомжтой. Энэ явцад тэдэнтэй олон талыг хамарсан дараах асуудлуудыг хөндөн ярилцаж болно.

- Маргалдагч үзэл санаа бүрийг дэмжих буюу эсэргүүцэх ямар баримт, учир шалтгаан байж болох? Аль нь үнэмшил муутай болох? Яагаад?
- Энэ асуудлыг өөр арга замаар шийдвэрлэж болох эсэх?
- Хөндлөнгийн байр суурь болоод маргагч талуудын хувьд энэхүү асуудлыг

яаж, хэрхэн шийдвэрлэснээр ямар үр дагавар учирч болох?

- Баримт нотолгоо, учир шалтгаан болон шийдвэр бүрийн давуу тал нь юу болох?

Оюутныг хууль зүйн баримт, шалтгааныг ашиглах, эрх зүйн онолын ойлголт, нийгмийн үнэт зүйл болон улс төр, эдийн засгийн холбоо хамаарлыг судалж чадаж байгаа бол урам өгөх нь чухал. Янз бүрийн нотолгоо, баримт, учир шалтгааныг тодруулах хэлэлцэх явцад бусдын буюу өөр нотолгоо, үндэслэлд хүлээцтэй, тэвчээртэй хандах, мөн хэлэлцүүлгийн ил тод байдлыг хангасан тийм уур амьсгал бүрдүүлэх нь зохистой байдаг. Оюутнуудаас шүүн хэлэлцэж буй ямар ч асуудал, санаа бодол, хүсэлт нь эв эетэй байдал, маргаан зөрүүтэй аль ч үед адил тэгш хэлэлцэх, ярих ёстой гэсэн байр суурийг баримталбал зохино. Өөрөөр хэлбэл, суралцагчид бусдыгаа сонсдог, үзэл санааг нь хүндэтгэдэг, бодитой хандаж, үнэлэлт өгөх чадвартай байна гэсэн үг.

Энэ үед тэдний бүх учир шалтгаан, нотолгоог сонссоны дараа шийдвэр гаргахад анхаарлыг нь төвлөрүүлэх нь чухал. Тэдний гаргасан шийдвэрийн үндэслэлийг заавал асуух хэрэгтэй. Хэрэв шийдвэрийг багш гаргасан буюу уншиж сонгосон бол дараа нь заавал оюутнаар үнэлэлт өгүүлэх хэрэгтэй. Тэд багшийн уншсан сэдэвтэй санал нийлж байгаа эсэх? Ямар учраас? Энэ шийдвэр нь уг ажиллагаанд оролцогч талуудад хэрхэн тусч байна вэ? Нийгэмд ямар үр дагавар авчрах вэ? гэх мэтээр асуух нь тэдэнд үнэлэлт, дүгнэлтээ хэлэх боломжийг олгоно. Хэрэв шийдвэрийг оюутнууд өөрсдөө гаргасан бол уг шийдвэрийг гаргах болсон шалтгаан, үндэслэлийг хэрхэн тайлбарлаж байгааг анхаарах нь зүйтэй. Энэ бүхний эцэст, сонгон авсан тохиолдол нь шүүхээр шийдвэрлэгдсэн бодит хэрэг байсан бол багш шүүхийн шийдвэрийг хэлж өгөх нь зүйтэй. Үүнийг хийхдээ, оюутнууд зөвхөн байгаа баримтад тулгуурлан өөр шийдвэр гаргаснаараа буруутай мэтээр өөрсдийгөө ойлгох байдал төрүүлэхгүйгээр хийх нь чухал. Үүний тулд багш дараах загвар асуултаас ашиглаж болох юм.

- Оюутны болон хуулийн байгууллагын гаргасан шийдвэрүүдийг харьцуулж, аль нь юуны учир илүү давуутай болохыг хэлэлцэнэ.
- Шүүх яагаад өөр шийдвэр биш, чухам энэ шийдвэрийг гаргах болов? Энэхүү шийдвэрийг гаргахад ямар шалтгаан нөлөөлөв?
- Та нар шийдвэртэй санал хэрхэн нийлж байна вэ? Танд энэ шийдвэр хэрхэн нөлөөлж байна? Бусад хүмүүст бол яаж нөлөөлөх вэ? Энэ шийдвэрийн нөлөө, ач холбогдол ямар байх вэ? гэх мэт.

Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлыг сонгох шалгуур:

- Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой, үнэхээр маргаантай асуудал мөн эсэхийг тогтооно.
- Хуулийг дээдлэхэд болон ардчиллыг хөгжүүлэхэд энэхүү асуудал нь чухал ач холбогдолтой эсэх



- Энэ асуудал нь тухайн оюутнуудад хэлэлцэхэд тохиромжтой болон эрх зүйн онол, арга зүйн хувьд ач холбогдолтой эсэх

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөх ба сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг зохион байгуулалт сайтай явуулах, үүссэн маргаантай байдлыг хяналтдаа байлгахад дараах дүрэм нь багшид тус болно.

Тухайлбал:

- Дүрмийг зөвшилцөж гаргаад бүгд биелүүлнэ.
- Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.
- Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусдадаа олгоно.
- Өөрийн байр суурийн эргэлзээтэй, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.
- Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Ийм дадалтай болгохын тулд бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна. Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

Хэрэгжүүлэх дараалал:

Нэгдүгээр үе шат:

Ангийн буланд хэлэлцэх асуудлын сэдвээс хамааран “Санал бүрэн нийлж байна”, “Санал нийлж байна”, “Шийдээгүй буюу эргэлзэж байна”, “Санал нийлэхгүй байна”, “Санал бүрэн нийлэхгүй байна” эсвэл “Маш зөв”, “Зөв”, “Буруу”, “Маш буруу” гэсэн бичиг бүхий цаасыг энэ дарааллаар байрлуулсан байна.

Хоёрдугаар үе шат:

Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлцэж батална.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг хийхэд баримтлах дүрмийн жишээ

1. Хэлэлцэж буй асуудлын хүрээнд суралцагчид өөрсдийн байр суурийг илтгэсэн бичиг бүхий буланд очиж зогсоно.
2. Суралцагчдыг өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарлахыг хүснэ. Бүх суралцагчдыг хамруулах үүднээс ижил сонголттой сурагчид нэг багийг үүсгэж ярилцаад байр сууриа танилцуулахад бэлдэнэ.
3. Өөрсдийн байр суурийг тайлбарласны дараа хэн нэг нь байр сууриа өөрчилж

өөр буланд очихыг хүсэж байгаа эсэхийг асууна. Хэрэв өөрчлөх хүсэлтэй хүн гарвал яагаад ингэх болсон шалтгааныг асууна.

4. Эсрэг баримтлалуудын дэвшүүлсэн үндэслэлээс аль нь хамгийн үнэмшилтэй байсныг асууна.

“ПРОФЕССОРУУД”-тай уулзах: Энэ арга нь хичээл дээр хөндлөнгийн зочин урьж яриа хийлгэх, тухайн чиглэлийн мэргэжилтнийг урьж оролцуулах хэлбэр юм. Энэ нь оюутны хувьд мэргэжлийн хүнтэй хамтран ажиллах, зочны сонирхолтой ярианд идэвхитэй оролцох сайхан боломж өгнө.

Хэрэгжүүлэх дараалал:

1. Тухайн хичээлийн салбарт мэргэшсэн зочныг ярилцлага хийлгэх зорилгоор урина. (Тухайлбал, харьцуулсан эрх зүй судлалын хичээл дээр энэ чиглэлээр судалгаа хийдэг судлаачийг урьж болно.)
2. Урьсан зочиндоо багш энэ хичээлээ хэвлэлийн бага хурал байдлаар явуулах юм гэдгийг ойлгуулан хэлж зохих бэлтгэлийг хангуулсан байна. Ийм хэлбэрээр явуулахад зочин хэдхэн товч тайлбар, эсвэл нилээд албаны ганц нэг мэдээлэл бэлтгэх бөгөөд гол нь “хэвлэлийнхний” асуултад зочин хариулахад л бэлэн байх хэрэгтэй.
3. Зочныг орж ирэхийн өмнө, хэвлэлийн бага хурлыг хэрхэн явуулах журмыг оюутантай хэлэлцэж, тэднийг бэлтгэсэн байх ба яриа хийх хүнд тавих олон янзын асуулт бэлтгэх бололцоогоор хангасан байх шаардлагатай.

Хэрэгжүүлэх хувилбар:

1. Нэг хичээл дээр хэд хэдэн зочин урьж, дугуй ширээний ярилцлага зохиож болно. Зочин бүр ширээ тойрон, эсвэл дугуйруулж тавьсан сандалд нэгэн жижиг бүлэгтэй хамт сууж мэдээлэл солилцох ажил гүйцэтгэнэ. Энэ нь илүү албаны байдалтай орчинд, ярицагчтайгаа сууж, хариулах замаар хамтран ажиллах боломжийг оюутанд олгоно. Хичээлээ хэд хэдэн үед хувааж болно. Хичээлийн нийт үргэлжлэх хугацаа, зочны тооноос хамаарч үргэлжлэхийг тогтооно. Ер нь 30 орчим минут байхад тохиромжтой. Жижиг бүлэг бүр үе өсөх тутам нэг ярилцагчаас нөгөөд шилжих байдлаар зохион байгуулагдсан байна.
2. Өмнө нь суралцаж төгссөн оюутныг зочноор урьж болно (Тухайлбал магистрт суралцаж байгаа болон практикийн байгууллагад ажиллаж байгаа ажилтан, судлаач гм).

Видео шүүмжлэл:

Хэрэгжүүлэх дараалал:

1. Оюутанд үзүүлэх нэг видео хичээл сонгон авна.
2. Видео үзүүлэхийн өмнө, оюутанд энэ бичлэгт шүүмжлэлтэй хандахыг хүсч



байгаагаа хэлээрэй. Бичлэгийн явцад оюутанд анхааран сайн ажиглах зүйлийг санал болгож хэлнэ. Тухайлбал,

- нөхцөл, байдал үнэмшилтэй эсэх
 - тухайн зүйл амьдралд байдаг эсэх
 - хамгийн сонирхолтой зүйлс, үл мартагдах агшин
 - агуулга, утга санааны зохион байгуулалт
3. Видео бичлэгээ үзүүлэх
 4. “Шүүмжлэгчдийн булан” гэж байгуулаад, маргаантай асуудлыг хэлэлцүүлэхэд бэлдэнэ.
 5. Зөвшөөрнө, зөвшөөрөхгүй гэсэн нийтийн үнэлгээний системийг ашиглан ангийн саналыг авна.

Хэрэгжүүлэх хувилбар:

1. Видео шүүмжлэгчдийн төлөөлөх хэсгийг байгуулна.
2. Видео бичлэгээ дахин үзүүлнэ. Хоёрдахь үзэлтээр тэдний шүүмжлэл өөрчлөгдөж болох юм.

Мэтгэлцээнийг хөгжөөх

Ер нь маргаан, мэтгэлцээнийг эхлүүлэх үйл ажиллагаанд багш санаачлагыг гартаа авч, сонирхлыг төрүүлэх сэдэлжүүлэх нь үр дүнтэй байх болно.

Буухиа ярилцлагын арга: Ярилцлагын энэ хэлбэр олон хүнтэй бүлэгт илүү тохиромжтой. “Буухиалах” маягийн нөхцөл, байдал буй болгосноор нийт оюутныг маргаанд татан оролцуулж болно.

Хэрэгжүүлэх дараалал

1. Хичээлийн холбогдолтой нэгэн сонирхолтой сэдэв, эсвэл тодорхой нэг асуудлыг сонгон авна. Түүнийгээ янз бүрийн мэдээ баримт, үзэл баримтлал ашиглаад, аль болох бодитойгоор, гэхдээ товч тайлбарлаж өг. Хэрэв хүсвэл, тэр сэдэв асуудлаа улам тодотгосон баримтуудыг урьдчилан бэлтгээрэй.
2. Тухайн сэдвээр оюутны санаа бодлыг гаргуулахад илүү анхаарал тавина. Тэгэхдээ бүгдийг нэр цохохын оронд дараагийнхаа хүнийг сонгох эрхийг оюутанд өгөх нь зүйтэй. Өөрийнхөө санаа бодлыг яриад дууссан оюутан бусдаасаа хэн нэгнийг ярихыг хүсэж нэг цохно (тухайлбал, гар өргөж байгаа оюутныг нэр дуудаж болох юм).
3. Бусад оюутан оролцохыг хүсэж байгааг сануулаад, аль болох товч тайлбарлахыг хүснэ. Хэрэв хүсвэл хугацааны хязгаар тогтоож болох юм. Өөрөө ярьж дуусаад хэнийг дараа нь дуудахаа урьдчилаад сонгочихсон байхыг сануулахад илүүдэхгүй.
4. Ярилцлагыг тодорхой үр дүн гартал үргэлжлүүлэх хэрэгтэй.

Хэрэгжүүлэх хувилбар

1. Хуралдааныг хэлэлцүүлэг хэлбэрээр явуулж болно. Оюутныг тэдний байр сууриас нь хамааруулан, өрөөний хоёр талаар суулгана. Мөн дараагийнхаа илтгэгчийг сонгохдоо эсрэг этгээдээс дуудах зарчмыг баримтлана. Хэлэлцүүлгийн явцад хэн нэгний үзэл бодол өөрчлөгдвөл нөгөө талд орж суухыг зөвшөөрөх хэрэгтэй.
2. Хуралдааныг төлөөлөх хэсгийн хэлэлцүүлгээс эхэлж болно. Төлөөлөх хэсгийн гишүүд өөрсдийн бодол санааг тайлбарлаад, дараа нь сонсогчдоо нэгнийг нь дуудаж яриулна.

Үзэл бодол-эсрэг байр суурь арга: Энэ нь хоорондоо уялдаатай, нийлмэл асуудлуудыг ойлгох нөхцөл бий болгох, мэтгэлцээнийг хөгжөөх сургалтын нэг арга юм. Мэтгэлцээнтэй төстэй боловч илүү уян хатан байдаг.

Хэрэгжүүлэх дараалал

1. Хоёр болон түүнээс ч олон талт асуудлыг сонгон авна.
2. Оюутан ямар байр суурьтай байгааг та таамаглаж байгаа бол түүнээсээ хамааруулаад хэд хэдэн дэд бүлгүүдэд хуваана. Дэд бүлэг бүрийг өөрсдийн байр сууриа хамгаалах нотолгоо бэлтгэхийг даалгана. Дэд бүлэгт ойр дотноороо нэгдэн ажиллахыг дэмжих хэрэгтэй.
3. Дэд бүлэг бүрийг хооронд нь тодорхой зайтайгаар суулгаад нэгдсэн ярилцлага хийнэ.
4. Хэн нэг оюутан маргааныг эхэлнэ. Тэр оюутны дараа түүнийг дэмжсэн нэг нотолгоо гаргуулаад, дараа нь өөр дэд бүлгийн гишүүд түүнээс ялгаатай юм уу эсрэг нотолгоог гаргах зэргээр явагдана. Бүх нотолгоог гаргаж дуустал маргааныг үргэлжлүүлнэ.
5. Ялгаатай байр сууриудыг харьцуулан ярилцах замаар үйл ажиллагааг дуусгана. Маргаантай, эсрэг тэсрэг үзэл бодолтой үлдэж болно.

Хэрэгжүүлэх хувилбар:

1. Ангиараа маргалдахын оронд дэд бүлэг бүрээс нэг сурагч орсон хэсгүүдийг байгуулж, тэдгээр нь хоорондоо маргалдаж болох юм. Энэ нь нэгэн зэрэг явагдах тул оюутан бүр нэг л ижил хугацаанд маргаанд оролцох болно.
2. Эсрэг бодолтой хоёр дэд бүлгийг өөд өөдөөс нь харуулж эгнүүлэн суулга. Хэн нэг нь өөрийн нотолгоогоо хэлээд ямар нэг зүйлийг (бөмбөг, алчуур зэргийг) эсрэг талын нэг гишүүн рүү шиднэ. Шидсэн зүйлийг авсан хүн өөрийнхөө нотолгоог хэлэх ёстой.

Парламентийн мэтгэлцээний арга: Парламентын мэтгэлцээн нь Парламентын танхимын онлын мэтгэлцээнийг дуурайн учир шалтгааны тайлал, хурц ухаан



уран илтгэлийг уралдуулах албан ёсны мэтгэлцээн юм. Засгийн газар болон сөрөг хүчнийгн төлөөлж буй багууд нь парламентын танхимд санал болгож буй шийдлийг хэлэлцүүлнэ. Мэтгэлцээний шийдэл гэдэг бол хоёр талын мэтгэлцэх гэж буй сэдэв юм. Мэтгэлцээний шийдэл нь 2 талтай асуудал байна, өөрөөр хэлбэл нотолж болон няцааж болохуйц байх юм.

Мэтгэлцээн явуулах дэг

Засгийн газрын баг нь Ерөнхий сайд, болон Засгийн газрын гишүүдээс бүрдэнэ. Харин Сөрөг хүчний баг нь Сөрөг хүчний удирдагч, болон Сөрөг хүчний гишүүдээс бүрдэнэ. Семинарт оролцож буй оюутны тооноос хамаарч засгийн газар, сөрөг хүчин, шүүгчдийн гэх 3 багт хуваана. Шүүгчдийн багийн тоо сондгой байх бөгөөд бусад 2 багаас тоогоор цөөн байж болно. Үг хэлэх дараалал нь дараах байдалтай байж болно.

Багийн гишүүдийн байрлал

1. Ерөнхий сайд
2. Сөрөг хүчний удирдагч
3. Засгийн газрын гишүүн
4. Сөрөг хүчний гишүүн
5. Сөрөг хүчний удирдагчийн дүгнэлт
6. Ерөнхий сайдын дүгнэлт

Эхний 4 илтгэлийг баримтлалын илтгэл, сүүлийн хоёр илтгэлийг дүгнэлтийн илтгэл гэнэ. Багш тухайн хичээлийн агуулгат тохируулан цагийг тус бүрт нь зааж өгч болно.

Ерөнхий сайдын баримтлалын илтгэл

Ерөнхий сайд нь өөрийн эхний илтгэлдээ шийдлийн нөхцлүүд болон үндсэн нэр томъёонуудыг тодорхойлох үүрэгтэй. Дээр дурдсанчлан зарим сэдвийг илүү өргөн хүрээнд тодорхойлно.

Сэдэвтэй нягт холбоотой байна. Засгийн газрын тодорхойлолт нь шийдэлтэй нягт холбоотой байх ба тухайн шийдэл, түүний тодорхойлолт хоёрын хооронд тодорхой логик уялдаа холбоо байх ёстой. Аль нэг салбараар хэт явцуурахгүй байна. Сөрөг хүчинд мэтгэлцэх боломж олгохын тулд засгийн газар нь тухайн тодорхойлолтод хязгаар тавих хэрэгтэй. Засгийн газрын нотолгоо нь олон нийтэд хүртээл болж чадаагүй баримтууд дээр тулгуурлаж болохгүй.

Тэрээр засгийн газрын шийдэл нь зөв болохыг тайлбарласан хэд хэдэн дүгнэлт хийх чиг баримтлалыг танилцуулна.

Сөрөг хүчний удирдагчийн баримтлалын илтгэл

Сөрөг хүчин нь мэтгэлцээнд зөрчилдөөн үүсгэх үүрэгтэй. Сөрөг хүчин засгийн газрын гаргасан дүгнэлтийг няцааж, өөрийн нотолгоог гаргах хэрэгтэй. Хэрэв ерөнхий сайдын тодорхойлолт дээр дурдсан шаардлагыг хангахгүй байвал, сөрөг

хүчний удирдагч өөрийн баримтлалын илтгэлдээ дурдаж өгөөгүй бол тэмцээний турш түүнийг хүлээн зөвшөөрөх болно.

Сөрөг хүчний бодлогыг өргөн хүрээтэй танилцуулсаны дараа нотолгоогоор дамжуулан өөрийн байр суурийг илтгэх маягаар үргэлжүүлнэ.

Засгийн газрын гишүүдийн баримтлалын илтгэл

Засгийн газрын гишүүн нь засгийн газрын баримтлалыг ахин тогтоох, сөрөг хүчний удирдагчийн нотолгоог няцаах үүрэгтэй. Засгийн газрын гишүүн нь ерөнхий сайдын тавьсан санаануудыг ахин төгөлдөржүүлэн, мөн засгийн газрын гишүүн нь, засгийн газрын байр суурийг илгэх нэмэлт, бие даасан нэмэлтүүдээр баяжуулна. Засгийн газрын гишүүн нь шийдэлийг ерөнхий сайдаас өөр байр сууринаас шинжиж, засгийн газрын баримтлал дээр нэмэлт дүгнэлт гаргана. Тухайлбал: ерөнхий сайд нь засгийн газрын баримтлалыг тусгасан гүн ухаанд анхаарлаа төвөрүүлж байхад, засгийн газрын гишүүн өөр бусад зүйлүүдийг шинжиж байж болно. Эцэст нь засгийн газрын гишүүн нь сөрөг хүчний удирдагчийн тавьсан бие даасан нотолгоонд няцаалт өгнө.

Сөрөг хүчний гишүүний баримтлалын илтгэл

Сөрөг хүчний гишүүн нь засгийн газрын гишүүнтэй нэгэн адил сөрөг хүчний гишүүний баримтлалыг ахин тогтоож, засгийн газрын нотолгоог няцаана. Сөрөг хүчний гишүүн нь засгийн газрын гишүүний шинээр дэвшүүлсэн нотолгоонд хариу өгөх үүрэгтэй, хэрэв няцаалт өгөхгүй үлдээвэл сөрөг хүчний удирдагч өөрийн няцаалтдаа тэдгээрт хариу өгөх эрхгүй. Сөрөг хүчний гишүүн нь сөрөг хүчний удирдагчийн баримтлалыг ахин тогтоож, өргөжүүлж, бие даасан дүгнэлтүүдийг дэвшүүлнэ.

Тодруулга авах үе

Тодруулгын үе гэдэг нь эсрэг талын илтгэгчийн яриаг түр тасалж асуулт тавих буюу буруу зөрүүтэй зүйлийг тодруулахыг хэлнэ. Ингэхийн тулд илтгэгч босч “Тодруулгын үе”-ийг таниас авахыг зөвшөөрнө үү гэж хэлэх хэрэгтэй. Илтгэгч тодруулгын үе авах эсэхийг бүрэн шийднэ. Тодруулгын үеийг аваагүй тохиолдолд мэтгэлцэгч суудалдаа суух хэрэгтэй. Тодруулгын үе авсан тохиолдолд мэтгэлцэгч нь илтгэгчид хандан асуултаа тавих буюу зөрүүтэй зүйлийг тодруулахыг хүснэ. Мэдээллийн үе нь 30 секунд байх бөгөөд үүнийг илтгэгчийн илтгэлийн хугацаанд тооцно. Тодруулгын үеийг эхний дөрвөн илтгэлийн үед тавьж болох бөгөөд няцаалтын үед авахыг хориглоно. Илтгэл бүрд 2-с доошгүй тодруулгын үеийг авах нь зүйтэй.

Дүрмийн үе

Дүрмийн үе гэдэг нь эсрэг талын илтгэгчийн илтгэлийн үед мэтгэлцээний дүрмийг



зөрчсөн хэмээн эсэргүүцэхийг хэлнэ. Дүрмийн үеийг тавихын тулд мэтгэлцэгч босч “эрхэм илтгэгч би дүрмийн үеийг тавихыг хүсч байна.” гэж хэлнэ. Энэ үед илтгэгч илтгэлээ зогсоож мэтгэлцэгч эсэргүүцлээ илэрхийлэхийг сонсоно. Дүрмийн үеийг доорх тохиолдолд авна.

- **Илтгэлийн цаг хэтэрсэн үед** : илтгэгч бүрт ярианы хугацаа дууссаныг мэдэгдэх ба илтгэгч илтгэлээ хаахын тулд нэмж 30 секунд ярихыг зөвшөөрдөг. Сүүлийн 30 секунд өнгөрсөн ч илтгэлийг зогсоогоогүй тохиолдолд эсрэг тал дүрмийн үеийг авна.
- **Тодруулгын үе сунжрах**: Мэтгэлцээний явцад тодруулгын үе авагдсан тохиолдолд тодруулга хийж буй баг асуултаа хэт сунжруулж харилцан яриа хэлбэрт оруулах буюу 15 секундээс хэтэрсэн тохиолдолд тухайн илтгэлийн үед зөвхөн 1 удаа дүрмийн үе авч болно.
- Баримтлалын илтгэлийн эхний болон сүүлийн 1 минутанд тодруулгын үе хэрэглэсэн тохиолдолд дүрмийн үе хэрэглэнэ.
- Дүгнэлтийн илтгэлийн үед тодруулгын үе хэрэглэсэн

Шүүгчийн шүүх зарчим

Мэтгэлцээний шийдвэрийг шүүгчид болон хурлын дарга гаргана. Энэ нь ерөнхий, тодорхой бус ойлголт хэдий ч дараах хэдэн зарчмыг шүүгчид анхааран үздэг. Үүнд:

- Нотолгоо, дүгнэлт
- Агуулга
- Няцаалт
- Зохион байгуулалт
- Хэлбэр, илтгэх чадвар
- Тодруулгын үе
- Дүрмийн үе
- Хамтын ажиллагаа

4.ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний хэлбэр: Харьцуулсан эрх зүй судлал хичээлийн явцад олж авсан мэдлэг, түүнийг практикт ашиглах чадвар хийгээд оюуны үнэт зүйлийн баримжаалалтад гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэхэд уг хичээлийн үнэлгээний гол зорилго оршино. Үнэлгээ нь бүхэлдээ зорилгодоо хүрч чадсан эсэхийг илрүүлэхэд чиглэгдэнэ.

Багш үнэлгээний дүнг дараах зорилгоор ашиглана:

- давтан судлах шаардлагатай эсэхийг тогтоох
- сурч боловсрох эрмэлзлэлийг идэвхжүүлэх

- сургалтын үр дүнд хүрэн явцад оюутны мэдлэг, чадвар ямар түвшинд байгааг тодорхойлох
- багш өөрийгөө болон хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх.

Үнэлгээний шалгуур:

Үнэлэх зүйл	Үнэлэх жишиг шалгуур
Мэдлэг	<ul style="list-style-type: none"> ■ асуудалд эрх зүйн онол болон харьцуулсан эрх зүйн үндэслэлийг ашиглан хариулж чадаж байгаа эсэх ■ харьцуулсан эрх зүйн мэдлэгээ бусдад танилцуулж, тайлбарлаж чадаж байгаа эсэх ■ тухайн судлагдахууны тодорхойлолт гаргах, үндсэн ба үндсэн бусыг ялгаж, харьцуулалт хийх, хамаарлыг тогтоох арга зүйг эзэмшсэн эсэх. ■ хариулт болон үзэл бодлынхоо онолын болон практик үндэслэл нотолгоог харьцуулсан эрх зүйн үүднээс гаргаж байгаа байдал
Чадвар	<ul style="list-style-type: none"> ■ харьцуулсан эрх зүйн мэдлэгийг ашиглан /үндэслэл, нотолгоо болгох, жишээ баримт татах, тайлбарлах/ тухайн асуудлыг тайлбарлаж, шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх ■ тохиолдол шинжлэх, шийдвэрлэхдээ харьцуулсан эрх зүйн мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх ■ харьцуулалт хийх чадварт суралцсан байдал ■ амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадварын хөгжлийн түвшин
Хандлага	<ul style="list-style-type: none"> ■ өөрийн үзэл бодол байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх, ийнхүү илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж, түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх ■ багийн гишүүн байх, бусдыг төлөөлөх чадварын хөгжилт ■ ялгаатай үзэл бодол байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа байдал

Дээрхээс гадна оюутны мэдлэг, чадварын түвшнийг дараах байдлаар ангилан, үнэлгээг ялгавартай тогтоож байх нь зүйтэй. Үүнийг хамгийн энгийн буюу доод түвшнээс хамгийн төвөгтэй буюу дээд түвшинд хүрэх дарааллаар тодорхойлж болно.

Мэдлэг. Хамгийн доод түвшин. Голчлон тодорхой баримт, мэдээллийг тогтоож авах, сэргээн санах чадварыг авч үзнэ.

Ойлгоц. Бусдын олж тогтоосон зүйлсийг оюутан наад захын түвшинд ойлгосон болохыг харуулж буй тайлбарлах, өөрийн үгээр илэрхийлэх, ургуулан бодож дүгнэлт хийх зэрэг чадвар юм.

Хэрэглээ. Оюутан мэдэж авсан ойлголт, зүй тогтол зэргийг урьд тохиолдож байгаагүй шинэ нөхцөл байдал, мөн практикийн тодорхой тохиолдолд хэрэглэх чадвар.

Анализ. Мэдээллийг бүрэлдэхүүн хэсгүүдэд нь задлан хувааж, ялгаж зааглахыг хэлнэ.

Синтез. Эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн бүхэл ойлголт бий болгохыг хэлнэ. Оюутан урьд нь байгаагүй бүтцийн шинэ хувилбарыг бүтээх чадвартай байх ёстой.



Үнэлэлт. Хамгийн дээд түвшин. Бусдын бүтээсэн зүйл, түүний логик бүтэц, үндэслэл нотолгоо нь бүрэн гүйцэд хийгдсэн эсэхэд үнэлгээ өгөх зэргийг ойлгоно.

Дээрх чадварын түвшинг дотор нь дараах байдлаар ангилж болно. Үүнд:

Сургалтын зорилго	Оюутны чадвар
Заавал эзэмшсэн байвал зохих /essential/	Мэдлэг, ойлгоц, хэрэглээ
Эзэмшсэн байвал сайшаалтай /desirable/	Анализ, синтез, үнэлгээ

5. СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Ном, сурах бичиг

Монгол хэл дээр:

1. Амарсанаа Ж. Хүний эрх, Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ. 2000 он
2. Амарсанаа Ж. Баясгалан Г нар Хууль зүйн тайлбар толь. УБ. 2003 он
3. Амарсанаа Б. Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он
4. Амгалан Ч. Болортунгалаг Н. Энхтуяа Б. Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил: Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл УБ.2004
5. АНУ-ын эрх зүйн товчоон УБ. 2006 он
6. Гүнбилэг Б., Төмөр А. Жишгийн эрх зүй УБ 2006 он
7. Гүнбилэг Б. Жишгийн эрх зүй УБ.2008 он
8. Минжүүрдорж Б. Даяаршиж буй дэлхий: харьцуулсан эрх зүй судлал УБ 2010 он
9. Нарангэрэл С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо УБ.2001 он
10. Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг УБ. 2007 он
11. Совд Г.Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй / УБ.1999 он
12. Сүхбаатар Ж. Харьцуулсан эрх зүй судлал /схем,тайлбар / УБ.2000 он
13. Отгончимэг Ч. Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он
14. Осакве К. Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги УБ. 2005 он
15. Х.Тэмүүжин Ёст үг-1 УБ. 2002 он
16. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиумын илтгэлүүдийн эмхтгэл УБ. 2000 он
17. Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2004 он
18. Нийтийн ба хувийн эрх зүй: Харьцуулсан судлал. /эрдэм шинжилгээний семинар. Илтгэлийн эмхтгэл./ УБ. 2006 он
19. Харьцуулсан эрх зүйн онол практикийн орчин үеийн асуудал /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2007 он

20. Монгол-Буриадын заншил, заншлын эрх зүй УБ. 2008 он /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/
21. АНУ-ын Үндсэн хууль
22. ХБНГУ-ын Үндсэн хууль
23. Францын Үндсэн хууль
24. ОХУ-ын Үндсэн хууль
25. БНХАУ-ын Үндсэн хууль
26. Японы Үндсэн хууль

Гадаад хэл дээр:

1. Amin S.H. Middle East Legal Systems. Glasgow. 1985
2. Alan Brudner, The Unity of Common Law: Studies in Hegelian Jurisprudence (Berkeley: University of California Press, 1995)
3. Bogdan M. Comparative Law. Kluwer Law and Taxation, 1994
4. De CRUZ, P. A modern approach to comparative law. Kluwer, 1993.
5. De CRUZ, P. Comparative law in a changing world, 2nd ed. Cavendish, 1999.
6. Conrad Zweigert and Hein Kotz, Introduction to Comparative Law (Oxford: Clarendon Press, 1998)
7. Eric A Feldman, The Ritual of Rights in Japan Law, Society, and Health Policy (Cambridge England, New York: Cambridge University Press, 2000)
8. GLENN, H P. Legal traditions of the world, 2nd ed. Oxford University Press, 2004 (1st edition gained the Canada Prize, International Academy of Comparative Law, 1998)
9. Harry W. Jones, ed., Legal Institutions Today: English and American Approaches Compared (Chicago, ABA, 1976)
10. Harding, A. (editors) Comparative law in the 21st Century. Kluwer Law International, 2002.
11. James Ph.S. Introduction to English Law. 12 ed.L., 1989
12. James A Coriden, An Introduction to Canon Law (New York: Paulist Press, 1991)
13. Kenneth Robert Redden, Modern Legal Systems Cyclopedia (Buffalo, Hein, 1984 -)
14. Koichiro Fujikura, Japanese Law and Legal Theory (New York, NY: New York University Press, 1996)
15. Kenneth L Port, Comparative Law Law and the Legal Process in Japan (Durham, N.C: Carolina Academic Press, 1996)
16. Lawrence M. Freidman. American Law. N.Y5 L., 1984
17. Legrand, P. and MUNDAY, R. (editors) Comparative legal studies: traditions and transitions. Cambridge University Press, 2003.
18. Legal Systems of the World: A Political, Social, and Cultural Encyclopedia (Santa Barbara, Calif.: ABC-CLIO, 2002)
19. Meryll Dean, Japanese Legal System Text and Materials (London: Cavendish, 1997)



20. Michael Arnhem, Common Law (New York: New York University Press, 1994)
21. Noel J Coulson, A History of Islamic Law (Edinburgh: Edinburgh University Press, 1964) Andrew Huxley, Religion, Law and Tradition Comparative Studies in Religious Law (London, New York: Routledge Curzon, 2002)
22. Poh-Ling Tan, Asian Legal Systems Law, Society and Pluralism in East Asia (Sydney: Butterworths, 1997)
23. Ramakrishnan, V. Guide to Indian Laws
24. Rene David and John E.C. Brierly, Major Legal Systems in the World Today: An Introduction to the Comparative Study of Law (London: Stevens, 1985)
25. Roscoe Pound, ed., Readings on the History and System of the Common Law (Rochester: Lawyers Co-Op, 1927).
26. Szladits' Bibliography on Foreign and Comparative Law, Daniel L. Wade, S. Blair Kauffman, and Tracy L. Thompson, eds. (New York: Oceana, 2001)
27. Sir Frederick Pollock, The Genius of the Common Law (New Jersey: Lawbook Exchange, 2000)
28. Ved P Nanda and S. Prakash Sinha, Hindu Law and Legal Theory (New York: New York University Press, 1996).
29. Давид Р. Спиноза К.Ж. Основные правовые системы современности М.1998г
30. Марченко М.Н.Правовые системы современного мира М. 2001г
31. Осаке К. Сравнительное правоведение М. 2009 г
32. Чернюков А.Э Введение в сравнительном правоведение М.1999г
33. Сайдов А.Х Сравнительное правоведение М. 2000г
34. Тихомиров Ю.А.Курс сравнительного правоведения М.1996 г

Эрдэм шинжилгээний илтгэл, нийтлэл:

1. Амарсанаа Ж. Харьцуулсан эрх зүйн онолын асуудал.“Эрх зүй” сэтгүүл 2000. 1
2. Амарсанаа Ж. Олон улсын болон үндэсний эрх зүйг уялдуулах арга зам. “Эрх зүй” сэтгүүл 2000.2-3
3. Баярсайхан Д. Үндэсний Үндсэн хуулийн эрх зүй ба Олон улсын нийтийн эрх зүйн хоорондын уялдаа, харьцааны тухайд.“Эрх зүй” сэтгүүл 2000.2-3
4. Тэмүүжин Х. Харьцуулсан эрх зүй судлал ба хууль зүйн соёл.“Эрх зүй” сэтгүүл 2001. 6-7
5. Отгончимэг Н. Харьцуулсан эрх зүй судлалын үүсэл, хөгжлийн тойм.“Эрх зүй” сэтгүүл 2001.6-7
6. Дин Вань Ин. Хятад Монгол хоёр улсын бусдын газар нутаг дээр барилга байгууламж барих эрхийн харьцуулсан судлал. “Эрх зүй” сэтгүүл 2004.13-14
7. Пьер Райвал Дувал. Английн болон Францын эрх зүйн нийтлэг зарчим.“Эрх зүй” сэтгүүл 2007.15
8. Хайтан О. БНХАУ-ын хөдөө тосгоноо тариачдын газар даачлал, Монгол улсын газар эзэмших асуудлыг харьцуулах нь.“Эрх зүй” сэтгүүл 2007.15

9. Лүндэндорж Н. Үндэсний эрх зүйн хөгжилд харьцуулсан эрх зүйн үүрэг. “Эрх зүй” сэтгүүл 2007.16-17
10. Өнөрбаяр Ч, Батсуурь М. Харьцуулсан эрх зүй дэх шинэ хандлага Монгол Улс дахь эрх зүйт ёсны төлөвшил. “Эрх зүй” сэтгүүл 2007.16-17
11. Үнэнтөгс Ш. ОУ-ын харилцаа Ази, номхон далайн орнуудын хэтийн төлөв, МУ-ын эзлэх байр суурь. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2003 он №1(01)
12. Гүнбилэг Б. Харьцуулсан эрх зүйн хөгжлийн чиг хандлага ба конвергенци. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2003 он №2(02)
13. Төмөр А. Олон улсын нийтийн эрх зүй, олон улсын хувийн эрх зүйн харилцан хамаарал. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2003 он №3(03)
14. Гүнбилэг Б. Жишиг эрх зүйн тухай ойлголт, үйлчлэх журам, хууль зүйн хүчин чадал. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2004 он №3(06)
15. Отгончимэг Н. ХЗШУ-нд харьцуулсан эрх зүйн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2004 он №4(07)
16. Баяр П. Монгол ба Болгар улсын эрх зүйн тогтолцоо. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2005 он №2(09)
17. Заяа Т. Серик А. Дорно ба өрнийн эрх зүйн томъёоллын түүхэн хандлага, ялгаа. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2005 он №4(11)
18. Гүнбилэг Б. Дэлхийн эрх зүйн тогтолцоог харьцуулсан эрх зүйн үүднээс ангилах нь. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2006 он №1(12)
19. Мөнхбат М. Олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүйн харилцан хамаарал. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2006 он №2(13)
20. Амарсанаа Ж. МУ дахь харьцуулсан эрх зүйн судалгаа. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2006 он №3(14)
21. Гүнбилэг Б. ИБУИНВУ ба МУ-ын жишгийн эрх зүй харьцуулалт. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2007 он №3(18)
22. Чимид Б. Харьцуулах, эс харьцуулах эрх зүй “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2007 он №4(19)
23. Ариунаа М. Шүүхийн прецедент эрх зүйн эх сурвалж болох нь “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2007 он № 2(17)
24. Жаргалсайхан Т. Гэмт хэгийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэлтийн талаар зарим улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2008 он №2(21)
25. Байгал Э. МУ ба ХБНГУ дахь хөршийн нөлөөллийн эсрэг ИЭЗ-н хамгаалалтын харьцуулсан судалгаа “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2008 он №2(21)
26. Энхцэцэг Н. Цэвэр абстракт хяналт ба МУ-ын үндсэн хуулийн хяналтын систем: харьцуулсан судалгаа “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2010 он №1(28)
27. Соёлмаа Ж. Гадаад орнууд дахь дотоод худалдааны эрх зүйн зохицуулалтын төлөв байдал “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2010 он №3(30)
28. Амарсанаа Ж, Мухийт Р, Мөнхбат М. Ази, номхон далайн бүсийн улсуудын эрх хөгжлийн чиг хандлага “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2011.4



29. Соёлмаа Ж, Оюунболд Г. Байгаль орчны эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт ба гадаад орны туршлагаас. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл 2011.4
30. Ганзориг Г. Гадаад улс орнуудын шүүхийн тогтолцоо, шүүгчийн хараат бус байдлын талаархи зарим асуудал “Монголын төр эрх зүй” сэтгүүл 1996.2
31. Амарсанаа Ж. Харьцуулсан эрх зүйн судалгааны арга зүй. “Монголын төр эрх зүй” сэтгүүл 2001.2
32. Зууннасан Э. Монгол Улс БНХАУ-ын эрүүгийн шүүн таслах ажиллагаан дахь өмгөөлөгчийн эрх зүйн байдлын харьцуулалт. “Монголын төр эрх зүй” сэтгүүл 2010.1
33. Сарантуяа Ц. Үндсэн хуулийн шүүх ба хууль тогтоох эрх мэдэл ХБНГУ болон АНУ-ын жишээ харьцуулалт. “Монголын төр эрх зүй” сэтгүүл 2011.3

Интернетийн хаяг:

1. www.Comparativelaw.com
2. www.comparativelaw.org
3. www.rechtwissenschaft.de
4. <http://legislationline.org/>
5. www.asil.org/resource/pil1.htm
6. www.lib.uchicago.edu/~llou/global.html
7. www.europa.eu.int/eurodicautom/Controlle r
8. www.lexml.de/rdf.htm
9. www.llrx.com
10. www2.lib.uchicago.edu
11. www.nyulawglobal.org/globalex/
12. www.llrx.com/comparative_and_foreign_law.html
13. <http://lcweb2.loc.gov/frd/cs/cshome.html>
14. www.unilex.info/dynasite.cfm?dssid=2375&dsmid=14276
15. www.ejcl.org/
16. www.comparativelawreview.com/
17. <http://www.eupublishing.com/journal/ajicl>
18. <http://www.lexadin.nl/wlg/>

А. ЛЕКЦИЙН ХИЧЭЭЛ

НЭГДҮГЭЭР СЭДЭВ: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ

Нэр томъёоны тайлбар:

- **Судлах зүйл**-танин мэдэхүйн эрэл хайгуулд өртөж буй судалгааны объектын онцлог шинж
- **Судалгааны арга**-судалгааны объект болон судлах зүйлийг хамгийн боломжит хугацаанд, оновчтой танин мэдэж, үр дүнг нээн илрүүлэхэд нөлөөлдөг арга хэрэгслийн цогц
- **Харьцуулсан эрх зүйн**-нэг төрлийн төрийн ба эрх зүйн институт, эрх зүйн тогтолцоо, тэдгээрийн үндсэн зарчим зэргийг харьцуулах замаар янз бүрийн улсуудын эрх зүйн тогтолцоог судалдаг эрх зүйн шинжлэх ухааны салбар
- **Үндэсний эрх зүйн тогтолцоо**-тодорхой улсын эрх зүй, хууль зүйн практик болон эрх зүйн тэргүүлэх үзэл суртлын цогц
- **Харьцуулалт**-судалгааны объектуудын нийтлэг хийгээд онцлог талуудыг нээн илрүүлэх үүднээс хууль зүйн үзэгдэлд харьцуулах хэсэг бүлэг аргыг хэрэглэж бүх талын цогц анализ хийх идэвхтэй ажиллагаа

Харьцуулсан эрх зүйн ойлголт

Орчин үеийн улсуудын хөгжлийн нийтлэг хэв шинжийг тунгаавал соёл иргэншил, нийгэм, улс төр, эдийн засаг, хууль, эрх зүйн бодлого зэргээрээ ойртон нягтрах, бие биенээсээ хамаарах үйл явц улам бүр эрчимжиж, дэлхийн нийтийн шинжтэй үзэгдэл болох даяаршлаар тодорхойлогдож байна. Үүний зэрэгцээ улс үндэстэн бүр өөрийн амьдрах арга ухаан, уламжлалт соёл иргэншил, өвөрмөц онцлогоо унаган төрхөөр нь хадгалан үлдэхийн тулд дангаарших хэрэгцээ шаардлага ч зүй ёсоор тулгарч байна

Даяаршил, дангааршлын зохист хослолыг бүрдүүлэх, үндэсний эрх зүйн тогтолцоог улам бүр төгөлдөржүүлэх, хөгжлийг түргэтгэхэд харьцуулсан эрх зүйн үр нөлөө, ач холбогдол оршино.

Харьцуулсан эрх зүй судлаачдын дунд:

- нэр томъёо, нэршил
- судалгааны объект, судлах зүйл
- шинжлэх ухаанд эзлэх байр суурийн талаар маргаан өрнөсөөр өнөөг хүрчээ.




Нэр томъёоны хувьд хараахан нэгдмэл ойлголтод хүрээгүй байна



Дээрх томъёоллуудаас хамгийн ерөнхий, багтаамж өргөн ойлголт нь **“харьцуулсан эрх зүй”** (comparative law, сравнительное право) бөгөөд түүний агуулгыг өргөн (*шинжлэх ухаан*) хийгээд явцуу (*судалгааны арга*) утгаар ойлгож болох юм.

Харьцуулсан эрх зүйг шинжлэх ухаан эсвэл судалгааны арга хэмээн ялгаатай байдлаар тодорхойлсон ч энэ нь агуулга /ойлголт/-ын зөрчилдөөнд төдийлөн хүргэдэггүй.

Шинжлэх ухаанд эзлэх байр суурийн талаар:



Орчин үед харьцуулсан эрх зүйг өөрийн судлах зүйл, судалгааны арга, зорилго, чиг үүрэгтэй **эрх зүйн шинжлэх ухааны нэг салбар** (*салбар эрх зүй бус*) мөн гэдэгтэй судлаачид санал нэгдэх хандлагатай байна.

Судалгааны объект, судлах зүйлийн хувьд:

Харьцуулсан эрх зүйн судалгааны объект, судлах зүйл, хамаарах асуудлыг яв цав, хөдөлбөргүй тодорхойлоход бэрхшээлтэй бөгөөд судлаачид харилцан адилгүй байдлаар тодорхойлж иржээ.

Харьцуулсан эрх зүйн судлах зүйлийг дараах хоёр хандлагаар тодорхойлж болно. Үүнд:

- Харьцуулсан эрх зүй судлалын хөгжлийн дэлхийн нийтийн хандлага, тэргүүлэх эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалыг баримжаалан **НИЙТЛЭГ** байдлаар тодорхойлох
- Үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, тулгамдаж буй асуудал, өөрийн орны харьцуулсан эрх зүй хөгжлийн түвшин зэргийг харгалзан **ҮНДЭСНИЙ БАРИМЖААТАЙ** тодорхойлж болох юм.

Гадаадын харьцуулсан эрх зүй судлаачдын төлөөлөл:

Доктор Ю.А.Тихомиров:

- Эрх зүйн бодит байдал ба улс төрийн бодлого, улс төрийн дэглэм
- Эрх зүйн тодорхой үзэгдлийг эрх зүйн аймагт хамааруулж тайлбарлах
- Эрх зүйн сургаал, чиг баримжаа
- Үндэсний эрх зүйн тогтолцоо
- Олон улсын байгууллагуудын эрх зүйн орчин
- Үндэсний хууль тогтоомж
- Эрх зүйн салбар, дэд салбар, институт
- Эрх зүйн хэм хэмжээний бүтэц
- Хууль зүйн арга ажиллагаа

Харьцуулсан эрх зүй судлаач А.Х.Саидов:

- Харьцуулсан эрх зүйн арга зүйн асуудлууд
- Орчин үеийн эрх зүйн тогтолцоо
- Харьцуулсан эрх зүйн судалгааны арга зүйн тодорхой журмууд
- Харьцуулсан эрх зүйн маргаантай асуудлууд
- Орчин үеийн олон улсын эрх зүйн маргаантай асуудал

Германы эрх зүйч К.Цвайгерт, Х.Кётц нар:

Харьцуулсан эрх зүйн судлах зүйлийг ерөнхий байдлаар “янз бүрийн орны эрх зүйн тогтолцоо” гэж үзсэн бөгөөд энэ харьцуулалт нь өргөн болон явцуу хүрээнд хийгдэж болно

Дотоодын харьцуулсан эрх зүй судлаачдын төлөөлөл:

Доктор, профессор Б.Чимид:

- Харьцуулсан эрх зүйн онол, арга зүйн үндсэн асуудал
- Эрх зүйн бүлүүдийн нийтлэг хийгээд онцлог
- Улсуудын болон үндэсний эрх зүйн тогтолцооны нийтлэг хийгээд онцлог
- Олон улсын ба үндэсний эрх зүйн нийтлэг, онцлог
- Дотоодын эрх зүйн салбар, институтын нийтлэг, онцлог
- Үндэсний хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн үе шатуудын нийтлэг, онцлог гэх мэт

Академич С.Нарангэрэл:

- Харьцуулсан эрх зүй судлал нь янз бүрийн эрх зүйн тогтолцоог судалдаг бөгөөд бүтцийн хувьд:
- арга зүйн хэсэг
- онолын хэсэг
- практикийн хэсэгт хуваагдана.



Академич Ж.Амарсанаа:

- Үндэсний эрх зүйн тогтолцоо бүхэлдээ, түүнчлэн түүний тусгайлсан элемент, салбар эрх зүй, хууль тогтоомж
- Эрх зүйн сургаал, үзэл баримтлал, эрх зүйн үзэл
- Улсуудын эрх зүйн тогтолцоо, түүний цогц илэрхийлэл болох олон улсын эрх зүй нь харьцуулсан эрх зүй судлалын объект болно.

Судлаач Н.Отгончимэг:

- Харьцуулсан эрх зүйн судалгааны арга зүйн асуудал
- Харьцуулсан эрх зүйн нийгэмд гүйцэтгэх чиг үүрэг
- Харьцуулсан эрх зүйг уялдуулан хэрэглэснээр илүү үр дүнд хүрэх хууль зүйн бусад салбар шинжлэх ухааны уялдаа
- Дэлхийн эрх зүйн голлох тогтолцоонуудын үүсэл хөгжил, орчин үеийн чиг хандлага
- Тодорхой бүс нутгийн эрх зүй
- Үндэсний эрх зүйг төрөлжүүлэхэд харьцуулсан эрх зүйн судалгааны үр дүнг хэрэгжүүлэх практик асуудал
- Гадаад улсын эрх зүйн тогтолцооны ололт амжилтыг үндэсний эрх зүйд зохистойгоор нийцүүлэн шилжүүлэх асуудал

Дээрх судлаачид харьцуулсан эрх зүйн судлах зүйлийг тодорхойлохдоо харьцангуй уян хатан хандах зарчмыг баримтлах нь зүйтэй гэдэг дээр санал нэгдэж байна. Энэ бүгдээс ерөнхийлөн дүгнэвэл:

Харьцуулсан эрх зүйн судалгааны объект нь улсуудын эрх зүйн тогтолцоо байна. Харьцуулсан эрх зүйн судлах зүйлийг тоймловол:


- Харьцуулсан эрх зүйн онол, арга зүйн үндсэн асуудал
- Харьцуулсан эрх зүйн үүсэл, хөгжил
- Харьцуулсан эрх зүйн зорилго, чиг үүрэг
- Эрх зүйн аймаг, түүний ангилал, тэдгээрийн үндсэн шинж, хөгжлийн хандлага
- Олон улсын ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал зэрэг асуудлууд хамаарна.

Харьцуулсан эрх зүй судлаачдын дунд энэ мэт маргаан өрнөдөг хэдий ч эдгээр нь харьцуулсан эрх зүйн үндсэн агуулга, үүрэг, ач холбогдлыг өчүүхэн ч бууруулдаггүй. Энэ тухайд Францын харьцуулсан эрх зүй судлаач Р.Давид *“харьцуулсан эрх зүй хөл дээрээ бат зогсож байгаа өнөө үед түүний судлах зүйл, шинжлэх ухаан хийгээд сургалтын хөтөлбөр дэх байр суурийн талаарх маргаан үндсэндээ ач холбогдлоо алджээ”* хэмээн бичсэн байна.

Харьцуулсан эрх зүйн судалгааны арга

Судалгааны арга гэдэг нь танин мэдэхүйн үйл ажиллагаанд мөрдлөг болговол зохих журам, хэрэгслийн цогц мөн.

Харьцуулалт бол шинжлэх ухааны танин мэдэхүйн нэг арга юм. Харьцуулсан эрх зүй нь харьцуулалтын аргад тулгуурлах боловч шинжлэх ухаан, танин мэдэхүйн олон аргуудыг ашиглана. Тэдгээрээс дурдвал:



Аливаа судалгаа, шинжилгээнд танин мэдэхүйн аль нэг арга дангаараа хэрэглэгдэх нь харьцангуй бага бөгөөд өөр бусад аргуудтай хослон хэрэглэгддэг зүй тогтолтой.

Харьцуулсан судалгааг үр дүнтэй, бодитой, шинжлэх ухаанч болгохын тулд харьцуулалтын аргыг дээр дурдсан бусад аргатай зохистой хослуулах явдал чухал.

Эрх зүйн шинжлэх ухаан болон харьцуулсан эрх зүйн харилцан хамаарал





Эрх зүйн боловсрол ба харьцуулсан эрх зүй

Эрх зүйн боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт харьцуулсан эрх зүй чухал байр суурийг эзлэж байна.

Орчин үеийн даяаршиж буй нийгэмд ажиллах хуульчдад харьцуулсан эрх зүй хөгжлийн хөтөч нь болох учиртай.

Харьцуулсан эрх зүй хичээлийн хөтөлбөрийн агуулга, бүтцийн хувьд гадаад, дотоодын их, дээд сургуулиуд, судлаачдын байр суурь харилцан адилгүй боловч дараах асуудалд санал нэгдсэн байна. Үүнд:

- ♦ Харьцуулсан эрх зүйн мөн чанар, чиг үүрэг, ач холбогдол
- ♦ Эрх зүйн тогтолцооны ангиллын асуудал
- ♦ Орчин үеийн эрх зүйн тогтолцооны онцлог шинжийг задлан судлах (*Англи, Америк болон Германы харьцуулсан эрх зүйн хичээлийн хөтөлбөрийн ерөнхий ангийн хүрээнд давхацдаг*)
- ♦ Хичээлийн хөтөлбөрийн бүтцийн хувьд ерөнхий болон тусгай анги гэсэн бүтэцтэй байх талаар санал нэгддэг.

Манай улсын хувьд 1997 онд Хууль зүйн сайд болон Гэгээрлийн сайдын тушаалаар харьцуулсан эрх зүйн хичээлийг эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудад заавал судлах хичээлийн жагсаалтад оруулжээ.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн боловсролын бакалаврын стандарт (2007 онд батлагдсан)-д зааснаар харьцуулсан эрх зүй хичээл нь заавал судлах мэргэжлийн суурь хичээл байхаар тусгагдсан байна.

ШИГТГЭЭ

Харьцуулсан эрх зүй хичээлийн зорилго нь харьцуулсан эрх зүйн мэдлэг эзэмших, эрх зүйн харьцуулалт хийх чадварыг хөгжүүлэх, эрх зүйн үзэгдэл, харилцаанд орчин үеийн эрх зүйн соёл, хөгжлийн үүднээс хандах хандлага төлөвшүүлэхэд оршино.

Эрх зүйн боловсролын бакалаврын стандарт

Хяналтын асуулт:

1. Харьцуулсан эрх зүй хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлбол зохих вэ?
2. Харьцуулсан эрх зүйн судлах зүйлийн агуулгыг тодорхойлно уу.
3. Харьцуулсан эрх зүй, харьцуулсан эрх зүй судлал, эрх зүйн харьцуулсан судлал, эрх зүйн харьцуулалт гэсэн нэр томъёоны агуулгын гаргалгаа хийнэ үү.
4. Эрх зүйн үзэгдэлд харьцуулалт хийхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлийг нэрлэнэ үү.

5. Харьцуулсан эрх зүй нь шинжлэх ухаан, хичээл, судалгааны арга зүй болох үндэслэлийг тайлбарлана уу.
6. Эрх зүйн үзэгдэлд харьцуулалт хийх ямар аргачлал байдаг вэ?
7. Эрх зүйн үзэгдлийн харьцуулалтын төрлийг нэрлэнэ үү.

Эх сурвалж:

1. Амарсанаа Б., Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он. 8-20 дахь тал
2. Минжүүрдорж Б., Даяаршиж буй дэлхий: харьцуулсан эрх зүй судлал, УБ 2010 он. 5-19 дэх тал
3. Монголын төр, эрх зүй сэтгүүл. УБ. 2001/2. 19-23 дахь тал
4. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, УБ.2001 он. 218-226 дахь тал
5. Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг УБ. 2008 он. 488, 609, 615 дахь тал
6. Сүхбаатар Ж., Харьцуулсан эрх зүй судлал (схем, тайлбар) УБ.2000 он
7. Отгончимэг Н., Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он. 7-22, 34-41 дэх тал
8. Осакве К., Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги УБ. 2005 он. 12-17, 19-22, 47 дахь тал
9. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиумын илтгэлүүдийн эмхтгэл УБ. 2000 он. 55-60 дахь тал
10. Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил (олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл), УБ. 2004 он. 102-111 дэх тал
11. Харьцуулсан эрх зүйн онол практикийн орчин үеийн асуудал (олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл), УБ. 2007 он. 10-20, 28-42, 62-74, 136-138 дахь тал
12. Саидов А.Х., Сравнительное правоведение М. 2007 г. с 23-52
13. www.Comparativelaw.com
14. www.comparativelaw.org
15. www.ejcl.org/
16. <http://www.lexadin.nl/wlg/>

ХОЁРДУГААР СЭДЭВ: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ

Харьцуулсан эрх зүйн үүсэл

Харьцуулсан эрх зүй нь бие даасан мэдлэгийн салбар болохын хувьд XIX зууны эцэс XX зууны эхэн үеэс үүсч бүрэлдсэн харьцангуй шинэхэн судлагдахуун боловч эрх зүйн харьцуулалтын анхдагч үзэл санаа эрх зүйн ойлголтын нэг адил эртний үеэс эхлэлтэй.



Эртний иргэншил дэх харьцуулсан эрх зүйн үүсэл

Харьцуулсан эрх зүй мэдлэгийн бие даасан салбар болж хөгжөөгүй, харин тухайн үеийн сэтгэгчид онолын үр дүнгээ бататгах, хууль тогтоомжийг боловсруулахдаа харьцуулалтын аргыг ашиглаж байжээ. Тухайлбал; Грек, Ромын сэтгэгчид улс, үндэстэн, хот улсуудын эрх зүй, төрийн байгууллыг харьцуулан судалж, зохиол бүтээлүүдээ туурвиж байжээ.

Эртний Грекийн сэтгэгч Платон “Хууль” бүтээлдээ Грекийн янз бүрийн хотуудын хуулиудад дүн шинжилгээ хийснээр төгс төрийн байгууламжийг боловсруулсан бол Аристотелийн “Улс төр” зохиол нь Грекийн ба варваруудын 153 хотын үндсэн хуулиудын харьцуулсан судалгаанд үндэслэсэн гэдэг.

Солон Афины хуулиудыг, Ромчууд 12 хүснэгтийн хуулийг боловсруулахдаа гадны хуулиудыг харьцуулан судлаж байсан баримт бий. Тухайлбал, грекийн процессын эрх зүйн зарчмуудад 1-р хүснэгтэд “Хэрэв хэн нэгнийг шүүхэд дуудвал заавал ир. Хэрэв ирээгүй бол дуудсанаа гэрчтэйгээр нотолж, дараа нь түүнийг хүчээр авч ир. Дуудагдсан этгээд зугтахыг оролдвол барьж ир”... гэсэн процессын журам нь грекийн эрх зүйд мөрдөгдөж байв.

Эрх зүйн хөгжлийн түүхэнд балрашгүй ул мөрөө үлдээсэн Ромын эрх зүй бол харьцуулсан эрх зүйн үр дүн мөн.

Харьцуулсан эрх зүйн үзэл сэтгэлгээ эртний эх газарт төдийгүй Азийн улсуудад мөн байсан байна. НТӨ IV зууны үеийн эртний Хятадын эх сурвалж болох “Шан хязгаарын захирагчийн бичигт” харьцуулсан эрх зүйн үзэл тусгагдсан гэж үздэг.

Дундад зуун болон сэргэн мандалтын үеийн харьцуулсан эрх зүйн сэтгэлгээ

Дундад зуун бол харьцуулсан эрх зүйн судлалын үндэс суурь тавигдаж, шинжлэх ухааны түвшинд хүрэх нөхцөлийг бүрэлдүүлж өгсөн үе.

Ромын эзэнт гүрэн нуран унаж, эртний соёл иргэншил төгсгөл болсон ч баруун Европын улс орнуудад Ромын эрх зүйг сэргээн судлаж, дахин боловсруулан хэрэглэж байсан нь харьцуулсан эрх зүйн сэтгэлгээний нэг илрэл юм. Нэг үгээр хэлэхэд баруун Европын улсуудад Ромын эрх зүйг шилжүүлэн хэрэглэх явдал түгээмэл байжээ. Учир нь, Ромын эзэнт улсын үеийн иргэний эрх зүйн хөгжил нь өндөр түвшинд хүрсэн байсан нь түүнийг Европын орнууд олзуурхан авч ашиглах нөхцөл болсон гэж үздэг.

XVI-XVII зууны үед Англид Canon law (шашны эрх зүй)-г Common law-тай харьцуулан үзэж, давуу талыг жишиж, Англи болон Францын эрх зүйг харьцуулан судалж байв.

Францын иргэний хуулийн нөлөөлөл тухайн үед маш тод илэрч байв. Энэ нь тухайн үеийн зарим улсад уг хууль шууд хэрэгжиж (Бельги, Германы зарим хэсэг, Швейцарийн хэд хэдэн муж), зарим улс (Испанийн колончлолоос чөлөөлөгдсөн латин-америкийн улсууд) өөрсдийн хуулиа боловсруулахдаа Наполеоны иргэний хуулийг загвар, жишиг болгон ашиглаж байсантай шууд холбоотой.

Ш.Монтескье “Хуулийн амин сүнс”, Фортескью “Английн хуулийг магтан дуулах нь”, “Англи дахь удирдлага”, Лейбниц “Эрх зүйг хэрэглэх хүрээ” зэрэг харьцуулсан эрх зүйн судалгааны бүтээлүүдээ туурвисан нь харьцуулсан эрх зүйн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн байна. Фортескью өөрийн бүтээлдээ Английн ба Францын хууль тогтоомжийг харьцуулан судалж, английн эрх зүйн тогтолцооны давуу талыг тодорхойлохыг эрмэлзэж байсан бол Лейбниц харьцуулсан эрх зүйн ач холбогдлыг уриалж байв.

Түүхийн энэ үед европын улс орнуудад Ромын эрх зүй, шашны эрх зүй мөн тухайн нутгийн заншлын хэм хэмжээ зэрэгцэн үйлчилж байжээ.

Харьцуулсан эрх зүй судлалын нийгэмлэг, холбоод байгуулагдсан үе

Өмнөх үеүдэд харьцуулсан эрх зүйн хэрэглээ ихэвчлэн Европыг хамрах хандлагатай байсан бол энэ үеэс өргөжин тэлэхийн сацуу харьцуулсан эрх зүйн зохиол бүтээлүүд нийтийн хүртээл болж, мэргэжлийн нийгэмлэг, холбоод байгуулагдаж эхэлсэн.

- ✓ 1829 онд Германд “Хууль зүйн шинжлэх ухаан ба гадаад орнуудын хууль тогтоомжийн шүүмж” сэтгүүл хэвлэгдэж эхэлжээ.
- ✓ 1869 онд Францад “Харьцуулсан хууль тогтоомжийн нийгэмлэг”
- ✓ 1895 онд АНУ-д “Харьцуулсан хууль тогтоомжийн нийгэмлэг” тус тус байгуулагджээ.

Орчин үеийн харьцуулсан эрх зүйн хөгжил

XX зуун бол харьцуулсан эрх зүйн хөгжилд чанарын өөрчлөлт авчирсан түүхэн үе байв. Чухам энэ үеэс харьцуулсан эрх зүй нь мөн чанар, агуулга, үүрэг зорилгын хувьд шинжлэх ухааны шалгуурыг хангаж, мэдлэгийн бие даасан тогтолцоо болж хөгжсөн хэмээн үздэг.

1900 онд Парист хуралдсан Харьцуулсан эрх зүйн олон улсын хурлаар хэлэлцсэн асуудлууд нь өмнөх түүхийг дүгнэсэн, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал нөлөө үзүүлжээ. Уг хурлаар харьцуулсан эрх зүйн тулгамдсан асуудал, судалгааны арга зүй, цаашдын чиг хандлага, харьцуулсан эрх зүйн судалгаанд гаргаж болзошгүй алдаа төөрөгдөл зэргийг тодруулахыг зорьжээ.

Энэ хурал нь харьцуулсан эрх зүйн шинжлэх ухааны бэлгэ тэмдэг бөгөөд эрх зүйн мэдлэгийн энэ салбарыг хөгжүүлэх үндсийг тавьсан гэж үздэг.

1916 онд Э.Рабелийн санаачилгаар Мюнхений их сургуулийн дэргэд Харьцуулсан эрх зүйн төв байгуулагдсан бөгөөд дайны дараа Германы олон сургуулиудад судалгааны институтууд шинээр байгуулагджээ. Дээрх төв нь 1924 онд “Харьцуулсан эрх зүйн академи” болон өргөжсөн.

1924 онд Харьцуулсан эрх зүй судлалын олон улсын академи Гаага хотноо байгуулагдаж, 1932 онд анхны бага хурлаа хуралдуулсан бол 1994 оны 8-р сард Афин хотноо Академийн ХИҮ бага хурал хуралдаж, харьцуулсан эрх зүйн онолын болон арга зүйн асуудлуудад дүн шинжилгээ хийсэн төдийгүй нийтийн эрх зүйн салбарын асуудал, олон улсын ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал, хүний эрхийн төлөв байдал зэрэг асуудлыг шинжлэн, дүгнэлт хийсэн байна.

Өдгөө дэлхийн олон оронд харьцуулсан эрх зүйн холбоо, нийгэмлэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж, харьцуулсан судалгаа шинжилгээний олон бүтээлүүд хэвлэгдэн гарсаар байна.

Эртний болон дундад зууны үед харьцуулсан эрх зүйн мөн чанар, үүрэг зорилго нь **үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ойртуулан ижилсүүлэх, нэгдмэл шинжийг эрэлхийлэхэд** оршиж байсан бол ХҮШ зууны үеэс европын нөлөө бүхий улсуудад үндэсний хууль тогтоомжийг төрөлжүүлэн нэгтгэх үйл явц эрчимжиж, энэ хэрээр **үндэсний эрх зүйн онцлог шинжийг дөвийлгөх, бусдаас ялгаатай талыг улам бүр онцлох** явдал газар авсан байна. Энэ үеийн харьцуулсан эрх зүйн үүрэг ч үүнд чиглэсэн хандлагатай байв.

Харин өдгөө харьцуулсан эрх зүйн хөгжилд **чанарын өөрчлөлт** гарч байна. Тодруулбал:

- ✓ Харьцуулсан эрх зүйн хөгжил **газар зүйн байршлын** хувьд өргөжин тэлж, европ төдийгүй ази, африк, латин-америкийн улс орнуудад эрчимтэй хөгжиж байна.
- ✓ Харьцуулсан эрх зүй нь үндэсний эрх зүйн тогтолцоонуудыг тусгаарлах бус харин **нэгтгэх, ойртуулах** чиглэлд хөгжиж байна.



- ✓ Улс орнуудын хамтын ажиллагаа өргөжихийн хэрээр олон улсын харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтын үүрэг, ач холбогдлыг нэмэгдүүлж байна. Энэ байдал нь харьцуулсан эрх зүйн **практикийн чиг үүргийг** өндөрсгөж байна.
- ✓ Харьцуулсан эрх зүйн үр дүнг зөвхөн хувийн эрх зүйн салбарт төдийгүй **олон улсын болон нийтийн эрх зүйд** өргөнөөр ашиглах болов.
- ✓ Харьцуулсан эрх зүй нь үндэсний **эрх зүйн тогтолцоог төгөлдөржүүлэх, хуульчдын эрх зүйн соёлыг дээшлүүлэх** үр дүнтэй арга болохыг зөвшөөрч байна.

МОНГОЛ УЛСАД ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ ҮҮСЭЖ ХӨГЖСӨН НЬ

Манай улсын хувьд харьцуулсан эрх зүй нь эрх зүйн шинжлэх ухааны бусад салбартай харьцуулбал харьцангуй залуу судлагдахуун хэдий ч хууль тогтоомжийн хүрээнд харьцуулсан судалгаа өнөөг хүртэл хийгдэж ирсэн баримт бий. Энэ тухай академич Ж.Амарсанаа нар **“Олон улсын Үндсэн хуулийн оршил. Анхдугаар Үндсэн хуулийн судалгааны эх сурвалж”** бүтээлдээ “... ХХ зууны эхэн үед монголчууд тусгаар тогтносон Хаант Монгол Улсыг байгуулахад дэлхийн улсуудын төрийн тогтолцоо, гадаад, дотоод бодлогын үндсийг богино хугацаанд судалж, Улсын хурлын байгууллага, яамдын бүтэц, эрх хэмжээг хуулиар тогтоосон нь тухайн цаг үеийн дэлхийн өндөр хөгжилтэй гэгдэх орнуудын төрийн байгууллын нийтлэг хэв шинжийг бүрнээ харгалзсаны томоохон илрэл болно” хэмээн дүгнэжээ.

Дээрх бүтээлд өгүүлснээр 1911 оноос хойш Богд хааны даалгавраар тухайн үед Америк, Европын зарим орнуудын Үндсэн хуулийг олж судлан, орчуулж байсан тухай, Анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах явцад гадаад орнуудын Үндсэн хуулийг хөрвүүлэхдээ цуглуулсан баримт бичгүүдээ нэгтгэж **“Олон улсын Үндсэн хуулийн оршил ба Англи, Америк, Япон, Норвеги улсын үндсэн хуулийн хамтарсан дэвтэр”** хэмээн нэрлэж нэг багц судалгаа болгосон тухай дурдсан байна.

Монгол улс социалист нийгэмд шилжсэнээс хойшхи хугацаанд Зөвлөлтийн болон социалист эрх зүйг жишиглэн баримжаалж, эрх зүйн хөгжлийн чиг хандлагаа тодорхойлж иржээ. Тодруулбал:

1924-1940-өөд он хүртлэх хугацаанд нэг талаас үндэсний соёл, зан заншил, уламжлалт сэтгэлгээг сэргээн хөгжүүлэхэд чиглэсэн (1925 оны Шүүх цаазын бичиг, 1926 оны Гаалийн дүрэм, 1929 оны Иргэний хууль г.м), нөгөө талаас Зөвлөлт засгийн нөлөөгөөр үндэсний ардчилсан үзлийг хязгаарласан (1929 оны Феодалын хөрөнгийг хураах тухай тогтоол, 1932 оны Мал тариалангийн албан татварын хууль г.м) шинжтэй хуулиуд батлагдан гарч байв.

1940-1960 оны үед Зөвлөлтийн улс төр, эрх зүйн сэтгэлгээнд ноёрхож байсан эрх зүйн үзэл баримтлалыг даган хэрэгжүүлснээр үндэсний эрх зүйн тогтолцоонд Зөвлөлтийн коммунист үзэл суртлыг дээдэлсэн эрх зүйн социалист хэв маягийн тогтолцоо төлөвшжээ.

Социалист байгууллын үе (1960-1990 оны эхэн)-д ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааны цогцолбор хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомжийг уялдуулан жигдлэх арга хэмжээг засаг төрийн бодлогын түвшинд зохион явуулж байв. Мөн энэ үед судлаачид харьцуулсан эрх зүйг мэдлэгийн тогтолцоо гэхээсээ илүүтэй харьцуулах аргын хувьд нь өргөн ашиглаж байсныг тухайн үеийн эрдэмтэн судлаачдын бүтээлүүдээс харж болно.

Монгол улс 1990-ээд оноос ардчилал, чөлөөт зах зээлийн харилцаанд шилжсэнээрнийгэм, эдийн засаг, улс төрийн байгуулал үндсээрээ өөрчлөгдсөнтэй уялдан эрх зүйн шинэтгэл хийгдэх шаардлага зүй ёсоор тулгарсан. 1998 онд УИХ-аас **“Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”**-ийг баталсан нь уг үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж өгөв.

Хууль тогтоомжийг шинэчлэх ажлын хүрээнд дэлхийн хөгжингүй улс орнуудын хууль тогтоомжийг харьцуулан судлах, өөрийн орны өвөрмөц онцлогийг тусган илэрхийлэх үндсэн дээр эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлж байна.

Харьцуулсан эрх зүйн хөгжлийн түвшин, үр нөлөө нь эрх зүйн шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болоод зогсохгүй нөгөөтэйгүүр эрх зүйн шинэтгэл нь эргээд харьцуулсан эрх зүйг дэлхийн нийтийн чиг хандлагын дагуу хөгжүүлэх шаардлагыг ч зүй ёсоор нөхцөлдүүлж байна.

Өнгөрсөн хугацаанд үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, төгөлдөржүүлэхэд харьцуулсан эрх зүйн ололт амжилтыг багагүй ашиглаж иржээ.

Энэ чиглэлээр эрх зүйн боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт харьцуулсан эрх зүйн хичээлийг заавал судлахаар тусгаснаас гадна эрдэмтэн, судлаачдын бүтээлүүд олноор хэвлэгдэж, мэргэжлийн холбоод, нийгэмлэг байгуулагдаж, олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, чуулган зохион байгуулагдаж, олон талт төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж, үйл ажиллагаа улам бүр өргөжин тэлж байна.



ШИГТГЭЭ

Харьцуулсан эрх зүйн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн, судлаачид

- | | |
|-------------------------|------------------------|
| ✓ Р.Шлезингер (Америк), | Э.Рабель (Герман), |
| ✓ Э.Ламбер (Франц), | М.Ансель (Франц), |
| ✓ Р.Давид (Франц), | К.Цвайгерт (Герман), |
| ✓ Х.Кётц (Герман), | Р.Сакко (Итали), |
| ✓ К.Осакве (Америк), | Д.Кларк (Америк), |
| ✓ М.Н.Марченко (Орос) | А.Х.Саидов (Орос) г.м. |

Харьцуулсан эрх зүйн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийгэмлэг холбоод

- ✓ Австралийн харьцуулсан эрх зүйн институт
- ✓ Макс Планкийн институт
- ✓ Үндсэн хуулийн эрх зүйн олон улсын ассоциаци
- ✓ Тюлейны их сургуулийн дэргэдэх Исонн- Вейнманны нэрэмжит харьцуулсан эрх зүйн төв
- ✓ Оксфордын их сургуулийн Европын болон харьцуулсан эрх зүйн төв
- ✓ Харьцуулсан эрх зүйн олон улсын академи
- ✓ Харьцуулсан эрх зүй судлалын нийгэмлэг
- ✓ Харвардын их сургуулийн хуулийн сургууль г.м.

Хяналтын асуулт:

1. Эртний Грекийн сэтгэгчдийн харьцуулсан эрх зүйн үүсэлд оруулсан хувь нэмрийг дурдана уу.
2. Эртний Ромын хуульчид харьцуулсан эрх зүй үүсэхэд ямар хувь нэмэр оруулсан бэ?
3. Аристотель “Улстөр” зохиолоо бичихдээ эртний Грекийн болон варваруудын 153 хотын Үндсэн хуулийн харьцуулсан судалгаан дээр үндэслэсэн гэдгийг түүхэн талаас нь тайлбарлана уу.
4. Дундад зууны үеийн харьцуулсан эрх зүйн хөгжилд эрх зүйн ойртуулах арга тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн гэсэн дүгнэлттэй Та санал нийлэх үү? Яагаад?
5. Ш.Монтескье “Хуулийн амин сүнс” зохиолоо бичсэн үе нь харьцуулсан эрх зүйн хөгжлийн аль үе шатанд хамаарах вэ?
6. Германы болон Францын харьцуулсан эрх зүйн хөгжлийн онцлогийг тодорхойлно уу.
7. Наполеоны хуулиудыг яагаад хууль зүйн үнэ цэнтэй эх сурвалж гэж үнэлдэг вэ?
8. Монгол Улс дахь харьцуулсан эрх зүйн үүсэл хөгжлийн үе шатыг тодорхойлно уу.

Эх сурвалж:

1. Амарсанаа Б., Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он. 21-24 дэх тал
2. Амарсанаа Ж. Баярсайхан Б, Шажинбат Р., Олон улсын Үндсэн хуулийн оршил. Анхдугаар Үндсэн хуулийн судалгааны эх сурвалж УБ. 2009 он.
3. Отгончимэг Ч., Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он. 24-30 дахь тал
4. Осакке К., Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги УБ. 2005 он. 54-56 дахь тал
5. Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2004 он. 9-14, 55-74 дэх тал
6. Харьцуулсан эрх зүйн онол практикийн орчин үеийн асуудал /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2007 он. 10-20, 28-42, 62-74 дэх тал
7. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо /олон улсын симпозиумын илтгэлүүдийн эмхтгэл/ УБ. 2000 он. 30-49 дэх тал
8. Марченко М.Н., Сравнительное правоведение М 2001 г. С.22
9. Саидов А.Х., Сравнительное правоведение М. 2007 г. С. 58-84
10. www.Comparativelaw.com
11. www.comparativelaw.org
12. <http://legislationline.org/>
13. www.ejcl.org/
14. www.lexadin.nl/wlg/

ГУРАВДУГААР СЭДЭВ: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ЗОРИЛГО, ЧИГ ҮҮРЭГ

Нэр томьёо:

- Харьцуулсан эрх зүйн зорилго
- Харьцуулсан эрх зүйн чиг үүрэг
- Танин мэдэхүйн чиг үүрэг
- Шинжлэх ухааны чиг үүрэг
- Мэдээллийн чиг үүрэг

Харьцуулсан эрх зүйн мөн чанарыг бүх талаас нь гүн гүнзгий танин мэдэхийн тулд түүний хөгжлийн чиг үүрэг, зорилгыг зөв тодорхойлох шаардлагатай.

Харьцуулсан эрх зүйн үүсэл, хөгжилд амьдралын, түүний дотор прагматик болон онолын ашиг сонирхол, зорилго чухал хамааралтай.

Харьцуулсан эрх зүй чухам ямар зорилгод хүрэхийн тулд үүсэн бий болж хөгжиж байна гэдэгт харьцуулсан эрх зүй судлаачид үндсэндээ нэгдмэл саналтай байна.

Энэхүү зорилгод хүрэх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд түүний нарийн төвөгтэй, олон агуулгатай, олон талтай болохыг юуны өмнө хүлээн зөвшөөрөх ёстой гэж үздэг.



Байгалийн шинжлэх ухааны үр дүн, ололтыг олон улсад тайлбарлах шаардлага байдаггүй. Оросын физик, Францын хими, Монголын биологи гэж үгүй. Тэгвэл эрх зүйн шинжлэх ухаанд арай өөр дүр зураг харагдана. Европ тивд эрх зүйн нэгдмэл байгаа хүчин зүйл нь түүний үндсэн эх сурвалж нь ромын эрх зүй байдагт оршино. Үүний адил англи хэлтний хүрээний “нийтлэг эрх зүй” дотоод нэгдэлтэй бөгөөд түүнд ромын эрх зүй хүчтэй нөлөөлөөгүй.

Харьцуулсан эрх зүйг судлах зорилго:

- Өөрийн орны төдийгүй, бусад орны эрх зүйг ойлгох, танин мэдэх сонирхол;
- Эрх зүйн өөр өөр тогтолцоог харьцуулан судалснаар хууль зүйн тодорхой асуудал өөрийн оронд болон бусад оронд хэрхэн шийдвэрлэгдэж байгааг танин мэдэхийг эрмэлзэл;
- Өөр өөр улсад ижил төстэй асуудлыг хэрхэн шийдвэрлэж буйг харьцуулан судлах онол, практикийн шаардлага;
- Эрх зүйн өөр өөр тогтолцооны бүрэлдэхүүн, чиг үүргийн нийтлэг зарчмыг илрүүлэн тодорхойлох

**ЧИГ ҮҮРЭГ, ЗОРИЛГЫН ТАЛААР ЭРДЭМТДИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ**

Х.Гуттериж	<ul style="list-style-type: none"> • Харьцуулсан эрх зүйн үндсэн зорилго бол эрх зүйн өөр өөр тогтолцооны байнгын болон тохиолдлын шинжийг илэрхийлэх явдал
П.Круз	<ul style="list-style-type: none"> • Эрх зүйн шинжлэх ухаан, боловсрол, хууль тогтоох, эрх зүйг хэрэглэх ажиллагаа, эрх зүйн хэм хэмжээг ойлгох, тайлбарлах, жигдрүүлэх, тохируулахад тус дөхөм болох
К.Цвайгерт, Х.Кётц	<ul style="list-style-type: none"> • Харьцуулсан эрх зүйн үндсэн зорилго нь танин мэдэхүйн хүрээг өргөтгөх

Харьцуулсан эрх зүйн бие даасан шинж нь түүний дараах чиг үүргээр тодорхойлогдоно.

- Харьцуулж буй өөр өөр эрх зүйн тогтолцоо, хэмжээ, институтийн адил ба ялгаатай талыг илрүүлэх, судлах чиг үүрэг
- Улсуудын эрх зүйн тогтолцоо, эрх зүйн хандлагыг судлах чиг үүрэг.

Хяналтын асуулт:

1. Харьцуулсан эрх зүйн зорилго хэмээх ойлголтын агуулгыг тодорхойлно уу.

2. Харьцуулсан эрх зүйн болон харьцуулсан судалгааны зорилго гэсэн ойлголтын ялгааг тайлбарлана уу.
3. Харьцуулсан эрх зүй нь практик дахь хууль зүйн мэдлэгийг “тэжээж байдаг” гэдгийг хэрхэн ойлговол зохих вэ?
4. Харьцуулсан эрх зүйн танин мэдэхүйн чиг үүрэг нь мэдээллийн чиг үүрэгтэй харилцан хамааралтай юу?
5. Өнөөгийн хуульчдад харьцуулсан эрх зүй ямар ач холбогдолтой вэ?
6. Хууль тогмоомжийн хөгжилд харьцуулсан эрх зүйн үзүүлэх нөлөөллийг тодорхойлно уу.
7. Гадаад улсуудын эрх зүйн тогтолцооны ололт амжилтыг үндэсний эрх зүйд зохистойгоор нийцүүлэн шилжүүлэхийн ач холбогдлыг жишээ гарган тодорхойлно уу.

Эх сурвалж:

1. Амарсанаа Б., Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он.
2. Минжүүрдорж Б., Даяаршиж буй дэлхий: харьцуулсан эрх зүй судлал УБ 2010 он.
3. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо УБ.2001 он.
4. Сүхбаатар Ж., Харьцуулсан эрх зүй судлал /схем,тайлбар / УБ.2000 он.
5. Отгончимэг Ч., Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он.
6. Осакве К., Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги УБ. 2005 он.
7. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиумын илтгэлүүдийн эмхтгэл УБ. 2000 он.
8. Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2004 он.
9. Харьцуулсан эрх зүйн онол практикийн орчин үеийн асуудал /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2007 он.
10. Саидов А.Х., Сравнительное правоведение М. 2007 г. С 23-52

ДӨРӨВДҮГЭЭР СЭДЭВ: ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Нэр томьёо

Монизм – олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй нь нэг салбар бөгөөд эрх зүй нь нийтлэг нэг норматив шинжтэй¹.

Дуализм – олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй хоёр хоёулаа эрх зүйн бие даасан тусдаа салбар².

Плюрализм – дуализмийг хэлнэ.

¹ Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ 2011, 35 дахь тал
² Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ 2011, 35 дахь тал



Жерард Фитцморис – английн шүүгч. Фитцморисийн үзэл санааг үндэслэгч.

Олон улсын эрх зүй – олон улсын харилцаанд оролцогчдын (субъектийн) хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний системийг ойлгоно³.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ - олон улсын хамтын нийгэмлэгээс тогтоож, хүлээн зөвшөөрсөн, хууль зүйн хувьд заавал даган биелэгдэх хүчин чадалтай зан үйлийн дүрэм⁴.


Олон улсын гэрээ – олон улсын эрх зүйн субъектүүд нийтлэг ашиг сонирхлынхоо асуудлаар олон улсын эрх зүйд нийцсэн бөгөөд заавал биелэгдэх эрх, үүрэг үүсгэсэн харилцаа тогтоох шийдвэрээ илтгэн нотолсон тохиролцоог хэлнэ.

Ерөнхий ойлголт

Олон улсын эрх зүй нь үндэсний эрх зүйтэй адилтгах нийтлэг болон ялгаатай зүйл их байдаг. Үндэсний эрх зүйгээр зөвхөн тухайн улсын дотоод дахь нийгмийн харилцааг зохицуулдаг бөгөөд тэр нь өөрийн улсын нутаг дэвсгэрт хамаардаг. Харин олон улсын эрх зүй нь хил дамнаж үйлчилж, олон улсын эрх зүйн субъект хоорондын харилцааг зохицуулдаг. Үндэсний эрх зүйн тогтолцоо хэрхэн олон улсын эрх зүйг хүлээн зөвшөөрөх нь тухайн улсаас өөрөөс нь шууд хамааралтай.

Онолын тухай ойлголт

Монизм болон дуализм (плюрализм) гэсэн хоёр үндсэн онол байдаг.




Монизм нь олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүй хоёрыг нэг эрх зүйн тогтолцоонд хатааруулдаг ба эдгээрийн хооронд зөрчилдөөн үүсвэл олон улсын эрх зүйг илүү давамгайлдаг гэж үздэг. Тухайлбал, Монгол Улсад 2012 оны 12 дугаар сарын байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй **466** хуулийн **150** гаруй нь “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан байдаг. Гэхдээ зөвхөн хууль хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээ л дотоодын хуулиас илүү хүчин чадалтай байх буюу олон улсын гэрээний зохицуулалт хуулийн зохицуулалтаас өөр байвал олон улсын гэрээний заалт үйлчилнэ. Монист улс нь олон улсын эрх зүйг үндэсний эрх зүйн нэгэн хэсэг гэж тооцдог⁵. Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд тодорхой дурдсан байдаг.


3 М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын эрх зүй, УБ 1999, 1 тал

4 Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол №9, 200802.28

5 Nutshells international law (2nd edn), 2010 он, Rebecca M.M.Wallace, Anne Holliday, p.32.



Дуализм нь олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй хоёр тусдаа бие даасан эрх зүйн тогтолцоо гэж үздэг бөгөөд зохицуулах зүйл нь өөр өөр байдаг. Тэдгээрийн үйл ажиллагааны салбар нь харилцан хамааралгүй бөгөөд нөгөө тогтолцоондоо нөлөө үзүүлдэггүй. Өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй хоорондоо зөрчилддөггүй. Хоёр эрх зүйн салбар зөрчилдөх тохиолдолд дотоодын шүүх дотоодын хууль тогтоомжийг хэрэглэдэг. Дуалист улс нь олон улсын эрх зүйг үндэсний эрх зүйн нэгэн хэсэг болгохын тулд бие даасан эрх зүйн акт гаргах шаардлагатай болдог⁶. Дуалист улсад Англи, АНУ, Австрали гэх мэт ихэнхдээ нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс багтдаг.




Фитцморисийн үзэл санаа нь олон улсын болон үндэсний эрх зүй хоёлаа үйл ажиллагааны тусдаа салбар буюу тогтолцооны хувьд хоорондоо зөрчилддөггүй. Зөрчилдөөн нь зөвхөн хоёр эрх зүйн салбарын хариуцлагын асуудалд илэрдэг.⁷

6 Nutshells international law (2nd edn), 2010 он, Rebecca M.M.Wallace, Anne Holliday., p.32.

7 Nutshells international law (2nd edn), 2010 он, Rebecca M.M.Wallace, Anne Holliday., p.32.




Тодруулбал, олон улсын эрх зүйгээр шаардсан аливаа үйлдлийг дотоодын хууль тогтоомжийн дагуу үйлдэх боломжгүй байх бөгөөд энэ нь дотоодын хууль тогтоомжийн дагуу аливаа зөрчил биш боловч олон улсын хувьд тухайн улсын хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх явдал юм⁸.



Үндэсний эрх зүйг олон улсын эрх зүйн талаас нь авч үзвэл

Олон тооны олон улсын гэрээнд гишүүн орныг өөрийн дотоодын хууль тогтоомждоо заавал тусгах шаардлагатай заалт оруулсан байдаг. Ингэж дотоодын хууль тогтоомжид тусгаснаар хуулийн биелэлт, хуулийг хэрэглэх нь илүү тодорхой болохоос гадна хэрэгжилтэд нь хяналт тавьж, дотоодын шүүхэд хуулиа хэрэглэхэд илүү боломжтой болдог. Тийм заалт нь ихэвчлэн хариуцлага хүлээлгэх болон хүний эрхтэй холбоотой байдаг. Монгол Улсын нэгдэн орсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Палермогийн конвенцийн хөрөнгө албадан хураахтай холбоотой 12 дугаар зүйлд “оролцогч улс бүр өөрийн дотоодын эрх зүйн тогтолцооны хүрээнд боломжийн хирээр тусгаж батална” гэж заасан. Олон улсын гэрээний оролцогч талд иймэрхүү байдлаар нээлттэй орхиж байгаа нь тухайн улсыг өөрийн үндэсний эрх зүйн нөхцөл байдал, хариуцлагын тогтолцоотойгоо уялдуулж ямар нэгэн хэлбэрээр заавал тусгахыг (трансформац) үүрэг болгож байгаа юм.

⁸ Ian Brownlie, Principles of Public International law, 6th edn, 2003, p.33.



Олон улсын эрх зүйг үндэсний эрх зүйн талаас нь авч үзвэл

Үндэсний эрх зүйд тодорхой нарийвчлан тогтоосон хэм хэмжээ байхгүй тохиолдолд олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг ашиглаж болдог. Үүнийг дотоодын шүүх байгууллагад ихэвчлэн хэрэглэдэг. Дотоодын шүүх аливаа хэрэг, маргааныг шүүх явцад дотоодын хууль тогтоомжийн зохицуулалт байхгүй үед тухайн улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтыг иш үндэс болгож болдог. Жишээг дараах схемээс харж болно.



Хяналтын асуулт

1. Монизм гэж юу вэ?
2. Дуализм гэж юу вэ?
3. Плюрализм болон дуализмын ялгаа юунд орших вэ?
4. Олон улсын эрх зүй, үндэсний эрх зүй хоёрын ялгааг тодорхойлно уу.



5. Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг заавал даган биелүүлэхгүй байж болох уу?
6. Монгол Улс монист, дуалистын алинд нь хамаарах вэ?
7. Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлаагүй олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж болох уу?
8. Монгол Улсын Засгийн газраар баталсан олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж болох уу?
9. Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан Засгийн газар хоорондын хоёр талт олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх үү?
10. Олон улсын шүүх Монгол Улсын хуулийг хэрэглэж болох уу?
11. Дуалист улсын хувьд аль эрх зүйн салбар нь илүү давамгайлдаг вэ?
12. Монист улсын хувьд үндэсний эрх зүй, олон улсын эрх зүйн аль нь давамгайлдаг вэ?

Эх сурвалж

1. ХЗҮХ, ФСЭЗХ, МУИС Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төв, Монголын олон улсын эрх зүйн нийгэмлэг, Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ 2011
2. Б.Гүнбилэг, А.Төмөр., Харьцуулсан эрх зүй, УБ 2005
3. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр., Олон улсын эрх зүй, УБ 1999
4. Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол №9, 2008.02.28
5. Nutshells international law (2nd edn), 2010 он, Rebecca M.M.Wallace, Anne Holliday
6. Ian Brownlie., Principles of Public International law, 6th edn, 2003
7. И.П.Блищенко, Ж.Дориа., Прецеденты в международном публичном и частном праве, Москва 1999

ТАВДУГААР СЭДЭВ: ЭРХ ЗҮЙН АЙМАГ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ

Эрх зүйн аймгийн тухай ойлголт

Аливаа нэг улс орны эрх зүйг үндэсний эрх зүй гэж нэрлэдэг. Үндэсний эрх зүй нь тухайн улсын эдийн засаг, улс төр, соёл, газар нутаг, үндэстэн ястан, эрх зүйн эх сурвалж, зан заншил, шашин шүтлэгийн түүхэн болон тухайн цаг үеийн хүчин зүйлээс нөхцөлдсөн уялдаа холбоо харилцан хамаарал, нэгдэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, үндэсний эрх зүйн тогтолцоо нь өөр өөрийн онцлогтой боловч эх авч үүссэн түүхэн нөхцөл, арга зүй, эх сурвалж, хууль зүйн техник зэрэг эдийн засаг, улс төрийн тогтолцооны адил төстэй хэв маяг, шашин суртал,

хэл соёлын нийтлэг, улс үндэстнүүдийн харилцан нөлөөллөөс уламжилсан нэг эхлэл, нийтлэлтэй байдаг. Тухайлбал, эх газрын Европын орнуудын эрх зүй нь эртний Ромын эрх зүйгээс уламжлан хөгжсөн байхад АНУ-ын эрх зүй, түүнчлэн Английн колони байсан орнуудын эрх зүй нь Англо-саксоны эрх зүйгээс эх авч түүний нөлөөнд төлөвшсөн байдаг. Гэхдээ улс орнуудын эрх зүйн тогтолцоо нийтлэг болон ялгарах шинжээрээ бүгд адил биш өөр өөр байна. Хэдий тийм боловч нэг хэсэг буюу хэд хэдэн улс орны эрх зүйн тогтолцоо нийтлэг шинжээрээ ижил буюу ойролцоо шинж байдалтай байдаг учраас дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоог хэд хэдэн аймаг болгон ангилан үздэг. Эрх зүйн системүүдийг адил төсөөтэй шинж чанаруудаар нь манай улсад ч мөн ангилан улмаар эрх зүйн

- “аймаг”
- “төрөл, бүл”
- “бүл” хэмээх нэр томъёогоор эх хэлнээ хөрвүүлэн буулгаж дэлхий дахины эрх зүйн ерөнхий онолыг даган хөгжиж байна.

Дэлхийн эрх зүйн тогтолцоог ийнхүү аймагчлан хуваахыг зарим судлаач эрх зүйн бүл гэж нэрлэж байгаа боловч бид энэхүү гарын авлагыг боловсруулах ажлын зөвлөх академич Ж.Амарсанаагийн зөвлөснөөр эрх зүйн аймаг гэсэн нэр томъёогоор нэрлэн хэвшүүлэхийг зорьлоо.

Тэгэхлээр *эрх зүйн аймаг* гэдэг нь эрх зүйн үүсэл, хувьсал, хөгжлөөрөө нэгдмэл, эрх зүйн эх сурвалж, эрх зүйн ухамсар, соёл боловсрол, бусад элементээрээ ижил төсөөтэй шинжүүдийг агуулсан улс орнуудын эрх зүйн тогтолцооны нэгдлийн тухай ойлголт юм. Эрх зүйн аймгийн талаар эрдэмтэн судлаачид дараах тодорхойлолтуудыг хийсэн байна.

Германы эрдэмтэн Х.Шоллер *“эрх зүйн бүл гэдгийн үзэл санаа нь эрх зүйн янз бүрийн байгуулал нь хүтүүсийн гэр бүлийн нэгэн адил нэг нь нөгөөгөө төрүүлдэг, өөр хоорондоо эцэг эх, үр хүүхэд ба ахан дүүсийн холбоо сүлбээтэй байдаг гэсэн утгыг агуулж байгаа юм”* гэжээ. Академич С.Нарангэрэл *“Эрх зүйн бүл гэдэг нь эрх зүйн эх сурвалж, эрх зүйн үндсэн ухагдахуун, эрх зүйн бүтэц ба тэдгээрийн бүрдэн тогтсон түүхэн затналын нийтлэг байдлыг нэгтгэсэн эрх зүйн үндэсний тогтолцооны нийлбэр”* гэсэн бол доктор Ц.Сарантуяа *“Эрх зүйн бүл гэдэг нь хууль зүйн шинж чанараараа ижил төсөөтэй бөгөөд үүгээрээ харьцангуй нэгдмэл гэж хэлж болохуйц эрх зүйн системүүдийн нэгдлийн хэлнэ”* гэжээ. Эрх зүйн аймгийг аймагчлан ангилах нь харьцуулсан эрх зүйн үндсэн асуудал юм.

Эрх зүйн аймгийн ангилал, түүний талаарх эрдэмтдийн үзэл баримтлал

Эрх зүйн аймгийг ангилах оролдлогыг олон эрдэмтэн судлаачид хийдгээс орчин үед Рене Давидын ангиллыг түгээмэл баримталж байна. Тэрээр эрх зүйн



системийг дараах байдлаар ангилжээ: Ром-Германы эрх зүй, Социалист эрх зүй, Нийтлэг эрх зүй, Шашны болон уламжлалт эрх зүй.

Манай улсын эрдэмтэн, судлаачид мөн эрх зүйг тогтолцоог аймагчлах асуудалд өөр өөр байр сууринаас ханддаг ба тухайлбал, хуульч Б.Чимид эрх зүйн аймгийг:

1. Нийтээр хэвшүүлсэн эрх зүйн буюу Англо-саксоны эрх зүйн тогтолцооны;
2. Эх газрын буюу ром-германы эрх зүйн тогтолцооны;
3. Шашин-хүй элгэний эрх зүйн тогтолцооны;
4. Социалист буюу үзэл сурталжсан эрх зүйн тогтолцооны гэж 4 хуваасан бол академич Ж.Амарсанаа:
 - а) эх газрын;
 - б) нийтлэг эрх зүйн;
 - в) лалын эрх зүйн;
 - д) уламжлалт эрх зүйн гэж 4 ангилж болох юм гэжээ.

Академич С.Нарангэрэл эрх зүйн аймгийг:

- Англо-саксоны эрх зүй;
- Ром-Германы эрх зүй;
- Мусульманы эрх зүй гэж ангилжээ.

Харин Кристофер Осаке орчин үеийн эрх зүйн тогтолцооны ангилал болон эрх зүйн аймгийг дараах байдлаар тодорхойлжээ.

Тодорхойлолт: эрх зүйн аймаг гэсэн ойлголтод түгээмэл шинж, чиг хандлагын үндсэн дээр хуваагдсан үндэсний эрх зүйн тогтолцооны нийлбэр цогцийг хамааруулдаг.

Орчин үеийн эрх зүйн тогтолцооны ангилал

Шашны эрх зүйн тогтолцоо

Шашны бус эрх зүйн тогтолцоо

Эрх зүйн аймгийн онцлог

Эрх зүйн аймаг

Ром-Германы эрх зүйн аймаг

Англи-Америкийн эрх зүйн аймаг

Социалист эрх зүйн аймаг

Шашны эрх зүйн аймаг

Үндсэн хуулийн хэм хэмжээ нь тэргүүлэх байр суурь эзэлдэг ба бичмэл үндсэн хуультай байдаг. Үндсэн хуулийн хэм хэмжээ нь тэргүүлэх байр суурь эзэлж, хууль зүйн хувьд дээд хүчин чадалтай байдаг.

Энэ эрх зүйн аймаг нь уламжлал ихтэй, эрх зүйн эх сурвалж нь шүүхийн жишиг юм. Бичмэл бус үндсэн хуультай.

Төр, эрх зүй аажмаар мөхөж нийгмийн харилцааг заншил болон ёс суртахууны хэм хэмжээгээр зохицуулах болно гэж үздэг.

Мусульман шашинтан хүний дагаж мөрдөх зан үйлийг тогтоосон журмуудаас бүрдэнэ. Төрийн үүргийг шашны итгэл үнэмшлийг хэрэгжүүлэх, хамгаалах явдал гэж үздэг.

Ром-Германы эрх зүйн аймаг (Эх газрын эрх зүйн аймаг)

Эрх зүйн энэ аймагт эх газрын улсуудаас гадна Латин Америкийн ихэнх улс орнууд, Африкийн зарим улс орон, Япон, Индонез, Шотланд, ӨАБНУ, Израйль зэрэг улс орнууд хамаарна. Ром-Германы эрх зүйн аймгийн гол шалгуур нь уг аймагт хамрагддаг улс орнуудын эрх зүйн үүсэл, эх сурвалж нь бичигдмэл эрх зүйн хэм хэмжээ нэгдмэл байдал мөн. Энэ аймаг нь Ром-Германы эрх зүйн аль алийг нь хэрэглэдэг. Тэгэхдээ Ромын эрх зүй нь Ромын хувийн эрх зүй, заншлын эрх зүйг, Германы эрх зүй нь Ромын хувийн эрх зүй, Германы заншлын эрх зүйг илүүтэй хэрэглэж, түүнд суурилдаг. Эрх зүйн энэ аймагт Евроазийн эх газрын болон Латин Америкийн ихэнх орнууд хамаардаг, түүний дотор Монгол улс ч орно. Энэ аймгийн орнуудад хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай эрх зүйд үндсэн хуулийг тооцдог. Эх сурвалжид үндсэн хууль, бусад хууль, эрх зүйн актыг хамруулан авч үздэг. Энэ аймгийн улс орнуудад хууль дээдлэх зарчим хэрэгжиж, хуульчид нь шударга ёсыг тогтоох хамгийн чухал арга хэрэгслийг хуульд нийцсэн шийдвэр гаргаж хэрэгжүүлэх явдал гэж үздэг. Ром-Германы улс орнууд эрх зүйгээ хувийн ба нийтийн эрх зүй гэсэн салбаруудад хуваадаг. Үүрэг хэмээх хууль зүйн ойлголтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлдэг Англи-Америкийн эрх зүйн аймагт ч байдаггүй, үүргийн эрх зүй гэдэг институт үйлчилж байдаг. Эрх зүйн хэм хэмжээг тодорхой асуудлыг шийдвэрлэх хэрэгсэл гэхээс гадна нийтээр заавал биелүүлэх зан үйлийн горим журам хэмээн ойлгодог байна. Энэ аймгийн улс орнуудад шүүхийн тогтолцоо нь шатлан захирах зарчмын дагуу зохион байгуулагдсан байх бөгөөд Франц, Швейцар зэрэг олон улс орнуудад захиргааны, цэргийн, гаалийн зэрэг дагнасан шүүхийн институт үйл ажиллагаа явуулдаг. Хууль ёсны хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүрэг бүхий прокурорын байгууллагын тогтолцоотой нь энэ аймгийн нэг онцлог юм. Шүүгчид эрх зүй бүтээх эрх эдлэхгүй, дээд шатны шүүхийн шийдвэрийг ижил төсөөтэй хэрэг маргааныг шийдвэрлэхдээ заавал мөрдөх үүрэгтэй байдаг.

Англи-Америкийн эрх зүйн аймаг (Нийтлэг эрх зүйн аймаг)

Англи-Америкийн эрх зүйн аймагт Английн эрх зүйн тогтолцоо болон англи хэлтэй улс орнууд бүгд хамаарна. Дэлхий дээр хамгийн их тархсан эл эрх зүйн аймаг нь дундад зууны үеийн Англид буй болжээ. Англи-Америкийн эрх зүйн аймгийг английн эрх зүй, америкийн эрх зүй гэсэн 2 хэсэгт хувааж үздэг. Английн эрх зүйн хэсэгт Англи, Хойд Ирланд, Канад, Австрали, Шинэ Зеланд зэрэг улс орнууд хамаарна. Английн эрх зүй бол уламжлал ихтэй, эрх зүйн үндсэн эх сурвалж нь шүүхийн жишиг байна. Орчин үед Английн шүүхийн жишиг 500 мянга орчим болж байна. Ром-Германы эрх зүйн аймгийн хуульчид эрх зүйг урьдчилан тогтоосон зан үйлийн горим, журам гэж үздэг бол Англо-саксоны эрх зүйн аймгийн хуульчид эрх зүйг шүүхийн шийдвэр гэж үздэг. Иймд энэ аймгийн улс орнууд шүүхийн шийдвэрийн зөв эсэхэд ихээхэн анхаарал



хандуулдаг байна. Шүүгчид нь нийтлэг шинжтэй шийдвэр гаргадаггүй бөгөөд тухайн маргааныг төгс шийдэх зорилго тавьдаг байна. Иймд нийтлэг эрх зүйн хэм хэмжээ нь нэлээд уян хатан, бөгөөд хийсвэрлэл багатай, казуист шинжтэй, тодорхой байдал багатай байдаг. Энэ эрх зүйн аймгийн гол онцлог нь бол хууль тогтоогчид бүх цаг үед, бүх харилцааг зохицуулсан хэм хэмжээг тогтоох бололцоогүй гэдгийг хүлээн зөвшөөрч, тэрхүү орон зайг нийтлэг эрх зүй буюу шүүхийн жишиг, зан заншил, эрх зүйн нийтлэг зарчмаар нөхөх зарчмыг баримталдагт оршино. Эрх зүйн энэ аймгийн орнууд бүх эрх зүйг нийтийн эрх зүй гэж үздэг ба нийтийн болон хувийн эрх зүй гэж ангилдаггүй. Түүнчлэн шүүхийн жишгийн зэрэгцээ эрх зүйн хэм хэмжээг бас хэрэглэж эх сурвалжаа болгодог.

Шашны эрх зүйн аймаг

Харьцуулсан эрх зүйн нэрт төлөөлөгч Р.Давид Лалын эрх зүйг эрх зүйн бусад аймгуудаас ялгагдах онцлог шинжийг нь онолын бие даасан салбар болон хөгжөөгүй бөгөөд Лалын шашинт орнуудад байдаг шашны үзэл номлолуудын илэрхийлэл гэж үзсэн байна. Лалын эрх зүйг “шариат” гэж нэрлэх бөгөөд энэ нь “дагаж мөрдөх ариун зам” гэсэн утгатай үг юм. Энэ нь лалын шашинтан хүний дагаж мөрдөх зан үйлийн тогтоосон журмуудаас бүрдэнэ. Шариат хааны үүрэг дээр тулгуурласан байна. Төрийн үүргийг шашны итгэл үнэмшлийг хэрэгжүүлэх, хамгаалах явдал гэж үздэг.

Лалын эрх зүйн үндсэн эх сурвалж нь:

1. Коран энэ нь шашны ариун судар
2. Сунна энэ нь Мухаммедын сургаал
3. Ижма энэ нь лалын ертөнцийн нэгдэл
4. Кияс энэ нь төсөөтэй хэрэглэх эргэцүүлэл гэх зэрэг болно.

Коран нь Аллах тэнгэрээс өөрийн шавь Мухаммедаар дамжуулан хүмүүст илгээсэн сургаалуудаас бүрдэнэ. Хууль зүйн энэ хэм хэмжээ Коранд төдийлэн элбэг биш боловч мусульманы хуульчид эрх зүйн хэм хэмжээг агуулсан гэж үздэг байна. Сунна бол хүмүүс итгэж шүтэн дагаж биелүүлэх зорилгоор айлдсан Мухаммедын өгүүлэлүүд юм. Энэ аймгийн онцлог нь зөвхөн эрх зүйн харилцаагаар хязгаарлагдахгүй нийгмийн бүхий л харилцааг хамаардаг шинжийг өөртөө агуулж байдаг. Орчин үед Мусульманы эрх зүйн тогтолцоотой орнууд өөрийнх нь эрх зүйн зохицуулалтад ордоггүй байсан хууль, эрх зүйн акт, хэлцэл зэргийг багагүй хэрэглэдэг болсон.

Социалист эрх зүйн аймаг

Нийгмийн хөгжлийн социалист чиг баримжаагаар хөгжиж байсан улс орнууд эрх зүйн социалист аймагт хамаарна. Эрх зүйн социалист аймаг нь Орос улсад 1917 онд ялсан хувьсгалын дүнд үүсэн бий болсон юм. Эрх зүйн энэ

систем нь марксизмын үзэл номлол дээр тулгуурлан хөгжиж байлаа. Социалист орнуудад эдийн засгийн төлөвлөгөөтэй хөгжүүлэх аж ахуй үйл ажиллагаанд төрийн идэвхтэй оролцоог хангах, хөдөлмөр, хэрэглээг зохицуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хувийн өмчийг бүх талаар хязгаарлах зэрэг марксист үзэл санаанууд хэрэгжиж байсан юм. Эдгээр улс орнуудад коммунист нийгэм эдийн засгийн байгууллагын үед төр, эрх зүй аажмаар мөхөж нийгмийн харилцааг заншил болон ёс суртахууны хэм хэмжээ зохицуулах болно гэж сургаж байв. Нийгмийн харилцааны олон төрлийг төрийн зүгээс хуулиар нарийвчлан зохицуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн. Эрх зүй бол улс төрийн бодлогын илрэл болж улмаар шинэ нийгмийн дэг журам бүтээх хэрэгсэл болсон байна. Энэ аймаг нь Ром-Германы эрх зүйн аймагтай нэлээд шинжээрээ төсөөтэй. Эрх зүйн эх сурвалж нь хууль зүйн техник, эрх зүйн бүтэц зэрэг шинжээрээ Ром-Германы эрх зүйн аймагтай төсөөтэй боловч онцлог ялгаатай талууд ч мөн байдаг. Эрх зүйн эх сурвалж нь хэм хэмжээний акт хэмээн үздэг байна. Энэ аймгийн улс орнууд төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг, хүний эрх эрх чөлөөний тухай ардчилсан үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрдөггүй. Шүүхийн тогтолцоондоо шүүхээс гадна ардын төлөөлөгчдийг шүүн таслах ажиллагаанд оролцуулдаг байна. Эрх зүйн ихэнх хэм хэмжээ нь императив шинжтэй бөгөөд эрх зүйгээ нийтийн ба хувийн гэж ангилдаггүй. Эрүүгийн болон захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр төрийн өмчийн давуу байдлыг хуульчлан баталгаажуулсан байдаг. Харин хүний амины өмчийн хэлбэрийг хүлээн зөвшөөрч энэ нь зөвхөн хүний амины хэрэгцээг хангах зорилготой гэж үздэг. Энэ аймгийн явцад төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хөлсний хөдөлмөрийг хамгаалах зэрэг институт хөгжсөн байна.

Эрх зүйн аймгийн төлөөлөл болсон улсууд, зарим шинж



Англи-Америкийн эрх зүйн аймаг

- Англи, АНУ, Канад, Австрали, Умард Ирланд, Шинэ Зеланд, Энэтхэг зэрэг
- Үүсэл зүй нь: Практик, үндсэн эх сурвалж: Шүүхийн жишиг, гол ач холбогдлоо өгдөг: Шүүх, эрх зүйн үндэс, эрх зүй, хуулийг үзэх үзэл: эрх зүй, хуулийг адилтгана



Ром-Германы эрх зүйн аймаг

- ХБНГУ, Франц, Бельги, Люксембург, Голланд, Итали, Португали, Австри, Швейцар
- Үүсэл зүй нь: Сургалт, үндсэн эх сурвалж: Хууль, гол ач холбогдлоо өгдөг: Хууль, эрх зүйн үндэс, эрх зүй, хуулийг үзэх үзэл: Шударга ёс, эрх зүйн акт



Социалист эрх зүйн аймаг

- БНХАУ, Куба, БНАСУ, Вьетнам зэрэг
- Үүсэл зүй нь: Ангиуд, үндсэн эх сурвалж: Хууль гэвч формаль, гол ач холбогдлоо өгдөг: Үзэл суртал, эрх зүйн үндэс, эрх зүй, хуулийг үзэх үзэл: Ноёлогч ангийн хүсэл



Шашны эрх зүйн аймаг


- Иран, Ирак, Афганистан, Пакистан, Марокко, Ливи, Саудын Араб, Судан гэх зэрэг
- Үүсэл зүй нь: Бурхан, үндсэн эх сурвалж: Шариаг, гол ач холбогдлоо өгдөг: Сүсэг бишрэл, эрх зүйн үндэс, эрх зүй, хуулийг үзэх үзэл: Уламжлалт хатуу дэг жаяг



Эрх зүйн аймгийг ангилах шалгуур

Эрх зүйн системийг аймагчлах оролдлого ХХ зуунаас Европт хийгдэж байсан бөгөөд тухайлбал, 1905 онд Эсмен янз бүрийн ард түмний бүрэлдэн бий болсон түүхэн онцлог, тухайн нийгмийн ерөнхий бүтэц, онцлох бусад шинжийг үндэслэн эрх зүйг ангилсан бол Леви-Ульман, эрх зүйн эх сурвалжийг шалгуур болгосон бол Армижон-Нольде-Вольф эрх зүйн үүсэл хийгээд бусад эрхтэй ижил, ялгаатай талыг, Шницер соёлын онцлог, түүний хамрах хүрээг, Цвайгерт хууль зүйн арга барилыг буюу эрх зүйн тухайн системийн түүхэн хөгжил, сэтгэлгээний онцлог, эрх зүйн эх сурвалж, түүнийг тайлбарлах арга, үзэл суртлын хүчин зүйлсийг үндэслэн ангилах нь зүйтэй гэж үзсэн байдаг. Орчин үед Рене Давидын үзэл суртлын болон хууль зүйн арга ажиллагааны шалгуурыг голлон ангилж байна.

Мөн түүнчлэн Даннел Бернал эрх зүйн аймгийн ангиллын шалгуур нь янз бүрийн нөхцөл байдал, бас тэдгээрийн шинж тэмдгүүд байдаг гээд тухайлбал, эрх зүйн бүтэц, эрх зүйн эх сурвалжуудыг тодорхойлох онол, практикийн өвөрмөц онцлогууд, нийгэм ба төрийн амьдралд эрх зүйн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийн талаарх бодол төсөөлөл, эрх зүйн аль нэг тогтолцооны хүрээнд хэрэглэгдэж байгаа хууль зүйн техник, эрх зүйн философи, улс төр болон бусад үндэс, зарчим байна гэжээ.



АНУ-ын эрдэмтэн Кристофер Осаквегийн “Харьцуулсан эрх зүй судлал” бүтээлд эрх зүйн тогтолцоог аймгаар ангилах шалгуурыг ийм байдлаар гаргасан байна. Эрх зүйн үзэл суртал гэдэг нь нийгмийн улс төр, эдийн засаг, социал харилцааг зохицуулдаг эрх зүйн философийн ерөнхий зарчмууд гээд энэ нь нийгмийн, улс төрийн, эдийн засгийн гэсэн 3 хүрээний үзэл санааг харуулдаг гэжээ.

Хяналтын асуулт

1. Эрх зүйн аймаг буюу эрх зүйн уламжлал гэсэн ойлголтуудыг тодруулан эдгээрийн ялгаатай талаар ярилцана уу.
2. “Эрх зүйн аймаг гэдэг эрх зүйн үүсэл, хувьсал, хөгжлөөрөө нэгдмэл, эрх зүйн эх сурвалж, эрх зүйн ухамсар, соёл боловсрол, бусад элементээрээ ижил төсөөтэй шинжүүдийг агуулсан улс орнуудын эрх зүйн тогтолцоог аймагчлан үзэх ойлголт” гэсэнтэй Та санал нэгдэх үү?
3. Эрх зүйн аймгийг ангилах шалгуурыг жагсаан бичиж тус бүрд нь дүн шинжилгээ хийнэ үү.

4. Эрх зүйн аймгийн ангиллын шалгуур элементэд хэл, газар зүйн байршил, шашин гэсэн хүчин зүйл нөлөөлөх талаар чөлөөт мэтгэлцээн явуулна уу.
5. Эрх зүйн аймгийн ангилалд эрх зүйн дотоод бүтэц буюу институц ямар үүрэгтэйг ярилцана уу.

Эх сурвалж

1. Кристофер Осаке., “Харьцуулсан эрх зүй судлал : ерөнхий ба тусгай анги бүдүүвч” УБ., 2005 он, 40 дахь тал.
2. Болортогос Б, Батханд Я., “Харьцуулсан эрх зүй”, УБ., 2012 он, 89-90 дах тал.
3. Гүнбилэг Б., “Жишгийн эрх зүй” УБ., 2008.
4. “Харьцуулсан эрх эрх зүйн онол, практикийн орчин үеийн асуудал” Шихихутаг ХЗДС УБ., 2007.
5. Амгалан Ч, Болортунгалаг Н, Энхтуяа Б., “Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил: Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл” УБ., 2004.
6. Нарангэрэл С., “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо” /харьцуулсан эрх зүй/ УБ., 2001. 226 дахь тал.
7. Отгончимэг Н., “Харьцуулсан эрх зүйн судлал” УБ., 2001.
8. Mathias Reimann and Reinhard Zimmermann, *The Oxford Handbook of Comparative law*, Oxford University press, 2006.
9. Rene David and John E.C. Brierly, *Major Legal Systems in the World Today: An Introduction to the Comparative Study of Law* (London: Stevens, 1985)
10. *Szladits' Bibliography on Foreign and Comparative Law*, Daniel L. Wade, S. Blair Kauffman, and Tracy L. Thompson, eds. (New York: Oceana, 2001)
11. Conrad Zweigert and Hein Kotz, *Introduction to Comparative Law* (Oxford: Clarendon Press, 1998)
12. <http://www.asil.org/resource/pil1.htm>
13. <http://www.lib.uchicago.edu/~llou/global.html>
14. <http://europa.eu.int/eurodicautom/Controller>
15. <http://www.lexml.de/rdf.htm>



ЗУРГАДУГААР СЭДЭВ: РОМ-ГЕРМАНЫ ЭРХ ЗҮЙН АЙМАГ

Нэр томъёо:

- ◆ Ромын эрх зүй
- ◆ Ром-Германы эрх зүй
- ◆ Эх газрын эрх зүй
- ◆ Хуульчлах (кодификаци)
- ◆ Хууль
- ◆ Нийтийн эрх зүй
- ◆ Хувийн эрх зүй
- ◆ Заншил
- ◆ Жишиг

Ром-Германы эрх зүй үүсэн төлөвшиж хөгжсөн үндсэн үе шат

Ром-Германы эрх зүйн аймаг нь Африкийн олон орон, Латин Америк бүхэлдээ, Ойрхи Дорнод, Индонез, Япон, Өмнөд Солонгос, Монгол, Европын орнуудыг хамаарч байна.

Энэ нь Ромын ба Германы гэсэн бүлэгт хуваагдаж байна.

Ромын бүлэг
<ul style="list-style-type: none"> • Франц, • Итали, • Испани, • Бельги, • Люксембург, • Голланд зэрэг

Германы бүлэг
<ul style="list-style-type: none"> • Герман, • Австри, • Швейцарь, • Япон, • Солонгос зэрэг

Ром-Германы эрх зүйн аймгийн хөгжлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн төв нь эх газрын Европ.

Тэгэхдээ дэлхийн олон газар нутаг, бүсэд эрх зүйн энэ аймаг идэвхтэй хөгжиж байна.

Үүнээс үндэслэн:

- Латин Америкийн;
- Скандинавын;
- Латиний;
- Азийн гэх зэргээр дэд бүлэгт ангилж байна.


Ром-Германы эрх зүйг бас иргэний эрх зүй (civil law) гэж нэрлэдэг. Энэ нь “jus civil” гэсэн латин үгнээс гаралтай. Ромын иргэнд (civis) үйлчилдэг эрх зүйг ингэж нэрлэдэг байв. Ромын бусад оршин суугчдад өөр эрх зүй болох “jus gentium” үйлчилж байв.

Ром-Германы эрх зүйн аймгийн гурван үндсэн үе шат



Ром-Германы эрх зүйн онцлог шинж

- Ромын эрх зүйн үндсэн дээр үүсч хөгжсөн, ромын эрх зүйтэй нягт холбоотой.
- Чухал эх сурвалж нь Юстинианы бүгд хууль (“Justinians Corpus juris civilas”).
- Бусад эрх зүйн аймгаас Ром-Германы эрх зүйн аймгийн онцлох чухал ялгаа нь түүний онолын, үзэл баримтлалын шинж юм.
- Ром-Германы эрх зүйн нэг чухал онцлог нь эрх зүйн эх сурвалжид хууль голлох үүрэгтэй байна.
- Ром-Германы эрх зүйн нэг өвөрмөц онцлог нь түүний “нийтийн эрх зүй”, “хувийн эрх зүй” гэж ангилагддаг явдал юм.
- Ром-Германы эрх зүйн онцлогийг илэрхийлэх нэг зүйл түүний хуульчлагдсан (төрөлжүүлэн хуульчлагдсан) байдал юм.





Хяналтын асуулт:

1. Ром-Германы эрх зүйн аймаг үүсч хөгжихөд Ромын эрх зүйн үзүүлсэн нөлөөллийг дүгнэнэ үү.
2. Ром-Германы эрх зүйн аймаг бүрэлдэн тогтоход тухайн үеийн Европын их сургуулиудын гүйцэтгэсэн үүргийг хэрхэн тодорхойлж болох вэ?
3. Ром-Германы эрх зүйн аймгийг зарим судлаачид яагаад “профессорын эрх зүй” хэмээн нэрлэдэг вэ?
4. Энэ аймгийн эрх зүйн эх сурвалжийн төрөл, эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурийг тайлбарлана уу.
5. Хуульчлахын ач холбогдлыг Та хэрхэн үнэлж байна вэ?
6. Ром-Германы эрх зүйн аймаг дахь эрх зүйн аймгийн эх сурвалжид заншил, шүүхийн жишиг ямар байр суурь эзлэх вэ? Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр жишиг мөн үү?
7. Ром-Германы эрх зүйн аймаг дахь эрх зүйн зарчим нь Англи-Америкийн эрх зүйн аймаг дахь эрх зүйн зарчмаас агуулга, гүйцэтгэх үүргийн хувьд ямар ялгаатай байдаг вэ? Жишээ гарган тайлбарлана уу.
8. Германы эрх зүйн тогтолцооны дэлхийн эрх зүйн хөгжилд нөлөөлсөн үр нөлөөг тодорхойлон ярилцана уу.
9. Германы хууль зүйн сургалтыг Монгол улсад нэвтрүүлж байгаа туршлага болон практик үр нөлөөг Та хэрхэн үнэлж байна вэ?
10. Өөрийн орны эрх зүйн тогтолцооны онцлог жинжийг Ром-Германы эрх зүйн аймгийн нийтлэг шинжүүдтэй харьцуулан ярилцана уу.

Эх сурвалж:

1. Амарсанаа Б. Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он.
2. Амарсанаа Ж, Баярсайхан Б, Шажинбат Р. Олон улсын Үндсэн хуулийн оршил. Анхдугаар Үндсэн хуулийн судалгааны эх сурвалж УБ. 2009 он.
3. Отгончимэг Ч. Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он.
4. Осакке К. Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги УБ. 2005 он.
5. Монголулс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2004 он.
6. Харьцуулсан эрх зүйн онол практикийн орчин үеийн асуудал /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2007 он.
7. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо /олон улсын симпозиумын илтгэлүүдийн эмхтгэл/ УБ. 2000 он.
8. Марченко М.Н. Сравнительное правоведение М 2001 г.
9. Саидов А.Х Сравнительное правоведение М. 2007 г.

ДОЛООДУГААР СЭДЭВ: АНГЛИ-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙН АЙМАГ

Англи-Америкийн эрх зүйн аймагт Английн эрх зүйн ач холбогдол

Англи-Америкийн эрх зүйн аймгийн хөгжил XVIII зууныг хүртэлх Английн эрх зүйн түүхээс хамааралтай болох нь нийтээр хүлээн зөвшөөрөгдөөд байна. Английн эрх зүй нь одоогийн Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улс (ИБУИНВУ)-ын нутаг дэвсгэрийг бүхэлд хамардаггүй бөгөөд зөвхөн Англи, Уэлсэд үйлчилж, ИБУИНВУ-ын бүрэлдэхүүн хэсэг болох Шотланд, Умард Ирландад хамааралгүй байдаг.

I. Англи-Америкийн эрх зүйн аймаг үүсэн бий болсон түүх

Английн эрх зүйн түүхийг 1066 оны Нормандын булаан эзлэлтээс Тюдорын үе (1485) буюу Нийтлэг эрх зүй (common law) бүрэлдэн тогтсон үе. Нийтийн эрх зүйн үндсэн хэсэгт жишгийн эрх зүй (прецедент) юм. Мөн Жишгийн эрх зүйгээс гадна шударга ёсны эрх зүй (equity) үүсэн бий болж зэрэгцэн оршиж байсан үе (1485-1832), 1832 оноос өнөөг хүртэлх үе гэж гурван үндсэн үечлэлд хувааж үздэг байна.

1. Англид хааны шүүх хүчирхэгжиж, нийтлэг эрх зүйг бий болгосон үе

Хаан шударга ёсыг бий болгох *Curia Regis* буюу зөвлөлтэй, тэр нь XIII зуунаас бие даасан бүтцүүдийг бий болгож эхэлсэн. Ийнхүү байгуулагдсан шүүх нь хэрэг шийтгэх ажиллагааны журмын хувьд тухайн цагтаа харьцангуй өндөр түвшинд байж, шийдвэрээрээ жишгийн эрх зүйг бий болж эхэлсэн.

Энэ үеийн шүүхийн гол шинжийг илэрхийлье гэвэл хүмүүс шүүхэд хандах эрхтэй биш, харин шүүх тодорхой хүмүүсийн асуудлыг өөрөө хүсвэл шийдвэрлэдэг байжээ. *Writ* буюу шүүхэд хандах зөвшөөрөл гэдэг нь хэн нэгнийг тодорхой зүйл хийхийг болон хийхгүй байхыг зааварласан, төрийн болон бусад эрх бүхий байгууллага, түүнд дотор шүүхээс бичгээр гаргасан шийдвэр гэж тодорхойлсон байдаг. 1227 онд гаргасан жагсаалтад 56 төрлийн шүүхэд хандах зөвшөөрөл, 1832 оны байдлаар 76 төрлийн шүүхэд хандах зөвшөөрөл байжээ.

Writ нь процессын эрх зүйн тодорхой үр дагаврыг агуулдаг байжээ. Процессын ажиллагааны төрөл бүр нь хоорондоо ялгаатай хянан шийтгэх ажиллагааны журамтай байсан учир асуулт тавих, нотлох баримтыг хүлээн авах, шийдвэрийг биелүүлэх ялгаатай журмыг агуулдаг байсан. Хэдийгээр шүүхэд хандах зөвшөөрөл өдгөө Английн эрх зүйд үндсэндээ байхгүй болсон ч түүний хамгийн гол агуулга болох шударга ёсыг олж тогтооход процессын эрх зүй нь материаллаг эрх зүйгээс илүүтэй ач холбогдолтой гэсэн илэрхийлэл Англи-Америкийн эрх зүйн аймагт хамаарах эрх зүйн тогтолцоонд одоо ч нөлөөтэй хэвээр байгаа юм.



2. *Нийтлэг эрх зүйг шинэчлэх шаардлага гарсан нь буюу шударга ёсны эрх зүй бий болсон үе*

Хааны шүүхийн шийдвэрт сэтгэл хангалуун бус үлдэх тохиолдол тухайн үед гарахад талууд эрх ашгаа хамгаалуулах өөр аргыг хайх болсон нь шударга ёсыг илэрхийлэгч хаанд шууд хандах явдал байжээ. Шүүн шийдвэрлэх үүргийг Чанселор хааны болон түүний зөвлөлийн нэрийн өмнөөс гүйцэтгэх болж, хэргийг “шударга ёсны шалгуур”-т үндэслэн шийддэг албан ёсны тогтолцоо бий болж эхэлсэн байна. Ийнхүү Жишгийн эрх зүйн хянан шийтгэх ажиллагааны хэт уян хатан бус байдал зэрэг шалтгаанаас нийтлэг эрх зүйн өрсөлдөгч тогтолцоо болох *Equity* буюу шударга ёсны эрх зүй гарч ирсэн.

3.1832 оноос хойших үе

XVII зууны эхээс нийтлэг болон шударга ёсны эрх зүйн аль нь оршин тогтнох вэ гэдэг асуудал үүссэн боловч харилцан бие биенээ хүлээн зөвшөөрснөөр үндсэндээ дуусгавар болсон гэж үздэг. 1873-1875 оны *Judicature Act*-ын шинэчлэлийн гол үр дүнг нь гурван хэсэгт хуваан авч үзэж болох юм. *Нэгдүгээрт*, бие даасан, өөрийн хянан шийтгэх ажиллагааны журамтай шүүхүүдийг нэг тогтолцоонд багтаахыг эрмэлзсэн. *Хоёрдугаарт*, хоёр ялгаатай эрх зүйг нэгтгэх үйл явцыг эхлүүлсэн. *Гуравдугаарт*, шүүхэд хандах зөвшөөрлийн тогтолцоог халсан байна.

II. Эрх зүйн дотоод бүтэц

A. Эрх зүйн ангилалт ба ойлголт

Англи-Америкийн эрх зүйн аймагт эрх зүйг Ром-Германы эрх зүйн аймгаас ялгаатай байдлаар ангилдаг.

Жишээ 1. Английн эрх зүйд эд хөрөнгийг *personal property* болон *real property* гэж хоёр ангилдаг. 1833 оны шинэчлэлээс өмнө *real actions* гэсэн нэхэмжлэлээр хамгаалагдаж байсан эд хөрөнгийг *real property*, мөн *personal actions*-аар хамгаалагдаж байсан эд хөрөнгийг *personal property* гэдэг байжээ.

Жишээ 2: Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд *action of assumpsit*-ийн үндсэн дээр зөвхөн хохирлыг төлүүлэх шийдвэрийг жишгийн эрх зүй гаргах боломжтой. Харин шударга ёсны эрх зүйн шүүх буюу Чанселорын шүүх нь “тусгай байдлаар үүрэг гүйцэтгэх” (*specific performance*) гэсэн үндэслэлээр гүйцэтгээгүй үүргийг гүйцэтгүүлэх боломжтой.

Жишээ 3: Трастыг үүсгэгч болох шилжүүлэгч нь нэг буюу түүнээс дээш итгэмжлэгдэгчид тодорхой хэмжээний хөрөнгийг хариуцуулан өгдөг байна. Гэхдээ трастыг үүсгэгч нь итгэмжлэгдэгчид хөрөнгө хүлээлгэн өгөхдөө гуравдагч этгээдийн тусын тулд гэсэн нөхцөлийг гол болгодог. Трастыг зарим онцлог шинжээр нь тайлбарлая.

- Итгэмжлэгдэгч нь төлөөлөгч буюу хөрөнгийг эзэмшиж байгаа этгээд гэхээс илүү тухайн итгэмжлэгдэн өгсөн хөрөнгийн өөрийн хүсэл зоригоор хөрөнгийг худалдах, бэлэглэх, шагнах эрхтэй өмчлөгч болдог. Гэхдээ түүний өмчлөх эрх ёс суртахууны хэм хэмжээгээр хязгаарлагдаж, өмчлөх туйлын эрхтэй бус эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх нь хязгаарлагдсан байдаг.

- Итгэмжлэгдэгчийн аль нэг нь нас барах буюу татан буугдах тохиолдолд түүний эрхийг залгамжлах гэсэн ойлголт байдаггүй.

Б. Хэрэг хянан шийтгэх эрх зүйн ач холбогдол

Англи-Америкийн эрх зүйн аймаг нь хэрэг хянан шийтгэх ажиллагаа, нотлох баримт, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг нэгтгэн нэрлэдэг хэрэг хянан шийтгэх эрх зүйд (*formelles Recht*) ихээхэн ач холбогдол өгдөг ба хянан шийтгэх ажиллагааны хатуу чанд журмыг баримтлах нь шийдвэрийг зөв гаргахад маш чухал үүрэгтэй гэж үздэг байна.

Тухайлбал, Английн давж заалдах шатны шүүх нь доод шатны шүүх, захиргааны байгууллага, арбитрын шийдвэрийг хянахдаа шийдвэр нь шударга ёсыг хангаж байна уу гэхээсээ өмнө шаардлагатай бүх талуудыг сонссон эсэх, хянан шийтгэх ажиллагаа явагдсан журам нь шударга болсон эсэхийг харгалздаг байна.

В. Эрх зүйн хэм хэмжээний мөн чанар

Эрх зүйн хэм хэмжээ ба эрх зүйн зарчим. Эрх зүйн хэм хэмжээ нь эрх зүйг илэрхийлэгчийнхээ хувьд суурь ойлголтод багтдаг. Гэтэл Англи-Америкийн эрх зүйн аймагт эрх зүйн хэм хэмжээг илэрхийлэх арга, томъёолол нь Ром-Германыхаас илт ялгардаг.

Ром-Германы эрх зүйн аймгийн хувьд урьдаас тогтоосон эрх зүйн хэм хэмжээний хүрээнд, түүнийг тайлбарлаж хэрэг, маргааныг шийдвэрлэдэг бол Англи-Америкийн эрх зүйн хувьд эрх зүйн хувьд шинээр гарч ирсэн тохиолдлыг шийдвэрлэх шинэ, ялгаатай эрх зүйн хэм хэмжээг бүтээх байдлаар хэрэг маргааныг шийдвэрлэдэг онцлогтой.

Иймээс Ром-Германы эрх зүйн аймагт хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь тодорхой нэг хэрэг маргаанд заавал чиглэхгүйгээр “онолын түвшин”-д тухайн хэм хэмжээ хэрэглэгдэх боломжтойгоор хууль тогтоогчоос ерөнхийлөн бүтээн бий болгосон хэм хэмжээ байж, Англи-Америкийн эрх зүйн аймагт хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь тухайн тохиолдолд илүүтэй чиглэсэн хэм хэмжээ байдаг. “Англи хүний нүдээр Францын эрх зүйн хэм хэмжээ нь эрх зүйн зарчим мэт байдаг бол Английн эрх зүйн хэм хэмжээ нь Францын хуульчдад хэрэг, маргаан бүрээр тодорхойлогдох, системчлэлийн хувьд хангалттай бус томъёололтой мэт харагддаг. (Рене Давид)



Жишээ 1. Хэлцэл хийх саналыг хэзээ хүлээн авсанд тооцох вэ? Ром-Германы эрх зүйн аймагт хамаарах хуульчид үүнд хариулахдаа хүлээн авснаар уу (*theory of emission*) эсвэл саналыг явуулснаар тооцох уу (*theory of reception*) гэсэн томъёоллоор ханддаг. Гэтэл энэ нь Англи-Америкийн эрх зүйн аймагт хамаарах хуульчдад хэтерөнхий байдлаар тавьсан асуулт учраас асуудлыг шийдвэрлэхгүй, харин энэ нь зарчмын тухай асуудал байна гэж ойлгогддог. Өөрөөр хэлбэл, нийтлэг эрх зүй нь тодорхой тохиолдол бүрээр хэлцэл хэзээ, хаана байгуулсан, биечлэн байгуулсан уу, тодорхой хэрэгслийг ашиглан байгуулсан уу гэх мэт тохиолдол бүрээр задалсан өөр өөр хэм хэмжээ хэрэглэгдэнэ гэж үздэг.

Жишээ 2. Монгол Улсын Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд аж ахуй эрхлэгч нь өрсөлдөгчийнхөө эсрэг шударга бус үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай заасан байдаг. Энэ хуулийн 6.1.11-д “гэрээний зүйлд хамаарахгүй болон гэрээт талд ашиггүй нөхцөлийг гэрээнд тусгахыг тулган шаардах” гэсэн заалт нь шүүхээс ямар тохиолдлууд энд хамаарахыг тогтоох ёстой болгож байгаа юм. Энэ нь жишгийн эрх зүйн хуульчдад тунхаглалын шинжтэй гэж ойлгогддог бөгөөд үүнийг шүүх хэрхэн ойлгож байгаагаас шинэ эрх зүйн хэм хэмжээг бий болдог гэж үздэг байна. Энэ утгаараа английн эрх зүйн хэм хэмжээг тодорхой хэрэг маргааны тохиолдлоос ялгаж ойлгох боломжгүй юм.

Шүүгчид олгож буй эрх зүйн хэм хэмжээний чөлөөт байдал. Англи-Америкийн эрх зүй нь тухайн тохиолдол бүрийг шийдвэрлэх нарийвчилсан эрх зүйн хэм хэмжээг агуулж байдгаараа шүүгчид харьцангуйгаар чөлөөт байдлыг олгодоггүй, олон тооны эрх зүйн хэм хэмжээний “торонд” шүүгчийг барьдаг гэж үзэх нь бий.

Харин Ром-Германы эрх зүйн аймагт эрх зүйг тодорхой хэдэн зарчмаар илэрхийлж, амьдралын тодорхой бодит баримтуудтай “хутгалдах” ёсгүй гэж үздэг. Энэ утгаараа Ром-Германы эрх зүйн аймаг дахь эрх зүйн хэм хэмжээ нь шүүгчид зарим тохиолдолд хэт их чөлөөт байдлыг олгодог гэж хэлж болох юм. Ром-Германы эрх зүйн аймагт хамаарах хэм хэмжээ нь шүүгчийг асуудал шийдвэрлэх хүрээ хязгаарыг зааж өгөөд, тухайн зааж өгсөн хүрээ хязгаар дотор нь өөрийн итгэл үнэмшлээр асуудлыг шийдвэрлэх ёстой гэсэн байдлаар томъёологдож байгаа юм.

Ш. Эрх зүйн эх сурвалж

Эрх зүйн эх сурвалжийн хувьд Англи-Америкийн эрх зүйн аймагт хамаарах нийтлэг болон ялгаатай шинжүүд бий. Тухайлбал, Үндсэн хуультай эсэх, муж улсын хууль гэх мэт зүйлээр эрх зүйн эх сурвалжийн хувьд тухайн аймаг дотроо ялгардаг. Нийтлэг шинжийн хувьд хууль, жишиг, заншлын хэм хэмжээ, эрх зүйн бүтээл нь эрх зүйн эх сурвалжид хамаарч байна.

Хууль буюу парламентын шийдвэр

Парламентаас батлагддаг хууль нь шүүгч хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэдэг эрх зүйн хэм хэмжээ байдаг. Хууль буюу ард түмний төлөөлөл болсон парламентын акт нь уламжлалт ойлголтоор шүүгчийн бүтээсэн, бий болгосон эрх зүйн хэм хэмжээг засан сайжруулах, илүү нарийвчлах байдлаар эрх зүйн тогтолцоог нөхөх, гүйцээх гэдэг утгаар ойлгогдож ирсэн.

Шүүхийн шийдвэр буюу жишиг

Англи-Америкийн шүүх нь өөрийн гаргасан шийдвэр буюу бүтээсэн хэм хэмжээг заавал дагаж мөрдөх журамтай, Улсын дээд шүүхээс бүтээсэн хэм хэмжээ нь Английн шүүхийн тогтолцоонд хамаардаг бүх шүүхэд хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ дагаж мөрдөх хэм хэмжээ болдог бол, түүний доод шатны шүүх буюу Давж заалдах шүүх нь Лордын танхимаас бусад бүх шатны шүүхүүдэд дагаж мөрдөх хэм хэмжээг бүтээдэг. Мөн Дээд шатны шүүх нь дээрх хоёр шүүхээс бусад бүх шүүхэд өөрийн бүтээсэн хэм хэмжээг дагаж мөрдөхийг шаарддаг байна.

Шүүхийн хувьд бүтээсэн хэм хэмжээ нь зөрчилдөх тохиолдолд босоо тогтолцооны дээд шатанд оршиж буй шүүхийн бий болгосон хэм хэмжээгээр асуудлыг шийдвэрлэнэ гэсэн үг юм. Нөгөө талаас өмнө дурьдсан ёсоор энэ гурван шүүхийн хувьд дээд шатны шүүхийн бүтээсэн хэм хэмжээг өөрчилсөн, ялгаатай хэм хэмжээ тогтоох боломж бийг анхаарах ёстой юм.

Шүүгч өөрийн шийдвэрийг тайлбарласан үндэслэлийг *ratio decidendi*, *obiter dictum* гэсэн хоёр хэсэгт хуваан ойлгож болох юм. Шийдвэрийн *ratio decidendi* нь шүүгчийн бүтээсэн хэм хэмжээг бүрдүүлдэг бөгөөд энэ утгаараа Английн эрх зүйн хэсэг болж ирээдүйд шийдвэрлэгдэх хэргүүдэд хэрэглэгддэг байна. Түүнээс гадна шүүгч нь хэргийг шийдвэрлэхэд заавал шаардлагагүй элементүүдийг итгэл үнэмшил төрүүлэх зорилгоор дурдсан саналыг *obiter dictum* гэдэг бөгөөд энэ нь дараа шийдвэрлэгдэх хэргүүдэд заавал дагаж мөрдөх хэм хэмжээ болдоггүй байна.

Тухайн хэргийг шийдвэрлэн эрх зүйн хэм хэмжээ бүтээж буй шүүгч нь *ratio decidendi*-г тодорхойлдоггүй бөгөөд харин төсөөтэй хэргийг дараа шийдвэрлэж буй шүүгч нь өмнөх шүүгчийн шийдвэрлэн эрх зүйг бүтээсэн хэм хэмжээ нь тухайн тохиолдолд хэрэглэгдэх үү, үгүй юу гэдгийг тодорхойлон өөрийн өмнө буй хэргийг шийдвэрлэдэг байна. Ийнхүү нийтлэг эрх зүйд хэн нэгэн дээрээс тогтоосон этгээд аль шийдвэр жишиг, аль хэсэг нь *ratio decidendi* байх вэ гэдгийг төвлөрсөн байдлаар тогтоодоггүй.

Заншлын хэм хэмжээ

Заншлын эрх зүйн тогтолцоонд гүйцэтгэх үүрэг нь жишиг болон хуулийг бодвол бага байдаг. Шүүхээс түүнийг заншил болохыг хүлээн зөвшөөрсөн, шийдвэрийнхээ үндэслэл болгосон үед л энэ нь заншил болж, дагаж мөрдөх шинжийг агуулдаг.



Эрх зүйн бүтээл

Англи-Америкийн эрх зүйн аймагт хамаарах эрх зүйн тогтолцоонд нэр хүнд бүхий хүмүүсийн бүтээлийг шүүх ишлэн шийдвэр гаргах тохиолдол байдаг. Энэ нь голдуу өмнө дурдсан эх сурвалжийг ишлэх боломжгүй үед тухайн эрх зүйн хэм хэмжээ байсан эсэхийг батлах зорилгоор үндэслэл болгодог гэсэн байдаг. Тухайлбал, *Glanvill, Bracton, Littleton, Coke* нарын бүтээлийг шүүгчид өргөнөөр иш татдаг практик байдгаараа Ром-Германы эрх зүйн аймгийн зарим орнуудаас Англи-Америкийн эрх зүйн аймаг ялгагддаг.

Хяналтын асуулт

1. Англи-Америкийн эрх зүйн аймгийн хөгжилд Английн эрх зүй хэрхэн нөлөөлснийг ярилцах
2. Эрх зүйг Англи-Америкийн эрх зүйн аймагт хэрхэн ангилдаг дэлгэрэнгүй жагсаалт гаргаж, ярилцах
3. Эрх зүйн хэм хэмжээ ба эрх зүйн зарчмын томъёоллын ялгааг эрх зүйн аймаг бүр дээр харьцуулан үзэх, үр дагаврыг үнэлж цэгнэх
4. Англи-Америкийн эрх зүйн аймаг болон Ром-Германы эрх зүйн аймаг дахь парламентын шийдвэр болох хуулийн хүлээн зөвшөөрөгдөх шинжийн ялгааг түүхэн талаас нь задлан шинжлэх.
5. Шүүхийн шийдвэр дэх *ratio decidendi, obiter dictum*-ын агуулгыг тайлбарлах, эрх зүйн үр дагаврыг шинжлэн ялгах.
6. Англи болон Америкийн эрх зүйн нийтлэг бус, ялгарах шинжийг задлан шинжлэх.

Эх сурвалж

1. Penny Darbyshire, *Eddey and Darbyshire on the English Legal system*, Sweet and Maxwell, 7th ed., 2001
2. Terence Ingman, *English Legal Process*, Oxford University Press, 9th ed., 2002
3. S.H. Bailey etc., *Smith, Bailey and Gunn on the Modern English Legalsystem*, Sweet and Maxwell, 4th ed., 2002
4. *English Private Law, Vol. I*, ed. Peter Birks QC FBA, Oxford University Press, 2000
5. Richard L. Abel, *Legal profession in England and Wales*, Blackwell, 1988
6. M. Partington, *Introduction to the English Legal System*, 2nd ed., Oxford University Press, 2003 (2000)
7. G. Slapper, D. Kelly, *The English Legal System*, 6th ed., Cavendish Publishing Limited, 2003 (1994)
8. Richard Ward, *Walker & Walker's English Legal system*, Butterworths, 8th ed., 1998
9. Margaret Z. Johns, Rex R. Perschbacher, *The United States Legal System*, Carolina Academic Press, 2002

10. William Burnham, Introduction to the Law and Legal system of the United States, 3rd ed., West group, 2002
11. Introduction to the law of the United States, ed. David S. Clark etc., 2nd ed., Kluwer Law International, 2002
12. S. A. Riesenfeld and W. J. Pakter, Comparative law casebook, Transnational publishers, Inc., 2001

НАЙМДУГААР СЭДЭВ: РОМ-ГЕРМАНЫ ЭРХ ЗҮЙН БОЛОН АНГЛИ-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙГ ОЙРТУУЛАХ

Нэр томъёо

- Ойртуулах (конвергенци)
- Хөрвүүлэх (рецепци)
- Шилжүүлэх (трансплантаци)
- Жигдрүүлэх (сближение)
- Ижилтгэх (унификаци)
- Уялдуулах (гармонизаци)
- Нэгтгэх (интеграци)

Ром-Германы болон Англи-Америкийн эрх зүйн нийтлэг ба онцлог

Нийтлэг тал

- Эрх зүйн суурь ижил: зах зээлийн (өрсөлдөөний) эдийн засаг; нийгэм-улс төрийн байгуулал; үзэл суртал, соёлын үндэс
- Барууны иргэншил
- Эрх зүйн соёл
- Эрх зүйн тогтолцоо нь нэгдмэл биш боловч адил төстэй, нийтлэг зүйлтэй.

Ялгаатай тал

- Зөвхөн Ром-Германы эрх зүйг нийтийн эрх зүй, хувийн эрх зүй гэж ангилдаг.
- Ром-Германы эрх зүй илүү хуульчлагдсан байдаг.
- Англи-Америкийн эрх зүйтэй жишвэл Ром-Германы эрх зүй илүү онолын шинжтэй.

Англи-Америкийн болон Ром-Германы эрх зүйг харилцан хатааралд нөлөөлж буй хүчин зүйл

- Ойртуулах эдийн засаг, нийгэм, улс төрийн ижил бүтэц, төрийн механизм, эрх зүйн соёлын ижил байдал.
- Саад болох хүчин зүйл нь түүхэн ба үндэсний уламжлал, эрх зүйн институт, төрийн байгууллагуудын зарим ялгаа



- Европын холбооны үйл ажиллагааны дэмжлэгээр эрх зүйг Европчлох хандлага нэмэгдэж буй байдал нь Англи-Америкийн эрх зүйд нөлөөлж байна.
- Америкийн эрх зүйг Европын эх газрын эрх зүйд буулгах: америкчлах буюу хөрвүүлэх (рецепци) үйл явц нь эрх зүйн хоёр аймаг ойртоход нөлөөлж байна.

Ойртуулах арга зам

- Эх сурвалжийг уялдуулах (хууль, шүүхийн жишиг, заншил, олон улсын гэрээ, эрх зүйн нийтлэг зарчим, эрх зүйн номлол).
- Эрх зүйн хэм хэмжээ тогтоох, эрх зүйг хэрэглэх, эрх зүйг тайлбарлах ажлыг жигдрүүлэх.

Хяналтын асуулт:

1. Эрх зүйг ойртуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлно уу.
2. Эрх зүйг ойртуулах зайлшгүй харгалзан үзвэл зохих хүчин зүйлсийг нэрлэж, үндэслэлийг тайлбарлана уу.
3. Эрх зүйг ойртуулах шинжлэх ухаан-танин мэдэхүйн болон практик-хэрэглээний чиг үүргийг тодорхойлно уу.
4. Ром-Германы ба Англи-Америкийн эрх зүйн харилцан нөлөөллийг тодорхой жишээгээр тайлбарлана уу.
5. Эх газрын эрх зүйд шүүхийн жишгийг нэвтрүүлэх шаардлага нэмэгдэх болсон, Англи-Америкийн эрх зүйд хуулийг олноор нь гаргах, тэдгээрийг шүүхийн жишигтэй уялдуулах, хослуулах эрмэлзлэл нэмэгдэж байгаа зүй тогтлыг харьцуулсан эрх зүйн үүднээс тайлбарлана уу.
6. Эрх зүйн зөрчилдөөн, алдаа, хийдлийг зөв таньж илрүүлэх, тэдгээрийг даван туулахад харьцуулсан эрх зүйн судалгааны үр дүнг харгалзан хийсэн ойртуулах ажлын ач холбогдлыг үндэсний эрх зүйн тогтолцооны хүрээнд тодорхой жишээгээр тайлбарлана уу.
7. “Өдгөө эрх зүйн аймгуудын зааг ялгаа тодрох бус, харин улам бүр ижилсэн ойртох хандлага давамгайлах шинжтэй болж байна” гэдэгтэй та санал нийлэх үү?
8. “Европын эрх зүй ба эрх зүйг ойртуулах” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулна уу.

Эх сурвалж

1. Амарсанаа Б., Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он.
2. Амарсанаа Ж, Баярсайхан Б, Шажинбат Р., Олон улсын Үндсэн хуулийн оршил. Анхдугаар Үндсэн хуулийн судалгааны эх сурвалж УБ. 2009 он.

3. Отгончимэг Н., Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он.
4. Осакке К., Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги УБ. 2005 он.
5. Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2004 он.
6. Харьцуулсан эрх зүйн онол практикийн орчин үеийн асуудал /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2007 он.
7. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо /олон улсын симпозиумын илтгэлүүдийн эмхтгэл/ УБ. 2000 он.
8. Марченко М.Н. Сравнительное правоведение М 2001 г.
9. Саидов А.Х. Сравнительное правоведение М. 2007 г.

ЕСДҮГЭЭР СЭДЭВ: ХИНДҮ ЭРХ ЗҮЙ

Хиндү эрх зүйн ойлголт

Эрх зүйн зохицуулалтын гол эх сурвалж нь шашины үзэл баримтлал хэм хэмжээнүүд болно. Хиндү шашин өнөөдөр дэлхий даяар тархсан гуравдагч шашин, түүнийг Дорнод болон Өрнөдөд нэг тэрбум шахам хүн баримталж байна.

Хиндү шашины язгуур үндэс нь Инд мөрний хөндий дэх Харапын соёл иргэншлээс үүдэлтэй. Энэхүү өндөр хөгжсөн, хотжсон соёл иргэншил НТӨ 2-3 дахь мянган жилийн тэртээ өнөөгийн Пакистаны нутаг дэвсгэр дээр цэцэглэж байв. Харапын шашины тухай тодорхой зүйл бага хэдий ч, үлдэж хоцорсон хэвлэлийн мэдээллийн дагуу дагина бурхан, Шивагийн эвэрт өвөг дээдэст мөргөн шүтдэг байсан талаар нотлон харуулдаг. Модод болон амьтдыг дүрсэлдэг нь бас л шашины ач холбогдолтой юм.

Брахманизм нь энэтхэгийн шашины эртний хэлбэр агаад үндэс язгуураараа НТӨ 2000 жилийн тэртээ Энэтхэгт Төв Азийн нүүдэлчдээс оржирсэн, аричуудын Ведийн шашинтай холбогддог. Аричуудын соёлыг олон тооны ёслол, санскрит бичиг үсгийн ашиглалт, Брахманыг болон Индра, Агни, Вайя зэрэг бурхдыг хүндлэн дээдэлдэг байснаар тодорхойлдог.

Хиндү эрх зүй 2000 гаруй жилийн тэртээ Энэтхэгт бүрэлдэн тогтсон ба өнөө үед Энэтхэгчүүдээс гаралтай орнуудад түгэн тархжээ.



Хиндүизм зүүн өмнөд Азид дэлгэрсэн байдал

Гол онцлог нь шашны зан заншлын хэм хэмжээгээр ихэвчлэн гэр бүл өв залгамжлан болон нийгмийн гишүүдийн нийгэмд эзлэх байр, эдлэх эрх (кастын систем) зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулдаг

Хиндү эрх зүйд шашны нөлөөний эмгэнэлтэй хийгээд өвөрмөц үзэгдэл болох полигами гэр бүлийн хэв маяг, нялхсын амийг хөнөөх, хүүхдийг багад нь гэрлүүлэх, кастаар ялгаварлах, гэрлэлтийн инж төлөх, бэлэвсэн эхнэрүүдийг шатаан алах зэрэг зан үйлүүд Энэтхэг оронд асар ихээр хийгддэг байсан бөгөөд одоо ч зарим нэг зан үйл нийгмийн гүнд оршсоор байгаа юм.

Энэ нь хэдий тухайн орны соёл зан заншлын нэг хэсэг хэдий ч хэт хатуу чанд дэглэм юм.

Хиндү эрх зүйн хөгжил хувьслын үе шатыг дараах байдлаар томъёолсон байдаг.



Хиндү эрх зүйн эх сурвалж

Сонгодог Хиндү эрх зүйн тогтолцооны үед нийгмийн харилцааг Брахманууд буюу лам нар, Кшатры буюу дайчид, Вайшя худалдаачид, Шудры буюу ажилчид, тариачид, Пурушу нар нь бурхны хөлнөөс гарсан гэсэн домогтой учраас дээрх 3 кастад үйлчлэх ёстой дорд гаралтай жирийн хүмүүс гэсэн агуулгатай кастын системээр зохицуулж байсан.

- Сонгодог Хиндү эрх зүйн үед тухайн харилцааг зохицуулж байсан дараах эх сурвалжууд голлох нөлөөг үзүүлж байжээ.

зан заншил

шашны сургаал / шрути, смрути /

Гэхдээ энэхүү зан заншил нь гол төлөв эмэгтэйчүүдийн эрх, гэрлэлт, гэр бүлийн харилцааны асуудал дээр хүчтэй нөлөөг үзүүлж байсан.

Хиндү шашны ариун гэгээн бичвэрүүд ариун хэл болох санскрит дээр бичигдсэн байдаг. Тэрээр шрути, смрути гэсэн хоёр хэлбэртэй.

ШРУТИ

Шрути нь санскритээс орчуулбал “сонссон зүйл” гэх бөгөөд бурханаас мэдлэг болон мөнхийн үнэнийг хэнд дамжуулсан, тэр хүн бичдэг.

Тийм маягаар бичигдсэн бичвэрүүд Веда (санскритээс орчуулбал “мэдлэг”) хэмээх ерөнхий нэрээр алдартай, золиосын хэлбрүүд, ариун тарниуд, сүлд дуунуудыг багтаадаг

СМРУТИ

Смрути нь санскритээс орчуулбал “тогтоосон зүйл” гэх бөгөөд бичвэрүүд үеэс үед дамжин тархдаг. Тэдгээр нь “Махабхарата”, “Рамаяна” зэрэг баатарлаг найраглалууд, хууль тогтоомжийн бичвэрүүд, домог үлгэрүүдийг багтаадаг.

НТӨ 500-аад жилийн үеэс Хиндү хууль ёсоор дараах нийтлэг хэм хэмжээг бий болгосон байна.

Охины сарын тэмдэг үзэгдэхээс өмнө охиноо гэрлүүлэхгүй байх нь эцэг хүний хувьд нүгэл хийж байгаад тооцогдож байв.

Брахман, Кшатры, Вайшя кастад хамаарах эрэгтэй хүүхдүүд шашны боловсрол эзэмшихээр сургуульд явах төдийгүй сургуулиа төгссөний дараа гэрлэх ёстой.

III, IV зууны үеэс сати буюу эр нөхөр нь нас барсан тохиолдолд бэлэвсэн эмэгтэй өөрийн хүслээр ууланд очиж нөхрийн цогцостой хамт шатаагдах эсвэл бүх насаараа даяанч, ганцаар амьдрах ёстой болж энэ нь хууль болсон.


Олон зууныг дамжин үйлчилсээр байгаа бас нэгэн заншил бол инж төлөх Даурын систем юм. Сайн сургуулийг сайн төгсөж чадсан залуу хүн бол хамгийн сайхан хүргэн болох бөгөөд хамгийн үнэд хүрдэг.

Португал, Голланд, Франц, Англи зэрэг европын хэд хэдэн орон Энэтхэгтэй худалдаа наймаа хийх сонирхолтой болж тархай бутархай жижиг улсуудыг 1500-гаад оны үеэс булаан эзэлж өөрийн колони тогтоохын төлөө тэмцэж эхэлснээс Англи хамгийн хүчтэй нь байж Энэтхэг улсыг өөрийн колони улс болгож чадсан байна.



Энэ үеэс буюу 1772 оноос 1947 хүртэл Английн нөлөөний Хиндү эрх зүй үйлчилж байжээ.

Англичууд шашны зан үйл болон олон зуун жил тогтон ирсэн уламжлалт зан үйлүүдийг ихээхэн эсэргүүцэж байсан бөгөөд Английн засгийн газар энэ явдлыг зогсоохдоо нэлээдгүй эргэлзэж байсан боловч энэтхэгчүүдийн эсэргүүцлийн хөдөлгөөнийг үндэслэн 1829 онд Английн гүн Бентинск тус заншлыг зогсоох шийдвэрийг гаргасан байна.



1909 он. Английн колони байсан Энэтхэгийн шашин шүтлэг

Уг шийдвэр нь Энэтхэг оронд олон зууныг дамжиж ирсэн бэлэвсэн эхнэрүүдийг шатаах үйл, полигами гэр бүлийн зан заншлыг эсэргүүцэн хориглосон шийдвэр байв. Тус бэлэвсэн эхнэрүүдийг шатаах, хүзүү мушгин алах зан үйлийг хориглосноос хойш нялх эмэгтэй хүүхдийг алах, хүнээр тахил өргөх зэрэг шашны зан үйлийн эсрэг хөдөлгөөнүүд эхэлсэн байна.


1856 онд Энэтхэгийн засгийн газар бэлэвсэн эмэгтэйчүүд дахин гэрлэж болох талаарх Актыг хуульчилснаар шашны сургаал, зан заншилд нийлээдгүй өөрчлөлт гарч Английн жишгийн эрх зүй шүүхийн тогтолцоог нэвтрүүлэх хандлага бий болсон юм. Энэ нь нөгөө талаас Христын шашны нөлөөлөл иргэдийн дунд газар авч тодорхой хөдөлгөөн бүлгэмүүдийг байгуулж байсантай холбоотой.

Англи боловсрол эзэмшсэн зарим хүмүүс тус ёс заншлын сүүдэртэй талыг хүмүүст таниулах, эсэргүүцэх явдал мэр сэр гарч байв. Үүний нэгэн жишээ нь

1912 оны 11 дүгээр сард Бомбей хотноо Арья нийгэмлэгийн гишүүд, нийгмийг шинэчлэгч зарим хүмүүс 150 эрэгтэй, эмэгтэй хүний оролцоотой оройн зоог барих ажлыг зохион байгуулсан бөгөөд ихэнх нь Энэтхэгийн баруун нутгаас ирсэн хүмүүс байв. Энэ хүмүүсийг гэртээ харихад нь аль хэдийнэ кастаас нь, гэр бүлээс нь хөөсөн байжээ.

XX зууны эхээр энэтхэгчүүд тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж эхэлсэн ба Махатма Гандигийн удирдсан хөдөлгөөн 1947 оны 8 сарын 15-нд ялалт байгуулж энэтхэг улс бүрэн эрхт тусгаар тогтнолоо олж авсан бөгөөд колонийг тавих хуулийн дагуу энэтхэг нь шашны үзэл суртлаараа Энэтхэг ба Пакистан гэсэн 2 хэсэгт хуваагдсан юм. Энэ үеэс эхлэн орчин үеийн Хиндү эрх зүйн үндэс тавигдсан байна.

Энэтхэгт нийтлэг болон хиндү гэсэн хоёр эрх зүй зэрэгцэн оршиж байгаа бөгөөд хиндү эрх зүй дээр дурьдсан цөөхөн харилцаанд л хэрэглэгддэг.



Анхны Үндсэн хууль 1950 онд батласантай холбоотойгоор 1955 онд Хиндү гэрлэлтийн тухай акт, 1956 онд Хиндү хүүхэд үрчлэлт ба харгалзан дэмжих тухай акт мөн Хиндү өв залгамлалын тухай акт, Хиндү насанд хүрээгүй хүүхэд ба түүнийг асран хамгаалах тухай актыг батлан гаргажээ.

Хяналтын асуулт:

1. Хиндү шашны эрх зүйн сэтгэлгээнд нөлөөлсөн нөлөөллийн талаар ярилцана уу.
2. Сонгодог Хиндү эрх зүйн онцлог шинжийг тоочно уу.
3. Их Британы колони байх үеийн Энэтхэгийн эрх зүйн тогтолцооны өөрчлөлт, сонгодог Хиндү эрх зүйн хувьслын талаар жишээ гарган тайлбарлана уу?
4. Орчин үеийн Хиндү эрх зүйн эх сурвалж, түүний онцлогийн талаар багаар ярилцлага зохион байгуулна уу.
5. Энэтхэгийн Үндсэн хуулийн онцлог, батлах болсон хэрэгцээ шаардлагын талаар ярилцана уу?
6. Энэтхэг улс нь яагаад нийтлэг эрх зүйн тогтолцоо давамгайлсан талаар багийн түвшинд дүгнэлт хийнэ үү?

Эх сурвалж:

1. Осакве Кристофер., “Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги бүдүүвч” УБ., 2005. 26-29 дэх тал




2. А.Х.Сайдов. Сравнительное правоведение. М. 2007. Стр- 402- 405
3. Cases;
 - Bishundeo v. Seogani Rai, AIR 1951 SC 280.
 - Harprasad v. Sheo Dayal, (1876) 3 IA 259.
 - Krishna Singh v. Mathura Ahir, (1981) 3 SCC 689
 - Pudiava v. Pavanasa, ILR (1922) 45 Mad 949 (FB).
4. Diwan,P., Modern Hindu Law, 17th Ed., Allahabad Law Agency, 2006
5. Gandhi, B.M, Hindu Law, 2nd Ed., Eastern Book Company, 2003
6. Gaur, A., Commentaries on Hindu Law, 1st ed., Dwivedi and Company, 2007.
7. Sharma, Dr.B.K, Hindu Law, 1st Ed., Central Law Publishers, 2007.
8. <http://www.lawisgreek.com/category/personal-law/hindu>
9. http://books.google.mn/books/about/Hindu_Law.html?id=DfdnQgAACAAJ&redir_
10. <http://www.ixmedeh.top.mn>
11. <http://www.wisegeek.com/what-is-hindu-law.htm>

АРАВДУГААР СЭДЭВ: ЛАЛЫН ЭРХ ЗҮЙ

Лалын эрх зүйн ойлголт

Лалын эрх зүй нь НТ VII-X бүрэлдэн тогтсон гэж үздэг ба Лалын шашны үүслийг Арабын хагас хойг, арлын баруун хэсэгт, одоогийн Саудын Араб улсын нутаг дэвсгэрийн баруун хэсэгт тухайн үеийн Араб угсаатны нэг болох Кушейшит овгийхны дотор үүссэн гэж үздэг. Лалын ертөнцөд энэ шашны үүссэн цаг хугацааг албан ёсоор 622 он ба Лалын он тоолол ч энэ оноос эхэлдэг.

Одоо мусульманчууд дэлхийд шашны нийгэмлэгийнхээ тоогоор христчүүдийн дараа хоёрдугаарт бичигддэг байна. Ихэнх мусульманчууд Ази, Хойд Африкт амьдарч байгаа ба ХХ зуунд тэд Америк, Европт ч тархжээ. Лалын шашин нь олон урсгал, дадлуудтай хэдий ч бүх мусульманчууд Мухамедийг өөрсдийн зөнчөө гэж үздэг.



Шийтийн үзлийн гол агуулга нь төрийн эрх мэдлийг имамаат буюу шашин төрийг хослон барих нь суннагийн үзлийнх шиг сонгогдох эсвэл тохоон томилогдох биш, бурханы хүсэл зориг, тааллаар үе удам дамжин уламжлагдах ёстой хэмээн номолдог. Шийтийн ёс Иран, Иракт зонхилж мөн Ливан, Йемен, Бахрейны хүн амын багагүй хэсэг баримталж байна. Шийтийг эсэргүүцэн суннизм үүссэн бөгөөд Лалын дийлэнх орон энэ чиглэлийг баримтладаг.

Лалын эрх зүйн тогтолцооны үндсэн эх сурвалж бол уг шашны гол хөлгөн судар Коран мөн.

Кораны одоогийн бичлэг, уншлага нь VII зууны үед Османы хаанчлалын үед бичиглэн ном болсон ба үүнээс өөр хувилбарыг хууль бус гэж үздэг. Энэ судрын нэг ч үг тэмдэгт өөрчлөгдөөгүй өнөөг хүрч хүчин төгөлдөр үйлчилсэн хэвээр байна. Мусульманчуудын хувьд Коран сударт Бурхнаас Мухамедэд далдыг мэдэхүйн нүдийг нь нээсэн тухай өгүүлнэ. Коран судрын эхний сура, буюу “Нээгч” бүлэг дараах байдлаар орчуулагддаг.



Энэрэлт Алладын төлөө,
Энэрэнгүй Аллах таныг магтъя
Элбэрэл энэрэлт ертөнцийн Эзэн,
Эргэцүүлэгч Шүүхийн эзэн чамд бид мөргье

Шигтгээ

Коран судар 114 сура буюу бүлэг, янз бүрийн шүлгүүдээс (аятууд) тогтдог. Хамгийн богино бүлэг нь хоёр шүлгээс, хамгийн том нь 286 шүлгээс бүрддэг.

Аль-Фатиха"-гийн дараачийн бүлгүүд хамгийн уртаас хамгийн богино хүртэл хэлжээгээрээ дараалдаг. 96 бүлгийг нь Мухамедын анхны далдыг тэдсэн зүйл хэмээн үздэг: түүний эхэнд нь “чангаар унших” гэж заасан байдаг. Бүхий л бүлгүүд нь “бистилла” буюу “Энэрэлт Алладын төлөө!” гэсэн үгээр эхлэдэг. Мусульманчууд энэ шүлгийг ятар нэгэн чухал үйлдлийн өтнө уншдаг. Коран судрыг бичиж буулгах, тодорхой дэс дараалалд оруулах ажлыг Мухамедын нас барсны нэг жилийн дараа, анхны халиф Абу Бакрын төр барих үед эхлэн бүлэг бүрт нэр оноожээ

Коран судрын агуулга маргаантай, эсвэл орчуулга нь өөр үгээр илэрхийлэгдсэн гэх боломжгүй. Түүнийг утга зохиолын ямар нэгэн шинжилгээний үүднээс өөрчилж эс болно. Кораны орчуулгууд байдаг хэдий ч, тэдгээр нь бүхий л ёслол, мөргөлийн үеэр сэргээн давтагддаг учир араб хэл дээр эхийн утгыг өөрчилж чадахгүй гэж үздэг байна.

Нийгмийн харилцаа өөрчлөгдөхийн хэрээр Коран судраар хэрхэн зохицуулах талаар нарийн төвөгтэй асуудлууд дурган гарч ирсэн. Энэ зөрчлийг Коран судрыг өөрчлөхгүйгээр түүний утга агуулгад тайлбар хийх Тафсирыг бий болгожээ.



ШАРИАТ

Лалын шашны үүсэл, хувьслын явцад мусульманчуудын үйл ажиллагаа, аж төрөх ёс, зан байдал, ёс суртахууныг зохицуулах эрх зүйн хэм хэмжээш тусгасан Шариат буюу Лалын шашны эрх зүйн үндсэн хэм хэмжээ XI-XII зууны үед боловсруулан бүрэлдэн бий болсон.

Шариат нь хууль, эрх зүйн хэм хэмжээг тогтоож, иш татахдаа Карон судар, суннагийн үзэл санаанд тулгуурладаг. Гэхдээ зөвхөн зарим газруудад үүнийг хуулийн үг хэмээн тодорхой зааж болно гэх зэргээр тэмдэглэсэн байдаг аж. Лалын шашны эхний шатуудад эрдэмтэд – хууль зүйн мэргэжилтнүүд хууль бүтээх ажил эрхэлж байв. Үүний үр дүнд бие биеэсээ эрс ялгаатай сунитийн исламын 4 хуулийн сургууль үүсч өнөөг хүртэл ажиллаж байна. Шариат – хуулиудын өргөн хүрээний эмхтгэл биш, тэрээр тайлбараасаа шалтгаалдаг. Энэхүү шалтгаанаар шариат дээр үндэслэгдсэн гэр бүлийн хуулиуд лалын шашинт орнуудад ялгаатай байдаг.

Энэ тогтолцоонд мөн сүүлийн жилүүдэд эрх зүйн хэм хэмжээний актын үүрэг өргөжих хандлага ажиглагдаж байна.

ЛАЛЫН ЭРХ ЗҮЙН НӨЛӨӨ

Шалгуур:

Орчин үеийн эрх зүйн аймгуудын тогтолцоонд Лалын эрх зүй үндсэн тогтвортой байгаа шалтгаан нөхцөлийг харьцуулсан эрх зүй судлаач А.Х. Саидов тайлбарлахдаа эрх зүйн тогтолцооны элементүүдийн бие даасан шинжээс хамаарсны зэрэгцээ түүхийн урт удаан хугацаанд өргөн хэмжээний нутаг дэвсгэрт байлдан дагуулалт хийх замаар шашны нөлөөг бий болгож чадсантай холбоотой гэжээ.

Үндэслэл:

Тухайлбал Омейядын халифийн төрт улсыг (661-750 он) үндэслэсэн Али Муравийн нас барсны дараа Сирийн төр баригчийн албан тушаалд өрсөлдөгчдийг хайж эхлэв. Мусульманы анхны угсаа залгамжилсан улсыг үндэслэн байгуулагчийн эдгээр үйлдлийн хууль ёсны эсэх нь эхнээсээ л маргааны сэдэв болжээ.

Гэвч исламын түрэмгийлэх бодлого хараахан зогсоогүй байв. Мусульманы армиуд Францын урд хил хүрч, Испанийн болон Хойд Африкийн византийн нутаг дэвсгэрийг булаан эзлэв.

Тэд үндсэндээ Энэтхэгийн хойг хүрч, Византийн эзэнт гүрний нийслэл, Константинополыг эзлэж авсан бөгөөд улмаар өмнөд Европыг бүхэлд нь эзэлсэн бөгөөд одоо ч энэ хэсэгт исламын эрх зүйн нөлөө байсаар байна.

Лалын эрх зүйн эх сурвалж

Лалын эрх зүйн тогтолцоотой орнуудын эрх зүйн эх сурвалжид олон зууны турш гол үүрэг гүйцэтгэсээр ирсэн дөрвөн үндсэн сурвалж байдаг.

ЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ҮНДСЭН ЭХ СУРВАЛЖ

КОРАН

Шашны эрх зүйн хамгийн чухал үндэс нь ариун судар-коран юм. Коран нь Аллах бурхны айлдваруудаас бүрдэх ба өөрийн сүүлчийн элч Мухаммедаар дамжуулсан сургаал ном юм. Мусальманчуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг.

СУННА

Ач холбогдлоор Кораны дараа орох бөгөөд гэгээн Мухаммедын хэлсэн үг, хийсэн үйлдлийг уламжлал болгон үлдээж, энгийн мусульман хүн тэдгээрийг үлгэрлэн дагахыг чухалчилсан юм. Сунныг Кораныг тайлбарлах замаар бүтээсэн.

Исламын эрдэмтдийн нэгдмэл саналын дүнд Коран, Сунныг тайлбарлаж, дэлгэрүүлэх зорилгоор гаргажээ. Коран болон Суннаас тодорхой асуудлын хариултыг олж чадахгүй бол ижмад ханддаг байлаа. Коранаас тусдаа орших Ижмын хүчин чадлыг хууль ёсны болгосон гол хүчин зүйл нь “нийгэмд хэзээ ч алдаатай шийдвэр гаргахгүй ба Мусульманчууд шударга үнэн гэж үзсэн бүхэн Аллахын нүдэнд шударга харагдах болно” гэсэн номлол байсан юм.

КИЯС

Коран, сунна, ижмад заасан хэм хэмжээ, журмуудыг шинэ нөхцөл байдлуудад нийцүүлж хэрэглэхийн тулд Кияст тайлбарласан байдаг

Лалын шашин нийгмийн хэв журам тогтвортой тайван байхад шүүгчид голлох үүрэгтэй ба тэд өөрсдөө үнэнч шударга, хээл хахууль авдаггүй байх талаар хөлгөн сударгаа чухалчлан заажээ.

Шийтгээ:

Лалын Бүгд найрамдах Иран улсад шүүгч нар нь шийтийн мужтахед буюу Коран болон Сунныг үндэслэн тайлбар хийх чадвартай, лал эрх нэвтэрхий мэддэг байхыг шаарддаг байна. Мөн Саудын Арабын вант улсад шүүгчийг шашин болон эрх зүйн мэдлэгийг харгалзан үзэж хаан томилдог байна

Лалын шашин нийгмийн хэв журам зөрчих, гэр бүлийн үүргийг үл биелүүлэх хулгай хийх, худал хэлэх явдалыг гэмт хэрэг хэмээн үзэж хэрхэн яаж шийтгэх, ямар тохиолдолд өршөөл уучилал үзүүлэх талаар Коран сударт тусгайлан заасан байдаг.

Мөн гэмт хэрэгтнүүдийг шүүж ял эдлүүлэх талаар хүнлэг бус, туйлын хатуу харгис, балар эртний болон дундад зууны үеийн залхаах, тамлах, зовоон тарчлаах ял шийтгэлийг тогтоожээ. Үүнд гэмт хэрэгтний гар хөлийг тайрах, дүүжлэх зэрэг харгис ялын төрлийг Коран сударт зааж тогтоосон. Мөн эхнэртэй эрийг чулуугаар үхтэл нь балбах ч юмуу, эсвэл гэрлэсэн эмэгтэйг садар самуунд



уруу татсан явдал гаргасны нь төлөө шүүхээс хатуу шийтгэл оноож болно. Гэхдээ эдгээр шийтгэлийг гүйцэтгэх нь шүүхээс хамааралтай, зөвхөн цөөн дарангуйллын орнуудад үг дуугүй гүйцэтгэдэг.

Өнөөдөр дэлхийн улсуудын 4/1 орчим нь шашны эрх зүйн тогтолцоотой байна. Тухайлбал: Алжир, Бангладеш, Йемен, Ливи, Малайз, Пакистан, Саудын Араб зэрэг улсад Лалын шашинг төрийн шашин гэж тодорхойлсон байдаг. Орчин үед Лалын эрх зүй шинэ шатанд гарч, шариатыг барууны хууль тогтоомжийн жишгээр хэлбэржүүлэх үйл явц өрнөх болжээ. Ингэхдээ шариатын үндэс, мөн чанарт ямар нэг шинэчлэл хийлгүйгээр гагцхүү хэлбэрийн өөрчлөлтийг хөндөж байна. Эрх зүйг төрөлжүүлэн хуульчлах болсон нь дундад зууны үед Лалын шашинт улсуудад тогтсон эрх зүйн эх сурвалжийн ойлголтод эргэлт хийсэн гэж үзэж болно.

Хяналтын асуулт:

1. Лалын шашин нь эрх зүйн сэтгэлгээ, тогтолцоонд хэрхэн нөлөөлсөн талаар харилцан ярилцана уу.
2. Лалын эрх зүйн эх сурвалж тэдгээрийн нийгмийн харилцаанд гүйцэтгэх үүргийг тодорхойлно уу.
3. Коран сударт тайлбар хийх болсон шалтгаан нөхцөл, үр дагаварын талаар ярилцана уу.
4. Лалын эрх зүйт улс орнуудын шүүхийн тогтолцооны онцлог, бусад эрх зүйн аймгуудтай харьцуулан дүгнэлт хийнэ үү.
5. Лалын эрх зүйт улс орнуудын ялын төрөл хийгээд шашны зан үйлийн талаар, бусад эрх зүйн аймгуудтай харьцуулан дүгнэлт хийнэ үү.
6. Орчин үеийн лалын эрх зүйн чиг баримжаа, хэтийн чиг хандлагын талаар тухайлсан улсуудыг жишээ болгон ярилцлага зохион байгуулна уу.

Эх сурвалж

1. Б. Амарсанаа., “Харьцуулсан эрх зүй судлал” УБ., 2005.
2. С.Нарангэрэл., “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо” УБ., 2001. 252-265 дахь тал
3. Б.Минжүүрдорж., Даяарчлагдаж буй дэлхий: харьцуулсан эрх зүй судлал. УБ., 2010. 30- 35 дахь тал
4. Н.Отгончимэг., “Харьцуулсан эрх зүйн судлал” УБ., 2001. 168-173 дахь тал
5. Осаке Кристофер “Харьцуулсан эрх зүй судлал : ерөнхий ба тусгай анги бүдүүвч” УБ., 2005. 26-29 дэх тал
6. Хууль зүйн үндэсний төв, Шинжлэх ухааны академи. “Дэлхийн улсуудын шүүхийн тогтолцоо” УБ., 2001
7. Давид.Р. Основные правовые системы современности. М., 1988. Стр- 386-398

8. Шихихутуг ХЗДС. Харьцуулсан эрх зүйн онол, практикийн орчин үеийн асуудал.УБ., 2007. 266- 286 дахь тал
9. Коран.М.,1990
10. G0ibb, Hamilton Alexander Rosskeen. Mohammedanism – An Historical Survey. UK.,1970
11. <http://www.cfr.org/religion/islam-governing-under-sharia/p8034>
12. <http://www.ixmedeh.top.mn>
13. <http://sharia-law.info>

АРВАННЭГ ДҮГЭЭР СЭДЭВ: ОХУ-ЫН ЭРХ ЗҮЙ



Европын дорнод хэсэг, Азийн хойд хэсэгт орших 89 эрх тэгш субъект буюу 21 бүгд найрамдах улс, 6 хязгаар, 49 муж, холбооны зэрэглэлтэй 2 хот, 1 автономит муж, 10 автономит тойргоос бүрдэх холбооны улс юм.

Төрийн удирдлагын хэлбэрийн хувьд Ерөнхийлөгчийн Бүгд найрамдах улс

Хууль тогтоох эрх мэдэл:




Холбооны улсын хэмжээнд Гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар дарга, орлогчид, сайдуудаас бүрдсэн ОХУ-ын Засгийн газар хэрэгжүүлнэ. Засгийн газрын тэргүүнийг Төрийн думтай зөвшилцсөнөөр Холбооны улсын Ерөнхийлөгч томилно. ОХУ-ын Үндсэн хуульд холбооны субъектуудын төрийн удирдлагын тогтолцоог хуулчилсан зохицуулалтгүй тул субъект бүр өөр өөрийн онцлогт тохирсон төрийн удирдлагыг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог нутаг дэвсгэртээ байгуулах эрхтэй.

ОХУ-ын эрх зүйн тогтолцоо 1917 оноос хойш 70 гаруй жилийн турш социалист эрх зүйн чиглэлээр хөгжиж байгаад 1990-ээд оноос Ром-Германы эрх зүйн аймагт багтах болсон.



ОХУ-ын эрх зүйн эх сурвалж, төрөл:



Холбооны улсуудын нэг түгээмэл шинж бол хууль тогтоомж нь холбооны ба холбооны субъектуудын гэсэн хоёр түвшинтэй байна. Эрх зүйн хэм хэмжээний актын тэргүүнд ОХУ-ын Үндсэн хууль, дараа нь холбооны бусад хуулиуд, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын хуульчилсан актууд, хууль тогтоох байгууллагаас гаргасан хэм хэмжээ

тогтоосон акт байна.

Үндсэн хуулиар холбооны улсад хамаарах эрх мэдэл ба холбооны субъектэд хамаарах эрх мэдлийн хуваарилалтыг нарийн заагласан байдаг.

Холбооны улсын эрх мэдэлд Үндсэн хууль, Холбооны хуулиудыг батлах, өөрчлөх, биелэлтэд хяналт тавих, холбооны төрийн байгууламж, нутаг дэвсгэр, иргэний эрх, эрх чөлөө, төр, засгийн байгууллагуудыг байгуулах журам, санхүү, татвар, гаалийн эрх зүйн зохицуулалт, ОХУ-ын гадаад харилцаа, батлан хамгаалах, аюулгүй байдал, шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагаа, эрүү, иргэний процессын хууль тогтоомж, өршөөл уучлал үзүүлэх харилцааны эрх зүйн зохицуулалт хамаарна.

ОХУ-ын субъектуудын эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актын шаталсан тогтолцоонд субъектуудын Үндсэн хууль, бусад хуулиуд, Бүгд найрамдах улсуудын Ерөнхийлөгчийн зарлиг, засаг, захиргаа, амбан захирагч, бусад удирдлагын зарлиг, тогтоол, захирамжууд, субъектуудын засгийн газрын шийдвэр, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын шийдвэр, хууль тогтоох байгууллагын хэм хэмжээ тогтоосон актууд, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан эрх зүйн хэм хэмжээний акт гэсэн дараалалтай байна.

ОХУ-ын дээд шүүхийн бүгд хурлын удирдамж, хууль тайлбарласан акт, албан ёсоор нэгтгэн дүгнэсэн шүүхийн практик нь хууль тогтоомжийг хэрэглэхэд онцгой үүрэг гүйцэтгэнэ. Гэхдээ ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь шүүхийн жишигтэй адил байр суурийг эзлэнэ.

ОХУ-ын иргэний эрх зүйн харилцаа, цөөн хүнтэй ард түмэнд хамаарах хэрэг маргааныг хянан шийдвэрлэх харилцаанд эрх зүйн заншлыг хязгаарлагдмал хүрээнд хэрэглэдэг байна.

1990-ээд оноос холбооны зарим субъектуудын хувьд лалын эрх зүйн хэм хэмжээг эх сурвалж болгон хуульчилж эхэлсэн.

ОХУ-ын эрх зүйн эх сурвалжийн нэг төрөл бол төрийн эрх барих дээд байгууллагуудын хооронд төрийн эрх мэдэл, бүрэн эрхийг зааглан ялгах тухай байгуулсан эрх зүйн гэрээ юм.

Олон улсын эрх зүйн акт болон эрх зүйн номлолыг эрх зүйн эх сурвалжид тооцож Үндсэн хуулиндаа олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим ба хэмжээ, ОХУ-ын олон улсын гэрээ нь үндэсний эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг гэж заажээ.

ОХУ-ын эрх зүйн салбарын шинжлэх ухааны судалгааны ажлыг ОХУ-ын ШУА-ийн төр, эрх зүйн институт, Засгийн газрын дэргэдэх хууль тогтоомж, харьцуулсан эрх зүй судлалын институт, ОХУ-ын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх хууль ёс, эрх зүйн дэг журмыг бэхжүүлэх асуудал судлах эрдэм шинжилгээний хүрээлэн, хууль зүйн академи, хууль зүйн их, дээд сургуулиуд хэрэгжүүлж байна.

ОХУ-ын иргэний эрх зүйн харилцааг барууны улс орнуудын иргэний эрх зүйн зохицуулалтын туршлага, өөрийн орны эрх зүйн уламжлалд тулгуурлан боловсруулсан 1995 оны төрөлжсөн хуулиар зохицуулж байна. Энэ хууль хоёр анги, 4 хэсэг, 60 бүлэг, 1109 зүйлтэй. Мөн энэ салбарт 1996 оны “Банк ба банкны үйл ажиллагааны тухай”, 1995 оны “Зүй ёсны ноёрхлын тухай”, 1996 оны “Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах” хууль үйлчилж байна.

Гэр бүлийн эрх зүйн үндсэн эх сурвалж нь 1995 оны төрөлжсөн “Гэр бүл”-ийн хууль юм. Хөдөлмөрийн харилцааг 1971 оны Хөдөлмөрийн тухай хуулиас гадна, хамтын гэрээ, хэлэлцээрийн, хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх тухай, хөдөлмөр хамгааллын тухай хууль зэрэг хууль тогтоомжийн актаар зохицуулж байна.

ОХУ нь эрүү, иргэний процессын төрөлжсөн хуультайгаас гадна арбитраар хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн харилцааг зохицуулсан бие даасан хуулиудтай.

Оросын Холбооны улсын эрх зүй

Салбар эрх зүй

Нийтийн эрх зүй

Холимог эрх зүй

Хувийн эрх зүй

Шүүхийн тогтолцоо:

ОХУ-ын шүүхийн тогтолцоо нь холбооны шүүх, үндсэн хуулийн шүүх, Бүгд найрамдах улсын дээд шүүх, хязгаар, муж, автономит тойргийн шүүх, дүүргийн шүүх, цэргийн ба тусгай шүүх, холбооны болон субъектуудын арбитраар шүүхээс бүрдэнэ.



ОХУ-ын шүүхийн тогтолцооны эрх зүйн үндэс нь ОХУ-ын болон субъектуудын Үндсэн хууль болон ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай хууль юм.

ОХУ-ын шүүхийн тогтолцоо нь үндсэн хууль, иргэн, захиргаа, эрүүгийн болон арбитрайн хэрэг маргааныг төрийн нэрийн өмнөөс, хараат бусаар, бие даан, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх бүхий шүүгч болон тангарагтан, арбитрайн төлөөлөгчөөс бүрдэнэ.

ОХУ-ын Дээд шүүх нь эрүү, иргэн, захиргааны болон нийтлэг шүүн таслах ажиллагаанд хамаарах хэргийн талаар болон шүүхийн хяналтыг хэрэгжүүлэн, шүүхийн практикийн тайлбар өгөх эрхтэй дээд байгууллага мөн. ОХУ-ын Дээд шүүхийн бүрэлдэхүүнд Дээд шүүхийн бүгд хурал, Дээд шүүхийн Тэргүүлэгчид, хяналтын танхим, иргэний хэргийн шүүх танхим, эрүүгийн хэргийн шүүх танхим, цэргийн шүүх танхим байна.

Бүгд найрамдах улсуудын дээд шүүх, хязгаарын (мужийн) шүүх, холбооны мэдлийн хотын шүүх, автономит мужийн шүүх, тойргийн шүүх нь эрх хэмжээний хүрээнд анхан болон хяналтын журмаар, шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэргийг хянан хэлэлцэж, дүүргийн шүүхийн үйл ажиллагаанд шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх, шүүхийн практикийг судалж, нэгтгэн дүгнэх, шүүхийн статистикт дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа эрхэлнэ.

Дүүргийн шүүх нь эрх хэмжээний хүрээнд хэргийн анхан шатны журмаар хэлэлцэнэ.

ОХУ-ын шүүхийн тогтолцоонд эвлэрлийн шүүх байна. Энэ шүүх нь гэрлэлт цуцлах, эцэг эхийн тухай маргаан, бага үнийн дүнтэй иргэний маргаан, газрын жижиг маргаан, захиргааны эрх зүйн жижиг зөрчлийн талаарх хэрэг маргааныг хянан шийдвэрлэнэ.

Цэргийн шүүх нь цэргийн албан хаагчдад хамаарх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эрхтэй.

Арбитрайн шүүх нь үйлдвэрлэлийн болон эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд иргэн, байгууллагын эрх ашиг зөрчсөн эсэхийг тогтоох, байгууллага, иргэнийг төлбөрийн чадваргүйд тооцох, эдийн засгийн маргаантай хэргүүдийг хянан шийдвэрлэнэ.

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлж ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны зөвлөл, Төрийн Дум, Холбооны зөвлөлийн гишүүн ба төрийн Думын депутатуудын тавны нэг, ОХУ-ын Засгийн газар, ОХУ-ын Дээд Шүүх, Арбитрайн дээд шүүх, ОХУ-ын субъектүүдийн хууль тогтоох ба гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хүсэлтээр дараах маргааныг хянан хэлэлцэнэ.

Үүнд:

Оросын Холбооны улсын Үндсэн хуулийн шүүх

- Холбооны хууль, ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Дээд зөвлөл, Төрийн Дум, ОХУ-ын Засгийн газрын хэм хэмжээ тогтоосон акт
- БНУ-ын Үндсэн хууль, дүрэм, ОХУ-ын төр, засгийн байгууллага болон ОХУ-ын субъектын төр, засгийн байгууллагын хамтарсан эрх хэмжээнд хамаарах асуудлаар гаргасан хэм хэмжээ тогтоосон акт
- ОХУ ба ОХУ-ын субъектын төр, засгийн байгууллага болон ОХУ-ын субъектүүдийн төр, засгийн байгууллагын хооронд байгуулсан гэрээ
- ОХУ-ын олон улсын гэрээ
- ОХУ болон ОХУ-ын субъектын төр, засгийн байгууллагын хооронд үүссэн маргаан
- ОХУ-ын субъектүүдийн төр, засгийн байгууллагын хооронд үүссэн маргаан
- Иргэдийн үндсэн хуулийн эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай гомдол

ОХУ-ын Үндсэн хуульд зааснаар 25 насанд хүрсэн, хууль зүйн дээд боловсролтой, таваас доошгүй ижл хууль зүйн мэргэжлээр ажилласан ОХУ-ын иргэнийг бүх насаар нь томилно. ОХУ-ын дээд шүүх, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, ОХУ-ын Арбитрийн дээд шүүхийн шүүгчдийг ОХУ-ын Ерөнхийлөгчийн санал болгосноор Холбооны зөвлөл томилно.

Харин бусад шүүгчдийг ОХУ-ын Ерөнхийлөгч томилно. ОХУ-д шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжлийн шүүгчдээс гадна тангарагтны⁹ төлөөлөгч оролцоно.

Тангарагтны төлөөлөгч нь ОХУ-ын иргэн байх бөгөөд тангарагтны төлөөлөгчийн жагсаалтад орсон, хуулиар тогтоосон журмын дагуу шүүхээр хэрэг хянан хэлэлцэхэд оролцох боломжтой байна. Иргэний хэрэг маргааныг шүүгч дангаар, эрүүгийн хэргийг хуульд зааснаар шүүгч дангаар буюу мэргэжлийн нэг шүүгч, ардын 2 төлөөлөгч, мэргэжлийн гурван шүүгч, мэргэжлийн нэг шүүгч 12 тангарагтны төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр тус тус хянан шийдвэрлэнэ.

ОХУ-ын шүүхийн тогтолцооны нэгдмэл байдал нь дараах байдлаар хангагдана.

- ОХУ-ын шүүхийн тогтолцоо нь ОХУ-ын болон субъектуудын Үндсэн хууль, ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай хуулийн дагуу байгуулагдсан шүүхээс бүрдэнэ.
- Бүх шатны шүүхүүд хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, бусад хууль, нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зарчим, нэгдэн орсон олон улсын гэрээний хэм хэмжээг баримтална.
- Хууль зүйн хувьд хүчин төгөлдөр болсон бүх шатны шүүхийн шийдвэрийг ОХУ-ын нутаг дэвсгэр дээр заавал биелүүлнэ.
- Шүүгчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.
- Бүх шатны шүүхийн төсөв зардлыг нэгдсэн журмаар төр санхүүжүүлнэ.

⁹ Тангарагтны төлөөлөгч ОХУ-д 1860-аад оны үед явагдсан эрх зүйн шинэтгэлийн үйл явцын хүрээнд иргэдийг шүүн таслах ажиллагаанд татан оруулах замаар шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бодит байдлыг хангах зорилгоор байгуулж байжээ. А.Х.Сайдов. Сравнительное правоведение. М.,2000. С.367



ОХУ-ын Прокурорын байгууллага нь хууль ёсны хэрэгжилтэд хяналт тавьдаг, төвлөрсөн нэгдмэл тогтолцоо бүхий байгууллага юм.

Хүн амд үзүүлэх хууль зүйн мэргэжлийн туслалцааг мэргэжлийн өмгөөлөгч хэрэгжүүлнэ. Төлбөрийн чадваргүй буюу бага орлоготой иргэдэд төрөөс өмгөөлөгч томилон эрх зүйн туслалцаа үзүүлдэг байна.

ОХУ-ын эрх зүйн хөгжлийн чиг хандлага:

Ардчилсан өөрчлөлтийн үйл явцын үр дүнд ОХУ-ын эрх зүйн тогтолцоо бүхэлдээ шинэчлэгдэн илүү либераль шинжтэй болсон. Мэргэшсэн парламентын үйл ажиллагаа тогтворжиж, хууль тогтоох үйл ажиллагаа эрчимтэй, дэвшилттэй явж байгаа нь нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтад хууль голлох үүрэг гүйцэтгэж байгаагаар ОХУ-ын эрх зүйн тогтолцоог ром-германы эрх зүйн бүлд хамаарах болохыг харуулж байна.

Орчин үеийн ОХУ-ын эрх зүйн тогтолцоонд нийгмийн хамгаалал, хөдөлмөр, санхүү, татварын хууль тогтоомжийн шинэ салбарууд бий болохын зэрэгцээ зах зээлийн эдийн засгийн хөгжилтэй уялдан нийтийн ба хувийн эрх зүйн салбарын хооронд ялгарал эрчимтэй явагдаж байна.

Гэр бүл, хөдөлмөр, газар, байгалийн нөөц ашиглахтай холбоотой эрх зүйн харилцаанд гэрээний зохицуулалтыг голлон баримтлах болсноор ХХI зуунд эдгээр салбарууд бие даасан салбар эрх зүй болон хөгжих хандлага гарч байна. ОХУ-ын эрх зүйн тогтолцоо холбооны, салбар эрхзүйн түвшинд ижилсэхийн хамт эрх зүйн эх сурвалжийн тогтолцоонд Холбооны улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хууль зүйн хүчин чадал, эрх зүйн зохицуулалтын нөлөө өсөн нэмэгдэж байна. Холбооны болон холбооны субъектуудын хооронд “Загвар хууль”-ийн үзэл хандлага, үүрэг дээшилж байна.

Шигтгээ

2012 оны 9 сарын 28-ны өдөр Улаанбаатар хот дахь Оросын Шинжлэх ухаан, соёлын төвд ОХУ-ын эрх зүйн талаар мэдээллийн төв нээлтээ хийжээ. Тус төв “ОХУ-ын хууль тогтоомж”, цахим хэлбэрээр гарсан эрх зүйн актуудын талаарх мэдээллийг үнэ төлбөргүй өгөх үйл ажиллагаа эрхэлж байна.

Хяналтын асуулт:

1. ОХУ-ын эрх зүйн тогтолцоо нь эрх зүйн аль аймагт хамаарах вэ? Үндэслэлээ тайлбарлана уу.
2. “ОХУ-ын эрх зүйн тогтолцоонд социалист эрх зүйн шинж хадгалагдаж байна” гэдэгтэй Та санал нийлэх үү? Үндэслэлээ тайлбарлана уу.
3. ОХУ-д хийгдэж буй эрх зүйн шинэчлэлийн үр нөлөөг хэрхэн дүгнэж байна вэ?

4. ОХУ болон Монгол Улсын эрх зүйн тогтолцооны нийтлэг болон ялгаатай талыг тодорхойлно уу.
5. ОХУ-ын шүүхийн тогтолцооны онцлогийн талаар ярилцаж өөрийн орны шүүхийн тогтолцоотой харьцуулна уу.
6. Тус улсын шүүхийн тогтолцоон дахь Тангарагтны шүүхийг Америкийн Тангарагтны шүүхтэй харьцуулан дүгнэлт гарган хэлэлцэнэ үү? Энэ харьцуулалт нь харьцуулалтын ямар төрөлд хамаарах вэ?
7. ОХУ-ын эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн зохицуулалтаас өөрийн орны эрх зүйд шилжүүлэх боломжтой эрх зүйн шийдэл, туршлагын талаар багаар мэдээлэл бэлтгэн санал солилцоно уу.

Эх сурвалж:

1. Амарсанаа Б., Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он
2. Минжүүрдорж Б., Даяаршиж буй дэлхий: харьцуулсан эрх зүй судлал УБ 2010 он
3. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо УБ. 2001 он
4. Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг УБ. 2011 он
5. Сүхбаатар Ж., Харьцуулсан эрх зүй УБ. 2000 он
6. Отгончимэг Н., Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он
7. Осакке К., Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги УБ.2005 он
8. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиумын илтгэлүүдийн эмхэтгэл УБ. 2000 он
9. Давид Р., Основные правовые системы современности. М., 1988.
10. Тихомиров В.А., Курс сравнительное правоведения. М., 1996
11. Сайдов А.Х., Сравнительное правоведение. М., 2007
12. Под.ред Сухарев А.Я., Правовые системы стран мира. М., 2001
13. <http://www.asil.org/resource/pil1.htm>
14. <http://www.lib.uchicago.edu/~llou/global.html>
15. <http://europa.eu.int/eurodicautom/Controller>
16. <http://www.lexml.de/rdf.htm>

АРВАНХОЁР ДУГААР СЭДЭВ: БНХАУ-ЫН ЭРХ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж, ойлголт

БНХАУ-ын хувьд эрх зүйн тогтолцоо нь өөрийн онцлогтой бөгөөд үүнийг нөхцөлдүүлж байгаа тодорхой хүчин зүйл бий. Тухайлбал, хууль тогтоомж болон коммунист намын бодлогын хоорондын хамаарлын асуудал байнга тавигддаг, мөн ихэнх судлаач, практик хуульчид хэвлэгдмэл хууль тогтоомж



болон бодит амьдрал дээр мөрдөгддөг хууль тогтоомж хоорондоо зөрөх, өөрөөр хэрэгжих тохиолдол цөөнгүй байдаг, эрх зүй ангийн тэмцлийг шийдвэрлэх зэвсэг гэж үздэг.

Үндсэн хууль

БНХАУ-ын өнөөгийн Үндсэн хууль нь 1982 онд батлагдаж, дөрвөн удаа өөрчлөлт орсон байдаг. Энэ Үндсэн хууль нь нийт 32 үндсэн зарчмыг агуулсан байдаг. Эдгээрийн нэг нь Үндсэн хуульд бүх хууль тогтоомж нийцсэн байх зарчим бөгөөд Үндсэн хуулийг бүх байгууллага, иргэн мөрдөх үүрэгтэй байдаг. Үндсэн хууль нь эрх зүйн дээд хүчин чадалтай баримт бичиг юм.

Олон улсын гэрээ

БНХАУ-ын Үндсэн хуульд олон улсын гэрээ нь эрх зүйн эх сурвалж болох талаар заасан зүйл байдаггүй. Энэ талаар өнөөгийн тогтсон номлол нь тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээ БНХАУ-ын дотоодын хууль тогтоомжийн нэг хэсэг болдог гэсэн үзэл юм. Мөн олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжийн хооронд зөрчилдөөн гарвал олон улсын гэрээг мөрдөх ёстой гэсэн үзэл судлаачдын дунд зонхилж байна. Ерөнхийдөө олон улсын гэрээний эх сурвалж болохтой холбоотой асуудал эрх зүйн тогтсон номлолын хүрээнд шийдэгдэж байна.

Хууль тогтоомж

Энэ эрх зүйн тогтолцоонд хууль тогтоомж гэдэгт багтах баримт бичгийн олон төрөл хэлбэр, хоорондын хамаарал, хаанаас баталсан зэргийг олж тогтоох нь нилээд төвөгтэй байдаг. Хууль тогтоомжийн олон төрөл хэлбэрийн заримаас дурдвал Бүх Хятадын Ардын Хурлаас хууль (fa), тогтоол (jueyi), шийдвэр (jueding) түүний байнгын хороо нь хууль (fa), журам (tiaoli), шийдвэр (jueding), тогтоол (jueyi), заавар (guiding) зэргийг баталдаг.

БНХАУ-д хууль болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг төрийн байгууллагын янз бүрийн түвшинд баталж мөрдүүлдэг. Тухайлбал, Бүх Хятадын Ардын Хурал, түүний байнгын хороо нь хуулийг, Төрийн Зөвлөл нь захиргааны журам, Орон нутгийн Ардын хурал, түүний байнгын хороо нь орон нутгийн хурлын журам, нутгийн захиргааны байгууллага болон Төрийн Зөвлөлийн харьяа яам, газар, Төв Банк, Хяналт шалгалтын газар нь нутгийн захиргааны болон захиргааны байгууллагын журам, Цэргийн төв комисс нь цэргийн дүрэм, журмыг баталж мөрдүүлдэг байна.

Бүх Хятадын Ардын Хурал (БХАИХ) нь суурь хуулиудыг батлах, түүний байнгын хороо нь түүнээс бусад хуулийг тогтоох эрхтэй байдаг. Гэхдээ түүний хороо нь БХАИХ хуралдаагүй үед суурь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй боловч, суурь хуулийн үндсэн зарчмыг өөрчлөх ёсгүй.

Одоогоор БНХАУ-д хууль тогтоомжийн хоорондын зөрчлийг арилгах боломжийг хэм хэмжээний түвшинд зохицуулсан хэдий ч энэ нь хангалттай бус байдаг гэж үздэг. Мөн хууль тогтоож байгаа болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг баталдаг байгууллагын хэм хэмжээ тогтоох эрх мэдлийн хүрээ хязгаар нь харьцангуй тодорхой биш байна. Хэм хэмжээний түвшинд БХАИХ нь байнгын хорооны шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, Байнгын хороо нь захиргааны журам болон орон нутгийн хурлын журмыг хүчингүй болгох, Төрийн зөвлөл нь өөрийн харьяа яам, хорооны шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй (Үндсэн хуулийн 62.11, 67.7, 67.8, 89.13). Мөн орон нутгийн хурлын журам болон Төрийн зөвлөлийн харьяа байгууллагын шийдвэр (guizhang) хоорондоо зөрчилдсөн тохиолдолд БХАИХ-ын Байнгын хороонд Төрийн зөвлөл асуудал оруулж шийдвэрлүүлдэг байна. Харин Төрийн зөвлөлийн харьяа байгууллагын шийдвэр хоорондоо, эсхүл нутгийн захиргааны байгууллагын журам болон Төрийн зөвлөлийн харьяа байгууллагын шийдвэр зөрчилдвөл Төрийн зөвлөл өөрөө шийдвэрлэх эрхтэй байдаг.

БНХАУ-ын Үндсэн хуулийн дагуу хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн харилцан хамаарлыг дараах байдлаар тогтоосон байдаг. Тухайлбал, хууль нь Үндсэн хуультай зөрчилдөхгүй байх ёстой, Төрийн зөвлөлөөс гаргадаг захиргааны журам нь Үндсэн хууль, хуультай зөрчилдөхгүй байх, нутгийн захиргааны байгууллагын журам нь Үндсэн хууль, хууль, захиргааны журамтай зөрчилдөхгүй байх ёстой байдаг (Үндсэн хуулийн 5, 89.1, 100 зүйл).

Шүүхийн шийдвэр

БНХАУ-д шүүхийн шийдвэр нь албан ёсоор эрх зүйн эх сурвалж болдоггүй. Гэхдээ Ардын дээд шүүхийн зарим шийдвэр нь доод шатны шүүх заавал дагаж мөрдөх хүчин чадлыг агуулах тохиолдол байдаг байна. Зарим хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр доод шатны шүүхэд баримтлах чиглэл болдог бөгөөд эдгээрт удирдлагын буруугаас болж бие махбодийн гэм хор, амь нас үрэгдсэн, хортой согтууруулах ундаа борлуулсан, хууль бус хэвлэмэл бүтээгдэхүүнийг хэвлэсэн, борлуулсны ашиг, цэргийн гэр бүлийн байдалд хохирол учруулсан эрүүгийн хэрэгтэй холбоотой хариуцлагын асуудлаар Ардын дээд шүүхийн гаргасан шийдвэр гэх мэт багтдаг байна. Ийм шинжтэй шийдвэрийн товчлол нь Ардын дээд шүүхийн хэвлэлд 1985 оноос хэвлэгдсэн бөгөөд ийнхүү хэвлэхдээ бусад шүүх хэргийг шийдвэрлэхэд хэрэглэсэн зарчмыг баримтлах ёстой хэмээн тусгайлан зааснаар бусад шийдвэрээс ялгардаг байна.

2. Шүүхийн байгууламжийн тойм

Шүүхийн байгууламж гэсэн ойлголтод шүүх болон прокурор хамаардаг бөгөөд энэ нь Үндсэн хуулийн дагуу бие даасан эрх зүйн байдалтай байдаг. Харин



хууль, шүүхийн тогтолцооны нэг хэсэг болдог нийтийн аюулгүй байдлын алба, шүүхийн захиргааны байгууллага нь Төрийн зөвлөлийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг. БНХАУ-д эрх мэдэл хуваарилах зарчим үйлчилдэггүй харин төрийн байгууллагын дотор чиг үүрэг болон хариуцлагыг хуваарилах зарчмаар үйл ажиллагаа нь тодорхойлогддог. Тухайлбал, төрийн эрхийг ардын хурлууд барих бөгөөд захиргааны байгууллага, шүүх, прокурор нь ардын хурлаас томилогдож, түүнд ажлаа тайлагнадаг журамтай. Мөн Хятадын коммунист нам нь өөрийн Улс төр-эрх зүйн ажлын хороогоороо дамжуулан шүүхийн байгууламжийг удирдан чиглүүлж байдаг бөгөөд ийм хороо нь нутаг дэвсгэрийн нэгж бүрт үйл ажиллагаа явуулж байдаг байна.

Шүүх


БНХАУ-д шүүхийн нийгэмд гүйцэтгэх үүрэг түүхийн тодорхой цаг үед төдийлөн ач холбогдолтой байгаагүй бөгөөд энэ нь албан ёсны номлолд ч тусгагдаж байжээ. Харин сүүлийн үед хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэх тоо өсч байгаа зэрэг хүчин зүйлийг авч үзвэл шүүхийн нийгэмд гүйцэтгэх үүрэг өсч байгаа юм.

БНХАУ нь нэгдмэл улс болохын хувьд Ардын дээд шүүх, Ардын дээд шатны шүүх, Дагнасан болон мэргэжлийн шүүх, Ардын дунд шатны шүүх, Ардын анхан шатны шүүх, Цэргийн хэргийн шүүх, Далайн хэргийн шүүх, Ойн хэргийн шүүх, Төмөр замын хэргийн шүүхээс бүрдсэн нэгдмэл тогтолцоотой. Хятадын шүүхийн тогтолцоо нь “шаталсан дөрвөн шүүхийн тогтолцоо ба хэргийг хоёр шатны шүүх хурлаар эцэслэх” зарчмын үндсэн дээр зохион байгуулагдсан гэж үздэг. Шаталсан дөрвөн шүүхийн тогтолцоо нь сумын төвшний 3 мянга орчим ардын анхан шатны шүүх, 400 шахам аймгийн төвшний Ардын дунд шатны шүүх, 31 мужийн Ардын дээд шатны шүүх, БНХАУ-ын Ардын дээд шүүхээс бүрддэг. Мөн 50 орчим цэргийн хэргийн, 70 гаруй төмөр замын хэргийн, 8 далайн хэргийн, ойн хэргийн шүүх энэ бүтцэд ордог.

Шүүх нь ерөнхийдөө эрүү, иргэн, эдийн засгийн болон захиргааны хэргийн танхимаас бүрддэг бөгөөд зарим шүүхэд эрүүгийн хэргийн хоёр танхим үйл ажиллагаа явуулах нь бий. Иргэний болон эдийн засгийн маргааны ялгаа нь ямар этгээд, ямар асуудлаар маргаж байгаагаар ялгагддаг. Тухайлбал, иргэний маргаан нь өр, өв залгамжлал, орон байрны асуудал, нэр хүнд, гэм хорын шинжтэй иргэн болон тэдгээрийн эд хөрөнгийн холбогдолтой байдаг бол эдийн засгийн маргаан нь үйлдвэрлэлийн болон арилжааны хүрээнд голлон гарч иргэдийн хооронд гэхээс илүү үйлдвэр, аж ахуйн газрын хооронд үүсдэг гэж үздэг.

Ардын анхан шатны шүүх нь хэрэг, маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэж, ардын эвлэрүүлэх хороонд зааварчилгаа өгч байдаг. Ардын дунд шатны шүүх нь Ардын анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах

журмаар эцэслэн шийдвэрлэхээс гадна хувьсгалын эсрэг хэрэг, бүх насаар хорих болон цаазаар авах ялтай хэрэг, гадаадын иргэдийн оролцсон эрүүгийн хэрэг, гадаадтай холбоо бүхий “чухал” иргэний хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэдэг. Ардын дээд шатны шүүх нь Ардын дунд шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан хэрэг маргааныг эцэслэн, мужийн төвшинд чухал ач холбогдол бүхий хэргийг анхан шатны журмаар хэлэлцдэг байна. Харин Ардын дээд шүүх нь Ардын дээд шатны шүүхийн шийдвэрийг эцэслэн, улсын хэмжээнд чухал ач холбогдолтой хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэдэг. Ардын дээд шүүх нь шүүн шийдвэрлэх эрх хэмжээнээс гадна шүүхийн тайлбар гаргах, доод шатны шүүхэд хэргийг шийдвэрлэхэд баримтлах хэм хэмжээг батлах зэрэг хууль тогтоох эрх хэмжээтэй байдаг.



БНХАУ-д шүүхээр хэрэг, маргааныг ихэнх тохиолдолд сондгой тоо бүхий бүрэлдэхүүнтэй шийдвэрлэдэг бөгөөд зарим иргэний, эрүүгийн хэргийг ганц шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх нь бий. Мөн анхан шатны журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэх шүүх нь дан ганц шүүгчээс бүрдэхээс гадна шүүгчтэй адил эрх, үүрэгтэй иргэдийн төлөөлөгчийн оролцоотой байх нь бий. Харин давж заалдсан тохиолдолд иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцдоггүй онцлогтой.

БНХАУ-д шүүх шийдвэр гаргах онцлог нь зөвхөн шүүх бүрэлдэхүүн хэргийг эцэслэн шийдвэрлэдэггүй, шүүх бүрэлдэхүүнээс гадна тухайн шатны шүүх дэх байнгын ажиллагаатай шүүн шийдвэрлэх хороо болон ерөнхий шүүгч хэргийг авч үздэгт оршино. Зарим ноцтой, хүнд хэргийг эхлээд шүүн шийдвэрлэх хороогоор хэлэлцэж, дараа нь шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх бөгөөд шийдвэрт ерөнхий шүүгч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог. Үүнийгээ онолын



хувьд шүүх өөрийн бүтэц доторх хараат бус, бие даасан байдал гол асуудал биш, харин төрийн бусад байгууллагаас хараат бус, бие даасан байх нь чухал хэмээн зөвтгөдөг байна. Үүгээрээ БНХАУ дахь шүүхийн процесс нь шүүн таслах шинжтэй гэхээсээ илүү, захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаатай төстэй хэмээн зарим судлаачид үздэг бөгөөд шийдвэр гаргах процесс нь хоорондоо уялдаа бүхий мэт харагддаг.

Шүүхийн үйл ажиллагаанд баримтлах дараах зарчим байна гэж тунхагладаг. Тухайлбал, шүүн шийдвэрлэх ажиллагааг хараат бус, бие даан хэрэгжүүлэх зарчим, хуулийн дор эрх тэгш байх зарчим, нээлттэй шүүн таслах ажиллагаа явуулах зарчим эдгээрт хамаарна. Харин төрийн нууц, хувийн нууц, насанд хүрээгүйчүүдийн гэмт хэрэгтэй холбоотой хэрэгт шүүн таслах ажиллагааг нээлттэй явуулах зарчим үйлчилдэггүй онцлогтой.

Шүүх нь үйл ажиллагааны хувьд ихээхэн онцлогтой байдаг. Нэгд, шүүн таслах ажиллагаа хүмүүжлийн ач холбогдолтой, шүүн таслах ажиллагааны үр дүнд иргэдийн социалист эх орондоо үнэнч байх, хуулийг сайн дураар дагаж мөрдөх ухамсар бэхждэг гэж үздэг. Шүүн таслах ажиллагааг олон нийтийн газар, ажлын байранд нь хийх тохиолдол бий. Хоёрт, шүүгч нь иргэн болон эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалт явуулах, нотлох баримт цуглуулах зэргээр шүүх хуралдаанд идэвхтэй үүрэг гүйцэтгэдгээс мэтгэлцээний зарчим шүүх хуралд үндсэндээ үйлчилдэггүй. Гуравт, иргэний хэргийн хувьд шүүгч нь сайн дураар эвлэрүүлэх ажиллагааг заавал гүйцэтгэдэг бөгөөд гагцхүү эвлэрээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг гаргадаг. Дөрөвт, шүүх нь шүүн таслах ажиллагааныхаа талаар коммунист намаас чиглэл, зааварчилгаа авах тохиолдол цөөнгүй байдаг. Тавд, шүүх нь дээд шатны шүүхээс тодорхой хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар зааварчилгаа хүсдэг төдийгүй, дээд шатны шүүх нь өөрийн санаачлагаар доод шатны шүүхдээ зааварчилгаа өгөх нь байдаг. Ийнхүү зааварчилгаа өгөх болон авах байдлаар хяналт тавих онолын үндэслэгээ нь шүүхийн шийдвэрийн чанарыг хянах механизм хэмээн ойлгодогт оршино.

Прокурор

Прокурорын байгууллага нь үндсэн үүрэг талаасаа барууны орнууд дахь гүйцэтгэх засаглалд хамаарах прокурорын байгууллагатай адил мэт харагддаг. Гэхдээ энэ улсын прокурорын байгууллагын эрх зүйн байдал нь Үндсэн хуулийн дагуу шүүх болон Төрийн зөвлөлтэй адил түвшинд байна хэмээн тодорхойлогдсоноороо онцлог юм. БНХАУ-ын прокурорын байгууллага хуучин Зөвлөлт Холбоот Улсын прокурорын жишгийг гол болгосон боловч зарим ялгаатай байдлаар үйл ажиллагаа явуулдаг. Тогтолцооны хувьд прокурорын байгууллага дээд шатны прокурорын болон тухайн шатны намын байгууллагын хяналтад үйл ажиллагаа явуулдаг онцлогтой.

Үндсэн хуулийн дагуу прокурор нь “төрийн эрх зүйн хүрээн дэх хяналт”-ыг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь намын сахилга бат, захиргааны хяналтаас ялгардаг. Эрх зүйн хүрээн дэх хяналт нь дөрвөн хүрээнд илэрдэг. Нэгд, прокурор нь баривчлах гэх мэт таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэх, хэрэгт яллах дүгнэлт үйлдэх эсэхийг шийдвэрлэхээс гадна шүүхэд яллагчаар оролцдог. Хоёрт, албан тушаалтны иргэний эрхийг зөрчсөн хэрэг, авилгын болон албан тушаалтаны эдийн засгийн холбогдолтой хэргийг иргэдийн мэдээллийн үндсэн дээр өөрөө мөрдөн шалгадаг. Гуравт, эрүүгийн хэрэгт эсэргүүцэл бичих замаар давж заалдах эрхтэй бөгөөд үүнийгээ хяналт хэрэгжүүлж буй нэг хэлбэр гэж үздэг. Мөн маргааны тал биш байсан ч иргэний болон захиргааны хэрэгт эсэргүүцэл бичих эрх хэмжээ прокурорт бий. Дөрөвт, нийтийн аюулгүй байдлын байгууллага болон хөдөлмөрийн засан хүмүүжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд ерөнхий хяналт тавих эрх хэмжээтэй.

3. Хуульчийн мэргэжил, гүйцэтгэх үүрэг

Хятадын нийгэм дэх хуульчийн мэргэжил, түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг ихээхэн хувьсаж ирсэн байдаг. Хорьдугаар зууныг хүртэл албан ёсоор хуульчийн мэргэжил гэж байгаагүй бөгөөд өнгөрсөн зууны эхээр хуульч, өмгөөлөгчийг албан ёсоор эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болохыг хүлээн зөвшөөрөх хандлага гарсан. Гэвч 1950-иад оноос хуульч, түүн дотор өмгөөлөгчийг нийгэмд хортой нөлөө үзүүлдэг этгээд хэмээж, 1970-аад оныг хүртэл хуульчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг хамгийн бага түвшинд авч үзэж байсан.

Шүүгчийг аль шатны шүүхэд харьяалагдахаас хамааран тухайн шатны ардын хурлын байнгын хорооноос томилж, тэдгээрийн өмнө ажлаа тайлагнадаг. Харин шат шатны шүүхийн ерөнхий шүүгчийг тухайн шатны ардын хурлаас сонгодог байна. Шүүгч нь тусгайлсан хугацаатайгаар сонгогдож, томилогддоггүй бөгөөд үүгээр төрийн бусад албан хаагчаас эрх зүйн байдал, баталгааны хувьд ялгардаггүй. Харин УДШ-ийн Ерөнхий шүүгч нь 5 жилийн хугацаатай сонгогдож, 2-оос илүү удаа улирах боломжгүй байдаг. Шүүгчээр ажиллахын тулд эрх зүйн мэргэжлийн мэдлэгтэй байх ёстой бөгөөд энэ улсад шүүгчийг сургах ажил нилээд тулгамдсан асуудал болж байна¹⁰. Мөн үүнтэй адилаар прокурорын сургалт, эрх зүйн мэргэжлийн боловсрол тулгамдсан асуудал болдог. Прокурор нь Үндсэн хуулиндаа нилээдгүй өндөр эрх зүйн байдалтай байдаг боловч бодит байдал дээр энэ нь хэрэгждэггүй.

Өмгөөлөгч нь “төрийн хууль цаазын ажилтан” байдаг бөгөөд тэдгээрийг төрөөс ихээхэн хэмжээгээр зохицуулахыг оролддог. Тухайлбал, өмгөөлөгчөөр ажиллах боломжийг Хууль зүйн яам, эсхүл орон нутгийн хууль зүйн албанаас олгодог бөгөөд хуулийн фирмийн тэргүүнийг хууль зүйн албанаас зөвшөөрөл авах байдлаар хяналт тавих механизм байдаг. Мөн коммунист намын салбар

10 1987 оны тоо баримтаар БНХАУ-д 98 мянга орчим шүүгч шүүн таслах ажиллагаа явуулдаг байна.



хороо өмгөөлөгчдийн байгууллагад үйл ажиллагаа явуулж байдаг.

Өмгөөлөгчийн нийгэмд гүйцэтгэх гол үүрэг нь ард түмэнд үйлчлэх явдал байдаг бөгөөд намын үзэл санааг үйл ажиллагаандаа удирдлага болгодог. Энэ тогтолцоонд төрийн, олон нийтийн болон хувь хүмүүсийн ашиг сонирхол давхацдаг бөгөөд зөрчилддөггүй гэж үздэг. Ийм ч учраас иргэд, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь хүлээн зөвшөөрөгдөх шинжийг агуулдаг байна¹¹.

Хяналтын асуулт:

1. БНХАУ-ын эрх зүйн тогтолцоонд коммунист намын бодлогын баримт бичиг хэрхэн нөлөө үзүүлдэг талаар судалж ярилцах.
2. Социалист үзэл суртал эрх зүйн тогтолцоонд хэрхэн хэлбэржсэнийг задлан шинжлэх.
3. Эрх мэдэл хуваарилах онол үйлчилдэггүй эрх зүйн тогтолцоонд шүүх нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж байгаа талаар өөрийн эрх зүйн тогтолцоотой харьцуулан үзэх.
4. “Шаталсан дөрвөн шүүхийн тогтолцоо ба хэргийг хоёр шатны шүүх хурлаар эцэслэх” зарчмын мөн чанар, үр дагаврыг шүүн ярилцах.
5. Шүүхийн шийдвэр ямар тохиолдолд эрх зүйн эх сурвалж болох талаар БНХАУ-ын жишээн дээр тайлбарлах.
6. Прокурорын байгууллага шүүхийн байгууламжийн нэг хэсэг болох тухай албан ёсны номлол ба МУ-ын Үндсэн хууль дахь Прокурорын байгууллагын эрх зүйн байдлыг харьцуулж, задлан шинжлэх.

Эх сурвалж:

Ном

1. БНХАУ-ын хуулийн эмхэтгэл, цуврал 1, УБ., 2008
2. Дэлхийн улсуудын шүүхийн тогтолцоо, УБ., 2005
 - БНХАУ-ын шүүхийн тогтолцоо, 30-32 дахь тал
3. Монгол улс дахь Эрх зүйн шинэтгэл болон харьцуулсан эрх зүй судлалын хөгжил (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл), УБ., 2004
 - Наранцогт., Дундад улсын эрх зүйн шинэчлэлт, өөрчлөлт, 51-54 дахь тал
4. Т.Мөнхжаргал., Монгол, БНХАУ-ын Иргэний хуулийн харьцуулсан судалгаа, УБ., 2011
5. Харьцуулсан эрх зүйн онол, практикийн орчин үеийн асуудал, УБ., 2007
 - Э.Зууннасан., Монгол, Хятад улсуудын Эрүүгийн шүүнтаслах ажиллагааны түүхэн уламжлал, шинэчлэлийн харьцуулсан судлал, 159-175 дахь тал

¹¹ БНХАУ-д нотариатын үйл ажиллагааг нотариатч хэрэгжүүлдэг.

6. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлангийн эмхэтгэл /2003-2009/, нэгдүгээр боть, УБ.,2012
 - Олон улсын эрх зүйн секторын судалгааны тайлан: БНХАУ дахь хүний эрхийн төлөв байдал, 520-541 дэх тал
7. Ж.Цэцэгмаа., Гадаад орнуудын төр, эрх зүйн түүх, УБ.,2007
Дундад зууны улсуудын төр, эрх зүй
 - Хятадын төр, эрх зүй, 259-272 дахь тал
8. Шүүхийн тогтолцоо: Улс төр, эрх зүйн зарим асуудлууд, УБ.,2009
 - Ц.Баярмаа., БНХАУ-ын Ардын дээд шүүх, 31-32 дахь тал
9. Б.Эрдэнэбат., Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал, УБ.,2008
10. Сэтгүүл

Хууль дээдлэх ёс сэтгүүл

1. И.Түвшинзаяа, БНХАУ-ын гэр бүлийн эрх зүйн зохицуулалт, 2007/№2
2. Хайтан, “ Хятад улсын газрын эрхийн дүрмийн одоогийн байдал хийгээд шинэчлэлийн асуудал, 2006/№4
3. Б.Энх-Амгалан, БНХАУ дахь хүний эрхийн төлөв байдал, 2005/№2

Өмгөөлөгч

4. Э.Зууннасан, Монгол улс болон БНХАУ-ын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн эрх зүйн байдлын харьцуулалт, 2008/№5

Эрх зүй сэтгүүл

5. Э.Зууннасан, Дундад улсын Эрүүгийн хууль дахь алах эрүү жич, түүнийг дахин хянах журам, 2004/№13-14
6. О. Хайтан, Хятад улсын эрх зүйн тогтолцоо хийгээд тулгамдаж буй асуудал, 2004/№13-14
7. Дин Вань Ин, Хятад, Монгол хоёр улсын бусдын газар нутаг дээр барилга байгууламж барих эрхийн харьцуулсан судлал, 2004/№13-14
8. Т.Мөнхжаргал, Монгол, БНХАУ-ын Иргэний хуулийг харьцуулан судлах асуудалд, 2011/№1
9. Э.Зууннасан, Хятад улс дахь хохирогчийн өөртөө заалдах эрхийн тухай, 2007/№16-17

Гэмт явдалтай тэмцэх асуудал

10. Зоу Баофен, Беккариагийн үзэл баримтлалтай БНХАУ-ын Эрүүгийн хуулийн зарчмыг баримжаалж үзэх нь, 2006/№2
11. Э.Зууннасан, Дундад улсын эрүүгийн хууль дахь таван ялын танилцуулга, 2003/№1
12. Zhang Xiuling, Дундад улс дахь насанд хүрээгүй хүний гэмт хэргийг сэргийлж шийдвэрлэж байгаа байдал, 2005/№3
13. Ма Раи Ран, БНХАУ-ын Эрүүгийн хууль дахь захиран хамаарах ялын тухай, 2007/№1



14. А.Мөнхтөр, Гадаадын зарим орнуудын Эрүүгийн хууль тогтоомжид завших үрэгдүүлэх гэмт хэргийг хуульчилсан нь, 21-23 дахь тал, 2005/№3
 - БНХАУ-ын эрүүгийн хууль тогтоомж, 23 дахь тал
15. Цэн Шиао Чин, БНХАУ-ын эмчилгээний эндэгдлийн тухай шинжилгээний дүрэм, түүнийг боловсронгуй болгох асуудал, 2007/№2

Б.СЕМИНАРЫН ХИЧЭЭЛ

НЭГДҮГЭЭР СЭДЭВ: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ

Нэр томъёоны тайлбар:

- **Харьцуулалт** судалгааны объектын нийтлэг хийгээд онцлог талыг нээн илрүүлэх үүднээс хууль зүйн үзэгдэлд харьцуулах хэсэг бүлэг аргыг хэрэглэж бүх талын гүнзгий цогцолбор анализ хийх идэвхтэй ажиллагаа.
- **Аргачлал** эрдэм шинжилгээний болон практикийн тодорхой асуудлыг шийдвэрлэхэд баримтлах дараалал, үйл ажиллагаанд ашиглагдаж буй аргыг хэрэглэх журам.

Харьцуулалтын ойлголт, төрөл, ач холбогдол

Харьцуулсан эрх зүй нь хоёр буюу түүнээс дээш улсуудын эрх зүйн тогтолцоог тодорхой зорилго, чиглэлтэйгээр зэрэгцүүлэн судлах замаар нийтлэг хийгээд онцлог шинжийг тодорхойлно. Харин үндэсний эрх зүйн тогтолцоон дотор харьцуулалт хийх нь харьцуулсан эрх зүйн зорилго биш юм. Гэхдээ үндэсний эрх зүйн тогтолцооны онцлогийг нарийвчлан тодорхойлоогүй үед бусад эрх зүйн тогтолцоотой харьцуулан судлах, нийтлэг хийгээд ялгаатай талыг бүрэн нээн илрүүлэх боломжгүй гэдгийг ямагт анхаарах хэрэгтэй.

Харьцуулалт нь **зорилго, зорилт, судалгааны цар хүрээ, судлаачийн хэрэгцээ, шаардлагаас** хамаараад ялгаатай түвшинд, өөр өөрийн онцлогтой хийгддэг.



Макро харьцуулалт- янз бүрийн эрх зүйн тогтолцооны мөн чанар, хэв маяг, арга зүй, бүтэц, түүх зэргийг бүхэлд нь харьцуулна.

Микро харьцуулалт- эрх зүйн тогтолцооны материаллаг болон процессын эрх зүйн тодорхой институтыг харьцуулна.


Онолын- харьцуулалтын үр дүнг эрдэм шинжилгээ, судалгаанд ашиглах зорилгоор хийсэн харьцуулалт.

Чиг үүргийн- үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн шилжүүлэг хийх зэрэг практик хэрэглээний зорилгоор хийсэн харьцуулалт.

Эрх зүйн аймаг хоорондын- хоёр буюу түүнээс олон эрх зүйн аймагт хамаарах эрх зүйн тогтолцоог харьцуулахыг ойлгоно.

Эрх зүйн аймаг доторх- нэг эрх зүйн аймагт хамаарах хоёр буюу түүнээс дээш эрх зүйн тогтолцоог харьцуулна.

Үндэсний эрх зүйн тогтолцоо доторх- холбооны улсын хоёр буюу түүнээс дээш субъектын эрх зүйн тогтолцоог харьцуулахыг ойлгоно.





Шүүмж харьцуулалт- судалж буй зүйлийн эерэг, сөрөг талыг нээн илрүүлэхэд чиглэнэ.

Урьдчилан таамаглах харьцуулалт- эрх зүйн үзэгдлийн өнгөрсөн ба одоо цагийн шинж төлөв, онцлогийг харьцуулсны үндсэн дээр ирээдүйн хандлагыг тодорхойлоход чиглэнэ.

Батлах харьцуулалт- судлагдахууны ижил төсөөтэй шинжийг илрүүлэхэд чиглэнэ.

Сөргүү харьцуулалт- судлагдахууны төсөөтэй шинж үгүйг батлахад ашиглана.

Асинхрон харьцуулалт- өнгөрсөн хугацаанд хамааралтай, түүхэн шинжийг илэрхийлсэн судалгаа.

Синхрон харьцуулалт- судалгаа нь одоо цагийн объектод тулгуурласан харьцуулалт.

Харьцуулалт хийх аргачлал

Эрх зүйн тогтолцоонуудыг харьцуулахдаа задлан шинжилгээг үр дүнтэй болгохын тулд судалгааны **тодорхой үе шатыг** дамжвал зохилтой. Энэ тухай судлаачдын үзэл баримтлалаас заримыг үзье.

Харьцуулсан эрх зүй судлаач К.Осаквегийн тодорхойлсноор:

Онолын харьцуулалт

- А ба Б системийн харьцуулсан журмуудыг илрүүлэх
- Тэдний нийтлэг ба ялгаатай шинжийг илрүүлэх зорилгоор журмууд (институт)-ыг зэрэгцүүлэх
- Өөрийн тогтолцоонд үйлчилж буй журмуудын үр нөлөө хийгээд амьдрах чадварыг нээн илрүүлэх
- Харьцуулж буй тогтолцоо бүр дэх тухайн журмуудын түүхэн шалтгаан нөхцөлийг тодорхойлох

Чиг үүргийн харьцуулалт

- Б эрх зүйн тогтолцооноос А тогтолцоонд шилжүүлэн суулгах замаар А эрх зүйн тогтолцооны хууль тогтоомж дахь хийдлийг нөхөх замаар үйлчилж буй журамд засвар оруулах шаардлагыг тогтоох
- Өөр тогтолцооноос нутагшуулж буй журмын тохирох эсэхийг тогтоох (Ж: тангарагтны шүүхийн институт Оросын эрх зүйд тохирох эсэх)
- Зээлдэн нутагшуулах журмыг орон нутгийн нөхцөлд нийцүүлэх (Ж: англи-америкийн эрх зүй дэх итгэлцлийн институт нь ОХУ-ын Иргэний хуульд эд хөрөнгийн итгэмжлэлийн үндсэн дээр мэдэх институт болж орсон)

Харьцуулсан эрх зүй судлаач П.Крузийн тодорхойлсноор:

Шийдвэрлэх асуудлаа аль болох тодорхой, нарийвчилсан байдлаар гаргах

Харьцуулагчийн хувьд гадаад улсын эрх зүйн талаар боломжтой бол аль эрх зүйн бүлд хамаарахыг тодорхойлох, танин мэдэх

Шаардлагатай үндсэн эх сурвалжийг тогтоох

Эрх зүйн соёл, эрх зүйн тайлбар хийх ялгаа, нийгэм-эдийн засгийн болон эрх зүйн бус хүчин зүйлийг тооцоолон, шийдвэрлэхээр зорьж буй асуудлын боломжит хариултыг гаргах

Үндсэн үнэт зүйлс болохын хувьд эрх зүйн зарчмуудад шүүмжлэлтэйгээр хандах

Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын талаар тодорхой дүгнэлт гаргах

Харьцуулсан судалгаа хийхэд анхаарах дүрэм

Харьцуулсан эрх зүйн судалгааны объект нэн өргөн, агуулга, багтаамж ихтэй, хэрэглэгдэж буй нэр томьёо, ухагдахуун нь улс орон бүрт ойлголтын болон чиг үүргийн хувьд ялгаатай, харилцан адилгүй байдаг зэрэг нь харьцуулалтыг хийхэд бэрхшээл учруулж байдаг. Иймд харьцуулсан судалгааг үр дүнтэй, бодитой, зөв хийхийн тулд дараах дүрмүүдэд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай.



Судлаач К. Осакве	Б.Амарсанаа (Ph.D)
<p>Эрх зүй нь яг л хэл хийгээд хөгжим лугаа адил ард түмнүүдийн соёл, уламжлал, сэтгэл зүй, сэтгэцийн түүхийг илэрхийлэх хэм хэмжээ мөн. Үнэмлэхүй адил эрх зүйн тогтолцоо дэлхий дээр байхгүй, байх ч бололцоогүй.</p>	<p>Харьцуулж болохуйц эсэхийг тунгаах шаардлагтай.</p>
<p>Эрх зүйн тогтолцооны харьцуулалтыг объектив оюуны эрэлхийлэлд түшиглэн хийх учиртай.</p>	<p>Аливаа эрх зүйн тогтолцоо тодорхой асуудлын хүрээнд адил, ойролцоо зүйлстэй тулгарч байдгийг анхаарах хэрэгтэй.</p>
<p>Харьцуулсан эрх зүй нь эрх зүйн тогтолцоог судлахдаа диалектик хандлагыг ашигладаг. Эрх зүйн тогтолцоо бүр өөрийн гэсэн давуу болон сул талтай байдаг. Тиймээс бусад эрх зүйн тогтолцооны туршлагад тулгуурлан үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох боломж байдаг.</p>	<p>Эрх зүйн тогтолцоо нь ойролцоо тохиолдлыг ялгаатай байдлаар шийдвэрлэдэг боловч харьцуулалтын үр дүнд хэт ялгаатай, эсвэл тодорхой асуудлыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэгддэггүй болох нь тогтоогдвол яаран дүгнэлт хийхээс өмнө үндсэн асуудлаа эргэн харах нь зөв. Дээрх тохиолдолд уг асуудлыг яагаад эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаггүй болохыг тогтоох нь ач холбогдолтой.</p>
<p>Эрх зүйн тогтолцоонууд нь түүхэн ялгаанаас үл хамааран тэдгээр нь хоорондоо ижилсэх, харилцан шалтгаалцах үйл явц ажиглагдаж байна.</p>	<p>Нийгмийн бүхий л дэд систем харилцан үйлчлэл дор оршдог гэдгийг анхаарах хэрэгтэй.</p>
<p>Эрх зүйн тогтолцоо бүр нийтийн эрх зүйгээс илүү хувийн эрх зүйн хүрээнд ижил төстэй байдлыг хадгалдаг бол нийтийн эрх зүй нь ихэнхдээ “цэвэр эрх зүй”-гээс илүүтэй “улс төр”-ийн нөлөөлөлд үндэслэдэг.</p>	<p>Тухайн судлагдаж буй гадаад улс орны эрх зүйн тогтолцоог аль болох гүн гүнзгий ойлгох хэрэгтэй.</p>
<p>Янз бүрийн эрх зүйн тогтолцооны үзэл санааг бие биенээс нь зээлдэн нутагшуулахыг хөхиүлэн дэмждэг. Гэсэн хэдий ч энэхүү зээлдэн нутагшуулсан зүйлсээ эрх зүйн тогтолцоондоо нийцүүлэхэд дүн шинжилгээ хийх шаардлагатай.</p>	<p>Шүүмжлэлтэй хандах нь харьцуулсан эрх зүй судлалыг ялгаатай болон төсөөтэй байдлын жагсаалт гарган тавих ядмаг байдлаас аврах хамгийн гол хэрэгслийн нэг.</p>
<p>Судалгааг хийхдээ тэдгээрийг сайн муугаар нь бүлэглэж үл болно. Харин тэдгээрийн бүрэлдсэн түүхэн нөхцөлийг ойлгох хэрэгтэй.</p>	<p>Тодорхой тохиолдлыг судлах нь илүү үр дүнтэй, нарийвчлалтай, үнэнд ойр байхад тустай.</p>
	<p>Асуудлыг тухайн харьяалагдах эрх зүйн тогтолцооны аливаа номлолоос нь салгаж ойлгох хэрэгтэй.</p>

Зөвлөмж: Харьцуулалт нь судлаачаас онолын болон арга зүйн мэдлэг, ур чадвар шаардсан нарийн төвөгтэй, чимхлүүр үйл явц бөгөөд харьцуулсан судлагаа хийхдээ хайхрамжгүй хандсанаас дараах алдаанд хүрч болохыг анхаарах хэрэгтэй.

Харьцуулалт хийх
объектыг буруу
сонгох

Нэр томьёо,
ойлголтыг буруу
хэрэглэх

Харьцуулалтын
түвшинг зөв
тогтоогоогүй

Эрх зүйн тодорхой
институт,
зохицуулалт үүсч
бүрэлдэхэд нөлөөлсөн
бодит хүчин зүйлсийг
зөв тооцоолоогүй

**Харьцуулалтын
явцад гарч
болзошгүй алдаа**

Үндэсний эрх зүйн
тогтолцооны өвөрмөц
онцлогийг оновчтой
тодорхойлоогүй,
түүнийг харгалзан
үзээгүй

Үндэсний хууль тогтоомжид
нийцгүй эрх зүйн зарчим,
үзэл баримтлал, эрх зүйн
зохицуулалтыг шууд
шилжүүлэх

Хэлэлцэх асуудал:

1. Эрх зүйн тогтолцоог судлах судалгааны үе шатуудын талаар ярилцаж, өөрсдийн хувилбарыг дэвшүүлээрэй.
2. Харьцуулсан судалгаа хийх үе шат, анхаарвал зохих дүрмийг баримтлан эрх зүйн аймгуудын үндсэн эх сурвалжийн харьцуулалтыг хийгээрэй. Уг харьцуулалт нь харьцуулалтын ямар төрөл, хэлбэрт хамаарахыг тодорхойлно уу.
3. Харьцуулсан эрх зүйн арга зүйн үндсэн зарчим нь “чиг үүрэг” (function)-ийн зарчим байна гэснийг учрыг тодорхой жишээн дээр тайлбарлана уу. Уг зарчим алдагдсанаас ямар алдаанд хүрч болох вэ?

Эх сурвалж:

1. Амарсанаа Б., Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он. 8-20 дахь тал
2. Минжүүрдорж Б., Даяаршиж буй дэлхий: харьцуулсан эрх зүй судлал УБ 2010 он. 5-19 дэх тал
3. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо УБ.2001 он. 218-226 дахь тал
4. Отгончимэг Н., Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он. 7-22, 34-41 дэх тал
5. Осаке К., Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги УБ. 2005 он. 12-17, 19-22, 47 дахь тал
6. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиумын илтгэлүүдийн эмхтгэл УБ. 2000 он. 55-60 дахь тал
7. Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2004 он. 102-111 дэх тал



8. Харьцуулсан эрх зүйн онол практикийн орчин үеийн асуудал /олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ. 2007 он. 10-20, 28-42, 62-74, 136-138 дахь тал
9. Сайдов А.Х Сравнительное правоведение М. 2007 г. с 23-52
10. www.comparativelaw.com
11. www.comparativelaw.org
12. www.llrx.com/comparative_and_foreign_law.html
13. www.unilex.info/dynasite.cfm?dssid=2375&dsmid=14276
14. www.ejcl.org/
15. www.lexadin.nl/wlg/

ХОЁРДУГААР СЭДЭВ: ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Нэр томьёо

Монизм – олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй нь нэг салбар бөгөөд эрх зүй нь нийтлэг нэг норматив шинжтэй.¹²

Дуализм – олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй хоёр хоёулаа эрх зүйн бие даасан тусдаа салбар.¹³

Плюрализм – дуализмийг хэлнэ.

Жерард Фитцморис–английн шүүгч. Фитцморисийн үзэл санааг үндэслэгч.

Олон улсын эрх зүй – олон улсын харилцаанд оролцогчдын (субъектийн) хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний системийг ойлгоно¹⁴.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ - гэдгийг олон улсын хамтын нийгэмлэгээс тогтоож, хүлээн зөвшөөрсөн, хууль зүйн хувьд заавал даган биелэгдэх хүчин чадалтай зан үйлийн журам гэж ойлгоно.¹⁵

Олон улсын гэрээ – олон улсын эрх зүйн субъектүүд нийтлэг ашиг сонирхолынхоо асуудлаар олон улсын эрх зүйд нийцсэн бөгөөд заавал биелэгдэх эрх, үүрэг үүсгэсэн харилцаа тогтоох шийдвэрээ илтгэн нотолсон тохиролцоог ойлгоно.

Бодлого 1

Монгол Улсын иргэн Х Баянгол дүүрэгт үйл ажиллагаагаа явуулдаг нэгэн компанидажиллаж байв. ИргэнХкомпанийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг

¹² Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ 2011, 35 дахь тал

¹³ Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ 2011, 35 дахь тал

¹⁴ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын эрх зүй, УБ 1999, 1 дэх тал

¹⁵ Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол №9, 2008.02.28

цаг тухайд нь хийж ирсэн бөгөөд компанийн ажилд аливаа доголдол гаргалгүй ажиллаж ирэв. Гэтэл компанийн захирал улс төрийн үзэл бодлын улмаас нэг өдөр ажлаас халсан тул иргэн Х Баянгол дүүргийн шүүхэд үндэслэлгүй ажлаас халсан гэж үзээд нэхэмжлэл гаргасан байна.

Асуулт:

Баянгол дүүргийн шүүх нэхэмжлэлийн дагуу Хөдөлмөрийн хууль болон бусад Монгол Улсын хууль тогтоомжийг иш үндэс болгохын зэрэгцээ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын алагчилахгүй байх (ажил, мэргэжил, хөдөлдмөр эрхлэлт) тухай 111 дүгээр конвенцийг нэхэмжлэлийн шаардлагыг хангахдаа иш үндэс болгож болох уу? Үндэслэлийг заана уу.

Бодлого 2

Монгол Улсын Засгийн газар өөр нэгэн улсын Засгийн газартай Улаанбаатар хотод соёлын төлөөлөгчийн газар байгуулах тухай хэлэлцээр байгуулав. Хэлэлцээрийг Засгийн газраар батлуулж хүчин төгөлдөр болсны дараагаар тэрхүү улсын соёлын төлөөлөгчийн газрыг Улаанбаатар хотноо албан ёсоор нээж үйл ажиллагааг эхлүүлэв. Тус төлөөлөгчийн газарт 10 гаруй гадны иргэд ажиллах бөгөөд хэлэлцээрийн дагуу тэдгээр хүмүүс дархан эрх ямба эдлэхээр заасан байна. Нэгэн өдөр тус төлөөлөгчийн төвд ажилладаг гадны иргэн эрүүгийн хэрэг үйлдсэн нь тогтоогдсон тул түүнд эрүүгийн хэрэг үүсгэхээр болсон байна.

Асуулт:

1. Засгийн газар хоорондын хэлэлцээр нь олон улсын гэрээнд хамаарах уу?
2. Төлөөлөгчийн газарт ажилладаг, хэлэлцээрийн дагуу дархан эрх ямба эдэлдэг гадны иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох уу?

Эх сурвалж:

1. ХЗҮХ, ФСЭЗХ, МУИС Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төв, Монголын олон улсын эрх зүйн нийгэмлэг Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ 2011
2. Б.Гүнбилэг, А.Төмөр, Харьцуулсан эрх зүй, УБ 2005
3. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын эрх зүй, УБ 1999
4. Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол №9, 2008.02.28
5. Nutshells international law (2nd edn), 2010 он, Rebecca M.M.Wallace, Anne Holiday



6. Ian Brownlie, Principles of Public International law, 6th edn, 2003
7. И.П.Блищенко, Ж.Дориа, Прецеденты в международном публичном и частном праве, Москва 1999

ГУРАВДУГААР СЭДЭВ: ЭРХ ЗҮЙН АЙМАГ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ

Нэр томъёоны тайлбар:

Эрх зүйн аймаг гэдэг нь эрх зүйн үүсэл, хувьсал, хөгжлөөрөө нэгдмэл, эрх зүйн эх сурвалж, эрх зүйн ухамсар, соёл боловсрол, бусад элементээрээ ижил төсөөтэй шинжүүдийг агуулсан улс орнуудын эрх зүйн тогтолцооны нэгдлийн тухай ойлголт.

Эрх зүйн уламжлал бол тухай нийгэмд гүйцэтгэх эрх зүйн чиг үүрэг, эрх зүйн мөн чанар, улс төрийн үзэл суртал, эрх зүйн тогтолцооны бүтэц, зохион байгууллалтын талаарх түүхэн урт хугацааны туршид хүмүүсийн ухамсарт төлөвшин тогтсон төсөөлөл.

Эрх зүйн соёл гэж аливаа эрх зүйн харилцааны хүрээнд илрэн гарах эрх зүйн мэдлэг, хэвшил, дадал, үйлдэл ба дагаж мөрдөж буй хууль тогтоомжийг хүндэтгэн, тэдгээрийг гуйвалтгүй сахин хангах тогтолцоо.

Дэлхийн эрх зүйн тогтолцоо гэдэг нь улс орны эрх зүйн тогтолцоог эрх зүйн аймгуудад хуваан үзэж ялган заагласан агаад тэдгээрийг зохих хэв шинжээр нь нэгтгэн үзэх явдал.

Эрх зүйн эх сурвалж гэж эрх зүйг бий болгож байгаа уг үндэс, эрх зүйн хэлбэр агуулгыг урьдаас тодорхойлж байгаа хүчин зүйлсийн тогтолцоо.

Эрх зүйн институт бол тухайн буюу хэд хэдэн салбар эрх зүйн дотоодод объектив байдлаар онцгойрон ялгарсан төрлийн шинж бүхий хэсэг бүлэг харилцааг зохицуулдаг эрх зүйн харилцан холбоотой хэм хэмжээний нийлбэр.

Шүүхийн жишиг гэдэг нь өөр нэгэн шүүх өмнө нь шийдсэн хэргийн шийдвэрийг өөр шатны шүүх, байгууллага, эсвэл ижил шатны шүүх, байгууллага ашиглаж хэргийг шийдэхийг жишиглэх гэх ба түүнд хэрэглэгдэж байгаа эх сурвалж буюу хэм хэмжээ.

Заншил гэж олон удаа давтагдан хэвших замаар зан үйлийн журам болж, төрийн хамгаалалтад авагдсан хийгээд түүний албадлагын хүчээр хангагддаг тодорхой нийгэмд буюу газар нутагт түүхэн ёсоор бүрэлдэн тогтсон зан үйл.

Заншлын эрх зүй гэдэг нь удаа дараа уламжлагдан хэрэглэгдсэн ба засаг төрөөс хүлээн зөвшөөрсний үр дүнд нийгэмд бүрэлдэн тогтсон зан үйлийн журмын нийлбэр цогц.

Дэлхийн эрх зүйн тогтолцооны ангилал буюу эрх зүйн аймгийн газар зүйн зураг

Зураг 1




Дэлхийн эрх зүйн тогтолцооны социалист эрх зүйн аймгийг орчин үед өөрчилсөн хандлага байгаа бөгөөд тухайлбал, дээрх зурган дээр нийтлэг эрх зүйн аймгийг улбар шар, хөх өнгөөр Ром-Германы эрх зүйн аймгийг, улаан өнгөөр шашны буюу Мусальманы эрх зүйн аймгийг дүрслээд ногоон өнгөөр тэмдэглэсэн улсуудыг хомилог эрх зүйн аймаг гэж тодорхойлжээ. 1990-ээд оноос хойш дэлхийн улс төр, эдийн засаг, үзэл суртлын амьдралд эрс өөрчлөлт гарснаас өөрөөр хэлбэл, социалист дэглэм задран социалист эрх зүйн мөн чанар, агуулгын хувьд бие даасан систем байна гэж үзэхэд зарим талаар бэрхшээлтэй болж байна.

Тухайлбал, социалист эрх зүйн аймгийг уламжлалт эрх зүйн аймаг гэж үзэж томъёолох чиг хандлага байна. Энэ чиг хандлагаар эрх зүйг аймагчилбал:

- Эх газрын эрх зүйн аймаг буюу Ром-Германы эрх зүй;
- Нийтлэг эрх зүйн аймаг буюу Англи-Америкийн эрх зүй;
- Уламжлалт эрх зүйн аймаг;
- Лалын эрх зүйн аймаг;
- Холимог эрх зүйн аймаг гэж 5 ангилсан байна.

Мөн түүнчлэн а) эх газрын эрх зүй, б) нийтлэг эрх зүй, в) уламжлалт, г) шашны эрх зүй, д) эх газрын болон нийтлэг эрх зүй, е) үл танигдах гэж ангилсан дэлхийн эрх зүйн тогтолцооны газар зүйн зураг байна.

Эх газрын болон нийтлэг эрх зүйн холимог аймаг нь 2 янз бөгөөд эрх газрын эрх зүйн аймаг дээр тулгуурласан нийтлэг эрх зүйн холимог эрх зүй болон нийтлэг эрх зүйн аймаг дээр суурилсан эх газрын эрх зүй гэж байдаг.



Хэлэлцэх асуудал:

1. Дэлхийн эрх зүйн тогтолцооны ангиллын талаарх дээр 2 газар зүйн зурагт анализ хийн, шинэ чиг хандлага, үзэл баримтлалын талаар багаар ярилцан аль чиг хандлага нь ямар онцлогтой байгааг шинжлэн ярилцана уу.
2. Эрх зүйн аймгийн үндсэн эх сурвалж болдог хууль, шүүхийн шийдвэр болон заншил зэрэг нь дангаар үйлчилдэг улс байдаг эсэх талаар багаар ярилцана уу.
3. Өөрсдийн сонгосон эрх зүйн аймгийн ангиллын талаарх дэлхийн улсуудын эрх зүйн тогтолцооны газрын зурагт дүн шинжилгээ хийж, багаар ярилцлага зохион байгуулах

Санал болгож буй арга: Чөлөөт хэлэлцүүлэг
Хүн бүр багш

Эрх зүйн эх сурвалж нь эрх зүйн аймгийг ангилах шалгуур болох нь

Эрх зүйн эх сурвалж нь эрх зүйн аймгийг ангилах шалгуур болох асуудал нь эрдэмтэн судлаачдын дунд зарим маргаантай байсан боловч одоо энэ нь маргаантай асуудлын хүрээнээс гарсан. Англи-Америкийн эрх зүйн аймгийг бусад аймгаас ялгах гол шалгуур нь шүүхийн жишиг бөгөөд өөрөөр хэлбэл, үндсэн эх сурвалж нь төрөөс тогтоосон хууль биш харин шүүхийн хэвшүүлсэн шийдвэр байна. Харин эх газрын эрх зүйн буюу Ром-Германы эрх зүйн аймгийн гол тодорхойлогч шинж нь хууль тогтоогчийн баталсан бичмэл хуулиуд хийгээд хэм хэмжээний бусад акт гол эх сурвалж нь болж, хууль хэрэглэгчид нь түүнийг баримтлан ажилладаг. Гэхдээ эдгээр эрх зүйн аймгийн аль алинд нь хууль болон шүүхийн жишгийг хэрэглэж байгаа боловч аль нь гол эх сурвалж болох асуудлаар ихээхэн ялгаатай байгаа нь эдгээрт хандах хандлага, хийсвэрлэлийн арга, техник нь хангалттай ялгаатай болохыг тодорхой харуулдаг. Эх газрын

эрх зүйн буюу Ром-Германы эрх зүйн аймгийн хувьд эрх зүйн эх сурвалжийн асуудлыг хөндөх тохиолдолд заавал биелэгдэх шинжтэй эх сурвалж болон заавал биелэгдэх шинжгүй эх сурвалж гэж авч үзэх нь зүйтэй юм.

Хэлэлцэх асуудал:

1. Эрх зүйн аймаг буюу уламжлалын шалгуур нь эрх зүйн эх сурвалж мөн эсэх талаар эрдэмтэд судлаачид өөр өөрийн үзэл баримтлалтай байдаг. Тэгвэл энэ талаар өөрсдийн санааг гарган түүнийгээ нотлон жишээгээр тайлбарлана уу.
2. Эх газрын эрх зүйн аймгийн заавал биелэгдэх шинжтэй эх сурвалжид:
 - a) Үндсэн хууль
 - b) Олон улсын гэрээ
 - c) Хууль
 - d) Хуульчилсан акт
 - e) Иргэний эрх зүйн хэлцэл зэрэг багтана.

Харин шүүхийн жишиг, эрдэмтдийн номлол, гадаад орнуудын шүүхийн хууль болон шүүхийн шийдвэр зэрэг нь ямар эрх зүйн эх сурвалжид тооцогдох вэ? Мөн Англи-Америкийн заавал биелэгдэх болон заавал биелэгдэх шинжгүй эх сурвалжийг жишин багаар ярилцана уу.

3. Эрх зүйн аймгийн үндсэн эх сурвалж болдог хууль, шүүхийн шийдвэр болон зан заншил зэрэг нь дангаараа үйлчилдэг улс орон байдаг уу? Байх боломжтой эсэхээр ярилцлага зохионо уу.

Дэлхийн эрх зүйн тогтолцооны нэгэн бүрдэл болох Монгол Улсын эрх зүйн онцлогийг бусад улс орныхтой харьцуулан үзэх нь

Монгол Улсын эрх зүй нь дэлхийн эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийн хувьд нийтлэг олон шинжийг агуулж буй бөгөөд түүнчлэн түүхэн хөгжлийн талаас ч өөрийн өвөрмөц онцлогтой байна. Хамаг Монгол улсын үед (1101-1206) монголын эрх зүй нь үндсэндээ заншлын эрх зүйгээс бүрдэж байсан ба Их Монгол улсын үед ч мөн адил заншлын эрх зүй голлож байсан боловч шинж чанар, агуулгад нилээд өөрчлөлт оржээ. XIII-XIV зууны үед монголчууд Юан гүрнийг байгуулж олон хууль баталснаас гадна Чингис хааны Их засаг хууль ч мөн адил үйлчилж байсан. XX зууны эхэн хүртэл Монгол улсын эрх зүй нь Манжийн төрийн бодлогыг тодорхойлсон олон хууль гарсан боловч заншлын хэм хэмжээ хүчтэй хэвээр байжээ. 1920-оод оноос хойш монголын эрх зүйд шууд өөрчлөлт орсон бөгөөд 1924 онд анхны Үндсэн хууль батлагдан гарах үйл явц нь Оросын эрх зүйн нөлөөнд хийгдсэн гэж үзэж болно. 1940-өөд



оны дунд үеэс Монгол Улс дэлхийн социалист эрх зүйн тогтолцооны хүрээлэлд орсноор социалист эрх зүй бодитойгоор хэрэгжиж эхэлсэн. 1990 оноос манай улс ардчилсан дэглэмд шилжиж түүнчлэн 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа баталж, хууль дээдлэх ёсны зарчмыг баримтлахаар тунхагласан юм. Ингэснээр Монгол Улс эх газрын эрх зүйн аймагт шилжин орсныг харуулсан хэрэг болсон байна.

Орчин үеийн дэлхийн эрх зүйн тогтолцооны газар зүйн зурагт Монгол Улсыг уламжлалт эрх зүйн аймагт, эх газрын эрх зүйн аймагт болон холимог эрх зүйн аймагт хамруулан янз бүрээр ангилсан байна.

Хэлэлцэх асуудал:

1. Үндэсний эрх зүйн тогтолцоо нь эрх зүйн аймгийн ангилалд ямар үүрэг гүйцэтгэдэг талаар багаар ярилцана уу.
2. Монгол улсын эрх зүйн тогтолцооны онцлог нь дэлхийн эрх зүйн тогтолцоо болон эрх зүйн аймгийн ангилалд хэрхэн нөлөөлж болох талаар багаар хэлэлцүүлэг зохионо уу.
3. Монгол Улсыг уламжлалт эрх зүйн аймагт, эх газрын эрх зүйн аймагт болон холимог эрх зүйн аймагт хамруулан ангилсан байдаг. Энэ талаар өөрсдийн үзэл бодлыг илэрхийлэн маргаан өрнүүлнэ үү.
4. Оросын нэрт эрдэмтэн Ю.А. Тихомиров Монголыг шашин заншлын гарал бүхий “Алс Дорнодын эрх зүйн тогтолцоотой” гэж үзсэн байна. Монгол Улс шашны эрх зүйн бүлд багтана гэдэг талаар дүн шинжилгээ хийнэ үү.
5. Доктор Б.Чимид “эрх зүйн аль нэг бүл, тогтолцоог давамгайлуулан үзэж, “туйлшруулах”, эсхүл тэдгээрийн онцлог ялгааг хайхрахгүйгээр алмайрах энэ хоёр хандлагын алиныг ч хүлээн зөвшөөрч болохгүй. Харин эрх зүйн бүлүүд, үндэсний эрх зүйн тогтолцоонууд адил тэгш “статустай” гэсэн үзлийг удирдлага болгон Монголын эрх зүй аль тогтолцооны бүлд илүү ойрыг тодорхойлох учиртай.” гэж хэлсэн байна. Даяарших үзэгдлийг эрх зүйг тогтолцоог аймагчлах явдалд нөлөөлнө гэж үзэж болох уу? Дээрх ойлголтын талаар багаар хэлэлцүүлэг зохионо уу.

Эх сурвалж:

1. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо, Олон улсын симпозиумын баримт материал, УБ., 2000 он. 58-60 дахь тал.
2. Нарангэрэл С., “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо” /харьцуулсан эрх зүй/ УБ., 2001.
3. Нарангэрэл С., “Эрх зүйн эх толь бичиг”, 2007 он, 201, 639, 645 дахь тал.
4. Болортогос Б, Батханд Я., “Харьцуулсан эрх зүй”, УБ., 2012 он, 88 дахь тал.
5. Минжүүрдорж Б., “Даяаршиж буй дэлхий: Харьцуулсан эрх зүй судлал”, 2010 он, 33 дахь тал.

6. Минжүүрдорж Б., “Эрх зүйн онол”, 2010 он, 64 дэх тал.
7. “Харьцуулсан эрх зүйн онол, практикийн очин үеийн асуудал”, Шихихутаг хууль зүйн дээд сургууль, 2007 он, 48 дахь тал.
8. <http://www.slideshare.net/guest52c665/the-legal-systems-of-the-world> сүүлд зочилсон 2012.12.25
9. http://www.notariusinternational.uinl.org/DataBase/2009/Notarius_2009_01_02_worldmaps.pdf сүүлд зочилсон 2013.1.17
10. <http://chartsbin.com/view/aq2> сүүлд зочилсон 2013.1.10

ДӨРӨВДҮГЭЭР СЭДЭВ: РОМ-ГЕРМАНЫ ЭРХ ЗҮЙ БОЛОН АНГЛИ-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙГ ОЙРТУУЛАХ

Харьцуулан судлах хэрэгцээ, шаардлага

Дэлхийн II дайнаас хойш харьцуулсан эрх зүй судлаачид Ром-Германы болон Англи-Америкийн эрх зүйн хоорондын хамаарал, нийтлэг болон онцлогийг эрчимтэй судалж эхэлсэн байна.

Энэ нь онолын төдийгүй практик, прагматик талаасаа чухал ач холбогдолтой байлаа. Ялангуяа, сүүлийн жилүүдэд нэг талаас Герман, Франц зэрэг “хуучин ардчилалтай” орнууд, нөгөө талаас Польш, Чех, Латви, Литва зэрэг “шинэ ардчилалтай” орнууд хэдийгээр хөгжлийн түвшин, соёл, эдийн засгийн бүтцээрээ ялгаатай ч Европын холбооны хүрээнд нэгдмэл ертөнц байгуулах эрмэлзэлтэй байна.

Эдийн засаг, нийгэм, улс төрийн төдийгүй эрх зүйн чиглэлээр ойртох, үүний тулд улс бүрийн эрх зүйн тогтолцоо, эрх зүйн аймгийг уялдуулах, жигдрүүлэх, ижилтгэх арга замын талаар харьцуулсан судалгааг өргөн хэмжээтэй хийж байна

Европын холбооны гишүүн орнуудын эрх зүйн тогтолцоо, эрх зүйн аймгийн харьцуулсан судалгаа нь бусад оронд ч улам их хамаарах болж байна. Тухайлбал, Монгол Улс Европын холбооны байгууллагуудтай хамтран ажиллаж, гэрээ байгуулж байна. Европын стандартыг Монголд нутагшуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд харьцуулсан эрх зүйн судалгааг өргөжүүлэх шаардлагатай.

Зарим онцлог

Дэлхийн улсуудын эрх зүйн тогтолцоо, эрх зүйн аймгийг онолын төдийгүй практик талаас нь ажиглахад Ром-Германы ба Англи-Америкийн эрх зүйн аймаг гэж хэт тусгаарлан туйлчилж ангилах шаардлагагүй юм. Зарим жишээг дурдья:



- а) Хэдийгээр Ром-Германы эрх зүйд гарцаагүй суурилдаг боловч зарим эрдэмтэд Норвеги, Швед, Дани, Финландийг хамарсан эрх зүй нь бие даасан “Скандинавын” эрх зүйн аймаг гэж үзэж байна.
- б) Ром-Германы болон Англи-Америкийн эрх зүйн тогтолцооны нийтлэг ба онцлогийг судлахдаа түүхэнхийгээд бусад учир шалтгааны улмаас “Холимог эрх зүйн уламжлал” бүрэлдэн тогтсоныг анхаарах шаардлагатай.

Жишээ 1:

Америк тивд өмнө нь Францын колони байсан, одоо АНУ-ын нэг муж болох Луизиан мужид хувийн эрх зүйн хувьд ром-германы эрх зүйн уламжлал, зарчим, институт үйлчилж байгаа бол нийтийн эрх зүйн хувьд нийтлэг эрх зүй, америкийн эрх зүйн уламжлал, зарчим хэрэгжиж байна.

Жишээ 2:

Канадын холбооны нэг субъект болох Франц хэлтнүүд оршин суудаг Квебек мужийн нийгмийн амьдралд 150 гаруй жилийн өмнөөс Ром-германы эрх зүйн аймаг оршин тогтнож үйлчилсээр иржээ. 1867 онд Англичууд Канадыг өөрийн хараат орноор зарласнаас хойш англи-америкийн эрх зүйн институт, уламжлал хэрэгжиж байна. 1866 онд “Доод Канадын иргэний хууль” батлагдсаны гадна 1981 онд “Квебекийн иргэний хууль” батлагдсанаар Квебекийн эрх зүйн тогтолцоонд эрх зүйн хоёр аймгаас бүрдсэн “завсрын” шинжтэй эрх зүй үйлчилж буйг харуулж байна.

Жишээ 3:

Өмнөд Африкийн бүгд найрамдах улсад Данийн эрх зүйн нөлөөгөөр ром-германы эрх зүй, Английн эрх зүйн нөлөөгөөр англи-америкийн эрх зүй “завсрын” шинжтэй үйлчилж байна. Шотланд болон бусад зарим орны эрх зүйн аймагт ч ийм шинж байна.

Ром-Германы болон Англи-Америкийн эрх зүйн адил тал нь

Хэдийгээр Ром-Германы болон Англи-Америкийн эрх зүйн аймаг ялгаатай боловч тэдгээрийг адилтган үзэх суурь бий гэдгийг харьцуулсан эрх зүй судлаачид нотолдог.

Энэ нь юуны өмнө барууны ардчилал юм.

Европын холбооны хүрээнд явагдаж буй ижилтгэх, нэгтгэх үйл явц нь тэдгээр улсын эрх зүйг адил болгох нөхцөл болж байна.

Капиталист зах зээлийн эдийн засаг нь эрх зүйн аймгийн адил шинжийг улам тодруулж байна. Газар өмчлөл, чөлөөт өрсөлдөөн, үндэсний болон улс хоорондын корпорациудын хөгжил, өсөлт нь үүний нотолгоо болж байна. Нийгэм улс төрийн байгуулалт, либераль үзэл баримтлал, иргэншлийн ба соёлын язгуур

үндэс нь Ром-Германы ба Англи-Америкийн эрх зүйн нийтлэг шинжтэй болохыг харуулж байна.

Ром –Германы ба Англи-Америкийн эрх зүйг ойртуулах арга зам

Ямар арга замаар ойртуулах вэ?

Эрх зүйн эх сурвалжийг ойртуулах, жигдрүүлэх.

Орчин үед эрх зүйн хүрээний европчилох хандлага, европын шинэ дэг журам тогтоох бүс нутгийн болон даяаршсан дэг журам тогтоох бодлого нь эрх зүйн хоёр аймгийг ойртуулах чухал үндэс болж байна.

Эрх зүйн эх сурвалжийг ойртуулах процесст эрх зүйн хэм хэмжээний акт (юны өмнө хууль), шүүхийн шийдвэр, заншил, олон улсын гэрээ, эрх зүйн нийтлэг зарчим, эрх зүйн номлол хамаарагдаж байна. Ром-Германы эрх зүйн уламжлалд шүүхийн шийдвэрийг эрх зүйн эрх сурвалжид тооцдоггүй байсан. Гэвч сүүлийн жилүүдэд шүүхийн шийдвэр (жишиг)-ийг эрх зүйн эх сурвалж болохыг улам бүр хүлээн зөвшөөрч байна.

1912 онд батлагдсан Швейцарийн иргэний хуульд шүүгч хуулийн заалтыг ягштал мөрдөхөөс гадна хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн номлол, шүүхийн жишгийг удирдлага болгох ёстой гэж заасан байдаг.

Эрх зүйн бүтэц, агуулгыг ойртуулах.

Эрх зүйн хоёр аймгийн хуучин бүтцийг өргөжүүлж, нийтлэгээр хэрэглэхийн зэрэгцээ шинэ салбар, институтийг бий болгох үйл явц хэрэгжиж байна. Тухайлбал нэгдлийн (корпораци) эрх зүй, мэдээллийн эрх зүй, интернет эрх зүй зэрэг шинэ салбар үүсэн төлөвшиж байна.

Ром-Герман, Англи-Америкийн эрх зүйн аймгийг бүтэц, агуулгын хувьд ойртуулах нэг арга зам нь шүүхийн хяналтын тогтолцоо, арга барилыг жигдрүүлэх үйл явц болж байна.

Хэлэлцэх асуудал:

1. Ром-Германы ба Англи-Америкийн эрх зүйн нийтлэг ба ялгаатай талыг тайлбарлах. Нийтлэг зүйлийн талаар дэлгэрэнгүй тайлбарлаж ярилцах.
2. Ром-Германы ба Англи-Америкийн эрх зүйн аймаг тус бүрийн эрх зүйн эх сурвалжийн талаар ярилцах.
3. Англи-Америкийн ба Ром-Германы эрх зүйг ойртуулах арга, хэлбэрийн талаар ярилцах.

Эх сурвалж:

1. Амарсанаа Б. Харьцуулсан эрх зүй судлал. УБ. 2005 он
2. Осакве К. Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги. УБ. 2005 он
3. Марченко М.Н. Сравнительное правоведение. М.2011 г.



4. Давид, Р. Основные правовые системы современности. М., 1988 г.
5. Отгончимэг Н. Харьцуулсан эрх зүй УБ.2001 он.
6. Амарсанаа Ж. Монгол Улсын харьцуулсан судалгааны хөгжил. “Зүүн Хойд Азийн орнууд дахь харьцуулсан эрх зүйн асуудал” олон улсын бага хуралд тавьсан илтгэл. 2009 он. Хятадын Чан Чун хот
7. Амарсанаа Ж. Харьцуулсан эрх зүйн онолын асуудал. Эрх зүй. Онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2000 он. №2
8. Амарсанаа Ж. Монгол Улс дахь харьцуулсан эрх зүйн судалгаа. Судалгааны илтгэлийн эмхтгэл. 2006 он.
9. Амарсанаа Ж. Монгол Улс дахь харьцуулсан эрх зүйн төлөв байдал. Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн “Эрдмийн ертөнц” сэтгүүл. УБ., 2008 он
11. Амарсанаа Ж. Монголын эрх зүйн хөгжил ба Дэлхийн эрх зүйн газрын зураг. /Монголын эрх зүйн түүхэн хөгжил, ирээдүйн хандлага. Бага хурал/. УБ.,2010 он

ТАВДУГААР СЭДЭВ: СКАНДИНАВЫН ЭРХ ЗҮЙ

1.Скандинавын эрх зүйн түүхэн хөгжил, Германы эрх зүйн үзүүлсэн нөлөө



Хойд Европын Швед, Норвеги, Дани, Исланд, Финланд улсууд хамаарна. Скандинавын орнууд эрх зүйн аль аймагт хамаарах тухайд ихэнх судлаачид “Энэ бүс нутгийн улс орнуудын үндэсний эрх зүйн тогтолцоон дахь эрх зүйн үндсэн ойлголт, категориуд нь Ром-Германы эрх зүйн аймгийнхтай адил мөн Англи-Америкийн эрх зүйн аймагтай харьцуулбал илүү хийсвэр шинжтэй” тул Ром-Германы буюу эх газрын эрх зүйн аймагт хамаарна гэж үзэж байна.

Скандинавын эрх зүйн хөгжлийн түүхэн тойм:

ХIY зуун хүртэл :

- Хойд Европын улс орнууд төрийн удирдлагын шатлан захирах тогтолцоо хөгжөөгүй, зөвхөн чөлөөт тариачдаас бүрдсэн, сүм хийдийн зүгээс нийгмийн зөрчилдөөнийг хүн амын янз бүрийн давхаргын ашиг сонирхлыг харгалзан шийдвэрлэх ардчилсан арга, хэлбэрийг сонгосон, эцгийн эрхт ёсыг бэхжүүлсэн эдийн засгийн бүтэц, хөгжилтэй байсан.
- Шведэд хууль тогтоомжийг консолидацчилж эхэлжээ.

ХIY-ХYII зууны үе

- Орон нутгийн эрх зүйг газрын эрх зүйтэй ижилсүүлэн хотын эрх зүй бий болох үйл явц эхэлжээ. Шведэд нэг нь хөдөө орон нутгийн оршин суугчдын харилцааг зохицуулдаг, нөгөө нь хотын иргэдийн хоорондын харилцааг зохицуулсан хоёр хуультай болж, эдгээр нь 400 жил үйлчилжээ. ХYII зуунаас Шведийн шүүхийн практикт ромын эрх зүйн зарчим, эрх зүйн хэм хэмжээг шилжүүлэн авсанаар ромын эрх зүйн элемент Шведийн эрх зүйн салшгүй хэсэг болсон.

ХYIII зуунаас одоо

- Хууль тогтоомжоо кодификацчилж эхэлсэн. 1880-аад оноос эхлэн Дани, Норвеги, Швед улсууд үндэсний хууль тогтоомжоо хооронд нь ижилтгэх үйл явцыг эхэлж үнэт цаасны тухай, барааны тэмдгийн тухай, худалдааны эргэлтийн тухай гм худалдааны хууль тогтоомж болон далайн эрх зүйн нэгдсэн төрөлжсөн хуультай болсон.
- Скандинавын эрх зүйн үндэс нь данийн болон шведийн эрх зүйн тогтолцоо гэдгийг, нөгөө талаас энэ эрх зүйд эх газрын эрх зүйн аймгийн нөлөө байгааг харуулж байна.
- Эдгээр улс орнууд эрх зүйн тогтолцоогоо өөр хоорондоо төдийгүй Европын эрх зүйтэй ижилсүүлэх үйл явц эрчимтэй явагдаж байна.

Нэг дэх хэсэг:

Дани, Норвеги, Исланд зэрэг улс хамаарна. ХYII зууны II хагасаас эхлэн дани, норвегийн эрх зүйд тулгуурлан үндэсний эрх зүйн тогтолцоо нь хөгжсөн

Хоёр дахь хэсэг:

Швед, Финлянд зэрэг улс хамаарна. 1734 оны Шведийн хуульд тулгуурлан үндэсний эрх зүйн тогтолцоо нь хөгжсөн.

Энэ хоёр хэсэг нь өөр хоорондоо харилцан ижилсэх нь :

Түүхэн урт удаан хугацааны туршид газар зүйн болон угсаатны зүйн харилцан хамааралтай оршин байгаа

Ромын эрх зүйг шилжүүлсэн нөлөө бараг байхгүй.

Ром-Германы эрх зүйн аймагийн адил эрх зүйг салбараар ангилах, хуулийг төрөлжүүлдэггүй.

Скандинавын эрх зүйд эрх зүйг нийтийн ба хувийн эрх зүй гэж ангилахгүй, эрх зүйг салбараар ангилахгүй, төрөлжсөн хуульгүй зэрэг шинжээрээ Англи-Америкийн эрх зүйн аймагт хамаархуйц байна . Кодификаци Ром-Германы эрх зүйн аймгийн улс орнуудад бүхэлд нь хамаарах нийтлэг шинж мөн гэж үзэж болохгүй болох нь харагдаж байна.

XIX-XX зуунаас скандинавын хуульчид германы эрх зүйн туршлагыг нэвтрүүлэн эрх зүйн шинэчлэлт хийсэн нь Шведийн бараг бүх хуульчид германы их сургуулиудад хуулийн боловсрол эзэмшсэнтэй холбоотой ч тэд Германы пандектын эрх зүй, төрөлжсөн хуулийн загвараас татгалзаж Францын загварыг нэвтрүүлсэн нь скандинавын эрх зүйн уламжлалтай холбоотой.



1899 онд Шведийн профессор Б.Ларсан “хувийн эрх зүйн бүх салбарын эрх зүйн зохицуулалтыг ижилсүүлнээр скандинавын иргэний нэгдсэн төрөлжсөн хуультай болох” саналыг дэвшүүлсэн. Үүнийг улс орнуудын төр засгийн зүгээс зарчмын хувьд дэмжиж иргэний нэгдсэн хуулийн төсөл боловсруулсан ч үл хөдлөх эд хөрөнгө, үүргийн эрх зүйн хүрээний эрх зүйн зохицуулалтын ижилсэлтийг илүү чухалчлан үзсэнээр эдгээр салбарт нэгдсэн хууль үйлчилж байна. Мөн гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын ижилсэлт эрчимтэй явагдаж эх газрын европын улсуудаас ч түрүүлэн гэр бүлдэх эхнэр нөхрийн тэгш эрх, гэрлэлт цуцлах үндэслэл, гэрлэлтээс гадуур төрсөн хүүхдийн эрхийг хамгаалах зэрэг эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна. Мөн 1872 онд болсон скандинавын орнуудын хуульчдын их хурлаас бүс нутгийн эрх зүйг ижилсүүлэх шийдвэр гаргаж хэрэгжүүлсний үр дүнд одоо гэр бүл, гэрээний эрх зүй, компанийн болон оюуны өмчийн эрх зүйн салбарт харьцангуй хурдацтай, харин эрүүгийн эрх зүй, татварын эрх зүй, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн харилцаанд үндэстний онцлогтой уялдсан эрх зүйн ижилсүүлэх үйл явц удаашралтай байна.

Дэлхийн II дайнаас хойш скандинавын улс орнуудад америкийн эрх зүйн үзэл номлол, хууль зүйн прагматик хандлага хүчтэй нөлөөлөх болж хууль зүйн сургалтын америкийн арга зүйн загварыг нэвтрүүлснээр даатгал, гэрээний хариуцлагын салбар дахь хууль зүйн ойлголт, нэр томьёо, хэм хэмжээний бүтэц зэрэгт нөлөөлсөн.

Орчин үед скандинавын эрх зүйн нэг давуу тал бол нийт европын эрх зүй бүрэлдэн хөгжих загвар болж байна гэж судлаачид үнэлж байна. Скандинавын улсуудын эрх зүй нь хууль зүйн үзэл баримтлалын хувьд өөр хоорондоо адил.

Скандинавын эрх зүйн эх сурвалжийн тогтолцоонд германы эрх зүйн үзүүлсэн нөлөө:

- Скандинавын болон германы хуульчид хамтран ажиллаж эрх зүйн мэдээллийг харилцан солилцож байдаг.
- Скандинав болон Герман нь хэл, соёлын уламжлалаар адил
- Германы эрх зүйн тогтолцоо нь хууль зүйн ойлголт, хууль зүйн сэтгэлгээ, эрх зүйн хэм хэмжээний логик бүтэц, үндэслэлийн хувьд хөгжлийн өндөр түвшинд хүрсэн

2. Скандинавын эрх зүйн эх сурвалж:



3. Норвегийн эрх зүйн тогтолцооны онцлог:



- Төрийн байгууламжийн хувьд 19 засаг захиргааны нэгж-мужаас бүрдэх нэгдмэл улс
- Төрийн удирдлагын хэлбэрийн хувьд Үндсэн хуульт парламентын хаант засаглалтай.
- Төрийн тэргүүн хаан хууль санаачлах эрхтэй.

Хууль тогтоох эрх мэдлийг

Парламент-Стортинг

Дээд танхим-Лагтинг -41 суудалтай

Доод танхим-Одельстинг-124 суудалтай

Эрх зүйн эх сурвалжийн хувьд эрх зүйн хэм хэмжээний актаас гадна худалдааны эрх зүйн харилцаанд эрх зүйн заншил, эрх зүйн зарчмыг хуульд нэмэлт байдлаар баримтална. Мөн шүүхийн жишиг, эрх зүйн номлол эх сурвалжийн тогтолцоонд тодорхой байр суурь эзэлнэ.

XII зуунаас эхлэн эрх зүйн заншлыг бичмэл болгож эхэлсэн бөгөөд манай үеийг хүртэл хадгалагдаж ирсэн эрх зүйн заншлын эх сурвалж нь 1150 оны “Гулатингийн хуулиуд”, 1190 оны “Фростатингийн хуулиуд” юм. Эдгээр эмхтгэлийг нэгтгэн Магнус хааны үед нийт ард түмний дунд үйлчлэх зориулалтаар “Газрын хууль” (1274-1276) болж гарсан. Энэ хуулиар сүм хийдийн эрх зүйн байдал, эрүүгийн, газрын, худалдааны эрх зүйн харилцааг зохицуулж байжээ. Энэ хуульд 1276 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийг “Хотын хууль” гэж нэрлэсэн бөгөөд уг хууль худалдаа, далайн тээврийн харилцааг зохицуулж байсан эрх зүйн заншлын зохицуулалтыг орлон гүйцэтгэх болсон байна. Эдгээр хууль нь төрөлжсөн хууль байсан бөгөөд 100 гаруй жил хүчин төгөлдөр үйлчилжээ.

1380 онд Норвегийг Дани улс байлдан эзэлж, шүүгчийн албан тушаалд даничууд ажиллах болсноор эрх зүйн хөгжид данийн эрхзүй гол үүрэг гүйцэтгэх болсон байна. Мөн орон нутгийн шүүхийн шийдвэр гаргасан гомдол, хүсэлтийг данийн дээд шүүх хянан үзэх болсон байна. Энэ үеэс Данийн хаан Норвегийн төрийн тэргүүний үүргийг давхар гүйцэтгэх болсноор үндсэндээ энэ улсад данийн хууль тогтоомж үйлчлэх болжээ. 1602-1604 онд Магнус хааны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар “IY Кристиан хааны хуулиудын эмхтгэл” гарсан байна. Үүний дараа эрх зүйн шинэтгэл явагдаж 1687 онд нийгмийн амьдралын бүхий л салбарын харилцааг зохицуулсан “V Кристиан хааны хуулиудын эмхтгэл” гарчээ.



Норвеги 1815 онд Данийн эзэмшлээс гарч 1905 он хүртэл Шведийн эзэмшилд оржээ. 1682 оны үеэс эхлэн Ослогийн Их сургуулийн хуулийн тэнхмээс 2 жил тутамд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудын он дарааллын эмхтгэлийг хэвлэн гаргаж байлаа.

Хууль тогтоомжоос гадна эрх зүйн эх сурвалжийн нэг хэсэг бол эрх зүйн заншил бөгөөд заншлын хэм хэмжээгээр худалдааны эрх зүйн харилцааны зарим хэсгийг зохицуулж байсан. Шүүхийн жишгийн эрх зүйн эх сурвалжид тооцон хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ дээд шатны шүүхийн шийдвэрийг иш татаж байна. Хуульч эрдэмтдийн хууль тайлбарласан ажлуудыг эрх зүйн эх сурвалжид тооцож байна. 1880 оноос эхэлж эрх зүйн хэм хэмжээний акт нь скандинавын бусад улстай ижил төстэй болж эхэлсэн нь энэ бүс нутгийн улс орны засгийн газар хамтран байгуулсан “хуулийн төсөл боловсруулах хороо”-ны үйл ажиллагааны үр дүн байсан.

Шүүхийн тогтолцоо:

Дээд шүүх, мужийн шүүх, тойргийн болон хотын шүүх, хөдөлмөрийн, гэр бүлийн, захиргааны дагнасан шүүхээс бүрдэнэ. ХҮП зууны үед байгуулагдсан Дээд шүүх нь шүүхийн тогтолцоог тэргүүлэх бөгөөд шүүхийн дарга, 17 шүүгчтэй, 2 танхимтай. Дээд шүүх нь иргэний маргааныг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй, эрүүгийн хэргийг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцдэг. Мужийн шүүх нь Осло, Скине, Берген, Тронхейм, Тромсё зэрэг 6 хотод ажилладаг. Энэ шүүх нь давж заалдах шатны шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлэн иргэний маргааныг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй, харин эрүүгийн хэргийг 3 мэргэжлийн шүүгч, 10 тангарагтны төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцдэг байна. Тойргийн болон хотын шүүх нь иргэний, эрүүгийн хэрэг маргааныг анхан шатны журмаар хянан хэлэлцдэг.

4. Шведийн эрх зүйн тогтолцооны онцлог:



- Төрийн байгууламжийн хувьд 24 тойрог-“лена”- бүхий нэгдмэл,
- Төрийн удирдлагын хувьд Үндсэн хуульт, парламентын вант улс.

Шведийн эрх зүйн эх сурвалж

- XIII зуунаас эхлэн заншлыг бичмэл болгох үйл ажиллагаа эхэлснээр XIV зууны үеэс худалдааны болон сүм хийдийн эрх зүй бий болсон байна. 1734 оны хууль батлагдсан .
- 1734 оны Шведийн хуулийг ромын эрх зүйн нөлөө ихтэй хууль гэж үздэг ба 9 бүлэгтэй, түүний 7 нь материаллаг эрх зүйн хэм хэмжээ агуулсан, тухайлбал, гэрлэлт, өв залгамжлал, үл хөдлөх хөрөнгө, барилга барих, худалдаа, хууль бус үйлдлийн тухай, ялын тухай, 2 хэсэг нь иргэн, эрүүгийн процессын хэм хэмжээ агуулжээ.

- 1809 онд Үндсэн хуульд өөрчлөлт орсноор Шведийн эрх зүйд шинэтгэл эхэлсэн. Энэ хуульд тулгуурлан 1920 онд Гэрлэлтийн тухай хууль, 1948 онд Шүүн таслах ажиллагааны тухай, 1959 онд Өв залгамжлалын тухай хуулиудыг шинээр батлан гаргасан байна.
- Иргэний болон худалдааны салбар эрх зүйн харилцааг 1734 оны хуулиас гадна 1905 оны худалдах-худалдан авах ажиллагааны тухай, 1915 оны гэрээ, хэлцлийн тухай, 1970 оны үл хөдлөх эд хөрөнгийн тухай, 1975 оны хувь нийлүүлсэн нийгэмлэгийн тухай, 1980 оны худалдааны нөхөрлөл, компанийн тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Хууль тогтоох дээд байгууллага “Риксдаг” хэмээх парламент бөгөөд нэг танхимтай, нийт ард түмнээс 3 жилийн хугацаагаар пропорциональ системээр сонгогдсон 349 төлөөлөгчтэй. Хууль санаачлах эрхийг Үндсэн хуулиар парламентын болон засгийн газрын гишүүн эдэлнэ.

Улс орны хэмжээнд гүйцэтгэх эрх мэдлийг кабинетын зарчмаар ажиллах Засгийн газар хэрэгжүүлнэ. Засгийн газар парламентын өмнө хариуцлага хүлээж, Ерөнхий сайд, сайд нарын бүрэлдэхүүнтэй ажиллана.

Швед бол Ром-Герман болон Англи-Америкийн эрх зүйн аймгийн холимог шинжийг агуулсан эрх зүйн тогтолцоотой улс.

- Гэрлэлт гэр бүлийн харилцааг 1920 оны гэр бүлийн тухай хууль, 1949 оны эцэг эх, хүүхдийн тухай хууль зэрэг хуулиар, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн зохицуулалтын хүрээнд 1976 оны хөдөлмөрийн харилцааны тухай, 1982 оны хөлсний хөдөлмөрийн тухай, 1962 оны даатгалын тухай хууль тус тус үйлчилж байна.
- Эрүүгийн эрх зүйн харилцаанд 1734 оны хуулиас гадна 1803 оны Австрийн, 1813 оны Баварын 1851 оны Пруссын эрүүгийн хуулийн хэв шинжийг агуулсан Шведийн эрүүгийн хуулийг 1965 онд батлан мөрдөж байна. Эрүү болон иргэний процессын эрх зүйн харилцааг 1734 оны хуулиас гадна 1942 оны шүүхийн процедурын хуулиар зохицуулж байна

Орчин үеийн Шведийн эрх зүй нь хөдөлмөрийн, аж үйлдвэрийн өмчийг хамгаалах, нийгмийн хамгааллын, байгаль орчныг хамгаалах зэрэг олон салбартай болсноос гадна XIX зууны дунд үеэс эхэлсэн нийгэм-эдийн засгийн хөгжилтэй уялдан бий болсон захиргааны эрх зүйн институтуудээс бүрдэнэ.

Эрх зүйн эх сурвалжид бичмэл хууль, эрх зүйн заншил, шүүхийн жишгийн эрх зүй хамаарна. Шведэд төрөлжсөн хуулийн тогтолцоо байгаагүй.



Шүүхийн тогтолцоо

- 1789 онд байгуулагдсан Шведийн дээд шүүх, давж заалдах шатны шүүх, тойргийн шүүх, захиргааны шүүх болон орон сууцны, газрын, нийгмийн даатгалын, худалдааны дагнасан шүүхээс бүрдэнэ. Дээд шүүх нь дарга 21 шүүгчтэй. Эрүү, иргэний хэрэг маргааныг хяналтын шатны журмаар хэлэлцэн шийдвэрлэхээс гадна төрийн өндөр албан тушаалтны үйлдсэн эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэнэ. Дээд шүүхийн шийдвэр нь бусад шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцээд зохих хэмжээгээр нөлөөлнө. Давж заалдах шатны шүүх нь 4-5 мэргэжлийн шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажиллана. Ойролцоогоор 100 гаруй тойргийн шүүх ажиллаж байна. Иргэний маргааныг арбитрийн журмаар бас хянан хэлэлцэнэ.

5. Данийн эрх зүйн тогтолцооны онцлог:



- Төрийн байгууламжийн хувьд “амт” хэмээх засаг захиргааны 14 нэгжээс бүрдэх нэгдмэл улс
- Төрийн удирдлагын хэлбэрийн хувьд Үндсэн хуульт хаант улс

1953 оны 3 сарын 23-ны өдрийн “Хаан ширээ залгамжлал”-ын тухай хуулиар эрэгтэй болон эмэгтэй талын аль аль нь хаан ширээ залгамжлах эрхтэй болсон.

Хаан Засгийн газрын гишүүн, төрийн өндөр албан тушаалтныг томилох, Парламентын ээлжит чуулганыг нээх, Парламентыг тараах бүрэн эрх эдэлнэ. Парламентын чуулган бүрийн хооронд хугацаат шинжтэй хууль зүйн хүчин чадалтай акт батлан гаргах, цэргийн дээд командлагчийн эрхтэй ч Парламентын зөвшөөрөлгүйгээр олон улсын гэрээнээс гарах, гадаад улсын эсрэг хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулах эрхгүй. Эзэн хааны гаргасан бүхий л актад Ерөнхий сайд гарын үсэг давхар зурж хууль зүйн хариуцлагыг хүлээнэ.

Хууль тогтоох эрх мэдлийг Фолькетинг хэмээх нэг танхимтай, 4 жилийн хугацаагаар нийт ард түмнээс пропорциональ системээр сонгогдсон 179 гишүүнтэй, парламент хэрэгжүүлнэ.

Засгийн газар-Сайд зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлэн төрийн удирдлагыг хэрэгжүүлж хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлнэ.

Парламентэд олонх болсон улс төрийн намын тэргүүн нь Ерөнхий сайд болно. Парламентын чуулган хооронд Засгийн газар нь Үндсэн хуульд зааснаар “онцгой тохиолдолд” түр үйлчлэх хууль батлан гаргаж Парламентын дараагийн чуулганаар хэлэлцүүлэн батлуулдаг байна. Засгийн газрын тэргүүн Парламентын чуулганд оролцох, үг хэлэх, Парламентын онцгой чуулган зарлан хуралдуулахыг шаардах эрхтэй.

Данийн эрх зүйн тогтолцоо нь Ром-Германы болон Англи-Америкийн эрх зүйн аймгийн аль алиных нь шинжийг илэрхийлнэ.

Данийн эрх зүйн түүхэн эх сурвалж:

1683 оны “Ү Кристианы Данийн хуулиуд” юм. Энэ хуулиар өмнө гарсан бүх хууль тогтоомжийг хүчингүй болгосон бөгөөд ихэнхдээ эрх зүйн янз бүрийн салбарт хамаарах казиуст шинжтэй хэм хэмжээнээс бүрдсэн байна. Энэ хуулийг албан ёсоор хүчингүй болсон тухай зарлаагүй ч зарим зүйл заалт нь одоо хүчин төгөлдөр үйлчилсээр байгаа.

Данийн эрх зүйн онцлог

Данийн эрх зүй үүссэн цагаасаа эхлээд гадны ямар нэгэн улсын нөлөөнд огт өртөж байгаагүй гэж үздэг байна. Ер нь Данид эрүүгийн хуулийг төрөлжүүлэх тал дээр л онцгой анхаарч ирсэн уламжлалтай.

1849 онд хэмжээгүй эрхт хаант засгийг халснаар хууль тогтоомжийг шинэчлэх үйл явц эхэлж, үүний дүнд 1866 оны Эрүүгийн төрөлжсөн хууль батлагдан гарсан байна. Данийн эрх зүйн эх сурвалжид шүүхийн жишиг чухал байр суурь эзэлнэ. Эрх зүйн зарим салбарын харилцааг дан ганц шүүхийн жишгээр зохицуулдаг байна. Шүүхийн шийдвэрийг хэрэглэн эрх зүйн харилцааг зохицуулах тал дээр Данид тусгайлан тогтоосон эрх зүйн журам үйлчилдэггүй. Шүүгч хэрэг маргааныг шийдвэрлэхдээ түүнтэй төсөөтэй хэрэг маргааны талаар урд гарсан шүүхийн шийдвэр, ялангуяа, дээд шүүхийн шийдвэрт онцгой анхаарал хандуулдаг байна. Далайн болон худалдааны салбарын эрх зүйн харилцааг зохицуулахад эрх зүйн заншил голлох үүрэг гүйцэтгэдэг байна. Дани улсын харьяанд байдаг Гренландад орон нутгийн заншил хэрэг маргааныг шийдвэрлэхэд чухал эх сурвалж болно. Гренландад зориулан иргэний процессын болон эрүүгийн төрөлжсөн хууль, өв залгамжлал, хүүхдийн эрхийн тухай хуулийг батлан гаргаж мөрдүүлж байна.

Иргэний эрх зүйн салбарын харилцааг 1926 оны газрын бүртгэлийн тухай, 1906 оны бараа бүтээгдэхүүн худалдах тухай, 1930 оны даатгалын тухай, 1966 оны худалдааны тухай зэрэг хуулиудаар зохицуулж байна. Гэр бүлийн эрх зүйн харилцаанд 1969 оны гэрлэлт, гэр бүл цуцлах тухай, 1960 оны хүүхдийн эрхийн тухай, 1956 оны хүүхэд үрчлэх тухай хууль тус тус үйлчилж байна. Хөдөлмөрийн эрх зүйн харилцааг хамтын гэрээгээр зохицуулна.

Байгаль орчныг хамгаалах хуулийг 1985 онд батлан гаргасан бөгөөд ойн тухай, загас агнуурын тухай, ашигт малтмал олборлох тухай, усан хангамжийн



тухай зэрэг ердийн хуулиуд үйлчилж байна. Эрүүгийн эрх зүйг 1930 оны төрөлжсөн хуулиар зохицуулахын зэрэгцээ 1978 онд цаазаар авах ялыг халсан байна. Гренландын нутаг дэвсгэрт үйлчилэх эрүүгийн тусгайлсан төрөлжсөн хуулийг 1954 онд батлан гаргасан байна.

Эрх зүйн салбарын шинжлэх ухааны судалгааны ажлыг Копенгаagens болон Орхусын Их сургуулийн хуулийн салбарууд голлон хэрэгжүүлдэг байна.

Шүүхийн тогтолцоо:


- Дээд шүүх 1661 онд Копенгагенд байгуулагдсан, тэргүүн шүүгч болон 15 шүүгчийн бүрэлдэхүүнтэй. Анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, хүсэлтийн дагуу эрүү, иргэний хэрэг маргааныг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэн шийдвэрлэнэ.
- Өрнөд болон дорнод хэсгийг харьяалсан давж заалдах шатны 2 шүүхтэй. Энэ шүүх хуульд заасан зарим хэрэгт анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах бөгөөд энэ үед 12 тангарагтан шүүх хуралдаанд оролцож шүүгчтэй нэгэн адил ял шийтгэх эрх эдэлнэ.
- Тойргийн буюу анхан шатны 84 шүүх ажиллаж, иргэний хэргийг шүүгч дангаар, эрүүгийн хэргийн иргэний 2 төлөөлөгч шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэдэг байна. Шүүхийн тогтолцоонд далайн хэргийн болон худалдааны дагнасан шүүх багтана. Энэ шүүх нь иргэний төдийгүй далайд үйлдэгдсэн эрүүгийн хэргийг мэргэжлийн 1 шүүгч иргэний 2-4 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

Данид захиргааны хэрэг маргааныг төрийн захиргааны байгууллага болон шүүхэд хандан шийдвэрлүүлдэг байна. Шүүгчийн албан тушаалд Хууль зүйн сайдын санал болгосноор 15-20 жил хуулийн байгууллагад ажилласан, хууль зүйн боловсролын дипломтой хуульчийг эзэн хаан насан туршид нь томилдог ба 70 насандаа өндөр насны тэтгэвэрт гардаг байна. Хууль зүйн яамны бүтцэд Прокурорын байгууллага байх бөгөөд “Эзэн хааны өмгөөлөгч” хэмээх албан тушаалтан энэ байгууллагыг тэргүүлнэ. Эрүүгийн хэрэгт хууль зүйн боловсролын дипломтой, хуульчийн ажлын туршлагатай хуульч өмгөөллийн үйл ажиллагаа явуулна. Иргэний хэрэг маргаанд ийм хязгаарлалт байхгүй. Хууль зүйн яамнаас төлбөрийн чадваргүй иргэдэд улсын өмгөөлөгч томилон ажиллуулдаг байна.

6. Финландын эрх зүйн тогтолцооны онцлог:



- Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс бөгөөд нутаг дэвсгэр нь 12 засаг захиргааны нэгж “ляни”-тэй.
- Төрийн удирдлагын хувьд Ерөнхийлөгчийн ба Парламентын холимог шинжтэй.



Үндсэн хуулийн зөвлөлөөс Ерөнхийлөгчийн бүрэн эрх, хувь хүний эдийн засаг, нийгмийн эрх, эрх чөлөө, өмчлөх эрхийг хамгаалах чиглэлээр эдгээр хуульд 1926, 1930, 1943, 1950, 1974 онуудад нэмэлт өөрчлөлт орж байжээ.

Хууль тогтоох эрх мэдлийг нэг танхим бүхий “Эдускунт” хэмээх парламент хэрэгжүүлнэ. Парламент нь нийт ард түмнээс 4 жилийн хугацаагаар сонгогдсон 200 гишүүнтэй. Жил бүрийн 2 сараас эхлэн 120 хоног хуралдаж үйл ажиллагаа явуулна. Үндсэн хуулиар хууль санаачлах эрх мэдлийг Парламентын гишүүн болон Ерөнхийлөгч эдэлнэ. Засгийн газар жил бүр үйл ажиллагааны тайлан тавих, засгийн газрын үйл ажиллагааны талаар мөрдөн шалгалт явуулах, итгэл хүлээлгэх эсэх асуудлаар шийдвэр гаргах зэрэг хэлбэрээр парламентын хяналтыг хэрэгжүүлнэ.

Төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийг 6 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч парламенттэй зэрэгцэн хууль тогтоох эрх мэдлээс гадна Засгийн газрын гүйцэтгэх эрх мэдлийг давхар хэрэгжүүлнэ. Хууль санаачлах, хуульд хориг тавих, зэвсэгт хүчнийг удирдах, дайн, энхийн асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

Финландын Засгийн газар нь Төрийн зөвлөл бөгөөд бүрэлдэхүүнд нь Ерөнхий сайд, яам толгойлсон болон яамгүй сайд нар байна. Засгийн газар гүйцэтгэх эрх мэдлийг улс орон даяар хэрэгжүүлэн, хамтын хариуцлагын зарчмаар үйл ажиллагаа явуулна.

Түүхэн онцлог нь:



Финланд XII зууны үеэс хойш 700 жил Шведийн мэдлийн нутаг дэвсгэр байсан бөгөөд энэ хугацаанд Шведийн вангийн гаргасан хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж байжээ.

1809 онд Оросын эзэнт гүрний харьяанд орж, 1918 онд тусгаар тогтнож, хөрөнгөтний Бүгд найрамдах улс болон хөгжсөн.



Эрх зүйн түүхэн эх сурвалж нь Швед, Финландын хуульчид хамтран боловсруулсан 1734 оны хууль юм. 1863 онд хууль тогтоох эрх мэдлийн байгууллага-Сейм байгуулагдсанаар эрүүгийн төрөлжсөн, дампуурлын, асран хамгаалах тухай, худалдаа, өв загламжлалын харилцааг зохицуулсан бие даасан хуулиуд гарч, үндэсний хууль тогтоомжийн үндэс суурь бүрэлдэн бий болжээ.

1919 оноос эхлэн одоог хүртэл Финландын эрх зүйн шинэчлэлийн үйл явц нийгмийн харилцааг төрөлжсөн хуулиар зохицуулах, эрх зүйн шинэ шинэ салбарын эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр явагдаж байна.



Хойд Европын бусад орнуудаас ялгаатай нь Финляндад худалдах-худалдан авах бие даасан хууль байхгүй.

Иргэний эрх зүйн салбар харилцааг 1734 оны Шведийн хуулийн зохих хэсгээр болон 1978 оны компаний тухай, 1954 оны хоршооллын тухай, 1947 оны зээлийн тухай, 1962 оны мөнгөний тухай, 1974 оны гэм хорыг арилгах тухай хуулиудаар зохицуулж байна. Гэр бүлийн эрх зүйн салбарт 1929 оны гэрлэлтийн, 1970 оны үеийн эцэг тогтоох тухай, 1979 оны үрчлэлтийн тухай, 1977 оны хүүхдийн эрхийг хамгаалах тухай, 1976 оны тэтгэлэг тогтоох, төлөх журмын тухай, 1987 онд асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны тухай хуулиуд тус тус үйлчилж байна. Хүн амын ихэнх хэсгийг хамарсан нийгмийн хамгаалын хууль тогтоомж үйлчилж, сүүлийн жилүүдэд байгаль орчныг хамгаалах чиглэлээр багц хуулиуд баталжээ.

Эрүүгийн эрх зүйн салбарт 1889 оны гэмт хэргийн тухай, эрүүгийн ял шийтгэлийн тухай хууль үйлчилж, 1949 онд цаазаар авах ялыг хэлбэрийн хувьд, 1972 онд бүрмөсөн халсан байна. Эрүүгийн болон иргэний процессын эрх зүйн харилцааг 1734 оны Шведийн хууль, 1919 оны Дээд шүүхийн тухай, 1918 оны Захиргааны хэргийн дээд шүүхийн тухай хуулиар зохицуулж байна.

1918 онд байгуулагдсан Дээд шүүх, Давж заалдах шатны шүүх, тойргийн болон хотын шүүх, хөдөлмөрийн захиргааны, дагнасан шүүхээс бүрдэнэ. Дээд шүүх нь Ерөнхийлөгч болон 21 шүүгчээс бүрдэх ба эрүү, иргэний хэрэг маргааныг хяналтын болон давж заалдах журмаар 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэнэ.

ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

Давж заалдах шатны шүүх нь тус улсын томоохон 6 хотод 1623 онд байгуулагдсан. Энэ шүүх Ерөнхийлөгч болон байнгын болон түр шүүгчээс бүрдэнэ. Давж заалдах гомдол, хүсэлтийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан хэлэлцэнэ. Мөн төрийн өндөр албан тушаалтны үйлдсэн гэмт хэрэг, төрийн эсрэг гэмт хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэнэ.

Тойргийн болон хотын шүүх нь анхан шатны шүүх бөгөөд эрүү, иргэний хэрэг маргааныг мэргэжлийн 1 шүүгч, 5-7 мэргэжлийн бус шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэнэ.

Хөдөлмөрийн дагнасан шүүх 1946 онд байгуулагдсан бөгөөд 3 мэргэжлийн шүүгч, ажил олгогч болон Үйлдвэрчний эвлэлийн болон салбарын мэргэжилтнээс бүрдэнэ. Захиргааны шүүх нь дээд, тойргийн, анхан шатны гэсэн тогтолцоотой.

Финландад хууль зүйн канцлерын албан тушаал байдаг. Энэ албан тушаалд насанд туршийн хугацаагаар улсын Ерөнхийлөгч томилох бөгөөд эрүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагааг хариуцна. Мөн парламентын нэрийн өмнөөс төрийн албан тушаалтнуудын хууль сахих үйл ажиллагаанд хяналт тавих Омбудсманьг 4 жилийн хугацаагаар Парламентаас сонгоно.

Эх сурвалж:

1. Баярсайхан Д., Эрх зүйн онол УБ. 2010
2. Минжүүрдорж Б., Даяаршиж буй дэлхий: харьцуулсан эрх зүй судлал УБ 2010
3. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо УБ 2001 он
4. Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг УБ.2011 он
5. Сүхбаатар Ж., Харьцуулсан эрх зүй судлал /схем, тайлбар/ УБ 2000 он
6. Отгончимэг Н., Харьцуулсан эрх зүй УБ 2001
7. Осаке К., Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги, УБ 2005 он
8. Давид Р. Основные правовые системы современности. М., 1988.
9. Hansen P. Bidrag till Finlands historia. Del. I. Helsingfors, 1883.
10. Kempin F. Historical introduction to anglo-american law. St. Paul. Minn., 1990
11. Norges Lov 1685-1985. Oslo, 1986; Suomen Lakikirja 1734-1991. Helsinki, 1992.
12. Loedrup P. Norway // International Encyclopedia of Comparative Law. Vol. 1. 1972.




13. Введение в шведское право. М.,1986
14. Тихомиров В.А. Курс сравнительное правоведения. М., 1996
15. Сайдов А.Х. Сравнительное правоведение. М.,2007
16. Под.ред Сухарев А.Я. Правовые системы стран мира. М., 2001
17. <http://www.asil.org/resource/pil1.htm>
18. <http://www.lib.uchicago.edu/~llou/global.html>
19. <http://europa.eu.int/eurodicautom/Controller>
20. <http://www.lexml.de/rdf.htm>

ЗУРГААДУГААР СЭДЭВ: АФРИК, ЛАТИН- АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙ

Африкийн эрх зүйн ойлголт

Африкийн ердийн эрх зүйн хэм хэмжээг Африкийн дийлэнх хүн ам хэрэглэж байна. Ердийн эрх зүй гэсэн нэр томъёо Африк ард түмний дунд үүссэн уламжлалт эрх зүйг ердийн эрх зүй гэж нэрлэдэг.



Ердийн эрх зүйн гол онцлог нь эрх зүйн хэм хэмжээ уламжлалт хэм хэмжээ хоёр нягт холбоотой ба тодорхой маргааныг шийдвэрлэхэд эхний ээлжинд эв зүйгээр зохицуулах асуудлыг удирдлага болгосон байдаг.



АФРИКИЙН ШҮҮХИЙН ГОЛ ЗОРИЛГО

Хэм хэмжээг хэрэглэх практик эрж хайхаас илүүтэйгээр хэм хэмжээг тухайн практикт хэр нийцэж байгааг тогтоох, гэм хорыг арилгах, харилцан зөвшилцөлд хүргэхийг эрмэлздэг.

АФРИКИЙН ШҮҮХИЙН ОНЦЛОГ

Тодорхой хувь хүнд хандсан биш бүлгийн харилцааг зохицуулахад гол зорилгоо болгодог. Тухайлбал, эд хөрөнгийг өв залгамжилж авсан тохиолдолд тухайн хувь хүнд бус гэр бүл тодорхой бүлэгт өв залгамжлуулах, мөн хохирол төлүүлэх явдалд гэр бүлээр нь хариуцлагыг ногдуулахыг зорьдог. Өөрөөр хэлбэл, гэр бүл хамт олны хариуцлагыг өндөрт авч үздэг.

АФРИКИЙН ШҮҮХИЙН ХЭЛБЭР

Африкт шүүхийн хоёр хэлбэр байдаг. Энэ хоёр шүүх нэгэн зэрэг үйл ажиллагаа явуулж нэгэн зэрэг үйлчилж болдог байна. Гэрлэлт, хүүхэд асран хамгаалах, өв залгамжлал, газрын асуудлыг гэр бүлийн гишүүд болон ахмад настнаас бүрдсэн шүүгчид шийддэг.

Хөршүүдийн хооронд янз бүрийн зөрчилдөөн үүсвэл: Тухайн гэр бүлийн ахмад настай хүмүүс асуудлыг бие даан шийдэж болдог.

Өөр нэг тогтолцоо нь төрийн тогтолцоо бөгөөд хууль зүйн хэлбэрийг агуулсан. Энэ нь төв засаг төвлөрсөн газар үйл ажиллагаа явуулдаг. Шүүх нь шаталсан тогтолцоотой байна.

Шүүх гэрчийг дуудах, торгууль, ял шийтгэл оногдуулах, хохирол төлүүлэх өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах эрхтэй байдаг.


Доод шатны шүүх нь жижиг удирдагчдийн шүүгчид ба дээд шатны шүүх нь томолохон овгийн ахлагч нараас бүрдсэн шүүх байдаг.

ГЭМТ ХЭРЭГ БА ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ

Хүнийг санаатайгаар алсан үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэдэг бол болгоомжгүйгээр алсан тохиолдолд эрүүгийн хэрэгт үл тооцон иргэний эрх зүйн зөрчил гэж шийдвэрлэдэг байна. Мөн үйлдэл нь давтан эсхээс шалтгаалан эрүү, иргэний хэргийг заагладаг. Тухайлбал, хулгайн гэмт хэрэг давтан үйлдсэн бол эрүүгийн хэрэг гэж үздэг байна.

Мөн ердийн эрх зүйд гэмт хэрэг ба иргэний эрх зүйн зөрчлийг тухай хэргийн нөхцөл байдлаас хамааран заагладаг тогтолцоо бий.

Африкийн ердийн эрх зүйд полигами гэрлэлтийн тогтолцоог хүлээн зөвшөөрдөг ба эхнэрийг худалдаж авч болно. Гэрлэлт цуцлах асуудал нь бараг байхгүй үзэгдэл юм. Гэрлэлтийг хувь хүний холбоо гэхээс илүүтэйгээр хоёр гэр бүлийн нэгдэл гэж үздэг. Иймд гэрлэлтийн асуудалд их ач холбогдол өгдөг. Тухайлбал, эхнэрийг сонгох, гэр бүл болох талаар зөвшилцөх, инж өгөх, гэр бүлийн доторх зөрчилдөөнийг шийдэх асуудал зэрэг нь нарийн дэг журамтай байдаг ба хэрэв гэр бүл цуцлах тохиолдолд талуудын гэр бүлийн оролцоогүйгээр шийддэггүй байна.



Домгоос нийгмийн амьдралыг зохицуулах зан заншил, хууль зүйн хэм хэмжээ үүдэн гарсан гэж үздэг. Тиймээс зан заншил, хууль зүйн хэм хэмжээний агуулгыг домог өөртөө багтаасан хэмээн тайлбарладаг.

Тухайлбал, дэлхий ертөнц болон нийгмийн үүслийн тухай домогт дэлхий ертөнц эмх замбараагүй байсан. Бурхан болон хүмүүс тэрхүү эмх замбараагүй байдлыг даван туулахыг хүссэн учраас нийгэм тодорхой зан заншил горим журамтай байдаг гэжээ. Уламжлалт эрх зүйд домог бол хуулийн үүрэг гүйцэтгэдэг байсан. Тухайлбал, эмх замбараагүй байдал үүсэх эсвэл эмх замбараагүй байдал бий болгох замаар айлган сүрдүүлэлт хэт их газар авсан үед домгоор дамжуулж төсөөлөгдөн бий болсон аливаа хориглосон зан үйлүүд нь эрх зүйн дэг журам тогтоох хариуцлагыг өөртөө үүрсэн удирдагч нарыг хүчирхэгжүүлэх гол хүчин зүйл болж байсан байна.

Зан заншлын талаар барууны хуульчдын үзэл баримтлал нь уламжлалд тулгуурласан уян хатан шинжтэй зан суртахууны хувьслыг дагаж түүнд нийцүүлэх байдлаар агуулгыг тайлбарласан байдаг. Үүний эсрэг байр суурь бол зан заншлын өнгөрсөн үед гүйцэтгэсэн үүргийг үнэлж өнөө үед зан заншил нь цаг хугацааны хэрэгцээ шаардлагаас үүдэн түүнд дасан зохицох зайлшгүй хэрэгцээ шаардлага бий эсэхийг үнэлэх гэсэн хандлага юм.

Африкийн ердийн эрх зүйн хүрээнд зан заншлыг хэрэглэхийн тулд тайлбарлах шаардлагатай гэж үздэг ба түүнийг тайлбарлах субъект нь овгийн ахлагч болон тухайн овог аймгийн гишүүн байж болдог.

Үүнээс үзвэл шинээр гарч ирсэн ямарч эх сурвалжийн хувьд өмнө байсан эрх зүйн эх сурвалжийг хэзээ ч орлож чадахгүй бөгөөд учир нь шинээр гарч ирсэн эх сурвалж ямар нэгэн байдлаар өмнөх эх сурвалжтайгаа холбоотой гэдэг санаа юм.

Африкийн улсууд колони байсны нөлөөгөөр эрх зүйн заншил хэрэглэх асуудал багасаж, хууль тогтоомжууд хэрэглэж эхэлсэн байна. Тухайлбал, орчин үеийн үүргийн эрх зүй, гэм хорын эрх зүйн асуудлуудтай холбоотой хууль тогтоомжуудыг батласан. Мөн ажлын найман цаг, хөдөлмөрийн хөлсний асуудал, эрүүл мэндийн үйлчилгээг хуулиар хамгаалснаар Африкийн эрх зүй шинэ шатанд гарч ирсэн. Төв засаг төвлөрөөгүй улсын нэг Кэни улс юм. Зөвхөн овгийн шүүхийн тогтолцоо үйлчилж байна.

Латин Америкийн эрх ойлголт, үүсэл хөгжил

Төв болон өмнөд Америкийн нутаг дэвсгэр дээрх Европын колончлол нь эх газрын эрх зүйн тогтолцоог тухайн улсын нутаг дэвсгэр дээр тархах нөхцөлийг бүрдүүлж өгсөн билээ.

Франци, Испани, Португали, Италийн хууль тархах үндэс нь XIV-XX зуунд хийгдсэн кодификаци нь нөлөө юм.

Латин Америкийн улс орнуудийн нийгэм эдийн засгийн байгуулал, улс төрийн тогтолцооны төсөөтэй байдал, улс оруудын түүхэн хувь заяаны нийтлэг талууд нь төсөөтэй эрх зүйн тогтолцоог бүрдүүлж өгсөн.

Барууны харьцуулсан эрх зүй судлаачид Латин Америкийн улс орнуудын эрх зүйг Эх газрийн эрх зүйд хамааруулж үздэг хандлага бий.

Р. Давидын үзсэнээр Латин Америкийн эрх зүй нь өөрийн бүтэц нийтлэг шинжээрээ эх газрын бүлд хамаарах боловч зарим нэг онцлог шинжээс хамаарч эх газрын эрх зүйн аймгийн хүрээнд онцлог бүхий бүлэг үүсгэж болно гэж үзжээ.

Эх газрын эрх зүйн тогтолцоотой ижилсэх гол шинж нь Латин Америкийн улс орны ихэнх хууль тогтоомж Европын загвараар хийгдсэнд байдаг. Өөр нэг төсөөтэй шинж нь эрх зүйн хэм хэмжээ нь хийсвэр шинжтэй юм

Латин Америк дахь улс орнуудийн хууль тогтоомжийн системчлэл нь нэг талаас колони эрх зүй болон түүнээс өмнөх үеийн эрх зүйн элементүүд хэрхэн өөр хоорондоо уялдаж буй байдал Латин Америк тивд шинэ эрх зүйн харилцаа үүсэх, хөгжихөд гол түлхэц болсон гэж үздэг.

Шинээр тусгаар тогтнолоо тунхагласан Латин Америкийн ихэнх улсуудын үндэсний иргэний эрх зүйн кодэкс Францын загвар бий болох гол үзэл санааны тулгуур нь бол Латин Америкийн улс орнуудад сэргэн мандалтын үеийн улс төр үзэл санааны сургаал хүчтэй нөлөөлсөн явдал юм. Үүнээс үзвэл Латин Америкийн иргэний кодэкс нь Наполеоны кодэксын ул мөрийг хадгалж үлдээсэн нь зайлшгүй юм.

Латин Америкийн эрх зүйн эх сурвалж

Латин Америкийн улс орнууд дахь хууль тогтоомжийн системчлэл нь удаан хугацаанд үргэлжилсэн. Уг системчлэлийн хүрээнд тухайн тивийн түүхэн онцлог байдлуудыг өөртөө тусган хөгжсөн байдаг.



Латин Америкийн улсуудын хууль тогтоомжийн системчлэл

Чилийн 1855 оны иргэний хуулийг Венесуэлийн хуульч Андресом Белло эхийг нь бэлтгэсэн ба тэрээр Францийн эх сурвалж Ромын эрх зүйн уламжлалт институтыг нэгтгэн тусгах замаар бүтээсэн байдаг. Чилийн энэхүү иргэний кодекс нь Францын иргэний кодексоос боловсронгуй, хэллэг, утга агууллага гүн гүнзгий болж чадсан гэж дүгнэдэг байна.

Чилийн Иргэний хууль нь 1860 оны Эквадорын, 1873 оны Клумбийн иргэний кодексын загвар болж чадсан ба 1862 оны Венесуэл, 1868 Уругвайн иргэний кодекс нөлөө үзүүлсэн байдаг.

Аргентиний иргэний хуулийг Кордовын их сургуулийн профессор Долмасио Велес Сарсфилд бүтээсэн юм.

Парагвай улс хууль тогтоомжоо Аргентиний загвараар хийсэн ба 1859 оны худалдааны гол хуулийг зохиохдоо Наполеоны кодекс тулгуурласан байдаг.

Бразилийн анхний иргэний кодекс 1916 онд олон төсөл дээр тулгуурлан бий болсон. Тухайлбал, Португали, Итали, Швейцарийн хуулиуд дээр тулгуурлан гол үзэл санаагаа Германы иргэний хуулийн ерөнхий ангийг загвар болгосон.

Мексикийн хууль тогтоомжуудад Ромын хууль тогтоомж болон Франци Испаний эрх зүйн нөлөө нилээдгүй орсон байдаг.

Латин Америкийн эрх зүйд Засгийн газарт эрх олгогдсоны дагуу хууль тогтоомжийг бүтээх ажилгааны үүрэг ач холбогдол одоо ч өндөр юм. Энэ нь ерөнхийлөгчийн засаглал болон удаан хугацаанд колончлогдож байсантай холбоотой.

Латин Америкийн эрх зүйд заншил эх сурвалж болдог боловч үүрэг нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал, Аргентинд заншлын нөлөө их бол Уругвайд харьцангуй бага байдаг. Энэ тогтолцооны улс орнууд нь Америкаас шүүхийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг нь хөрвүүлэн авсан байдаг.

Латин Америкийн хувийн эрх зүйн салбарыг хоёр хэсэгт хуваан авч үздэг

Нэг. Францын иргэний хуулийг хуулбарлан авсан.

Үүнд: 1825 оны Гаити, 1830/ 1875 онуудын Болив, 1845/ 1884 онуудын Доминикан, 1870/ 1884, 1928/ 1932 онуудын Мексикийн иргэний хууль

Хоёр. Францын иргэний хуулиас хөрвүүлэг хийсэн боловч Аргентиний Иргэний хуультай төстэй.

Үүнд: 1855оны Чилийн иргэний хууль

Латин Америкийн улсуудын үндсэн хууль нь бүгд найрамдах засаглалтай улсын хэлбэрээр хийгдсэн боловч Америкийн эрх зүйн тогтолцооны институтыг шилжүүлэн авсан байдаг. Энэхүү байдал нь Латин Америкийн эрх зүйн дуалист шинжийг гаргаж ирдэг.

Хэлэлцэх асуудал:

1. Африкийн эрх зүйд овгийн ёс, заншил нь нөлөөллөө авч үлдэж чадсан эсэх талаар ярилцлага зохион байгуулах
2. Африк тивийн улсуудад колоний нөлөө, эрх зүйн тогтолцооны өөрчлөлтийн талаар тодорхой улсын жишээн дээр багаар ажиллан тодорхойлох
3. Латин Америкийн эрх зүйн үүсэл хөгжил, эрх зүйн тогтолцооны онцлогийн талаар эссе бичих
4. Латин Америкийн эрх зүйд Ром-Германы эрх зүйн аймгийн үзүүлсэн нөлөөллийн өнөөгийн байдлын талаар тухайлсан улс дээр тайлбарлан ярилцах

Эх сурвалж:

1. Б. Амарсанаа., “Харьцуулсан эрх зүй судлал” УБ., 2005.
2. Ч.Отгончимэг., “Харьцуулсан эрх зүйн судлал” УБ., 2001.179-182 дэх тал
3. Осакве Кристофер., “Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги бүдүүвч” УБ., 2005. 26- 29 дэх тал
4. А.Х.Сайдов., Сравнительное правоведение. М., 2007. Стр- 287- 291, 425-434
5. http://www.pravo.vuzlib.org/book_z1928_page_118.html
6. <http://www3.law.harvard.edu/orgs/hala/>
7. <http://www.latinlaws.com/>
8. <http://www.legal500.com/books/la500>

ДОЛООДУГААР СЭДЭВ: ЯПОНЫ ЭРХ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж, ойлголт

Японы орчин үеийн эрх зүйн тогтолцоо нь 19 зууны дунд үеэс Франц, Германы эрх зүйн тогтолцоог дууриах байдлаар бүрэлдэн тогтож, 20 зууны дунд үед АНУ-ын шахалтаар дахин хэлбэрийн болон агуулгын хувьд зарим байдлаар өөрчлөгдсөн байдаг. Энэ утгаар нь Японы эрх зүйн тогтолцоог эх газрын эрх зүйн бүлд хамаарах эрх зүйн тогтолцоотой гэж үзэх нь бий. Гэхдээ Японы эрх зүйн тогтолцоо нь бусад эрх зүйн тогтолцооноос тохиромжтой элемент, институцийг нь өөртөө нэвтрүүлэх буюу рецепци хийх замаар бүрдсэн учраас зарим судлаачид холимог эрх зүйн тогтолцоотой хэмээн нэрлэх нь ч бий. Ерөнхийдөө эрх зүйг кодификацчилах, парламентаас тогтоох явдал зонхилдог учраас эх газрын эрх зүйн тогтолцооны шинж давамгайлдаг.

Японы эрх зүйн тогтолцооны хувьд хууль дээдлэх ёс гол зарчим байдаг бөгөөд Үндсэн хуульд хууль, тэдгээрт Засгийн газрын тогтоол, тэдгээрт Сайдын тушаал нийцэх ёстой байна. Төв засгийн газрын хэм хэмжээний баримт бичгээс гадна орон нутаг бүр хуулийн хүрээнд өөрийн журмыг баталдаг байна.



Мөн ерөнхий зарчмын хувьд хоёр хууль хоорондоо зөрчилдвөл нарийвчилсан зохицуулалт бүхий хууль үйлчилдэг. 2008 оны байдлаар нийт 1788 хууль, 1928 засгийн газрын тогтоол (дайнаас өмнөх эзэн хааны зарлиг), 3591 сайдын тушаал үйлчилж байна.

Энэ эрх зүйн тогтолцоо нь төрийн хэлбэрийн хувьд бэлгэдлийн буюу ёс суртахууны шалгуурыг илэрхийлэгч хаантай, парламентын бүгд найрамдах улс бөгөөд ёс суртахууны үнэлэмж, ичих үзэл эрх зүйн эх сурвалжийн үндэс байдаг талтай. Дараах эх сурвалж Японд эрх зүйн эх сурвалж болдог.

Үндсэн хууль

Япон нь Ази тивд хамгийн анхны Үндсэн хуультай болсон улсуудын нэгд тооцогддог бөгөөд одоогийн Үндсэн хууль нь 1946 онд батлагдсан. Үндсэн хууль нь Японы эрх зүйн тогтолцоонд дээд хүчинтэй баримт бичиг бөгөөд хууль, дүрэм журам энэхүү Үндсэн хуульд нийцсэн байх ёстой байдаг. Японы Үндсэн хууль нь эрх мэдэл хуваарилах онолыг үндэс болгосон бөгөөд хаант засаг бүхий бүгд найрамдах улсыг тунхагласан шинжтэй. Үндсэн хууль нь гурван зарчмыг тунхагладаг бөгөөд эдгээр нь засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх зарчим, гадаад улстай энх тайвнаар зэрэгцэн орших зарчим, хүний үндсэн эрхийг дээдлэх зарчим юм.

Олон улсын гэрээ

Япон улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь Японы Үндсэн хуулийн дагуу заавал дагаж мөрдөх шинжийг агуулдаг бөгөөд онолын хувьд энэ нь дотоодын эрх зүйн нэг хэсэг болдог гэж үздэг. Олон улсын зарим гэрээг Засгийн газар байгуулдаг бөгөөд зарим гэрээг парламентаар батлуулах ёстой байдаг. Гэхдээ энэ тохиолдолд парламент зөвхөн батлах, эс батлах гэсэн хоёр шийдвэрийн аль нэгийг гаргаж, гэрээг өөрчлөх эрхийг эдэлдэггүй. Япон улс нь олон улсын гэрээг өөрийн хууль тогтоомжид тусгахгүйгээр, хэвлэгдсэнээр шууд дагаж мөрддөг. Хэдийгээр хуульд олон улсын гэрээ нь дотоодын хуулиас давуу хүчинтэй хэмээн заагаагүй ч ерөнхийдөө олон улсын гэрээ нь давуу хүчинтэй гэдэг үзэл зонхилдог. Харин Үндсэн хууль олон улсын гэрээнээс илүү хүчинтэй гэсэн үзэл зонхилж байна.

Хууль

Хууль нь Үндсэн хуулийн дараах дээд хүчин чадалтай, Японы бүх нутаг дэвсгэрт үйлчилдэг баримт бичиг юм. Хуулийг Японы хоёр танхим бүхий парламентаас баталдаг. Японд кодификацлал нилээдгүй хөгжсөн бөгөөд Иргэний хууль, Худалдааны хууль зэрэг нь кодификацлалын үр дүнд бий болсон байдаг. Хуулиар зохицуулагдах харилцааны хүрээ хязгаарыг тодорхойлох онолын үндэслэл нь эрх зүйн этгээдэд эрхийг хязгаарласан, эсхүл

үүрэг болгосон байх явдал бөгөөд парламентаас бусад этгээд ийм агуулгатай баримт бичиг гаргах нь зөвхөн парламентаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд байх ёстой гэж үздэг.

Хууль нь *Kanpō* буюу албан ёсны газет [official gazette]-д хэвлэгддэг. Мөн *Kōppō* хэмээх албан бус хуулийн эмхтгэл жил бүр гарч байдаг. Хуулийн албан ёсны хэвлэлийг төлбөртэйгээр Үндэсний хэвлэх алба (the National Printing Bureau's Web site)-ны вэб хаягаас үзэж болно.

Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ

Парламентас олгогдсон эрх хэмжээний хүрээнд гарсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ нь аль байгууллагаас гаргаж байгаагаар ангилагддаг бөгөөд Сайд нарын танхимын тогтоол, сайдын тушаал, Ерөнхий сайдын албаны шийдвэр энд хамаардаг. Японы эрх зүйн тогтолцоонд парламентаас олгосон эрх хэмжээг нилээд өргөн хүрээнд ойлгож, хэрэглэдэг. Энэ хэм хэмжээ нь Үндсэн хууль, хуульд нийцэх, эдгээрт Сайд нарын танхимын тогтоол, эдгээрт сайдын тушаал нийцэх ёстой.

Мөн нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг орон нутгийн хурлын шийдвэр, яамнаас доод төвшний захиргааны байгууллага гаргадаг байна.

Эрх зүйн заншил

Заншил нь нийтийн дэг журам, ёс суртахуунд харшлахгүй байх ёстой бөгөөд хуулиар зөвшөөрсөн эсхүл тухайн харилцааг зохицуулсан хууль байхгүй бол дагаж мөрддөг.

Шүүхийн шийдвэр буюу Ханрей

Японы эрх зүйн тогтолцооны нэг онцлог нь дээд шатны шүүхийн шийдвэрийг бусад шүүх ихээхэн харгалзан үздэг, шийдвэр гаргахад нөлөөлдөг нь бодит байдал юм. Энд шүүхийн зарим шийдвэрийг тогтмол хэвлэдэг бөгөөд ийнхүү хэвлэх явдал нь бусад шүүх, байгууллага, иргэд түүнийг дагаж мөрдөх явдалд түлхэц өгдөг байна. Ийм шийдвэрийг ханрей гэж нэрлэдэг. Гэхдээ энэхүү ханрей нь хуулийн хүрээнд байж, хуулиар хязгаарлагдаж байдаг. Товчоор хэлбэл, шүүх нь эрх зүйг шинээр бий болгохоос илүүтэй хуулийг тайлбарласан ханрейг бий болгодог байна.


Судлаачдын бүтээл, онол нь эрх зүйн эх сурвалж болдоггүй бөгөөд харин маш цөөн тохиолдолд шүүхийн шийдвэрт ишлэгддэг. Хүчин төгөлдөр хууль, Засгийн газрын шийдвэр, Яамдын шийдвэрийг [the Hōrei dēta teikyō sisutemu](#) болон [Hōko](#), [Seitei hōritsu](#), [Gian](#)-ээс олж болно. Мөн парламентад хуулийн төсөл хэлэлцсэн хурлын тэмдэглэлийг [Kokkai kaigiroku kensaku system](#), шүүхийн шийдвэрийг [Saibanrei jōhō](#)-оос авах боломжтой байдаг. Мөн хуулийн англи хэл дээрх орчуулгыг www.japanlawtranslation.go.jp хаягаар үзэх бололцоотой.



Шүүхийн тогтолцооны тойм

Япон нь нэгдмэл улс болохын хувьд Улсын дээд шүүх, Дээд шатны шүүх, Орон нутгийн шүүх, Гэр бүлийн хэргийн шүүх, Жижиг хэргийн шүүхээс бүрдсэн нэгдмэл тогтолцоотой. Улсын дээд шүүх нь иргэн, эрүү, гэр бүлийн хэргийг шийдэх эцсийн шат байх бөгөөд Үндсэн хуулийн хяналтын үүргийг мөн гүйцэтгэдэг.

Улсын дээд шүүх нь зөвхөн эрх зүйн маргаантай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг бол Дээд шатны, Орон нутгийн, Гэр бүлийн хэргийн, Жижиг хэргийн шүүх нь эрх зүйн маргаантай асуудлаас гадна баримт нотолгооны маргааныг шийдвэрлэдэг. Японы Улсын дээд шүүх болон Дээд шатны шүүх нь анхан шатны журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэдэггүй, харин Жижиг хэргийн шүүх, Орон нутгийн шүүх, Гэр бүлийн хэргийн шүүх нь хоорондоо тодорхой ялгаатайгаар хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэдэг байна. Жижиг хэргийн шүүхийн гаргасан иргэний хэргийн шийдвэрийг давж заалдах болвол Орон нутгийн шүүхэд ханддаг бол эрүүгийн хэргийн хувьд Жижиг хэргийн шүүхийн шийдвэрийг шууд Дээд шатны шүүхэд давж заалдах журам үндсэндээ үйлчилдэг. Орон нутгийн шүүх нь тодорхой үнийн дүнгээс дээш гарсан иргэний маргаан, зарим ноцтой гэмт хэрэг, зарим гэр бүлийн маргаан болон захиргааны эрх зүйн маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэдэг байна. Харин Орон нутгийн шүүхийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг Дээд шатны



шүүхэд давж заалдаж, эцсийн хяналтыг Улсын дээд шүүх хийх эрх зүйн боломжтой байдаг. Харин Гэр бүлийн хэргийн шүүхийн хувьд гэр бүлийн маргаан болон насанд хүрээгүйчүүдийн үйлдсэн гэмт хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэж, энэ шүүхийн шийдвэрийг Дээд шатны шүүхэд давж заалдах бололцоотой байдаг. Японд зарим хүнд эрүүгийн хэргийн хувьд иргэдийн төлөөлөгч-

шүүгч (анг. jury, япон saiban-in) шүүхээр гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх тогтолцоо нэвтэрсэн.

Японд захиргааны байгууллагатай буюу захиргааны акттай холбоотой хэргийг дүүргийн шүүх иргэний хэрэг шийдвэрлэх тусгай журмаар хянан хэлэлцдэг. Мөн Үндсэн хуулийн хяналтыг Улсын дээд шүүх, бусад шүүх хянан

шийдвэрлэх эрх хэмжээтэйн хувьд хууль тогтоомж, захиргааны акт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар шийдвэр гаргадаг. Улсын дээд шүүхийн Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэх харьяаллын хувьд олон улсын гэрээ хамаардаггүй онцлогтой. Бодит байдал дээр Үндсэн хуулийн хяналтыг Япон улсын шүүх маш болгоомжтой хэрэгжүүлдэг бөгөөд зарим тохиолдолд тодорхой маргааныг шүүхийн шийдвэрлэх асуудал биш, улс төрийн процессын үндсэн дээр ард түмний төлөөлөгч шийдэх нь зүйтэй хэмээн шүүх үзэж, өөрөө ийм төрлийн маргааныг шийдвэрлэхээс зайлсхийсэн тохиолдол байдаг. Нөгөө талаас Японы шүүх нь засгийн газрын дур зоргыг хязгаарласан дэвшилттэй шийдвэрийг гаргадаг, мөн ийм түүх бий.

Улсын дээд шүүхийг оролцуулан Япон улсын шүүх нь багагүй ачаалалтай ажилладаг. Тухайлбал, Улсын дээд шүүх нь 2006-2010 оны статистикаар жилдээ 7-8 мянган иргэн, эрүүгийн хэргийг нийт 15 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэдэг байна.¹⁶ Мөн найман Дээд шатны шүүх нь эрүүгийн 6-9 мянган хэрэг, иргэний 22-26 мянган маргаан, тавин Орон нутгийн шүүх нь 160-260 мянган иргэний маргаан, 80-110 мянган эрүүгийн хэрэг, 438 Жижиг хэргийн шүүх нь 408-654 мянган иргэний маргаан, 12-17 мянган эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн тоо баримт байна. Гэр бүлийн хэргийн шүүхийн хувьд 743-815 мянган гэр бүлийн маргаан, насанд хүрээгүйчүүдийн үйлдсэн 167-217 мянган хэргийг тавин Гэр бүлийн хэргийн шүүх шийдвэрлэсэн байдаг.

Японы шүүхийн тогтолцооны нэг онцлог нь хуульчид буюу шүүгч, өмгөөлөгч, прокурорыг бэлтгэх тогтолцоонд байдаг бөгөөд шүүхийн тогтолцоо нь шалгалтад тэнцсэн шинэ хуульчдыг Улсын дээд шүүхийн харьяаны институтэд 1 жилийн хугацаатай сургах чиг үүргийг гүйцэтгэдэг. Харин энэ институтэд сурах шалгалт (япон shihou-shiken)-ыг гүйцэтгэх засаглал (Хууль зүйн яам) орон даяар зохион байгуулж, түүнд тэнцээнийг нь дээр дурдсан институт руу илгээдэг байна.

Хуульчийн мэргэжил, гүйцэтгэх үүрэг

Хуульчийн нэр хүнд энэ улсад харьцангуй өндөр бөгөөд жирийн иргэд хуульчдаас ерөнхийдөө эмээх хандлага зонхилдог. Эрх зүйн тогтолцоо нь иргэдийн итгэлийг хүлээсэн, хараат бус байдаг хэдий ч иргэд, байгууллага нь шүүхийн тогтолцоо, эрх зүйн системд хандахаас илүүтэй, өөр хоорондоо албан бусаар иргэний шинжтэй маргааныг шийдвэрлэх уламжлалт хандлага зонхилдог онцлогтой. Гэхдээ сүүлийн үед шүүхийн тогтолцоо, эрх зүйн системээс өөрт тулгарч байгаа аливаа асуудлаа шийдэх гарцыг иргэд, байгууллага хайх хандлага нэмэгдэж байна. Дээд дурдсан үндсэн хандлагтай холбоотойгоор хуульчийн нийгэмд гүйцэтгэх үүрэг нь тоо хэмжээний хувьд зарим улсаас бага

¹⁶ http://www.courts.go.jp/english/info/statistical_table/index.html 2013.01.31



байдаг. Энэ нь зарим талаар хүн амын тоотой харьцуулбал маш цөөн хуульч (ихэнх хөгжингүй орнуудын дунджаас доогуур тооны хуульч) энэ улсад үйл ажиллагаа явуулдагтай холбоотой.

Япон улсад хуулийн мэргэжилд шүүгч, өмгөөлөгч, прокурорыг багтаадаг. Шүүгчийн албан тушаал нь Японд нэр хүндтэй бөгөөд шүүгч нь бодит байдал дээр ажлын онцлогоос хамааран нийгмээс тодорхой хэмжээгээр тусгаарлагдмал шинжтэй байдаг. Энд хуульчдын хамгийн сайн нь шүүгч болдог гэж үзэх хандлага зонхилдог. Улсын дээд шүүхийн шүүгчийг Сайд нарын танхимаас, дараагийн удаа тэтгэвэрт гарах нас хүртэл нь хугацаагүй томилдог. Мөн Улсын дээд шүүхийн шүүгчдийг 10 жил тутам парламентын сонгуультай давхцуулан ард түмэн хянах тогтолцоо байдаг хэдий ч энэ нь хэлбэрийн төдий үйлчилдэг гэж үздэг. Улсын дээд шүүхээс бусад шатны шүүхийн шүүгч нь анх удаа томилогдохдоо 10 жилийн хугацаатайгаар Улсын дээд шүүхийн санал болгосны дагуу Сайд нарын танхим томилдог бөгөөд цаашид тэтгэвэрт гарах нас хүртэл дахин томилж болдог. Эхний удаа томилохдоо 10 жилийн хугацаа заасан нь шүүгчийн шалгуурт тэнцэхгүй хүмүүсийг солих боломжтой байх зохицуулалт хийсэн. Харин тэдгээрийг чөлөөлөхдөө шүүгчийн эсрэг гаргасан гомдлыг парламент импичментын журмаар шалгаж шийдвэрлэдэг байна.

Өмгөөлөгчийн хувьд төрөөс харьцангуй хараат бусаар өөрийн бие даасан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өмгөөлөгч нь төрийн байгууллага, томоохон компанийн эсрэг зогсох гол хүч мэт нийгмийн зарим хэсэг үздэг. Өмгөөлөгч нь ихэнхдээ цөөн тоогоор нэгдэж, тухайлсан нэг бүс нутгийн иргэд, байгууллагад хууль зүйн туслалцаа үзүүлэх хандлага зонхилдог. Өөрөөр хэлбэл, Японд хэдэн зуу эсхүл мянган өмгөөлөгч нэгтгэсэн хуулийн том пүүс маш цөөнөөр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд томоохон компаниуд нь ихэнхдээ өдөр тутмын хууль зүйн холбогдолтой асуудлаа өөрийн нэгжээр гүйцэтгүүлэх нь элбэг байдаг. Бодит байдал дээр өмгөөлөгч нь шүүхэд талуудыг төлөөлөх давуу эрхтэй байдаг.

Прокурорын чиг үүргийг гүйцэтгэх эрх мэдлийн нэг хэсэг болох Хууль зүйн яам хэрэгжүүлдэг. Прокурорын тогтолцоо нь төвлөрсөн, босоо чиглэлийн удирдлагатай бөгөөд зохион байгуулалтын хувьд шүүхийн тогтолцоотой зэрэгцсэн зохион байгуулалттай байдаг. Ерөнхий прокурор болон түүний орлогчийг Засгийн газар томилж, Эзэн хаан баталгаажуулдаг бөгөөд бусад прокурорыг Хууль зүйн сайд томилдог.

Прокурор нь эрүүгийн хэргийн мөрдөн байцаалт, ял эдлүүлэхэд хяналт тавих, шүүхэд яллах үүрэгтэйгээс гадна зарим ноцтой хэргийг өөрөө мөрдөн байцаах нь бий. Мөн иргэний хэргийн хувьд нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн үед төлөөлөх үүрэг гүйцэтгэдэг.

Япон улсад хуульчийг бэлтгэх тогтолцоо нь эрх зүйн болон эрх зүйн бус бакалаврын зэрэгтэй хүнийг хуульчаар мэргэшүүлэх сургууль (*law school*)-д 2-3

жил сургахаас эхэлдэг. Энэ сургууль аль нэг дээд сургуулийн харьяанд хуулийн сургуулиас тусдаа, профессор болон практик хуульчдаар хичээл заах байдлаар сургалт явуулдаг. Энэ сургуульд сурч байгаа эсхүл хуулийн доктор (*juris doctor*) зэрэгтэй болсон бол Хууль зүйн яамны зохион байгуулдаг улсын шалгалт (*shihoushiken*)-д тэнцэх ёстой бөгөөд ийм этгээд Улсын дээд шүүхийн харьяа Шүүхийн дадлагын төвд 1 жил суралцах байдлаар хуульчийн мэргэшүүлэх сургалт явагддаг. Тус төвийг амжилттай төгссөн этгээд шүүгч, прокуророор томилогдох, эсхүл аль нэг өмгөөлөгчдийн холбоонд бүртгүүлснээр хуульчийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог.

Шүүгч, прокурор, өмгөөлөгчөөс гадна хуульчийн зарим чиг үүргийг гүйцэтгэдэг *шихошэши*, *гёосэйшёоши* гэх мэт ажил мэргэжил Японд байдаг.

Хэлэлцэх асуудал

1. Японы эрх зүйн тогтолцоог холимог эрх зүйн тогтолцоотой хэмээдгийн учрыг хэлэлц. Шүүн хэлэлцэхдээ яагаад эх газрын эрх зүйн бүл, эсхүл жишгийн эрх зүйн бүлд хамаарч эсхүл хамаарахгүй байгаа шинжийг нь тодруулах ярилцах.
2. Хаант засагтай парламентын бүгд найрамдах улсад эзэн хаан нийгмийн өмнө болон эрх зүйн тогтолцоонд ямар (чиг) үүрэг хүлээдэг талаар ярилцах. Эзэн хаан тухайн нийгмийн ёс суртахууны эталон байгаа үед энэ нь эрх зүйн тогтолцоотой хэрхэн уялдах боломжтой талаар хувилбаруудыг шүүн хэлэлцэх.
3. Шүүхийн шийдвэрийг хэвлэх явдал эрх зүйн тогтолцоонд хэрхэн нөлөөлж болох талаар ярилцах. Японы эрх зүйн тогтолцоонд шүүхийн шийдвэрийг хэрхэн шилж сонгодог талаар судлан шүүмж ярилцлага хийх. Монголын эрх зүйн тогтолцоонд энэ нь нөлөөлөх боломжтой эсэх, хэрхэн нөлөөлөх үр дагаврыг хэлэлцэх.
4. Шүүхийн тогтолцоо баримт нотолгооны асуудал болон эрх зүйн маргаантай асуудлыг ялгамжтай байдлаар хүлээн авч байгаа нь зөвхөн шүүхийн зохион байгуулалтын асуудал уу, эсхүл өөр учир шалтгаан байна уу. Энэ талаар хэлэлцэх.
5. Японд хуульчийн нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар лавшруулан судалж, хуульч, мөн эрх зүйгүйгээр нийгэм байх боломжтой эсэх, боломжтой бол ямар тохиолдол, ямар нөхцөл байдал, нийгмийн институт үүсвэл энэ нь боломжтой талаар ярилцах.
6. Эрх зүйн гүйцэтгэх үүрэг хэтийдсэн тохиолдолд нийгэмд ямар үр дагавар үүсэх талаар дээрх асуулттай холбон ярилцах.

Эх сурвалж

1. Б.Гүнбилэг., Жишгийн эрх зүй, УБ.,2008
 - Японы эрх зүй дэх жишгийн тухай онолын болон практикийн маргаантай асуудлууд: Японы эрх зүй нь энэхүү судалгааны ажлын объект болох нь, 123-138 дахь тал



2. Дэлхийн улсуудын шүүхийн тогтолцоо, УБ., 2005
 - Япон улсыг шүүхийн тогтолцоо, 46-50 дахь тал
3. Монгол улс дахь Эрх зүйн шинэтгэл болон харьцуулсан эрх зүй судлалын хөгжил (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл), УБ.,2004
 - Масанори Сайто. Япон улс дахь шүүхийн прецедентийн эмхэтгэл, 36-41 дэх тал
 - Такао Сайто. Газар өмчлөл болон Япон улсын хуулийн хязгаарлалт, 49-50 дахь тал
 - Накамура Масаки. Гадаад улсуудын Үндсэн хуулийн орчуулга, Монгол улсын Үндсэн хуультай холбоотой баримт бичиг 71-74 дэх тал
4. Моригава Ясутомо, Хуульчийн ёс зүй, УБ.,2007
5. Олон улсын Үндсэн хуулийн оршил (Анхдугаар Үндсэн хуулийн судалгааны эх сурвалж), УБ.,2009
 - Япон улсын Үндсэн хууль- 236-256 дахь тал
6. Судалгааны итгэлийн эмхэтгэл (2005-2006 оны хичээлийн жил), УБ.,2006
 - Д.Гангабаатар. Гэрлэлт цуцлалт болон гэр бүлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа (Япон улсад)-51-55 дахь тал
7. Үндсэн хууль ёс ба Үндсэн хуулийн эрх зүйн тогтолцоо (Олон улсын симпозиум II), УБ., 2009
 - Уэчи Ичиро. Японы эрх зүйн соёл, 63-71 дэх тал
8. Л.Хайсандай, Олон улс судлалын өгүүллүүд, УБ.,2003
 - Монгол, Японы харилцаа: эерэг хандлага, өөдрөг үйл явц 125-141 дэх тал
9. Харьцуулсан эрх зүйн онол, практикийн орчин үеийн асуудал, УБ.,2007
 - Б.Гүнбилэг. ИБУИНВУ, ХБНГУ, Япон, Монгол улсуудын жишгийн эрх зүйг харьцуулах нь- 103-113 дахь тал /Шүүхийн жишиг Японы эрх зүйн эх сурвалж болох нь- 109 дэх тал/
10. Шүүх эрх мэдэл- шинэ зуун (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал), УБ.,2001
 - Шозо Ота. Япон улс дахь шүүхийн хараат бус байдал- 89-106 дахь тал
11. С.Энхцэцэг, Н.Энхбаатар, Хууль бүтээх журмын онцлог : Япон улсын туршлага, харьцуулалт, УБ.,2006
12. Б.Эрдэнэбат, Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал, УБ.,2008
13. Япон улсын Үндсэн хууль (орч.П.Амаржаргал), УБ.,2011

Хууль дээдлэх ёс сэтгүүл

14. Б.Гүнбилэг, Японы эрх зүйн тогтолцоо болон түүнд шүүхийн жишгийн эзлэх байр суурь, 2007/№1

Монголын төр, эрх зүй

15. Кодама Шигэрү, Японы 1990-ээд оны үеийн захиргааны шинэчлэл, 2011/№4

Өмгөөлөгч

15. Миха Изка, Японы өмгөөлөгчдийн хууль зүйн статусын тухай 2007/№3
16. Миха Изка, Япон дахь төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа 2007/№11
17. Миха Изка, Японы шүүхийн эрүүгийн хэргийн ялын дээд хэмжээний тухай 2008/№5
18. Миха Изка, Японы өмгөөллийн үүх түүхээс, 2008/№10
19. А.Мөнхтөр, Гадаадын зарим орнуудын Эрүүгийн хууль тогтоомжид завших үрэгдүүлэх гэмт хэргийг хуульчилсан нь, Гэмт явдалтай тэмцэх асуудал, 2005/3, 21-23 дахь тал
 - Японы эрүүгийн хууль тогтоомж, 24 дэх тал
19. Ч.Нямсүрэн, Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрхийг шүүхийн бус журмаар шийдвэрлэж буй гадаад орнуудын туршлага, Гэмт явдалтай тэмцэх асуудал, 2007/3, 23-29 дэх тал
 - Японы байцаан шийтгэх тогтолцооны хослол, 35-36 дэх тал
20. З.Төрмандах, Японы цагдаагийн байгууллагын хээл хахуулын гэмт хэрэгтэй тэмцэхэд гүйцэтгэдэг чиг үүрэг, 2004/№2

<http://www.loc.gov/law/help/japan.php> АНУ-ын Конгрессын номын сангийн мэдээлэл

НАЙМДУГААР СЭДЭВ: БНСУ-ЫН ЭРХ ЗҮЙ

Солонгосын эрх зүйн тогтолцоо, түүхэн хөгжил болон эрх зүйн онцлог

Солонгосын эрх зүй гэдэгт Өмнөд болон хойд Солонгосын эрх зүй хамрах ба өөрөөр хэлбэл, Солонгосын эрх зүй гэсэн өргөн хүрээний ойлголтоос бид БНСУ-ын эрх зүйг тусгайлан авч үзнэ. Солонгосын эрх зүйн хувьд Солонгосын хойгт байгаа улсын эрх зүй гэж ойлгох учраас Солонгосын хойгт нэгдсэн улс байгуулагдаад 1500 гаруй жилийн нүүрийг үзэж байна. Тэгвэл үүнээс өмнө Солонгосын хойгт Кугурё улс байсан ба энэхүү улс нь тухайн үеийн Манж Чин улс байжээ. Манж Чин улс Солонгосын хойгт амьдарч байсан үед ч солонгос үндэстэн оршин тогтнож байсан ба гэхдээ тэр үеийн эрх зүйг Солонгосын эрх зүй гэж үзэх нь маргаантай асуудал болдог.



Дэлхийн дийлэнх улс орнуудын эрх зүйн түүх нь гадаад орнуудаас дамжин орж ирж нутагших хандлагатай байдаг ба Солонгосын эрх зүйн хувьд ч мөн адил хөрш зэргэлдээ болон гадаадын зарим орнуудын эрх зүйн ололт, хөгжилд тулгуурлан өөрийн эрх зүйн түүхийг бүтээсэн байдаг.

Эртний Чусонд 8 зүйл бүхий Эрүүгийн хуулийг хэрэглэж байсан баримт байх ба үүнийг Пал Жу Бабгим гэдэг байжээ. НТӨ 2333 жилийн өмнө хэрэглэгдэж байсан энэхүү эртний Солонгосын хуулиар хүн амь, хулгай, бусдын бие махбодийг гэмтээсэн зэрэг гэмт хэргүүдийг хуульчилж байсан байна. Түүнчлэн энэ хуульд цаазаар авах ял, торгох ял зэргийг оногдуулж байсан ба ингэхдээ тариа будаагаар торгох буюу мөнгөн зоосоор торгох гэхчлэн ялгамжтай байсан. Энэхүү хуулийн дараагаар Солонгосын эрх зүйн түүхэнд ямар хууль үйлчилж байсан нь тодорхойгүй бөгөөд аман эрх зүйн эх сурвалжийг хэрэглэж байсан байх магадлалтай.

Солонгосын эрх зүйн түүхэн хөгжилд ихээхэн нөлөөлсөн улс бол Хятад бөгөөд тухайлбал НТ 313 онд Хятадын буюу тухайн үеийн Манж Чин улсын нутаг дэвсгэрт оршиж байсан Кугурё улс Хятадын Юүл Рёон -ийг шилжүүлэн хэрэглэж байсан байна. “Юүл” нь одоогийн Эрүүгийн хууль харин “Рёон” нь захиргааны хуультай агуулгын хувьд төстэй юм. Юүл Рёон нь Солонгосын эрх зүйн анхны бичмэл эх сурвалж болохын хувьд 19 дүгээр зууны сүүл хүртэл орчин үеийн эрх зүйг хэрэглэх хүртэл 1700 жилийн турш солонгосын эрх зүйн үндсэн эх сурвалж болон хэрэглэгдэж байжээ.

Чусоны эзэнт гүрний үед буюу 1397 онд “Эдийн засгийн 6 эмхэтгэл” гэх анхны улсын хэмжээний эмхэтгэл гарсан ба 1485 онд түүнд нэмэлт оруулж Солонгосын өвөг дээдсийн хууль хэмээн нэрлэгддэг “Гёонгүг Тэжон” хэмээх эмхэтгэл болсон. Энэ нь захиргааны хууль ба тусгай эрүүгийн хуулийг агуулсан төдийгүй Их захирамж хууль зэрэг багтсан байжээ. “Гёонгүг Тэжон” нь Их захирамж хууль шиг Хятад улсаас үүсэлтэй биш солонгосын язгуур эрх зүйн эх сурвалж байсан гэдгээрээ алдартай юм.

XIX зууны сүүл үеэс Чусоны эзэнт улс өрнөдийн эрх зүйн үзэл санаа, хэм хэмжээг авч зээлдэн нутагшуулсан гэж үзэж болох ба учир нь шууд утгаараа зээлдэн аваагүй ч Японы эрх зүйг авч хэрэглэснээрээ давхар өрнөдийн эрх зүйг авч хэрэглэж байсан юм. 1905 онд батлан гаргасан Эрүүгийн хууль болох “Хёон Боб Тэжон” нь зөвхөн эрүүгийн эрх зүйн харилцааг зохицуулсан төдий биш Иргэний болон захиргааны эрх зүйн хэм хэмжээ агуулсан байдаг. 1910-1945 оны хооронд Солонгосын эрх зүйн хөгжил үндсэндээ зогсонги байдалд орж гадаадын эрх зүйн буюу өрнөдийн эрх зүйн соёлын нөлөөгөөр боловсрогдон батлагдсан Японы эрх зүйгээр Солонгосын нийгмийн харилцааг зохицуулж байжээ. 1945 оноос Солонгос улс Япон улсаас хараат байдлаас гарч БНСУ-ын бие даасан засгийн газар бүрэлдсэн хэдий ч эрх зүйн дорвитой өөрчлөлт гараагүй байна.

1948 оноос өрнөдийн эрх зүйн соёл, үзэл санааг шууд чөлөөтэй авч хэрэглэснээр Японы эрх зүйн мөн чанар, зарчмаас гадна Германы эрх зүйн үндсэн зарчим, үзэл баримтлалыг зээлдэн нутагшуулжээ. 1987 онд Үндсэн хуулийн шүүх байгуулж тэрхүү шүүх нь хүний үндсэн эрхийг хамгаалсан олон хууль болон шийдвэр гаргаж хүний эрхийг хангах, зах зээлийн суурь зарчмыг баталгаажуулж өгсөн. 1997 оноос АНУ-ын эрх зүйн хэв шинжийг агуулсан эрх зүйн шинэчлэлтийг хийсэн байна. Иймд Солонгосын эрх зүйн онцлог нь бүхэлдээ Германы эрх зүйн хэв маяг давамгайлдаг боловч Америкийн эрх зүйн нөлөө нилээдгүй байдаг. Өөрөөр хэлбэл, БНСУ-ын орчин үеийн эрх зүйн тогтолцоо нь Ром-Германы эрх зүйн аймагт хамаарах хэдий ч Англи-Америкийн эрх зүйгээс авсан зүйл нилээд бий. Түүнчлэн солонгосчуудын эрх зүйн ухамсар, эрх зүйн соёл нь Дорнод Азийн ард түмний нийтлэг шинжтэй Кунзийн сургаалын уламжлал болох хамтач үзэл, эцгийн эрхт ёс, ёс зүйн хэм хэмжээ зэрэгт нь тодорхой хэмжээгээр тулгуурладаг байна.

Солонгосын эрх зүйн эх сурвалж



БНСУ-ын Үндсэн хууль нь улсын үндсэн гол хууль, төрийн засаглалын бүтэц, засаглалын үйл ажиллагааны зарчмыг тогтоож, иргэдийн үндсэн эрхийг хамгаалсан хамгийн дээд хууль юм. 1948 оны 7 сарын 7-ны өдөр анх Үндсэн хуулиа баталсан ба үүнээс хойш есөн удаа шинэчлэн найруулсан. Одоогийн дагаж мөрдөж буй Үндсэн хууль нь 1987 оны 10 сарын 29-ны өдөр шинэчлэгдсэн ба удиртгал, 10 бүлэг, 130 зүйл, нэмэлт 6 зүйлтэй.

Үндсэн хуульд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү хууль тогтоох байгууллага болох Парламент (Ерөнхий Ассамблей)-д хадгална гэж заасан. Үүний дагуу Ерөнхий Ассамблей хуулийг тогтоон баталж, тунхаглана. Бүгд Найрамдах Солонгос Улс нь нэгдмэл улс бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь нь 9 провинц, Сөүл, Пусан хотоос бүрдэнэ. Хууль нь Солонгосын эрх зүйн үндэс суурь, нийгмийн бүхий л харилцааг зохицуулах ба 2011 оны 11 сарын байдлаар Солонгост 1206 хууль байна. Хуулийг батлахад хуралдаанд оролцсон парламентын гишүүдийн олонхийн саналаар (2/3-аас дээш) шийдвэрлэх ба баталсан хуулийг Ерөнхийлөгчид шилжүүлнэ. Олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр байх ба мөн Ерөнхий Ассамблей соёрхон батламжилна. Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, яамны шийдвэр болон нутгийн удирдлагын шийдвэр, тогтоол ба захирамж нь эрх




зүйн эх сурвалжийн төрлүүд бөгөөд Үндсэн хуульд зааснаар эдгээр шийдвэр, тогтоол, захирамж зэрэг нь хууль тогтоомжийн хүрээнд түүнийг нарийвчилсан зохицуулалт байна гэжээ.

Дээр дурдсан эрх зүйн эх сурвалжаас гадна бичмэл бус эрх зүй буюу заншлын эрх ба зүй тогтол (амьдралын хэвшил) нь Солонгосын эрх зүйн тогтолцоонд ялангуяа, Иргэний харилцаанд ашиглагдаж байдаг хэм хэмжээ гэж үзэж болох юм. Мөн түүнчлэн шүүхийн шийдвэр нь эх сурвалж мөн үү гэдэг нь маргаантай байдаг асуудлын нэг бөгөөд ихэнх судлаачид Солонгосын эрх зүйн шүүхийн жишиг нь зөвхөн шүүхтэй холбоотой учраас “жишиг эрх зүй” болж чадахгүй гэж үздэг байна. Үндсэндээ Солонгосын эрх зүйд 2 төрлийн шүүхийн шийдвэр гардаг ба нэг нь иргэн, эрүү, захиргааны хэргүүдтэй холбоотой дээд шүүхийн шийдвэр, нөгөө нь үндсэн хууль зөрчсөн хууль тогтоомжийг хянадаг үндсэн хуулийн шүүхийн шийдвэр байдаг.

БНСУ-ын шүүхийн тогтолцоо

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хууль болон Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль (1949) нь тус улсын шүүхийн тогтолцооны эрх зүйн үндэс болдог. Нийт шүүхийн тогтолцоонд Дээд шүүх тэргүүлэх байрыг эзлэх ба энэ нь цэргийн шүүхэд хамаарах хэргийг оролцуулан мөн иргэн, эрүү, захиргааны бүхий л хэргийн давж заалдах хамгийн дээд шатны шүүх мөн.



Сөүл, Кванджу, Тэгү дэх дээд шатны шүүх нь иргэний болон эрүүгийн хэргийн талаар гаргасан доод шатныхаа шүүхүүдийн шийдвэрт давж заалдсан гомдлыг авч үзэх бөгөөд бас Засгийн газрын дээд байгууллага, дээд албан тушаалтнуудын эсрэг гаргасан нэхэмжлэлийн хувьд анхан шатны үүрэг гүйцэтгэнэ. Иргэний болон эрүүгийн ихэнх хэргийн хувьд Сөүл болон бусад аймгуудын гол гол хошуудад тойргын шүүхүүд анхан шатны шүүхийн үүрэг гүйцэтгэдэг. Солонгос улс нь гэр бүлийн шүүхтэй бөгөөд энэ шүүхээр гэр бүлийн эрх зүйн асуудлууд болон насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэнэ. Гэр бүлийн шүүхийн зэрэгцээ цэргийн шүүхийг тусгай шүүхэд тооцдог.

Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Үндэсний хуралтай зөвшилцөн томилох ба бусад шүүгчдийг Ерөнхий шүүгчийн санал болгосноор Үндэсний хуралтай зөвшилцсөний

дараагаар мөн Ерөнхийлөгч томилно. Доод шатны шүүхийн шүүгчдийг Дээд шүүхийн шүүгчдийн бага хуралтай зөвшилцөн Ерөнхий шүүгч томилно. Дээд шүүхийн шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил, доод шатны шүүхийн шүүгчдийн хугацаа 10 жил байна.

Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн дагуу хэрэгжүүлэх эрхийг Дээд шүүх болон Үндсэн хуулийн шүүх эдэлнэ. Дээд шүүх нь тодорхой шүүн таслах ажиллагааны явцад үүссэн асуудалтай холбогдуулан гаргасан декрет болон бусад хуульчилсан акт Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шалгана. Үндсэн хуулийн шүүх нь тодорхой байцаан шийтгэх ажиллагааны явцад шүүхийн хүсэлтээр хууль, Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг түүнчлэн эрх зүйн хамгаалалтын бусад бүхий л хэрэгслээр аливаа этгээдийн гомдлоор хууль Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хэлэлцэнэ. Үүнээс гадна улс төрийн намыг тараах тухай шийдвэр, Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд болон бусад тушаалтнуудыг ажлаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх зэрэг онцгой бүрэн эрхийг Үндсэн хуулийн шүүх эдэлдэг. Ерөнхий Ассамблей, Ерөнхийлөгч, Дээд Шүүхийн Ерөнхий шүүгчээс тус бүр 3 хүнийг томилсон 9 шүүгч Үндсэн хуулийн шүүхийг бүрдүүлнэ. Үндсэн хуулийн шүүхийн даргыг тэдгээр 9 шүүгчдийн дундаас Ерөнхийлөгч томилно.

Эрх зүйн мэргэжил

Солонгосын эдийн засаг, улс төр нь боловсронгуй хууль тогтоомж дээр бат суурилсан байдаг. Бүгд Найрамдах Солонгос Улс хууль зүйн салбарт ч сүүлийн хэдэн арван жил онцгой өөрчлөлт хийж чадсан. Бусад үндэстний туршлагыг үр дүнтэйгээр Солонгосын нөхцөлд нутагшуулах замаар Солонгосын хууль зүйн системийг тогтвортой, нэг чиглэлтэй хөгжүүлсэн. Энэхүү эрх зүйн боловсролын шинэтгэл хийх явцад багагүй бэрхшээл байсан ч илүү шударга, боломжтой нийгмийн төлөөх ард түмний хэрэгцээнд тулгуурлан хөгжүүлж иржээ. Солонгос улсад хуульч болохын тулд бүх хүн ижил зам туулах шаардлагатай бөгөөд тэдгээр нь Үндэсний хуулийн шалгалт өгөх (цаашид “ҮХШ” гэх), Хууль зүйн сургалт, судалгааны төвд сургалтад хамрагдах явдал байжээ. Үндэсний хуулийн шалгалт нь жил бүр авдаг улсын хэмжээний сорил бөгөөд Засгийн газар хуульчдаа сонгоход ашиглаж байсан. Түүнчлэн, Солонгосын Дээд шүүхийн дэргэдэх хууль зүйн мэргэжлийн сургалтын төвд дадлагад гарахаас өмнө хуульчид сургалтад хамрагддаг байжээ. Төвд хууль зүйн боловсрол эзэмшсэн иргэд мэргэшсэн байдлаас үл хамааран бүгд ижил нөхцөлд сурч, ижил шалгалт өгдөг байсан ба Солонгосын хуульчдын хүрээнийхэн ижил түвшинд байсан байна.

Эрх зүйн мэргэжил эзэмшүүлэх сургалтад шинэтгэл хийх тухай асуудал маргаан дагуулсан асуудал байсан бөгөөд анх 1993 оноос эхлэн Шүүхийн тогтолцооны хөгжлийн комисс болон Даяарчлалын хороо хууль



зүйн боловсролын шинэчлэлийн асуудлыг хэлэлцэж эхэлсэн. 2005 онд Ерөнхийлөгчийн дэргэдэх Шүүхийн шинэчлэлийн хороо шүүхийн шинэчлэлийг хууль зүйн боловсролын шинэтгэлтэй хамт хэрэгжүүлснээр шинэчлэлийн үйл явц эрчимжсэн. Үүний дүнд Өмнөд Солонгос Улсад Америк маягийн хууль зүйн сургуулийн загвар бүхий Хууль зүйн сургуулийн тухай хууль 2007 онд батлагдсан байна. Шинэ боловсролын систем нь АНУ-ын хууль зүйн сургуулийн загварыг агуулсан – мэргэжлийн дээд түвшний гурван жилийн сургалттай болсон ба 2009 онд нийтдээ 25 хуулийн сургууль нээгдэж, янз бүрийн мэргэжил, ажлын туршлагатай 2500 оюутан элсүүлсэн. Тус улсын эрх зүйн боловсролын тогтолцоон дахь хуулийн сургуулийн тоо болон оюутнуудын тоог сургууль тус бүрээр нь Засгийн газар тогтоодог онцлогтой байна.

2012 онд Солонгосын шүүхийн нийгэмлэгт идэвхтэй шүүгчдийн тоо нийтдээ 11725 гэж бүртгэгдсэн. Нийт шүүгчдийн тоо 2003 онд 5586, 2006 онд 7603, 2009 онд 9612, 2011 онд 10976 байжээ. Хуулийн сургуулиуд хуульчдыг жил бүр ихээр гаргаж байгаа бөгөөд хуулийн салбарын зах зээл дэх хуульчдын өрсөлдөөн нэмэгдэж байгаа нь иргэдийг хууль зүйн үйлчилгээг хүртэх боломжийг ч нэмэгдүүлдэг байна.

Хэлэлцэх асуудал:

1. Солонгосын эрх зүй БНСУ-ын эрх зүй гэдэг ойлголтын ялгаатай талуудыг ярилцана уу.
2. БНСУ-ын эрх зүйд Японы эрх зүйн үзүүлсэн нөлөө, түүгээр дамжуулан Өрнөдийн эрх зүй нэвтэрсэн тухай хэлэлцүүлэг зохионо уу.
3. Зүүн өмнөд Азийн эрх зүйн хөгжилд Солонгосын эрх зүйн үзүүлэх нөлөөний талаар ярилцана уу.
4. Дээрх 2 улсын эрх зүйн тогтолцооны нийтлэг болон ялгаатай талуудыг гэрийн даалгаварт бэлтгэн ирж маргаан өрнүүлнэ үү.
Санал болгож буй арга нь: Хэлэлцүүлэг зохиох
Хүн бүр багш
5. Солонгосын эрх зүйн эх сурвалжуудын талаар ярилцаж, шүүхийн шийдвэр эрх зүйн эх сурвалжид хамаарах талаар багаар ярилцана уу.
6. БНСУ-ын эрх зүйг судалснаар ямар ач холбогдолтой болон өөрийн оронд эрх зүйн шилжүүлэг, хөрвүүлэг хийж болох эрх зүйн шилдэг зохицуулалтын талаар оюутан бүр өөрийн санааг дэвшүүлэн багаар чөлөөт ярилцага зохион уу.

Санал болгож буй арга: Багаар ажиллах
Хэлэлцүүлэг хийх

Эх сурвалж:

1. Солонгосын эрх зүйн удиртгал, Солонгосын Боловсролын Хөгжлийн Институт, 2011 он. 87-113 дахь тал.
2. Нарангэрэл С., *Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо*, Улаанбаатар 2011. 420-422 дахь тал.
3. Chun Shin-yong., *Legal system of Korea*, International Cultural Foundation, 2000.
4. <http://www.korealaw.com/sub/information/boardView.asp?brdIdx=2&mode=view&brdId=overview>
5. <http://www.nationsencyclopedia.com/Asia-and-Oceania/Korea-Republic-of-ROK-JUDICIAL-SYSTEM.html>